



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1-2
Хуралдааны товч тэмдэглэл:	3-75
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	76-285
1.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	76-97
2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	97-106 179-180
3.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/	106-112 180-181
4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	112-128 181-182
5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	128-130
6.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	130-139
7.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/	139-161 182-184
8.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	161-169 184-222
9.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	169-172 222-238
10.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газар зүйн нэрийн	172-174

жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	238-240
11.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	174-179 240-261
12.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	261-277
13.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	277-281
14.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	281-282
15.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	282-285

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 18-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, Н.Номтойбаяр, Б.Түвшин, Д.Цогтбаатар, Ө.Шижир;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, Д.Батлут, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Б.Заяабал, П.Мөнхтулга, Б.Найдалаа, С.Одонтуяа, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Б.Тулга, Г.Тэмүүлэн, А.Ундраа, С.Цэнгүүн, Д.Энхтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Х.Болормаа, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, М.Сарнай;

Тасалсан: С.Амарсайхан, С.Лүндэг.

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-01 минут, О.Алтангэрэл-11 минут, Н.Алтаншагай-21 минут, Х.Баасанжаргал-1 цаг 33 минут, Ц.Баатархүү-22 минут, Б.Батцэцэг-16 минут, Б.Баярбаатар-26 минут, Э.Болормаа-3 цаг 26 минут, Ж.Галбадрах-1 цаг 43 минут, Д.Ганбат-31 минут, Л.Гантөмөр-13 минут, Б.Дэлгэрсайхан-12 минут, Б.Жаргалан-13 минут, Д.Жаргалсайхан-43 минут, Ж.Золжаргал-13 минут, Г.Лувсанжамц-19 минут, Т.Мөнхсайхан-03 минут, Ц.Мөнхтуяа-15 минут, Ч.Номин-06 минут, О.Саранчулуун-14 минут, Р.Сэддорж-35 минут, Ч.Ундрам-05 минут, Г.Уянгахишиг-02 минут, Ж.Чинбүрэн-03 минут, Ж.Энхбаяр-2 цаг 12 минут, Р.Эрдэнэбүрэн-04 минут.

Өргөн мэдүүлсэн төслийн талаарх мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Засгийн газраас 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд;

2.Засгийн газраас 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

3.Засгийн газраас 2026.06.11-ний өдөр өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

4.Засгийн газраас 2026.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн

тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:10/

Нэг.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Энхтүвшин, А.Ариунзаяа, О.Батнайрамдал, П.Ганзориг, Р.Эрдэнэбүрэн, Л.Гантөмөр, Б.Жавхлан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос

гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 11 цаг 33 минутаас хуралдааныг даргалав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, М.Мандхай нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:50/

Гурав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:12/

Дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Бадамсүрэн, Б.Мөнхсоёл, Ц.Мөнхбат, О.Саранчулуун, Х.Баасанжаргал, Б.Жавхлан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Н.Учрал нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:05/

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 04 минут үргэлжилж, 13 цаг 06 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 13 минутад эхлэв.

Тав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал

гараагүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /STREAM+/ төслийн зөвлөх Я.Хишигт оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Ж.Галбадрах, П.Наранбаяр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:52/

Долоо.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигч Д.Ариунболд, Ж.Болд, Д.Давааням, Д.Мөнхзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт А.Амармэнд нар байлцав.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулснаар үргэлжлэв.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ганбаатар, Ц.Баатархүү, Д.Ганбат, Х.Баасанжаргал, Б.Жаргалан нарын тавьсан асуултад нэр дэвшигч Д.Ариунболд, Ж.Болд, Д.Давааням, Д.Мөнхзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:15/

Найм.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүн Н.Баярмаа, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Х.Эрдэм-Ундрах, Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Л.Энхбилэг, Дүүргийн Эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Н.Одонтуул, Улсын Ерөнхий прокурорын газрын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга О.Мөнхбаатар, мөн газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, ахлах прокурор Г.Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, мөн газрын Иргэний бүртгэлийн газрын дарга Н.Наранцэцэг, мөн газрын улсын ахлах бүртгэгч Б.Нарангэрэл, Б.Отгон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч А.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ж.Галбадрах нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:44/

Ес.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Гэмт хэрэг, зөрчил шалгах албаны хэлтсийн дарга Б.Шинэбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 16 цаг 44 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:50/

Арав.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, мөн газрын Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, Шинжлэх ухааны академийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч, шинжлэх ухааны доктор, академич Ц.Цэрэндорж, мөн академийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн Газар зүйн мэдээллийн систем, зураг зүйн салбарын дарга Ц.Наранцацрал, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга, доктор Н.Нарангэрэл, Монгол Улсын гавьяат барилгачин, зөвлөх инженер Д.Оюунчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх А.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:55/

Арван нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, судлаач Ч.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Санал хураалт явуулах цаг болсон тул асуулт, хариултыг түр хойшлуулав./17:17/

Хоёр дахь асуудал буюу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “1.5 тэрбум” гэснийг “2.5 тэрбум” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “25-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, 26.2 дахь хэсэг, 30.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “05-ны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “10-ны” гэснийг “05-ны” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	20
Бүгд:	91
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.	

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирыг дэмжсэнээр тооцож, 79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Гурав дахь асуудал буюу Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал/

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтын “албан татвар төлөгчийн” гэснийг “иргэний” гэж, “аялал жуулчлалын бүс” гэснийг “, улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд баригдсанаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 17
Бүгд: 91
81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын 21.2 дахь хэсгийг хасаж, 7 дугаар зүйл болгох.

“7 дугаар зүйл.Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 20
Бүгд: 91
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв дэх асуудал буюу Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 72
Бүгд: 91
20.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Долоо дахь асуудал буюу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан томъёоллоор нууц санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Байнгын хорооны саналаар Дашживаагийн Ариунболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 31
Бүгд: 91
65.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Доржсүрэнгийн Мөнхзоригийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 35
Бүгд: 91
61.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Жамсрангийн Болдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Довдонгийн Даваанямыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 34
Бүгд: 91
62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Бүрэн эрхийн хугацаа нь дууссантай холбогдуулан Мажигийн Амгаланбаатар, Гочоосүрэнгийн Байгальмаа нарыг болон гаргасан хүсэлтийнх нь дагуу Төмөрбаатарын Сүхболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 29

Бүгд: 91

68.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-т заасны дагуу санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:32/

Уг асуудлыг 17 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа дахь асуудал буюу Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал/

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын байнгын хорооны
дэмжсэн санал:**

С.Бямбацогт: 1.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” гэснийг “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд” гэж, 13.1.4 дэх заалтын “энэ хуулийн 6.8-д заасан” гэснийг “энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 23

Бүгд: 91

74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Найм дахь асуудал буюу Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Одонтуяа, Г.Уянгахишиг, О.Алтангэрэл, А.Ариунзаяа, Д.Ганбат, Л.Мөнхбаатар, С.Зулпхар, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, О.Саранчулуун, Б.Тулга, С.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль,” гэсний дараа “Иргэний хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 16
Бүгд: 91
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэх” гэснийг “дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих” гэж, 4.1 дэх хэсгийн “насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах” гэснийг “Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хүүхэд хамгааллын” гэж, 4.2 дахь хэсгийн “хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн” гэснийг “эрх ашиг нь хөндөгдсөн” гэж, 4.3 дахь хэсгийн “сум, хорооны Засаг дарга, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Хүүхэд хамгааллын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан байгууллага” гэж өөрчилж, 4.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.Гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй байх зарчмыг баримтална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 19

Бүгд: 91
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “хүүхдийн асрамжийн” гэснийг “хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоох” гэж өөрчилж, 5.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.11.гэрлэлтийн бүртгэлгүй хамтын амьдралаас үүсэх хөрөнгийн харилцаатай холбоотой маргаан.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 19
Бүгд: 91
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.6.гэрлэлт сэргээх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 19
Бүгд: 91
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“6.2.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2-т заасан хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд шилжсэн хүүхдийн хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах;

6.2.7.асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 24
Бүгд: 91
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.1, 7.2, 7.3 дахь хэсэг болгох:

“7.1.Гэр бүлийн хэргийг Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх, сум, сум дундын шүүх, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

7.2.Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн гэр бүлийн хэргийг Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

7.3.Энэ хуулийн 7.2-т зааснаас бусад тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 19
Бүгд: 91
79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “бага насны” гэснийг “0-14 нас хүрээгүй” гэж, мөн дугаарыг “9.1” болгон тус тус өөрчилж, төслийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйл, энэ хуулийн 9.1-д заасны дагуу нэхэмжлэгч шүүхийг сонгосон бол энэ хуулийн 7.1-д заасан нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 20
Бүгд: 91
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 11 дүгээр зүйл нэмэх:

“11 дүгээр зүйл.Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах

11.1.Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн гардуулна.

11.2.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүх энэ хуулийн 11.1-д заасны дагуу дараах нэхэмжлэлийг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй бол хариуцагчийн ажлын газрын хаягаар, хариуцагчийн албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа 30 хоногийн дотор хийж, тодруулж ирүүлсэн хаягаар тус тус гардуулна:

- 11.2.1.гэрлэлт цуцлуулах;
- 11.2.2.хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоолгох;
- 11.2.3.тэжээн тэтгэх, тэтгүүлэх;
- 11.2.4.хүүхдийн эцэг, эхийг тогтоолгох;
- 11.2.5.эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасуулах, эсхүл сэргээлгэх;
- 11.2.6.хүүхэд үрчлэлт;

11.2.7.асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах.

11.3.Шүүх энэ хуулийн 11.2-т заасны дагуу холбогдох нэхэмжлэлийг хариуцагчид хүргүүлсэн боловч тухайн хаягт оршин суудаггүй бол Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаарх мэдээллийн сүлжээ, сангаар дамжуулан хариуцагчийг эрэн сурвалжлах арга хэмжээ авхуулна.

11.4.Энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд шүүх нэхэмжлэлийг гардуулах болон хэргийн оролцогчид хэргийн материал танилцуулахдаа эрсдэлд орсон гэрлэгч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүний нэхэмжлэлд тусгасан хувийн мэдээллийг уншигдах боломжгүй байдлаар нууцална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	23
Бүгд:	91

74.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Хэргийн оролцогч, хүүхэд хамгааллын байгууллага, ажилтны хамтран ажиллах үүрэг

11.1.Хэргийн оролцогч үйл баримтын талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх бөгөөд үйл баримтыг тогтооход хамтран ажиллах үүрэгтэй.

11.2.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтан, хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ажиллах, энэ талаар гаргасан шүүгчийн захирамжийг биелүүлэх үүрэгтэй.

11.3.Шүүхээс гарах шийдвэр нь маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаагүй этгээдийн эрх, үүрэгт сөргөөр нөлөөлөхөөр байвал, эсхүл хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах шаардлагын үүднээс шүүхийн шийдвэр гарахаас өмнө уг этгээдийн өөрийнх нь, эсхүл зохигчийн хүсэлтээр, эсхүл шүүх санаачилгаараа бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.

11.4.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх явцад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрвэл шүүгч энэ талаар эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

11.5.Шаардлагатай тохиолдолд шүүх гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл өгөх, холбон зуучлах ажиллагааг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 20
Бүгд: 91
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “хэргийн материалтай” гэснийг “хэргийн материал, нотлох баримттай” гэж өөрчилж, 12.3 дахь хэсгийн “энэ хуулийн 6.1-д заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргээс бусад” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 24
Бүгд: 91
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.2, 12.1.3 дахь заалт, 12.3 дахь хэсэг нэмэх:

“12.1.2.хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоолгох;

12.1.3.тэжээн тэтгэх, тэтгүүлэх;”

“12.3.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шууд дамжуулах болон олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 20
Бүгд: 91
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “14.1-д” гэснийг “14.1, 14.2-т” гэж, 14.6 дахь хэсгийн “Нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд шүүгч нэхэмжлэлийг буцаана.” гэснийг “Нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй, энэ хуулийн 14.3-т заасны дагуу албадан ирүүлэх боломжгүй бол шүүгч нэхэмжлэлийг буцаах эрхтэй.” гэж, 14.9 дэх хэсгийн “Эрх ашиг нь хөндөгдсөн этгээд энэ хуулийн 14.3-т заасан захирамжийн торгууль ногдуулсан хэсэгт” гэснийг “Энэ хуулийн 14.3-т заасан үндэслэлээр торгуулсан зохигч, түүний төлөөлөгч” гэж өөрчилж, 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулан 14.1, 14.2 дахь хэсэг болгон 14.3 дахь хэсгийн “Энэ зөрчлийг давтан гаргасан бол шүүгч зөрчил бүрд арга хэмжээ авах эрхтэй.” гэснийг хасах:

“14.1.Өмгөөлөгч оролцож байгаа эсэхээс үл хамааран зохигч шүүх хуралдаанд өөрөө хүрэлцэн ирж оролцох үүрэгтэй. Зохигч хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд шүүх хуралдаанд өөрөө оролцох үүргээ цахим хэлбэрээр хэрэгжүүлж болно.

14.2.Шүүх хуралдаанд оролцох үүргээ шүүхийн байрнаас бусад газарт цахим хэлбэрээр хэрэгжүүлж байгаа тохиолдолд шүүгч шаардлагатай гэж үзсэн нөхцөлд зохигч Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71.1.14-т заасан шүүх хуралдаан хийх шаардлага хангасан байрнаас шүүх хуралдаанд оролцоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	20
Бүгд:	91

78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам” гэснийг “Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаа” гэж өөрчилж, 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.Энэ хуулийн 25.4-т зааснаас бусад гэрлэлт цуцлуулах маргаанд шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	24
Бүгд:	91

73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “насанд хүрээгүй хүүхдийг хүмүүжүүлэх, түүнд асрамж тогтоох” гэснийг “хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоолгох” гэж өөрчилж, 16.2, 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.Хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоох, тэжээн тэтгэх асуудлыг шүүх гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж, шийдвэртээ энэ талаар тусгана.

16.4.Хүүхэд 7 буюу түүнээс дээш настай бол хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтооход түүний санал болон энэ хуульд заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайланг харгалзан үзнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	21
Бүгд:	91

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.5 дахь хэсэг нэмж, 16.5 дахь хэсгийн дугаарыг “16.6” болгон өөрчлөх:

“16.5.Нэхэмжлэл нь хуульд заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно. Нэхэмжлэгч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол шүүгч уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 21
Бүгд: 91
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ

18.1.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүгч шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар, эсхүл талуудын хүсэлтээр дараах арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно:

18.1.1.насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, нэмэлт зардлыг гаргуулах;

18.1.2.хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах;

18.1.3.хүүхдийг эцэг, эсхүл эхтэй хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, шүүхээс томилсон бусад этгээдийн хяналтад, эсхүл дангаар уулзуулах түр хуваарь гаргах;

18.1.4.энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд аюул учруулж болзошгүй гэрлэгчийг гэрээсээ өөр газарт байхыг даалгах;

18.1.5.энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд гэрлэгчид уулзах, ойртох болон аливаа хэлбэрээр харилцаа тогтоохыг хориглох;

18.1.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.2-т заасан үүргээ биелүүлж, тохирсон арга хэмжээ авахыг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд даалгах;

18.1.7.гэрлэгч хэн нэгийгээ тэжээн тэтгүүлэх;

18.1.8.орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, барьцаалах, захиран зарцуулахыг хориглох;

18.1.9.шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх.

18.2.Шүүх холбогдох этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр энэ хуулийн 18.1.2, 18.1.3, 18.1.4, 18.1.5, 18.1.8, 18.1.9-д заасан урьдчилсан арга хэмжээг авч болох боловч урьдчилсан арга хэмжээ авснаас хойш 14 хоногийн дотор эрх ашиг нь хөндөгдсөн хэргийн оролцогчийн тайлбарыг авна. Шаардлагатай тохиолдолд шүүх хуралдааныг зарлан хуралдуулж болно.

18.3.Шүүх энэ хуулийн 18.1-д заасан захирамж гаргасан бол уг захирамжийг холбогдох этгээдэд нэн даруй хүргүүлнэ.

18.4.Урьдчилсан арга хэмжээ тогтоосон шүүгчийн захирамжийг зөрчсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн санал, эсхүл талуудын хүсэлтээр шүүгч хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шийтгэвэр гарган зөрчил гаргасан зохигч, түүний төлөөлөгчийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хүртэл хэмжээний төгрөгөөр торгож, албадан ирүүлэх захирамж гаргаж болно.

18.5.Шаардлагатай тохиолдолд гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан эцэг, эхийг шүүх өөрийн санаачилгаараа, эсхүл талуудын хүсэлтээр гэрлэлт цуцлуулах, түүний үр дагавар, хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь, хүүхдээ тэжээн тэтгэх зэрэг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх сургалт, хөтөлбөрт хамруулж болно.

Тайлбар: Энэ зүйлийн 18.1.3 дахь заалтад заасан “бусад этгээд” гэж сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	67
Татгалзсан:	24
Бүгд:	91

73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн гарчгийн “Гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах” гэснийг “Хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судлах” гэж өөрчилж, 19.1.1, 19.1.3 дахь заалт, 19.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19.1.3 дахь заалтын дугаарыг “19.1.2.” гэж, 24 дүгээр зүйлийн дугаарыг “19” болгон өөрчлөх:

“19.1.1.хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судалж, тайлан гаргахыг энэ хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэнд даалгах тухай захирамж гаргах;

19.1.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан аюулын зэргийн, 32 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээ болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.2.3-т заасан эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээг хийлгүүлэхээр даалгах тухай захирамж гаргах.”

“19.4.Энэ хуулийн 19.1.2-т заасан холбогдох дүгнэлтийг шүүгчид ирүүлсэн, эсхүл дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсхүл захирамжаар тогтоосон хугацаа өнгөрсөн бол шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80.3-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх бөгөөд энэ захирамжид гомдол гаргахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	71
Татгалзсан:	20
Бүгд:	91

78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн гарчгийн “Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч” гэснийг “Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн” гэж өөрчилж, 20.1, 20.2, 20.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.1.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судлах чиг үүрэг бүхий шүүхийн захиргааны ажилтан байна.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 88¹-д заасан шаардлагыг хангасан байна.

20.3.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь дараах бүрэн эрхтэй:

20.3.1.зохигч болон холбогдох бусад этгээдээс асуулт асуух;

20.3.2.эцэг, эх, хүүхэд болон холбогдох бусад этгээдтэй ганцаарчилсан болон хамтарсан ярилцлага хийх;

20.3.3.гэр бүлийн нөхцөл байдал, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, нийгмийн бүх орчинд ажиглалт явуулах;

20.3.4.холбогдох байгууллагаас лавлагаа, тодорхойлолт, баримт гаргуулах;

20.3.5.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад нэвтрэх, албан тушаалтнаас шаардлагатай асуудлаар мэдээлэл, тайлбар авах;

20.3.6.хүүхэд 7 буюу түүнээс дээш настай бол түүний саналыг авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 22

Бүгд: 91

75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайлан

23.1.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь энэ хуулийн 19.1.1-д заасны дагуу хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг 21 хүртэл хоногийн дотор судалж, тайланг шүүхэд хүргүүлнэ.

23.2.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг тал бүрээс нь судалж, тайлан гаргах бөгөөд тайланд дараах асуудлыг тусгаж болно:

23.2.1.маргааны шалтгаан, нөхцөл, талуудын хүсэл зориг, байр суурь;

23.2.2.гэрлэгчдийн эрүүл мэнд, сэтгэлзүй, зан үйл, нийгэмшилт, хөдөлмөр эрхлэлт;

23.2.3.хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтооход шаардлагатай хүүхдийн нөхцөл байдалтай холбоотой хүчин зүйлийг Гэр бүлийн тухай хуулийн 14¹.4-т заасны дагуу тодорхойлох;

23.2.4.эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах боломжит хувилбар;

23.2.5.хүүхдийн онцлог байдал, хүүхдийн цаашдын хүмүүжил, төлөвшилд эцэг, эхээс анхаарвал зохих асуудал;

23.2.6.талууд эвлэрэх боломжтой эсэх талаарх санал.

23.3.Энэ хуулийн 23.1-д заасан тайлан гаргах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

23.4.Энэ хуулийн 23.1-д заасан тайлангаас тодруулах, нэмэлт дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж үзвэл шүүх энэ талаар асуулт, шаардлага тавьж мэргэжилтэнд дахин хугацаа тогтоон хүргүүлж болно. Шүүгч шийдвэр гаргахдаа тайланг харгалзан үзнэ.

23.5.Хүүхэдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд үл нийцэх бусад баримтыг түүний эцэг, эх тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулахыг хориглоно.

23.6.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн энэ хуулийн 23.2-т заасан бүх асуудлыг болон хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг бүхэлд нь хамарсан иж бүрэн, эсхүл маргааны зүйлээс шалтгаалан шүүгчийн тавьсан асуулт, шаардлагын хүрээнд хэсэгчлэн тайлан гаргаж болно.

23.7.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 23.1-д заасан тайланг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрээр хүргэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 24
Бүгд: 91
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 24
Бүгд: 91
73.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8, 25.9 дэх хэсэг нэмэх:

“25.8.Хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарийг зөрчсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн санал, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд, эсхүл хүүхдийн эцэг, эсхүл эхийн хүсэлтээр шүүгч хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шийтгэвэр гарган зөрчил гаргасан эцэг, эсхүл эхийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хүртэл хэмжээний төгрөгөөр торгож, албадан ирүүлэх захирамж гаргаж болно.

25.9.Гэрлэлт цуцалсан тухай болон бусад шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш тухайн шүүх ажлын гурван өдрийн дотор уг шийдвэрийн

хувийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 26
Бүгд: 91
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.3.Хүнийг нас барсан гэж зарласан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш шүүх ажлын гурван өдрийн дотор уг шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 31
Бүгд: 91
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.2.Энэ хуулийн 29.1-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш шүүх тухайн хүний хөрөнгөд тогтоосон эрхлэн хамгаалалтыг өөрчилж, уг шийдвэрийн хувийг ажлын гурван өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 26
Бүгд: 91
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.2.Сэтгэцийн хувьд эрүүл гэдгийг мэдсээр байж хүнийг эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцуулахаар энэ хуулийн 30.1-д заасан хүсэлт гаргасан нь тогтоогдвол шүүхийн бүх зардлыг буруутай этгээдээс гаргуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 25
Бүгд: 91
72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

**“34 дүгээр зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр
тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлт**

гаргах түүнийг хянан шийдвэрлэх

34.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтэд шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

34.2.Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

34.3.Шүүх хүсэлтийг хангавал асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүйд тооцох тухай шийдвэр гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 25
Бүгд: 91
72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.5.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайлан гарсан тохиолдолд хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах үүднээс эцэг, эхээс нууцалбал зохих хэсгээс бусдыг энэ хуулийн 35.3-т заасан шүүгчийн захирамжид хавсаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 31
Бүгд: 91
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.6 дахь хэсэг нэмэх:

“35.6.Шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, хадмал бичвэр, дуун тайлбар бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 30
Бүгд: 91
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.Эвлэрүүлэн зуучлах баг нь шүүгч, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, сэтгэл зүйчээс бүрдэнэ. Шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 29
Бүгд: 91
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенг дэмжсэнээр тооцож, 69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“36.4.Эвлэрүүлэн зуучлах баг эвлэрүүлэх ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

36.4.1.эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах;

36.4.2.маргаанд ямар нэг хувийн ашиг сонирхолгүйгээр төвийг сахисан байр суурьтай байх;

36.4.3.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 10.1-д заасан Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлөөс баталсан эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийг чандлан сахих.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 28
Бүгд: 91
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч

37.1.Энэ хуулийн 36.1-д заасан сэтгэл зүйчид дараах шаардлага тавигдана:

37.1.1.сэтгэл судлаач мэргэжлээр бакалавр зэрэгтэй байх;

37.1.2.хүүхэд, гэр бүлийн чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

37.1.3.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон мэргэшүүлэх сургалтад хамрагдах;

37.1.4.Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй.

37.2.Энэ хуулийн 36.1-д заасан сэтгэл зүйч нь мэргэжлийн ёс зүй болон хараат бус байх зарчмыг баримтлах бөгөөд дараах үүргийг хүлээнэ:

37.2.1.хугацаагүйгээр нууц хадгалах, задруулахгүй байх;

37.2.2.хараат бус, хувийн ашиг сонирхолгүй байх зарчмыг баримтлах;

37.2.3.эвлэрүүлэх хуралдаанаас өмнө гэрлэгчдэд эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг тайлбарлаж, ганцаарчилсан болон хамтын уулзалт хийх;

37.2.4.гэрлэгчдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;

37.2.5.маргааныг сайн дурын үндсэн дээр шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, гэрлэгчдийн харилцааг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, хамтын шийдэл олоход чиглүүлэх;

37.2.6.гэрлэгчдийн хүсэлтээр мэргэжлийн байгууллагад холбон зуучлах;

37.2.7.хямралын үеийн сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

37.2.8.сэтгэл зүйч нь албан ёсны эрхтэй тест, асуумж, сорилыг ашиглах.

37.3.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага томилно.

37.4.Эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийн эвлэрүүлэн зуучлах багт ажилласны урамшууллыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгох бөгөөд урамшуулал авахаас татгалзаж болно.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан урамшууллын хэмжээг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн “Эвлэрүүлэх хуралдааны” гэснийг “Эвлэрүүлэх уулзалтын” гэж, 38.2 дахь хэсгийн “хуралдаан даргалагчийг” гэснийг “уулзалт чиглүүлэгчийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 25

Бүгд: 91

72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “танилцуулахыг хориглоно” гэснийг “танилцуулах эсэхийг шүүгч, хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний саналыг үндэслэн шийдвэрлэнэ” гэж өөрчилж, 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 39.3, 39.4 дэх хэсэг болгох:

“39.3.Эвлэрүүлэх уулзалтаас дэлгэрэнгүй тэмдэглэл гарна. Дэлгэрэнгүй тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлнө.

39.4.Энэ хуулийн 39.2-т заасан сүүлчийн уулзалтаас дэлгэрэнгүй ба хураангуй тэмдэглэл гарна. Хураангуй тэмдэглэлд гагцхүү гэрлэгч аль нэг асуудлаар эвлэрсэн, эсхүл эвлэрээгүй талаар дурдсан байна. Хураангуй

тэмдэглэлийг эвлэрүүлэх уулзалтын чиглүүлэгч үйлдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 29
Бүгд: 91
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.1.Энэ хуулийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 26
Бүгд: 91
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Гэр бүлийн хэргийн” гэсний өмнө “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “эцэг” гэсний дараа “, эх” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “бүрэлдэхүүнтэй” гэсний өмнө “шүүх” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “гэр бүлийн” гэсний өмнө “хүүхэд,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “зохигчийн хүсэлтээр” гэсний өмнө “өөрийн санаачилгаар, эсхүл” гэж, 25 дугаар зүйлийн 25.4.2 дахь хэсгийн “гэрлэлт” гэсний өмнө “гэрлэгчид” гэж, 30 дугаар зүйлийн гарчгийн “хязгаарлагдмал чадамжтай” гэсний өмнө “эрх зүйн” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “30 хоногоос” гэсний өмнө “шүүгчийн захирамж гарснаас хойш” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “багийн” гэсний өмнө “эвлэрүүлэн зуучлах” гэж, 39.5 дахь хэсгийн “хэргийг” гэсний өмнө “холбогдох” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж, 6.2 дахь хэсгийн “тогтоохдоо онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ” гэснийг “тогтооно” гэж, 6.2.6 дахь заалтын “гэрлэлтийг хүчин төгөлдөр бус” гэснийг “гэрлэлт болон” гэж, 6.4 дэх хэсгийн “гэм хор, нөхөн төлбөр гаргуулах” гэснийг “гэм хорыг арилгуулах” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “хүүхдэд асрамж” гэснийг “хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь” гэж, 10.3 дахь хэсгийн “үрчлэлттэй холбоотой” гэснийг “үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай” гэж, 10.5 дахь хэсгийн “Иргэнийг” гэснийг “Хүнийг” гэж, 10.6 дахь хэсгийн “уг иргэний” гэснийг “тухайн хүний” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “шүүхийн журмаар эцэг, эх” гэснийг “хүүхдийн эцэг, эхийг” гэж, 12.1.3 дахь заалтын “эцэг, эх байх эрхийг хасах, эсхүл сэргээх тухай нэхэмжлэлтэй холбоотой хэрэг” гэснийг “эсхүл сэргээх” гэж, 12.1.4 дэх заалтын “үрчлэлттэй холбоотой нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг” гэснийг “үрчлэлт” гэж, 12.1.5 дахь заалтын “дэмжихтэй холбоотой нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг” гэснийг “дэмжих” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “цуцлах” гэснийг “цуцлуулах” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “цахимаар оролцохгүй” гэснийг “оролцох үүргээ цахим хэлбэрээр хэрэгжүүлэхгүй”

гэж, 14.6 дахь хэсгийн “хариуцагчийн” гэснийг “түүний” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “эцгийн нэр” гэснийг “эцэг/эх-ийн нэр” гэж, “гэрээ байгаа эсэхийг” гэснийг “гэрээ байгуулсан эсэхийг” гэж, 16.3 дахь хэсгийн “шаардлагатайгаас тэтгэвэр” гэснийг “шаардлагатай тохиолдолд тэтгэлэг” гэж, “эд хөрөнгийн талаар гарсан” гэснийг “хөрөнгөтэй холбоотой” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “гэрээний биелэлттэй” гэснийг “гэрээтэй” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “тодорхойлолтыг” гэснийг “тодорхойлолт, баримт” гэж, 19.2 дахь хэсгийн “19.1.1-д” гэснийг “19.1.2-т” гэж, 19.3 дахь хэсгийн “19.1.1-д” гэснийг “19.1.1, 19.1.2-т” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 20.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь” гэснийг “Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь хүүхэд,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтын “шийдвэр гарсан” гэснийг “шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “иргэний хэрэг” гэснийг “гэр бүлийн хэрэг” гэж, 25.6 дахь хэсгийн “нэхэмжлэлийг үндэслэн” гэснийг “нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд” гэж, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “29.1-д” гэснийг “30.1-д” гэж, 34 дүгээр зүйлийн гарчгийн “Хүүхэд үрчлэлттэй холбоотой” гэснийг “Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах” гэж, 34.1 дэх хэсгийн “хэргийг” гэснийг “хүсэлтийг” гэж, 34.2 дахь хэсгийн “нэхэмжлэлийг” гэснийг “хүсэлтийг” гэж, 34.3 дахь хэсгийн “хүүхэд асран хүмүүжүүлэх” гэснийг “хүүхдийг асрамж, халамжийн” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “30 хоногоос илүүгүй хугацаанд” гэснийг “30 хоногийн дотор” гэж, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “дүнд” гэснийг “үр дүнд” гэж, мөн хэсгийн “эвлэрсэн” гэснийг “харилцан тохиролцсон” гэж, 39.5 дахь хэсгийн “хүсэлтээ дэмжиж байгаа бол” гэснийг “хүсэлттэй бол” гэж, 39.6 дахь хэсгийн “хүүхэдтэйгээ уулзах уулзалт” гэснийг “хүүхэдтэй уулзах хуваарь” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “тэдгээрийн аль нэгний асрамжид байгаа” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалтын “эд” гэснийг, 8 дугаар зүйлийн гарчгийн “/оршин байгаа/” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2 дахь заалтын “нэхэмжлэлтэй хэрэг” гэснийг, 12.4 дэх хэсгийн “энэ хуулийн 12.3-т заасан хэргийн материалтай” гэснийг, 14.3 дахь хэсгийн “энэ хуулийн 14.1, 14.2-т заасан” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “холбогдох этгээдээс” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “журмын” гэснийг, мөн хэсгийн болон 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “гэр бүлийн хэрэгт” гэснийг, 25.4.1 дэх заалтын “байнгын” гэснийг, 39.6 дахь хэсгийн “тусдаа амьдрах” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	25
Бүгд:	91

72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай “1.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэсэн 1 дэх заалт нэмэх:

“2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүртээмжтэй байх бөгөөд эрх ашгаа хамгаалахад шаардагдах хүртээмжийн зардлыг тухайн шатны байгууллага хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 29
Бүгд: 91
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.2 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “1.2” гэснийг “1.1” гэж, “тойргийн шүүх” гэснийг “шүүх, сум, сум дундын, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар” гэж, 15, 18 дахь хэсгийн “Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн” гэснийг “Эрүүгийн хэргийн танхим” гэж, 15 дахь хэсгийн “прокурор, оролцогчийн” гэснийг “прокурорын” гэж, 16 дахь хэсгийн “тойргийн шүүхийн” гэснийг “шүүх, хуульд заасан бол дүүргийн анхан шатны шүүхийн” гэж, “бусад нутаг дэвсгэр дэх” гэснийг “сум, сум дундын” гэж, 17 дахь хэсгийн “өсвөр насны яллагдагч, шүүгдэгчид” гэснийг “өсвөр насны хүнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн “өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч” гэснийг “өсвөр насны хүн” гэж агуулгад нь тохируулан тухай бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 29
Бүгд: 91
68.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу “14.15 дугаар зүйл” гэснийг “14.16 дугаар зүйл” гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь хэсэг болон 3 дахь хэсгийн “Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэж” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай “6.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэг” гэсэн 2 дахь заалт нэмэх:

“9.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, эрх бүхий албан тушаалтан гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн, хэргийн хохирогч, гэрч хүүхдийн мэдээллийг харьяа хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд даруй мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 27
Бүгд: 91
70.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай “18.12 дугаар зүйл” гэсэн 7 дахь заалт нэмэх:

“18.12 дугаар зүйл.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх журам

1.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд энэ хуулийн Арвандолдугаар бүлэгт заасан тусгай журмаас гадна энэ зүйлд заасан журмыг баримтална.

2.Өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн бол хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг мөрдөгч, эсхүл прокурорт гаргаж болно.

3.Өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлтийг прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө гаргана.

4.Өсвөр насны хүн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлтийг гаргахад энэ хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг хамаарахгүй.

5.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөс гадна хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.

6.Прокурор, мөрдөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан өсвөр насны хүн, хууль ёсны төлөөлөгчид Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 8.8 дугаар зүйл, 8.4 дүгээр зүйлд заасныг үндэслэн ял хөнгөрүүлж оногдуулах, ялаас чөлөөлөх, 8.6 дугаар зүйлд заасныг үндэслэн хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, 8.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай энэ зүйл болон энэ хуулийн Арвандолдугаар бүлэгт заасан журмаар хэрэг хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг танилцуулна.

7.Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн бол мөрдөгч 14 хоногийн дотор мөрдөн байцаалт явуулна. Хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагааг 14 хоногийн дотор дуусгах боломжгүй бол прокурор энэ хуулийн 31.13 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгана.

8.Прокурор хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчид энэ хуулийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, энэ хуулийн Наймдугаар бүлэгт заасан эрх, үүргийг танилцуулна.

9.Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь мөрдөн шалгах ажиллагааны явцад гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 8.8 дугаар зүйл, 8.4 дүгээр зүйлд заасныг үндэслэн ял хөнгөрүүлж оногдуулах, ялаас чөлөөлөх, 8.6 дугаар зүйлд заасныг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол

биелүүлэхийг хойшлуулах, 8.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд саад болохгүй.

10.Прокурор хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн материалтай даруй танилцаж, дараах нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг хянана:

10.1.гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсэх;

10.2.энэ хуулийн 18.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан нөхцөл байдал;

10.3.гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар тогтоогдсон эсэх.

11.Өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлтээсээ татгалзсан, хэргийн зүйлчлэл, хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар санал зөрсөн, эсхүл энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан нөхцөл байдал тогтоогдоогүй бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр прокурор тогтоол гаргана.

12.Прокурор өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хохирол нөхөн төлсөн, эсхүл хохирол нөхөн төлөхөө илэрхийлсэн байдал, түүний хувийн байдал, хохирогчийн гаргасан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх талаарх санал, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний талаар гаргасан саналыг харгалзан түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчид танилцуулж, зөвшөөрвөл гарын үсэг зуруулж, яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд даруй шилжүүлнэ.

13.Өсвөр насны хүн, түүний хууль ёсны төлөөлөгч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хүлээн зөвшөөрч нөхөн төлөхөө илэрхийлсэн бол шүүх уг хохирлыг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэнэ. Сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөр болон бусад тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчийн гаргасан иргэний нэхэмжлэлийг хэлэлцэхгүй орхиж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

14.Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл тогтоогдвол өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, прокурорын саналын хүрээнд өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай шийдвэр гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	29
Бүгд:	90

67.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 25.3 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Арван зургаан насанд хүрээгүй хүнээс тусгай өрөөнд ярилцлагын аргаар мэдүүлэг авна. Мэдүүлэг авах ажиллагааг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 29
Бүгд: 90
67.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 25.3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмэх:

“9.Арван зургаан насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг хоёроос илүүгүй удаа явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд шүүгч, прокурорын зөвшөөрлөөр тус бүр нэг удаа мэдүүлэг авч болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 35.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “дуу-дүрсний төхөөрөмж” гэсний өмнө “шүүгчийн захирамжаар” гэж нэмж, “Бага насны” гэснийг “Арван зургаан насанд хүрээгүй” гэж өөрчилж, 8 дахь заалт буюу 33.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.4.өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр үйлдсэн хэргүүдийг нь нэгтгэх үндэслэл илэрсэн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 32
Бүгд: 90
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “14.11 дүгээр зүйлийн” гэсний өмнөх “12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн,” гэж,” гэснийг, “25.2 дугаар зүйлийн” гэсний өмнөх “18.3 дугаар зүйлийн 1.5 дахь заалтын “төрвөл” гэсний дараа “энэ талаар болон тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараах сэтгэл санааны байдал, гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсныг тогтоох зорилгоор” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 34
Бүгд: 90
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дүгээр зүйлийн” гэсний өмнө “8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “мөрдөгч” гэсний дараа “шүүгч,” гэж,” гэж, “18.3 дугаар зүйлийн” гэсний өмнө “18.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ердийн журмаас гадна” гэсний дараа “Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам болон” гэж,” гэж, “35.15 дугаар зүйлийн” гэсний өмнө “28.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “... тус бүрд гарын үсэг зурна.” гэсний дараа “Арван зургаан насанд хүрээгүй хүн гарын үсэг зурахгүй байж болно.” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 18.2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2 дугаар зүйл.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага

1.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа түүний эрх, дээд ашиг сонирхлыг хангана.

2.Өсвөр насны хүнтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгоход анхаарч ажиллана.

3.Өсвөр насны хүний хувийн мэдээлэл, түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийн агуулгыг олон нийтэд мэдээлэхгүй.

4.Өсвөр насны хүний эрх, дээд ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг харгалзан ял шийтгэлийн талаарх лавлагаа, мэдээллийг хуульд тусгайлан заасан үндэслэл, журмаас гадуур задруулахгүй байх нөхцөлийг шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллага, хуулиар үүрэг хүлээсэн бусад этгээд хангаж ажиллана.

5.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг хангаж ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 31
Бүгд: 90
65.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай “18.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэсэн 3 дахь заалт нэмэх:

“5.Шүүх өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх явцад Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан Хүүхэд, гэр

бүлийн мэргэжилтнийг томилж, өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараах сэтгэлзүйн болон бусад нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээний талаар дүгнэлт гаргуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 33

Бүгд: 90

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гэрчээс” гэснийг “хүнээс” гэж, “хүүхдийн асуудал эрхэлсэн” гэснийг “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан” гэж, 4 дэх заалт буюу 25.5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “гэрч, хохирогчид” гэснийг “хүнд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай “37.5 дугаар зүйл” гэсэн 6 дахь заалт нэмэх:

“37.5 дугаар зүйл.Хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1.Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлд зааснаар өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлд зааснаар ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасан журмын дагуу хамтран хэрэгжүүлнэ.

2.Шүүх Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийн талаар улиралд нэг удаа хяналт тавьсан прокурорын газар, шийдвэр гаргасан шүүхэд тайлан хүргүүлнэ.

4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж прокурор үзвэл шүүхээс тогтоосон хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай дүгнэлтийг шүүхэд хүргүүлж болно.

5.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурор 14 хоногийн дотор эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай дүгнэлтийг шүүхэд хүргүүлнэ.

6.Шүүх прокурорын дүгнэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхийн хэлэлцүүлэг товлон явуулна. Шүүхийн хэлэлцүүлэгт өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, прокурор, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны төлөөлөл оролцоно.

7.Өсвөр насны хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн шийдвэр гаргана.

8.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

9.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

10.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

11.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг үйлдвэл шүүх Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	33
Бүгд:	91

63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “танхимын тэргүүн” гэснийг “танхим” гэж, 8.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу” гэснийг “өмгөөлөгчид” гэж, 15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч” гэснийг “шийдвэрийг гаргасан шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр” гэж, 18.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын “хэрэг үүсгэж яллагдагчаар татах” гэснийг “хэрэг үүсгэсэн талаарх” гэж, 2.3 дахь заалтын “яллагдагч” гэснийг “өсвөр насны хүн” гэж, 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ.” гэснийг “өмгөөлөгчид нь даруй мэдэгдэнэ.” гэж, 5 дахь хэсгийн “өсвөр насны сэжигтэн, цагдан хоригдсон өсвөр насны яллагдагчийг” гэснийг “болон хоригдсон өсвөр насны хүнийг” гэж, 18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “өмгөөлөгч, эсхүл” гэснийг “өмгөөлөгчөөс гадна” гэж, 2 дахь хэсгийн “гэмт хэргийн яллагдагчид” гэснийг “өсвөр насны хүнд” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “яллагдагч, өсвөр насны шүүгдэгч” гэснийг, 9.5 дугаар

зүйлийн 1.1 дэх заалтын сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэснийг, 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “яллагдагч, шүүгдэгч,” гэснийг, 14.11 дүгээр зүйлийн “яллагдагч” гэснийг, 18.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч” гэснийг, 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “сэжигтэн” гэснийг, 18.9 дүгээр зүйлийн гарчгийн “яллагдагч” гэснийг, 34.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “яллагдагч, өсвөр насны шүүгдэгч” гэснийг тус тус “хүн” гэж, 18 дугаар бүлгийн болон 18.1 дүгээр зүйлийн гарчгийн “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид” гэснийг, 18.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “яллагдагчид” гэснийг, 18.7 дугаар зүйлийн гарчгийн болон 1 дэх хэсгийн “яллагдагчид” гэснийг, 18.9 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “яллагдагчид” гэснийг, 18.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “шүүгдэгчид” гэснийг тус тус “хүнд” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн” гэснийг, 18.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн” гэснийг, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “яллагдагчийн” гэснийг, 18.3 дугаар зүйлийн гарчгийн болон мөн зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгийн “яллагдагч, шүүгдэгчийн” гэснийг, 18.4 дүгээр зүйлийн гарчгийн болон 2 дахь хэсгийн “яллагдагчийн” гэснийг, 18.5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “сэжигтэн, яллагдагчийн” гэснийг, 18.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “яллагдагчийн” гэснийг, 18.10 дугаар зүйлийн гарчгийн болон 1, 2, 3, 4, 5 дахь хэсгийн “шүүгдэгчийн” гэснийг, 34.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн” гэснийг тус тус “хүний” гэж, 18.5 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын “сэжигтэн, яллагдагчийг” гэснийг, 18.6 дугаар зүйлийн гарчгийн болон 2, 4 дэх хэсгийн “сэжигтэн, яллагдагчийг” гэснийг, 18.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “яллагдагчийг” гэснийг, 18.11 дүгээр зүйлийн гарчгийн “шүүгдэгчийг” гэснийг, 31.12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “сэжигтнийг” гэснийг тус тус “хүнийг” гэж, 18.5 дугаар зүйлийн 2.3 дахь заалтын “сэжигтэн, яллагдагчаас” гэснийг, 31.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “сэжигтнээс” гэснийг, 35.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “шүүгдэгчээс” гэснийг, 35.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гэрчээс” гэснийг тус тус “хүнээс” гэж, 14.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “1.3” гэснийг “1.3, 1.4-т” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 33
Бүгд: 91
63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “18.3 дугаар зүйлийн” гэсний дараах “5,” гэснийг хасаж, “тус тус хүчингүй” гэсний өмнө “18.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “1.5, 1.6-д” гэсний өмнөх “1.4, ” гэснийг, 18.5 дугаар зүйлийн 2.3 дахь заалтын “мөрдөгч, прокурорын зөвшөөрснөөр” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 37
Бүгд: 91
59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/6.12 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Өсвөр насны хүн зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялыг дараах байдлаар эдэлсэн бол прокурорын дүгнэлтийг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно:

1.1.таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны нэгээс доошгүй хувийг;

1.2.таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг;

1.3.арван хоёр жилээс дээш хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг эдэлсэн бол.”

2/8.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж хянан хүмүүжүүлэх хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.”

3/8.8 дугаар зүйл: “8.8 дугаар зүйл.Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

1.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан дараах байдлаар эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно:

1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй, эсхүл хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх;

1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй, эсхүл хорих ялын дээд хэмжээг найман жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол

хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах, эсхүл энэ хуулийн 8.7 дугаар зүйлд заасны дагуу хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах;

1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний хоёрны нэгээс хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах;

1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний гуравны хоёроос багагүй ял оногдуулах.

4/16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Энэ гэмт хэргийг хүүхдийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	46
Бүгд:	91

49.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Б.Б.Мөнхсоёлын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	46
Татгалзсан:	45
Бүгд:	91

50.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	39
Бүгд:	91

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “2 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний өмнө “саатуулагдсан,” гэж, 8.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ял дээр нэмж” гэсний дараа “энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 36
Бүгд: 91
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “3 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.6 дугаар зүйл:

“8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жил, дээд хэмжээг арван хоёр жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн, эсхүл түүнээс доош хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

2.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан бол энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна.

3.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага хамтран хэрэгжүүлэх талаар шүүхийн шийдвэрт тусгана.

4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй талаарх прокурорын дүгнэлтийг үндэслэн хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

5.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

6.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон

хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

7.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны хүн санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

8.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолыг хойшлуулсан хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.”

2/8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтаас гадна дараах үүрэг, хязгаарлалтыг хүлээлгэнэ:

2.1.өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвөлгөө, эмчилгээ авахыг даалгах;

2.2.нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд хамруулах;

2.3.хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах;

2.4.хохирогчоос уучлал хүсэхийг даалгах;

2.5.шөнийн цагаар гэртээ байхыг даалгах;

2.6.өсвөр насны хүнийг хүмүүжүүлэхэд шаардлагатай бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 33

Бүгд: 91

63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нараг дэмжсэнээр тооцож, 64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Баривчлагдсан” гэснийг “Баривчлагдсан, саатуулагдсан” гэж, 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүх” гэсний дараах “анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн,” гэснийг “хөнгөн гэмт хэрэг үйлдсэн” гэж, 8.7 дугаар зүйлийн гарчгийн “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” гэснийг “Ял оногдуулахгүйгээр тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “ял оногдуулахыг тэнсэж хүмүүжлийн нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно” гэснийг “ял оногдуулахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч болно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “хүүхэд, гэр бүлийн

хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой 35.6” гэж, 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хоёр жилээс найман жил” гэснийг “таван жилээс арван хоёр жил” гэж, дугаарыг “3” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 31
Бүгд: 91
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг “ӨӨРЧЛӨЛТ” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний дараа “нэг зуугаас” гэснийг “тавиас” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.8 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн “Арван зургаагаас арван найм хүртэлх насны хүний” гэснийг “Хүүхэд” гэж, “тойргийн шүүх” гэснийг “шүүх, сум, сум дундын, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар” гэж, 13 дахь хэсгийн “танхимын тэргүүн” гэснийг “танхим” гэж, 13 дахь хэсгийн “прокурор, оролцогчийн” гэснийг “прокурорын” гэж, 14 дэх хэсгийн “арван зургаагаас арван найм хүртэлх насны хүний” гэснийг “хүүхэд” гэж, мөн хэсгийн “тойргийн шүүхийн” гэснийг “шүүх, хуульд заасан бол дүүргийн шүүхийн” гэж, мөн хэсгийн “бусад нутаг дэвсгэр дэх” гэснийг “сум, сум дундын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн “15.7” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 31
Бүгд: 91
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэн 1 дүгээр зүйлийг “2 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 88¹ дүгээр зүйл нэмсүгэй:

“88¹ дүгээр зүйл.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн

88¹.1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэнд дараах шаардлага тавигдана:

88¹.1.1.25 насанд хүрсэн;
88¹.1.2.сэтгэл судлал, боловсрол, нийгмийн ажил, эсхүл социологийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй;

88¹.1.3.энэ хуулийн 88¹.1.2-т заасан мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 33
Бүгд: 91
63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/71 дүгээр зүйлийн 71.1.14 дэх заалт:

“71.1.14.шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах болон шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам, шүүхийн шаардлага хангасан байрны жагсаалтыг хуульд заасны дагуу батлах;”

2/88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг:

88.1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн Тамгын газрын ажилтан нь шүүхийн захиргааны ажилтан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 28
Бүгд: 91
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйлийн “135.2.2,” гэсний дараа “135.2.3,” гэж нэмэх:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 179.1.4 дэх заалт нэмсүгэй:

“179.1.4.шүүхийн санаачилгаар, эсхүл зайлшгүй оролцуулбал зохих этгээдийг гуравдагч этгээдээр оролцуулалгүйгээр гэр бүлийн хэргийг, эсхүл хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “тусдаа амьдрах эцэг, эсхүл эх нь хүүхэдтэйгээ уулзах уулзалт” гэснийг “эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь” гэж өөрчилж, төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаанд” гэснийг гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаанд” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны” гэснийг Гэр бүлийн тухай хуулийн 14.4-т зааснаас бусад гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаанд” гэж, 32 дугаар зүйлийн гарчгийн “Гэр бүлийн холбогдолтой маргааныг” гэснийг “Гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргааныг” гэж, мөн зүйлийн 32.1 дэх хэсгийн “гэр бүлийн холбогдолтой маргаанд” гэснийг “гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаанд” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 33
Бүгд: 91
63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 31
Бүгд: 91
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гэр бүлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/14¹ дүгээр зүйл:

“14¹ дүгээр зүйл.Хүүхдийн асрамж, хүүхдийн талаар шийдвэр гаргах болон эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь

14¹.1.Шүүх гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлтэй хамт болон гэрлэлт цуцлуулснаас хойш 14 насанд хүрсэн хүүхэд, эсхүл хүүхдийн эцэг, эсхүл эхийн аль нэгний гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр дараах асуудлыг шийдвэрлэнэ:

14¹.1.1.хүүхдийн асрамж;
14¹.1.2.эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь.

Тайлбар: Энэ хуулийн 14¹.1.1-д заасан “хүүхдийн асрамж” гэдэгт хүүхдийг хэний асрамжид үлдээх буюу амьдрах газрыг ойлгоно.

14¹.2.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн байдлаар талууд өөрөөр тохиролцоогүй бол шүүх энэ хуулийн 14¹.1.1-д заасан хүүхдийн асрамжийг авсан талд хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийг олгох бөгөөд тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй.

14¹.3.Шүүх энэ хуулийн 14¹.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина.

14¹.4.Шүүх хүүхдийн нөхцөл байдалтай дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ:

14¹.4.1.хүүхдийн бие махбод, оюун санаа, сэтгэлзүй, нас, хөгжлийн онцлогт нийцсэн хэрэгцээ;

14¹.4.2.хүүхдийн эцэг, эх, ах, эгч, дүү, эмээ, өвөө болон хүүхдийн амьдралд чухал нөлөө бүхий бусад хүнтэй тогтоосон харилцаа;

14¹.4.3.эцэг, эхийн хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэхэд оролцож байсан оролцооны байдал, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл бололцоо;

14¹.4.4.хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэх төлөвлөгөө, хүүхэдтэй харилцах чадвар, эцэг, эхийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, эрхэлсэн ажил, ажлын цаг;

14¹.4.5.ёс зүй, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдэд үзүүлэх нөлөө.

14¹.5.Энэ хуулийн 14¹.4.5-д заасан гэр бүлийн хүчирхийлэл болон түүний хүүхдэд үзүүлэх нөлөөг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан холбогдох үнэлгээний дүгнэлт болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайлангаар тодорхойлно.

14¹.6.Хүүхдийг эцэг, эсхүл эхтэй хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, шүүхээс томилсон бусад этгээдийн хяналтад, эсхүл хяналтгүйгээр уулзуулах хуваарийг шүүх тогтооно.

14¹.7.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл хүүхдийн асрамж, хүүхэдтэй уулзах хуваарь тогтоосон шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр хүүхдийн эцэг, эсхүл эх энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.”

Тайлбар: Энэ хуулийн 14¹.2-т заасан “хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрх” гэдэгт хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд гадаад улсад удаан хугацаагаар зорчих, шашин шүтэх, эс шүтэх, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйланд сургах зэрэг хүүхдийн хөгжил, хүүхдийн хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиран зарцуулах талаар шийдвэр гаргах эрхийг ойлгоно.

2/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2.Хүүхдийн асрамж, хүүхэдтэй уулзах хуваарь тогтоосон шийдвэрийг өөрчлөн шийдвэрлэсэн бол шүүх холбогдох шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор гэрлэлтийг бүртгэсэн улсын бүртгэлийн байгууллагад болон аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.”

3/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:

“27.3.Эцэг, эх байх эрх хязгаарласан тухай шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүх ажлын гурван өдрийн дотор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

4/29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг:

“29.3.Эцэг, эх байх эрх хязгаарласныг хүчингүй болсонд тооцох тухай шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүх ажлын гурван өдрийн дотор аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан

байгууллага болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

5/32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг:

“32.4.Эцэг, эх байх эрхийг сэргээх тухай шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүх ажлын гурван өдрийн дотор шүүх аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	30
Бүгд:	91

67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийн “гурван өдрийн дотор” гэсний дараа “аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад” гэж, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн “шүүх” гэсний дараа “аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон” гэж тус тус нэмсүгэй.”

“3 дугаар зүйл.Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.4.Гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон, эсхүл гэрлэгчид сүүлийн таваас доошгүй жилийн хугацаанд хамтран амьдраагүй бөгөөд бага насны хүүхэдгүй, гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, эсхүл эд хөрөнгийн маргаантай боловч 18-аас доош насны хүүхэдгүй гэрлэгчид гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн бол шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.

14.5.Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдийг хэн нэгний асрамжид үлдээх, хүүхэд эцэг, эхтэйгээ өнгөрүүлэх цаг, хүүхдийн талаар шийдвэр гаргах хуваарилалт, хүүхдийн тэтгэлэг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.

14.6.Гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол эдгээр асуудлыг шүүх шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	31
Бүгд:	91

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1 Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт:

“6.2.7.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж.”

2/201 дүгээр зүйлийн 201.5-201.10 дахь хэсэг:

“201.5.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэд өсвөр насны хүнд ерөнхий боловсрол олгох ерөнхий боловсролын сургууль, амьдрах ухааны дадал олгох мэргэжлийн сургалтын төв байна.

201.6.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ирсэн өсвөр насны хүнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

201.7.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэдэх ерөнхий боловсролын сургууль өсвөр насны хүнийг Боловсролын ерөнхий хуульд заасан суралцагчийн нийгмийн баталгаа, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан суралцагчийн эрхээр хангагдах боломжийг бүрдүүлнэ.

201.8.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дотоод журмыг Улсын ерөнхий прокурор, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

201.9.Өсвөр насны хүн дараах эрх зүйн баталгаагаар хангагдана:

201.9.1.сургалт, нийгэмшүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилго бүхий өөрсдийн хүсэл санаачилгаар дугуйлан, секц, клуб байгуулах, уралдаан, тэмцээн зохион байгуулах, оролцох;

201.9.2.байгууллагын захиргаанд ерөнхий боловсролын сургалтад шаардлагатай ном, сурах бичиг, сургалтын орчныг шаардах;

201.9.3.элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, шалгалт өгөх;

201.9.4.энэ хуульд заасны дагуу чөлөө авах.

201.10.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нийгмийн ажилтан шинээр ирсэн өсвөр насны хүнд байгууллагын дотоод журам, цагийн хуваарь, нийгэмшүүлэх хөтөлбөр, түүний үр дагавар, эрх, үүргийн талаар мэдээлэл өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3, 4, 5 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:

“18.4.Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой, эсхүл төлбөр төлөгчид тодорхой хугацааны туршид давтамжтай төлбөр төлөх болон бусад үүрэг хүлээлгэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхэд энэ хуулийн 18.1.4, 18.5-д заасан хугацаа хамаарахгүй бөгөөд үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацааны туршид албадан гүйцэтгэж болно.”

2/90 дүгээр зүйлийн 90.2 дахь хэсэг:

“90.2.Хүүхдийн тэтгэлгийг төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлого, мөнгөн болон бусад эд хөрөнгөөс гаргуулахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл болон татварт ногдох хэсгийг хассан үнийн дүнгээс тэргүүн ээлжид олгоно.”

3/201 дүгээр зүйлийн 201.3 дахь хэсэг:

“201.3.Өсвөр насны хүн арван найман насанд хүрсэн тохиолдолд ялыг нь сургалт-хүмүүжлийн байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл ялыг нь нээлттэй хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар өсвөр насны хүнийг арван найман насанд хүрэхээс 3 сарын өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.”

3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 201 дүгээр зүйлийн 201.1, 201.6 дахь хэсгийн “хоригдлын” гэснийг “хүний” гэж, 220.1 дэх хэсгийн “хоригдлыг” гэснийг “хүнийг” гэж, 201.6 дахь хэсгийн дугаарыг “201.4” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 236 дугаар зүйлийн 236.1 дэх хэсгийн “хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 201 дүгээр зүйлийн 201.4, 201.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 36
Бүгд: 91
60.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийг дэмжсэнээр тооцож, 61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван нэг.Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж, мөн төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтын “Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх” гэсний өмнө “Нийслэл дэх” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	33
Бүгд:	91

63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйл болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтын “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэж, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтын “Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн Багануур дүүргээс бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” гэж, мөн заалтын “анхан шатны тойргийн шүүх” гэснийг “анхан шатны шүүх” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	57
Татгалзсан:	34
Бүгд:	91

62.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван хоёр. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “бүлгийг” гэснийг “бүлэг болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1.11 дэх заалтыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	33
Бүгд:	91

63.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван гурав.Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 19 цаг 13 минутаас 19 цаг 40 минутад түр завсарлав.

Ес дэх асуудал буюу Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг хасах:

“6.1.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтад байгаа гэрч, хохирогч.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 38

Бүгд: 90

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн “туслалцааны” гэснийг “туслалцаа үзүүлэх” гэж, “мэдээ, мэдээлэл баримт” гэснийг “мэдээлэл, баримт бичиг” гэж тус тус өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.7.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага энэ хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлсэн хувийн өмгөөлөгчийн гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг Өмгөөлөгчдийн Холбоонд хагас жил тутамд хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, “Тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол” гэснийг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.3.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь энэ зүйлийн 20.1-д заасан үндэслэлээр өмгөөлөгч томилуулах тухай хүсэлтийг Өмгөөлөгчдийн холбоонд хүргүүлэх бөгөөд тус холбооноос өмгөөлөгчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр хувийн өмгөөлөгчийг ажиллуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлээс “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг,” гэснийг, “, 6.7” гэснийг, “10 дугаар зүйлийн 10.12 дахь хэсэг,” гэснийг, “14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90

58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “нийтэд тустай” гэсний өмнө “Өмгөөлөгчийн” гэж нэмж, 29.3 дахь хэсгийн “төрийн байгууллага,” гэснийг “төрийн байгууллагад өргөдөл, гомдол,” гэж өөрчилж, мөн зүйлийн зүйлийн гарчгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа”

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	53
Татгалзсан:	37
Бүгд:	90

58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.4.Өмгөөлөгч энэ хууль болон Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан журмын дагуу дараах хэлбэрээр хууль зүйн мэргэжлийн туслалцааг үзүүлнэ:

29.4.1.Хууль зүйн туслалцааны хуульд заасан хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн үйлчилгээний жишиг хөлсөөр;

29.4.2.сайн дурын үндсэн дээр үнэ төлбөргүйгээр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	51
Татгалзсан:	39
Бүгд:	90

56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.5.Өмгөөлөгчдийн Холбоо нь хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн энэ хуулийн 29.4-д заасан хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийг түүний мэргэшсэн эрх зүйн салбарыг харгалзан саналыг нь авч, зөвшилцсөний үндсэн дээр томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	36
Бүгд:	90

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.6.Энэ хуулийн 29.5-д заасны дагуу томилогдсон өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсгийг хасаж, 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.9.Өмгөөлөгчдийн Холбоо өмгөөлөгчдөөс нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх санал, санаачилгыг дэмжих, тэдгээрийг уялдуулан зохион байгуулах, уг үйл ажиллагаанд нийт өмгөөлөгчдийн оролцоог хангах үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 41
Бүгд: 90
54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 40
Бүгд: 90
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, 0-3 насны хүүхэдтэй эх, хөдөлмөрийн чадвараа

бүрэн алдсан хүн, арван найм хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч байгаа хүн, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтад байгаа өвчтэй хүнд оногдуулахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 40
Бүгд: 90
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл, эсхүл эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 5.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “биед халдсан нь” гэснийг “эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдэж халдсан нь” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 35
Бүгд: 90
61.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалтын 10.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн бол зөрчлийг арилгуулж, учруулсан

хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуульд заасны дагуу гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлөөгүй, эсхүл хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй гадаад ажилтныг зөвшөөрөлгүйгээр өөр байгууллагад шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлсэн, эсхүл хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авснаас өөр зорилго, байршилд ажил үүрэг гүйцэтгүүлсэн бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “үүргээ биелүүлээгүй” гэсний дараа “бол зөрчлийг арилгуулж” гэж нэмэх, “тавин” гэснийг “гурван зуун” гэж, “таван зуун” гэснийг “гурван мянган” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 39
Бүгд: 90
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “Зуучлагч нь” гэж, “нэг мянган” гэснийг “дөрвөн мянган” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 39
Бүгд: 90
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Тусгай зөвшөөрөлгүй этгээд Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ үзүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “ажилтны төлөөллийн байгууллагын” гэснийг “ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын” гэж өөрчилж, 10.16 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.ажилтныг үйлдвэрчний эвлэлийн гишүүнээр элссэн, үйл ажиллагаанд оролцсонтой нь холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг нь дордуулсан;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 1.5 дахь заалтын “хамтын хэлэлцээ хийх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын “Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас” гэснийг “ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан /хоёр ба түүнээс дээш/ гаргасан, эсхүл хөдөлмөр эрхлэлтийн харилцааг шууд цуцлахаар хөдөлмөрийн гэрээнд тусгайлан заасан ноцтой зөрчил гаргасан, эсхүл ажил олгогчийн мөнгө болон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах, эсхүл захиран зарцуулах эрх бүхий ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон, эсхүл ажилтан ажилд орох үедээ боловсрол, мэргэжил, мэргэшлийн

түвшнийг нотлох баримт бичгээ хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсоноос” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын 10.16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.Ажил олгогч ажилтантай хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хөдөлмөрийн гэрээг байгуулаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээ байгуулаагүй бол ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээс хуульд заасан хугацаанд хөдөлмөрийн гэрээг нөхөн байгуулаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Ажил олгогч ажилтанд хууль тогтоомжийн дагуу олговол зохих цалин хөлс, олговрыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй, эсхүл хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээгээр тогтоосноос доогуур хэмжээгээр олгосон, эсхүл ажилтны цалин хөлснөөс хуульд зааснаас бусад үндэслэлээр суутгал хийсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 41
Бүгд: 90
54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын “ажилд авахдаа болон” гэснийг хасаж, мөн зүйлийн 6.4 дэх заалтын “зөвшөөрөгдсөнөөс” гэснийг “зөвшөөрснөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 42
Бүгд: 90
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “хөдөлмөр эрхлүүлсэн” гэсний дараа “нь эрүүгийн

хариуцлага хүлээлгэхээргүй” гэж нэмж, 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын 10.16 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “өөрөө зөвшөөрөөгүй” гэсний дараа “бол” гэж, “Эмнэлэг хөдөлмөрийн” гэсний өмнө “эсхүл” гэж тус тус нэмж, “насанд хүрээгүй ажилтан,” гэснийг, 10.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 40
Бүгд: 90
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “дуусгавар болгосон,” гэсний дараа “эсхүл ажлын байрны шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан” гэж нэмж, “ажиллуулах үүргээ биелүүлээгүй” гэснийг “ажиллуулаагүй бол зохих орон тоо тутамд ногдох хуульд заасан төлбөрийг төлөөгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “бол хүнийг” гэсний өмнө “хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлд өөрчлөлт оруулахыг хориглосныг зөрчсөн” гэж нэмж, “цуцалсан” гэснийг “цуцлах зэргээр” гэж өөрчилж, 10.16 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.Ажил олгогч хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулсан, эсхүл өдрийн, долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаарыг зөрчиж ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.Ажил олгогч дараалсан хоёр ажлын өдөр хоорондын тасралтгүй амралтын хугацааг зөрчиж ажиллуулсан, эсхүл ажлын хоёр ээлжинд дараалуулан ажиллуулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.Ажил олгогч ажилтныг нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулах хязгаарлалтыг зөрчиж ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 40
Бүгд: 90
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг хасаж, 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.Ажил олгогч ажилд орох гэж байгаа хүн болон ажилтнаас мөнгө, эд зүйл, эсхүл боловсролын баримт бичиг, мэргэжлийн үнэмлэх, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний эх хувийг шаардан авч барьцаалсан бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь хэсэг нэмэх:

“17.Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд ялгаварлан гадуурхалтаас ангид байх, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг дотоод журамд тусгаагүй, эсхүл ажлын байрны дарамт, хүчирхийллийн талаарх гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах, утас, цахим шуудангийн хаягийг нийт ажилтанд харагдахуйц газар байршуулаагүй бол зөрчлийг арилгуулж, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18 дахь хэсэг нэмэх:

“18.Хамтын хэлэлцээ хийх явцад шашны байгууллага, улс төрийн нам, төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн хөндлөнгөөс оролцсон, нөлөөлсөн, аливаа хэлбэрээр саад учруулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	54
Татгалзсан:	36
Бүгд:	90

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	38
Бүгд:	90

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	52
Татгалзсан:	38
Бүгд:	90

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “6.8 дахь заалтын” гэсний дараа ““6.5 дугаар зүйлийн 1, 2, 5, 9, 10, 11, 16 дахь хэсэг,” гэсний дараа “6.6 дугаар зүйлийн 13,17, 18 дахь хэсэг,” гэж, мөн заалтын” гэж, “мөн зүйлийн 6.17 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.16 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.6 дугаар зүйлийн 15, 21, 25 дахь хэсэг,” гэж,” гэж, “мөн зүйлийн 6.55 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.53 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “10.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж,” гэж, ““6.26 дугаар зүйл,” гэсний дараа “7.18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж,” гэсний дараа “мөн хэсгийн “14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12” гэсний дараа “дугаар зүйл, 15.29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэж,” гэж, “тус тус” гэсний өмнө “, мөн хэсгийн “8.6, 8.7 дугаар зүйл,” гэсний дараа “10.16 дугаар зүйлийн 18 дахь хэсэг” гэж, мөн хэсгийн “14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг,” гэсний дараа “15.4,” гэж, мөн хэсгийн “15.33 дугаар зүйл” гэсний өмнө “дугаар зүйл, 15.29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, мөн хэсгийн “18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь” гэсний дараа “хэсэг,

17.2 дугаар зүйлийн 3, 4 дэх” гэж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн ““15.29 дүгээр зүйл,”” гэснийг ““15.29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг”” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлээс ““15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараа “15.4,” гэж, мөн заалтын” гэснийг, “мөн заалтын “15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараа “15.4,” гэж,” гэснийг, “мөн зүйлийн 6.57 дахь заалтын “6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12” гэсний дараа “, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30” гэж,” гэснийг, “7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “мэдээлэх” гэсний ард “, тээврийн хэрэгслийг саатуулах, тусгай талбайд хүргэх” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “6.7 дахь заалтын” гэсний дараа ““5.13 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6,” гэснийг “5.13,” гэж, мөн заалтын” гэж, “мөн зүйлийн 6.8 дахь заалтын” гэсний дараа ““5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь,” гэснийг “5.13 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэж, мөн заалтын” гэж, “мөн зүйлийн 6.14 дэх заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.11 дэх заалтын “6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.2 дахь заалт” гэснийг “6.6 дугаар зүйлийн 4, 14 дэх хэсэг,” гэж” гэж, “мөн зүйлийн 6.14 дэх заалтын” гэсний дараа ““6.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг” гэснийг “6.6 дугаар зүйлийн 15, 16 дахь хэсэг,” гэж,” гэж, “мөн зүйлийн 6.53 дахь заалтын” гэсний өмнө “мөн заалтын “10.16” гэснийг “10.16 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 6.2, 6.3, 6.4 дэх заалт, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17 дахь хэсэг” гэж, мөн заалтын 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт” гэж,” гэж, “6.53 дахь заалтын” гэсний

дараа “10.15,” гэснийг “10.15 дугаар зүйл, 10.16 дугаар зүйлийн 6.1 дэх заалт,” гэж, мөн зүйлийн 6.57 дахь заалтын “эм, био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын байцаагч” гэж, мөн заалтын “6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12” гэснийг “6.6” гэж, “2.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 7 дахь хэсгийн “5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг” гэснийг “5.4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг” гэж, мөн хэсгийн “6.26 дугаар зүйл” гэснийг “6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг” гэж, гэж, “тус тус” гэсний өмнө “, 9.1 дүгээр зүйлийн “5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг” гэснийг “5.4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг,” гэж, “6.26 дугаар зүйл” гэснийг “6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг” гэж, “17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг,” гэснийг “17.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэг,” гэж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл,” гэснийг “7.6 дугаар зүйлийн 1, 4, 5, 8 дахь хэсэг, 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 5, 7, 8 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дэх хэсгийн 4.2, 4.3 дахь заалт, 7.11 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 7.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, “10.15 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэснийг “10.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлээс “мөн зүйлийн 6.48 дахь заалтын “7.8,” гэснийг “7.8 дугаар зүйл, 7.18 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 4.3 дахь заалт,” гэж,” гэснийг, “10.15,” гэснийг “10.15 дугаар зүйлийн 1, 2, 4, 5 дахь хэсэг,” гэснийг, “2.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх,” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх; гэж, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд” гэж, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.” гэж, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлнэ” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд даруй бүртгэнэ.” гэж, 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлж,” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд даруй бүртгэж,” гэж” гэснийг, “6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “6.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт” гэж, 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “3.8 дугаар зүйлийн” гэснийг “3.10 дугаар зүйлийн” гэж, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “7.6 дугаар зүйлийн” гэснийг “7.7 дугаар зүйлийн” гэж,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “мөн зүйлийн 6.27 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.13 дахь заалтын “16.3,” гэснийг,” гэж, “6.60 дахь заалтын “10.14, 10.29” гэснийг,” гэсний дараа “мөн зүйлийн 7 дахь хэсгийн “5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэснийг” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 55 дугаар зүйлийн гарчгийн “сургалт зохион байгуулах” гэснийг “сургалтын зорилго, агуулга, зохион байгуулах хугацаа” гэж өөрчилж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийг 55.4 дэх хэсэг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 55.1, 55.2 дахь хэсэг болгох:

“55.1.Хуульчийн сургалтын зорилго нь хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуульч нь мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бусаар ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

55.2.Хуульчийн сургалтын хөтөлбөр нь энэ хуулийн 55.1-д заасан зорилгод чиглэсэн, хуульчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тодорхой үе шат, дараалалтай, уялдаа холбоотой боловсруулсан агуулгатай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 37

Бүгд: 90

58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 55 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 55.3 дахь хэсэг нэмэх:

“55.3.Хуульчийн сургалтын хөтөлбөр нь хууль зүйн шинжлэх ухаан, бусад шинжлэх ухааны холбогдох сэдвийг агуулсан байх бөгөөд уг хөтөлбөрт дараах сэдвийг заавал тусгасан байна:

55.3.1.Монгол Улсын Үндсэн хууль;

55.3.2.Монгол Улсын олон гэрээ;

55.3.3.хүний эрх;

55.3.4.хуульчийн ёс зүй;

55.3.5.хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэл.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 38

Бүгд: 90

57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 39

Бүгд: 90

56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5 дугаар зүйлийн 5.1.18 заалтын “дээдэлсэн байх” гэснийг “дээдлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.2.18 заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.18.“хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэхэд чиглэсэн байхыг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6 дугаар зүйлийн 6.5.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 39
Бүгд: 90
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 44
Бүгд: 90
51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 39
Бүгд: 90
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар эшлэлийг нийцүүлж, өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зарим хуулийн төслийг буцаасантай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12-т “Байнгын хороо энэ хуулийн 39.25-д заасан үндэслэлээр хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.” гэж заасны дагуу баталсанд тооцов./20.51/

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Арав дахь асуудал буюу “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн

байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Н.Алтаншагай, Б.Бейсен, М.Ганхүлэг, А.Ундраа, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Гатлага,” гэсний дараах “Говь,” гэснийг, “Толгой,” гэсний дараах “Тохой,” гэснийг, “Хад,” гэсний дараах “Харгайт,” гэснийг, “Цав,” гэсний дараах “Чулуу” гэсэн дэвсгэр нэрийг хасаж, эдгээрт хамаарах газар зүйн нэрийг “Салаа”, “Бөөрөг”, “Хаалга”, “Хөтөл”, “Уул”, “Товог”, “Бэлчир”, “Даваа”, “Тал” хэсэгт тус тус харгалзуулж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “Уул” хэсгийн “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Сагсай” гэснийг “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Алтай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 39
Бүгд: 90
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтын “Ам” гэсний дараа “Ар”, гэж, “Шанд” гэсний дараа “Ширээ,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 38
Бүгд: 90
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3. Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Энэ тогтоолоор баталсан газар зүйн нэрийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх;

2/Монгол Улсын Их Хурлаас баталсан газар зүйн нэрийг батлагдсан стандартад нийцүүлэн латин үсэгт галиглан хэрэглэх, газар зүйн нэрийг судлах, сурталчлах, хамгаалах, мөрдүүлэх, газар зүйн нэрийн цахим системээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3/Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотголыг хийж, сумдын хилийн цэсийг албан ёсны газар зүйн нэрийн дагуу шинэчлэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж 2027 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 39
Бүгд: 90
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан 4 дэх заалт нэмэх:

“4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/-д даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 36
Бүгд: 90
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, латин хөрвүүлгэд холбогдох хууль зүйн техникийн засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 37
Бүгд: 90
58.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг дэх асуудал буюу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, судлаач Ч.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Ганхуяг, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл, Ц.Мөнхтуяа, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./22:02/

Уг асуудлын 22 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Т.Цэрэнбадрал, мөн хорооны Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын

байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, А.Ариунзаяа, С.Эрдэнэбат, П.Ганзориг, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./22:56/

Арван гурав.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./23:10/

Арван дөрөв.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Ш.Үнэнтөгс, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Э.Дарханцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./23:13/

Арван тав.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Д.Мөнгөнтуул, мөн газрын Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч М.Цогтбаатар, мөн яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч Ж.Азжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, мөн газрын Иргэний бүртгэлийн газрын дарга Н.Наранцэцэг, мөн газрын улсын ахлах бүртгэгч Б.Отгон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Э.Баярбаясгалан, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын харьяат хариуцсан ахлах мэргэжилтэн С.Солонго, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн, Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны гишүүн Д.Ундраа, Гэр бүлийн бодлого судлаач З.Түвшинжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./23:20/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 15 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн урилгаар Хэнтий аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид, Дорнод аймгийн Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Баянхонгор аймгийн Байдраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Хөдөө аж ахуйн техникумын 1986 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Цемент шохой компанийн аж ахуйн хэлтсийн ажилтнууд, Ховд аймгийн Алтай, Булган, Дарви сумдын Ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Өвөрхангай аймгийн Баянгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон Ашигт малтмалын баяжуулалтын технологийн ангийг төгсөж буй оюутнууд, Хөвсгөл аймгийн Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Увс аймгийн Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид, Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаярын урилгаар Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн албан хаагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 11 цаг 46 минут үргэлжилж, 126 гишүүнээс 93 гишүүн хүрэлцэн ирж, 73.8 хувийн ирцтэйгээр 23 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БЯМБАДУЛАМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлынхаа гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирвэл зохих 126 гэснээс 64 гишүүн буюу 50.8 хувийн ирцтэй чуулганы ирц бүрдсэн тул 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн Пүрэв гаргийн чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Гишүүд харж байгаа байх тэр дэлгэц дээр чуулганы нэгдсэн хуралдаанд ирсэн гишүүдийг яг ирсэн цагийнх нь дарааллаар цаг минутаар нь гаргадаг болсон байгаа. Цааш цаашдаа яг санал хураалт яг ийм байдлаар гардаг болно оо. Ийм байдлаар чуулганы хуралдаанд хэн, хэдэн цагт ирсэн, хэн ирээгүй байгаа, өвчтэй, чөлөөтэй, гадаад, дотоод томилолттой байгаа, мөн санал хураалтад оролцсон, оролцоогүй, ирцдээ орчоод, санал хураалтад оролцсон, оролцоогүй гэх мэт мэдээллүүд иймэрхүү байдлаар олон нийтэд нээлттэй, ил тод, гишүүдэд бас нээлттэй ил тод ийм байдлаар гардаг болж байгаа шүү гэдгийг гишүүддээ хэлье ээ.

Энэ 7 хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай мэдээллийг гишүүддээ хүргэе.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Энхтүвшин, Тэмүүжин, Баасанжаргал нарын гишүүнд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төслийг хийж байгаа. Анхны хэлэлцүүлэг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан хуралдаж байх явцад АН-ын бүлэг ажлын нэг өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байгаа. Завсарлагын хугацаа дууссан тул эдгээр хуулиудыг энэ 7 хоногт хуваарьт орсон Улсын Их Хурал өөрийнхөө үйл ажиллагааг зохицуулсан хуулиа батлах талаар жаахан анхааралтай ажиллаад Ардчилсан 2 намын бүлэг ойлголцоод өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад анхны хэлэлцүүлгээ хийчихвэл маргааш нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх боломжтой болно оо.

Дараагийн асуудал Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг Засгийн газар 2025 оны 1 сарын 8-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг хийж байгаа. Мөн Эдийн засгийн байнгын

хорооны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг ажлын 5 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацааг өмнө нь дуусгаад хуралдаад явах боломж байж байгаа. Хэрэв өмнө нь дуусгах юм бол Эдийн засгийн байнгын хороо өнөөдөр хуралдаад энийгээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх боломж бий болно оо.

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 3 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал хэлэлцэгдэж байгаа. Эдийн засгийн байнгын хорооны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурал дахь Ардын намын бүлэг ажлын 5 өдрийн завсарлага авсан. Нам эвслийн бүлэг завсарлагаа хугацаанаас нь өмнө дуусгаж болох боломжтой ийм хуулийн заалттай. Үүний дагуу хэрвээ наана нь дуусгавал Эдийн засгийн байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг өнөөдөр хийгээд явчих ийм боломж байгаа. Тийм болохоор энэ 7 хоногт хэлэлцсэн асуудлуудаа хэлэлцээд дуусгачихвал хэрэгтэй байгаа. Энэ үүднээс Улсын Их Хурал дахь Ардын намын бүлэг, АН-ын бүлгийн дарга нарыг энэ боломжоо бүрдүүлээд асуудлаа шуурхай хэлэлцүүлэх тал дээр нэг хоорондоо уулзаад тодорхой ойлголцолд хүрэхийг хүсэж байна аа.

Өнөөдрийн хуралдааны ирцэд бүртгүүлсэн эхний 5 гишүүдийг танилцуулъя. Сая дэлгэцэд гарсан. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Лутаагийн Энхнасан, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Сүхбаатарын Эрдэнэболд, Хассуурийн Ганхуяг нарын гишүүд өглөө хамгийн эртэч гишүүдээр тодорчихсон байна. Баяр хүргэе. Чуулганы хуралдаандаа эрт ирсэн гишүүддээ.

Зочин танилцуулъя.

Дорнод аймгийн Хэрлэн сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Төгсөлтийнхөө 40 жилийн ойг хийж байгаа нийт төгсөгчиддөө Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. Төгсөлтийн 40 жилийн ойгоо сайхан тэмдэглээрэй.

Хэлэлцэх асуудалдаа орёе оо.

1.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

3.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна

4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна

5.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг.

6.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

7.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг.

8.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг.

9.Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

10.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг. Энэ газар зүйн байршил, нэрийн жагсаалт батлах тухай тогтоол байгаа.

11.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг, Засгийн газар өргөн мэдүүлсэн.

12.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх, Засгийн газар өргөн мэдүүлсэн, 2026 оны 3 сарын 18-ны өдөр.

13.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг, Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 8 гишүүн өргөн мэдүүлсэн 6 дугаар сарын 4-ний өдөр.

14.Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Одонтуяа нарын гишүүд өргөн мэдүүлсэн.

15. Бусад асуудлын хүрээнд Гэр бүлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

2.Орон сууцны санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд,

3.Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд,

4.Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсан.

Та бүхэнд мэдээллийг хүргэж байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхсоёл: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын энэ 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбар хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар.

С.Бямбацогт: Мөнхсоёл гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүрэг орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн дарга, Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллээ үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно оо.

Хэрвээ эдгээрийг зөрчих юм бол Улсын Их Хурлын тухай хууль болон Төрийн албаны тухай хууль бусад хуульд заасны дагуу хуулийн хариуцлага хүлээдэг болохыг сануулъя. Тэгээд та бүхнийг Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж, үнэн зөв, бодитой мэдээлэл өгч, асуултад тодорхой гүйцэд хариулахыг хүсье ээ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороонд танилцуулахтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Өглөөний мэнд хүргэе. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулаад нэг хэдэн зарчмын зүйлийг асуумаар байна. Нэгдүгээрт нь болохлоор энэ мөнгө угаах гэмт хэрэг гэж байгаа. Ер нь бол бид нар мэдэж байгаа. Эдийн засгийн харилцааг эрүүлжүүлсэн, эрүүлжүүлэх тэр гол үндэслэл шалтгаан нь татвартай холбогдон гарч ирдэг. Татвар төлөхөөс зайлсхийх, нуун дарагдуулах, дээрээс нь ингээд мөнгө угаах гэсэн асуудлууд орж ирж байгаа юм л даа. Тэгэхээр энэ харилцааг яг олон улсын жишигт нийцсэн түвшинд энэ зохицуулалт орж ирж чадаж байна уу гэдэг асуулт 1 дүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь эдийн засгийн харилцааг маш их эрүүлжүүлдэг, улс төржүүлдэг, одоо ингээд сонгууль болдог улс төрийн өрсөлдөгчөө намнах зорилгоор

аль нэгэн бизнесменүүдийн бизнесүүдийг, дансыг нь хаадаг царцаадаг тэгээд олон нийтэд төрийн албан ёсны институт, хууль хүчний байгууллагуудаар дамжуулж хэвлэлийн хурал мэдэгдэл гаргадаг. Тэрнээс тийшээгээ тэдэн төгрөг шилжсэн, мөнгө угаасан, татвараас зайлсхийсэн гэсэн асуудлууд гарч ирдэг. Энд яагаад энийг асууж байгаа юм бэ гэхээр ер нь бид нар энэ улс төржилт улс төрчид нь тодорхой нөлөөллийг бий болгох тодорхой шалтгаант холбоог нийгэмд үүсгээд ямар нэгэн хар пи ар тархи угаах иргэдийн санаа бодлыг өөрчлөх ийм хандлагыг гаргаад ингэхдээ төрийн институтүүдийг байгууллагуудыг ашигладаг.

Ингэхдээ татварын байгууллагыг ашигладаг. Одоо бид нар сайн мэдэж байгаа. Олон олон жишээнүүдийг ярьж болно оо. Тэгэхээр энэ одоо улс төрийн зорилготой, зохиомол халдлагаас хамгаалахад яг энэ хууль ямар дархлаатай байж чадаж байгаа вэ? Энэ төрлийн зохицуулалтуудыг нь юу гэж харж байгаа вэ гэсэн асуултыг эхлээд асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя аа.

Нэгдүгээрт Засгийн газраас бол НӨАТ-ын босгыг 50 саяыг 400 сая болгох ийм хуулийн төсөл өргөн барьсан. Ажлын хэсэг дээр энийг буцаагаад 50 сая болгох зарчмын зөрүүтэй санал гаргаж 50 саяар оруулж байгаа. Ерөөсөө үндсэн шалтгаан нь юу вэ гэхээр яалт ч үгүй нөгөө татвараас зайлсхийх нуун дарагдуулах ийм боломж нь 50 саяыг 400 сая болгосноор бий болох юм байна гэж үзсэн. Яагаад вэ гэж үзэхээр ганцхан жишээ хэлэхэд одоо энэ чөлөөт бүсүүдээс архи, тамхи, онцгой татвартай бүтээгдэхүүнүүдийг баяр болгоны өмнө зохион байгуулалтаар улс орон даяар зардаг. Тэгээд тэрийгээ дандаа хувь хүмүүсийн дансаар орлогыг нь авдаг. Энэ эргээгээд бид нар зөвхөн НӨАТ ч биш онцгой албан татвар нөгөө бүтээгдэхүүнд тавигдах хяналт шалгалт гээд олон асуудлуудыг энэ НӨАТ өөрөө бүртгэлийн систем болохоор энэ бүртгэлийн систем алдагдах юм байна аа. Татварын тогтолцоо сөрөг үр дагавар авчрах юм байна гэж үзээд бид нар 50 саяыг, 400 сая болгох хуулийн төсөл дэмжээгүйгээр буцаагаад 50 сая болгохоор зарчмын зөрүүтэй санал гаргаад ажлын хэсгээс ингэж оруулж ирж байгаа юм. Нэг ёсондоо НӨАТ өөрөө бүртгэл, хяналтын тогтолцоо юм байгаа юм.

Хоёрдугаарт таны ярьж байгаа асуудал дээр өнгөрсөн 2024, 2023 онд бол ингээд данс хаах асуудал их тавигддаг байсан. Данс хаах асуудал. Одоо хамгийн бодит жишээ Монполимет гээд компанийг сонгуулийн үеэр дансыг нь хааж байсан. Одоо энэ шинэ хуулиар данс хаахыг нь хориглож байгаа. Зүгээр орж ирсэн мөнгөнөөс тодорхой хэмжээг нь татвар авдаг, нөгөө компанид нь үйл ажиллагаа явуулах боломж бүхий мөнгийг нь дансан дээр нь үлдээдэг болгож байгаа. Ийм 2 өөрчлөлт орж байгаа. 70, 30-аар.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэгийн урилгаар Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2 дугаар сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд ажлын өндөр амжилт, амьдралд нь эрүүл энх сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Манай Ганхүлэг гишүүн Отгонбаяр гишүүд тэнд ирчихсэн байна аа. Идэрбат гишүүн маань энд зогсож байна шүү харж байгаа байх тийм ээ. Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Сая энэ өргөн баригдаад хэлэлцэх эсэх нь шийдэгдээд байгаа Бизнесийн эрх чөлөөний хууль байгаа шүү дээ. Энэ Бизнесийн эрх чөлөөний хуулийн концепц яг энэ татварт оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт 2 яг уялдаж чадаж байгаа юу. Дахиад танаас би яг тодруулаад дахиад асуучихъя. Ер нь энэ татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ бизнесийн эрх чөлөөний хууль гэдгийн яг тэр эдийн засгийг эрүүгүйжүүлэх гэдэг зүйл яаж зохицуулагдах вэ? Ер нь цаашдаа энийг бид нар зохицуулах шаардлагатай байгаад байгаа шүү дээ. Эдийн засгийг эрүүлжүүлээд санкцтай болгоод шударгаар бизнес хийх гээд зээл авдаг өөрийнхөө мөнгийг эрсдэлд эргэлтэд оруулдаг явж байгаад шоронгийн яллагдагч ялтан болчихоод байгаа юм.

Тэгэхээр Монгол Улс бизнес хийх иргэдийн идэвхжил олон улсын дунджаас өндөр мөртөө бизнест халгаатай байгаа татвар болон бусад зүйлсээр дарамталж байгаа хүнд суртал гаргаж байгаа авлига хээл хахууль нүх сүв ихтэй байгаа учраас энэ нь өөрөө эргээд трансперенси интернэйшналын дохио.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Манайх дээрээс нь танд хэлэхээ мартсан байна. ОЕСТ-ийн нөгөө хил хязгааргүй татварын алба гэдэг конвенцод нэгдэж орсноор тэгээд компани бүрээр хил дамнасан олон улсын компаниудын Монголд үйл ажиллагаа явуулж байгаа байдлаар нь бид нар тайлангаа солилцох боломж бүрдэж байгаа. Тэр нь 2028 оноос хэрэгжиж эхэлнэ. Тэгэхээр Монгол Улс мөнгө угаах байдаг юм уу эсвэл татвараа шилжүүлэх байдаг юм уу? Тэр боломжууд дээр бид нар хяналт тавих боломж бүрдэж байгаа .

Хоёрдугаарт бизнесийн эрх чөлөөний бид нар бол үндсэндээ л ер нь энэ татварын хөнгөлөлтүүд рүү энэ төрөө жижигхэн болгох, төсвөө жижигхэн болгох, төр аль болох бага оролцох энэ үйл ажиллагаануудыг бид нар хуулиараа хийж өгөх ёстой юм. Тэр нь одоо яалт ч үгүй бид нар энэ татварын хуулиудаар орж ирж байгаа. Татварын хөнгөлөлт, нөгөө талдаа бизнесийн эрх чөлөөний хуулийг дагаж орж байгаа тэр зөвшөөрлийн хуулиудаар аль болох зөвшөөрлийн тоог багасгах төрийн оролцоог багасгах энэ зохицуулалтууд нь эргээгээд тэр төрийн оролцоо багасагдсанаар бид нар энэ бизнес эрх чөлөөг илүүтэй олгоно гэсэн үг.

Гуравдугаарт ер нь хамгийн том асуудал.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ Татварын ерөнхий хууль нь хуулийн төсөл ААН-үүдэд хэрэгтэй нэг заалт орсон байгаа. Татвар төлөх үүрэг бол Үндсэн хуулиараа заавал үл маргах журмаар төлөх ийм үүрэгтэй байгаа. Тэгэхдээ аж ахуй бизнесийн үйл ажиллагаанаас шалтгаалаад татварын өрүүд үүсдэг. Энэ өртэй холбоотойгоор татварын байгууллага бол үл маргах журмаар энэ татварын өрийг барагдуулах арга хэмжээнүүд авдаг байсныг бизнесийн үйл ажиллагааны тасалдлыг багасгах үүднээс энэ орлогыг нь орж ирсэн орлогыг нь дансанд орж ирсэн орлогыг нь татварын өрөнд суутгаж авдаг байсан хэмжээгээ багасгаж байгаа юм.

Тэгэхээр ААН-үүдэд татварын орлогынхоо 30 хувийг үйл ажиллагаандаа зарцуулах ийм бололцоо боломжуудыг олгож байгаа. Тэгэхээр ААН-үүд бас энэ зүйл заалтуудыг мэдээсэй гэдэг үүднээс энэ үгийг хэлж байгаа юм. Тэгээд энэ Татварын ерөнхий хуулийн хэрэгжих заалтууд бол энэ саяын 63.2 дахь заалтаас

бусад заалтууд нь 2027 оны 1 сарын 1-ээс хэрэгжих юм. Тэгэхээр энэ саяын хэлсэн таагдсан данснаас үл маргах журмаар гаргах хэмжээ нь 70 хувиас хэтрэхгүй байхаар энэ хуулийн заалт бол батлагдсан өдрөөсөө хэрэгжих юм. Тэгэхээр энэ Татварын ерөнхий хууль батлагдахаар ААН-үүдийн хувьд бол ийм бололцоо боломжууд нээгдэж байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ эрх нь зөрчигдөх ч юм уу асуудал үүсвэл татварын байгууллагууд ч гэсэн энэ хэрэгжилт дээрээ ААН-үүддээ ойлголт өгөөд энэ бололцоо боломжуудыг нь хангаж өгөөсэй гэж хэлмээр байна. Тэгээд асуулт байхгүй үг хэллээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Үг хэлчихлээ асуулт асуусангүй.

Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Татварын багц хууль эцсийн хэлэлцүүлгийн шатад явж байна орж ирлээ. Эцсийн хэлэлцүүлэг гэдэг маань бид ямар ч зарчмын зөрүүтэй санал гаргах боломжгүй. Дараагийн удаа бол бид нар 64 гишүүнээрээ батлах нь ээ. Ингээд батлах явцаасаа өмнө олон нийт болон Улсын Их Хурлын гишүүдэд эцсийн байдлаар энэ багц хуулиуд үр дүн нь юу байгаа вэ гэдгийг товч тодорхой хариулж өгөхийг Ганхуяг ажлын хэсгийн ахлагчаас хүсэж байна аа.

Нэгдүгээрт, багц хууль хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ? Яг хугацаа нь тэдэн сарын тэднээс хэрэгжиж эхэлнэ ээ. Данс хаахтай холбоотой данс хаахаа больчих л больсон гэж та хэлж байх шиг байна. Үгүй данс хаана. Гэхдээ 30 хувийн үлдэгдлийг чинь үлдээгээд 70 хувийг нь царцаана. Та өр төлбөрөө барагдуулах тэр боломжийг чинь нээлттэй үлдээгээд тэгээд эргээд 70 хувийг чинь эргүүлээд нээнэ гэдэг ч юм уу яг энийгээ тодорхой хэлж өгөөч ээ. НӨАТ төлөгч 400 биш 50 сая болж үлдсэн хэвээрээ байгаа юм байна аа. Хувь хүний энэ НӨАТ, хувь хүний татвар дээр орон сууц борлуулалтын 2 хувийн татварыг цуцалж байгаа гэсэн ийм мэдээллийг өгөөд байх шиг байна лээ. Энийгээ яг тодорхой анхны орон сууц бөгөөд 5-аас доошгүй жил амьдарсан ийм орон сууцын энэ татварыг хүн чөлөөлж байгаа гэдгийг яг тодорхой хэлж өгмөөр байна аа. Тэрнээс биш нийтлэг бүх хүнд үйлчилнэ, нийтлэг бүх ААН-үүдэд үйлчилнэ гэдгийг биш юм шүү гэдгийг залруулж хэлээсэй гэж хүсэж байна аа. Мөн түүнчлэн шаталсан татвартай холбоотой яг хэдээс хэдэн төгрөгийн хооронд хэдэн хувийн татвар тавигдаж байгаа вэ? Энийгээ яг шаталсан байдлаар нь тайлбарлаж эцсийн энэ мэдээллийг өгөхийг хүсэж байна аа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Энэ удаагийн Татварын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар 2027, 2028 онд эдийн засгийн өсөлт 0.7 функтээр нэмэгдэхээр энэ тооцоолол гарч ирж байгаа. 0.7 хувиар. Өрхийн орлого 3 хувиар нэмэгдэх боломж бүрдэж байгаа. Энэ удаагийн татварын багц хуулиар Хувь хүний орлогын албан татварыг 2 шатлал нэмэгдсэн байгаа.

Нэгдүгээр шатлал бол 0-792 мянган төгрөгийн орлого дээрээ 0 хувийн татвар. Энэ бол 2027 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлнэ ээ. 792-оос 2 сая төгрөгийн орлого дээрээ нэг хувийн татвар төлнө өө. Энэ бол одоо 2028 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлнэ ээ. Энэ болохоор 2 сая төгрөгийн орлоготой иргэн дээр л үйлчилнэ гэж зарим иргэд ташаа ойлгоод байна лээ. Энэ бол ерөөсөө бүх иргэний гар дээр ирж байгаа цалин. Нэг хувийн татвараараа гар дээрх цалин нэмэгдэнэ л гэсэн үг. 2 сая төгрөгийн орлого дээр нэг хувь тэрнээс дээших нь 10 хувь гэсэн үг.

ААНОАТ дээр 15 хувийн шатлал орж ирж байгаа. Энэ одоо уул уурхайн бус компаниудын орлогыг нь хамгаалах зорилгоор шууд 10-аас 25 хувь руу өсдөг байсан тэр шатлалын дундуур нь 15 хувийн шатлал орж ирж байгаа гэсэн үг. Тэгэхээр уул уурхайн бус компаниудын бид нар үйл ажиллагааг нь тодорхой хэмжээгээр дэмжиж өгч байна гэсэн үг. Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 22.9 дээр бид нар Азийн наадмын спортын төрлийг нэг хувийн татварын хөнгөлөлт эдлэх боломжийг нь олгож байгаа. Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль дээр бид нар НӨАТ төлөх хугацааг нь хойшлуулж байгаа. Нэг ёсондоо НӨАТ-ын тайлан гарлаа. Шууд татварын өртэй болдог байсан бол ингээд 2 сарын дотор тухайн компанийн үйл ажиллагаанаас нь хамаараад үнэлгээ хийгдэнэ. Тэр үнэлгээний дагуу 2 сараар хойшлуулж мөнгө орсон даруй орж ирснийхээ дараа НӨАТ-ынх нь татварыг төлөх ийм боломж нь бүрдэж байгаа гэсэн үг. Энэ бол одоо нөгөө компаниудын эргэлтийн хөрөнгө дээр эерэг дүн авчирна. Банкнаас юм уу, банк бусаас юм уу зээл мөнгө тэр тэр зээлэх шаардлагагүй болно гэсэн үг. Мөн одоо эргээгээд тендерт ороход НӨАТ-ын өртэй гэдэг байдал чинь харьцангуй багасна гэсэн үг.

Тэгэхээр энэ бол одоо эргээгээд НӨАТ-ын хуульд ерөөсөө гол асуудал юу байсан бэ гэхээр НӨАТ-ын өртэй болдог байсан эргэлтийн хөрөнгийн дутагдалд ордог байсан асуудлыг нь энүүгээрээ шийдэж байгаа гэсэн үг. ХХОАТ дээр мөн орон сууц, анхны орон сууцаа тусгай хамгаалалттай газрын бүс нутагт биш л бол орон сууцаа зарвал тэр 2 хувийн дотроосоо хөнгөлөгддөг байхаар энэ Татварын хууль нэмэлт, өөрчлөлт орж байгаа. ААНОАТ дээр мөн шууд дансыг нь хаахгүйгээр битүүмжлэхгүйгээр орж ирсэн орлогоос нь хэрвээ татварын өртэй компани байвал 70 хувийг нь татварын алба татвартаа авдаг, 30 хувийг нь тухайн компанийн үйл ажиллагаа явуулах боломжийг нь бүрдүүлэх үүднээс 30 хувийг нь дансан дээр нь үлдээдэг байхаар хуулийн зохицуулалтыг оруулж ирж байгаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Би энэ ААН-ийн өр төлбөртэй холбоотой хэсгийг ойлгосонгүй дахиад тодруулаад өгөөч. Өр төлбөртэй ААНБ орлого хаа нэгтээгээс орж ирлээ гэхэд тэрний 70 хувийг нь автоматаар Сангийн яам авах гэж байгаа юм уу? Яг энэ процессыг татвар авах гэж байгаа юм уу? Энийг нэг тодруулаад өгөөч. Би ойлгохдоо уг нь хууль санаачлагч бол дансыг нь битүүмжлэх юм байна гэхдээ 30 хувийг нь нээлттэй үлдээх юм байна. Тэгээд компани өөрөө боломжоороо энэ өр төлбөрөө барагдуулаад 70 хувиа энэ царцаасан байдлаас нь гаргах юм байна гэж ойлгож байсан. Ажлын хэсэг болохлоор өөрчлөхдөө дансыг ямар ч юуг нь ч царцаахгүй орж ирж байгаа орлогоос нь 70 хувийг нь шууд татварын алба өөрөө авна гэсэн ийм зохицуулалт юм шиг ийм ойлголт төрүүлчих юм. Энийгээ яг сайн тайлбарлаад өгөхгүй юу?

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Цогтнаран дарга нэмж хариулъя. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Цогтнаран. Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Татварын ерөнхий хууль дээр татварын өрийг хугацаандаа төлөөгүй татварын өрийг үл маргах журмаар барагдуулах ийм зохицуулалт байгаа. Энэ зохицуулалт дээр дансанд нь ирээдүйд орж ирэх орлогынх нь 70 хувийг нь татварын

өрөнд нь суутган тооцно. 30 хувийг нь ААН-д өөрийнхөө үйл ажиллагааг тасралтгүй явуулахтай холбоотойгоор үлдээхээр шийдвэрлэж байгаа. Өөрөөр хэлбэл данс битүүмжлэх ажиллагаа хийгдээд тухайн компанийн дансанд 10 сая төгрөг орж ирлээ гэж үзвэл 7 сая төгрөгийг нь татварын өрөнд татварын байгууллага суутгаж авна. Дансанд нь 3 сая төгрөгийг нь үлдээнэ гэсэн ийм хуулийн өөрчлөлт орж ирж байгаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн дахиж тодруулъя.

А.Ариунзаяа: Тэгэхээр татварын өртэй ААН байгууллагуудын орж ирж байгаа орлогоос нь 70 хувийг нь шууд автоматаар авдаг байхаар зохицуулалт орж ирж байгаа юм байна гэж ойлголоо шүү. Тэгэхээр энэ өөрөө эргээд ямар нэгэн асуудал үүсэх үү үүсгэхгүй юу? Дараагийн асуудал байх нь байна. Ямар ч байсан бид нар ийм хуулийг эцэслэн батлах гэж байгаа юм байна шүү гэдгийг олон нийт болон Улсын Их Хурлын гишүүддээ ойлгуулъя аа. 2027 оны 1 сарын 1-ээс 792 мянган төгрөг хүртэл цалин хөлс түүнтэй ажиллах орлогоос татвар авахгүй байх нь байна аа. Энэ бүрэн орж ирэх нь байна. Тэрнээс биш 2 сая төгрөг хүртэлх энэ орлого дээр нэг хувийн татвар авна гэдэг нь 2028 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхлэх юм байна гэдгийг ойлгож авлаа. Орон сууцын борлуулалт дээр анх удаа эзэмшиж байгаа 5-аас доошгүй жил ажилласан нэг удаагийн энэ борлуулалтын татвараас чөлөөлөгдөх юм байна гэж ойлгож байна аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Ер нь Ариунзаяа гишүүний ярьж байгаа зөв шүү. Бид нар гишүүддээ энэ хэлэлцэж байгаа баталж байгаа хуулиудынхаа агуулга, зорилго, ач холбогдол, ард иргэд, олон нийт дэх үр өгөөжийг бид нар сайн ярьж таниулж ойлгуулж байх ёстой. Энэ талдаа манай гишүүд анхаарцгаая бүгдээрээ цаашдаа.

Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн Байдраг сумын ЕБС-ийн 10-ын В ангийг 1986 онд төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Төгсөлтийнхөө 40 жилийн ойгоо тэмдэглэж байгаа иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя.

Б.Батнайрамдал: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол дэмжиж байгаа. Гэхдээ нэг болж байгаа үйл процесстой холбоотой нэг үг хэлэх хэрэгтэй байна.

Оюу Толгойтой холбоотой бухимдсан иргэдийн үзэл бодлоо илэрхийлж талбай дээр жагсаж байна. Цагаан хад дээр очиж зам хаасан эсэргүүцлээ илэрхийлсэн үйлдлүүд сүүлийн 7 хоног гарлаа. Энэ асуудлаа шийдэхгүй байгаа бухимдсан иргэдийн цөхөрсөн үйлдэл шүү дээ. Бухимдаж байгаа иргэдээ буруутгахын оронд асуудлаа шийдэх хэрэгтэй шүү дээ.

Улсын Их Хурлаас шийдлийг нь гаргаад 120 дугаар тогтоол баталж өгсөн. Эсэргүүцээд ирэнгүүт 5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээлээ гээд үсрээд бүгдээрээ гарч ирээд ярьж байна л даа. Тэр хүмүүс 115 тэрбум төгрөгийн зээлийн хүүг давхар ярих хэрэгтэй шүү дээ. 120 дугаар тогтоол батлагдсанаас хойш 7 сар өнгөрсөн байна шүү. Зээлийн хүүд нь 3 их наяд төгрөг Оюу Толгой Рио Тинтод төлөхөөр болоод байгаа юм, 3 их наяд төгрөг. Энийгээ ярихгүй юм уу тэгээд. Ард түмэн

шийдэл л нэхэж байгаа байхгүй юу. Шийдэл л нэхэж байна шүү дээ. Бухимдахгүй яах юм. Тэр хүмүүсийн өмч шүү дээ.

Иргэд нэг уул уурхайг эсэргүүцээд байгаа юм биш шүү дээ. Хөгжил авчирдаггүй, өрөнд оруулдаг, хариуцлагагүй, ашиг нь ирдэггүй, ил тод биш, тайлагналаа хийдэггүй, харилцан ашиггүй энэ тогтолцоог л эсэргүүцээд байгаа байхгүй юу. Тэгээд эцэстээ явсаар байгаад бухимдсан иргэдийн буруу болж таарахгүй шүү. Тэгээд сая Оюу Толгой уриалга гаргасан чинь Эрдэнэс Оюу Толгой бас үсэрч очоод хоёрхон цагийн дараа нэг мэдэгдэл гаргаж байна аа.

Нөгөө 2 Оюу Толгой болон Эрдэнэс Оюу Толгойн гаргасан мэдэгдлийг харьцуулаад харсан чинь нэг хүн биччихсэн юм шиг л юм гарч ирж байна шүү дээ. Тэгээд бүр гайхаад хиймэл оюуны шинжилгээ хийж үзлээ. Тэгсэн чинь 2 мэдэгдлийн агуулга, бүтэц, үг хэллэг, өнгө аяс маш өндөр түвшинд ойролцоогоос 90-ээс 95 хувь төстэй байна гээд хиймэл оюуны дүгнэлт гарч байна. Нэг ноорог нэг PR эсвэл нэг зохиогчоос боловсруулагдсан байх магадлал 85-аас 95 хувь гэж хиймэл оюун дүгнэж байна шүү. Энийг сонсож байгаа залуучууд та нар Оюу Толгойн мэдэгдэл эрдэнэс Оюу Толгойн гаргасан уриалгыг ингээд хиймэл оюунаар өөрсдөө уншуулаад үзээрэй. Уул нь нэг шинэ захирал томилогдсон. Улсын Их Хурлын гишүүнээс чинь бараг хэд дахин өндөр цалин авдаг ажил шүү дээ. Өнөөдөр Монгол Улсад хамгийн үнэ цэнтэй компани бол 12 тэрбум доллароор үнэлэгдэж байгаа Эрдэнэс Оюу Толгой шүү дээ. 12 тэрбум доллароор Морган үнэлсэн байгаа шүү. Тэгэхээр ийм хариуцлагатай үед хариуцлагатай үйлдэл гаргамаар байна.

С.Бямбацогт: Батнайрамдал гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асууя.

О.Батнайрамдал: Татвартай холбоё л доо. 2013-2020 оны хооронд Оюу Толгой дээр 365 сая долларын акц тавьсан байгаа. Бүгд маргаантай 2013 оноос хойш 2020 оны хооронд бүх татварууд бүгдээрээ маргаантай арбитрын шийдвэр хүлээгээд л байж байгаа. Ийм л нөхцөлтэй байдалтай байгаа шүү дээ. Татвартай холбоё л доо. Дөнгөж 2021-2022 онд Монгол Улсын татварын албанаас дахиад 465 сая долларын татварын акц Оюу Толгой дээр тавьсан байгаа. Татварын маргаангүй нэг ч татвар Оюу Толгой дээр байхгүй шүү дээ. Ийм л нөхцөл байдалтай байгаа байхгүй юу. Энийгээ шийдээч ээ. Ажлын хэсгийг ахалж байгаа Энхбаяр сайд 120 дугаар тогтоолоо унших хэрэгтэй. Улирал тутам Эдийн засгийн байнгын хороонд ирж тайлагнаа тавина гээд 120 дугаар тогтоол дээр цагаан дээр хараар биччихсэн байгаа шүү. Одоо энэ хаврын чуулгандаа багтаж Энхбаяр сайд ажлын ахлагчийн хувьд Эдийн засгийн байнгын хороон дээр ирж тайлангаа тавих хэрэгтэй. Энийг ард түмэн хүлээж байгаа шүү.

С.Бямбацогт: Холбогдох албан тушаалтнууд энэ дээр мэдээлэл өгмөөр байгаа юм. Иргэдийн мэдэх эрхийг хангамаар байна. Энэ олон жил үргэлжилсэн даамжирсан татварын маргааныг хэрхэн яаж шийдвэрлэх юм. Энэ дээр ямархуу алхам хийгдэж байгаа юм. Алив Татварын ерөнхий газраас хариул. Энэ мэдэх эрхийг хангах ёстой. Их Хурлын гишүүд төдийгүй ард иргэд мэдэх эрхтэй. Үл ойлголцол чинь мэдээлэл багатайгаас болоод байгаа шүү дээ. Тэгээд үл ойлголцлыг сайн мэдээлэл өгч байж үнэн зөв бодитой мэдээлэл өгч байж бид нар иргэдийн мэдэх эрх хангагдана. 4 дүгээр микрофон.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Цогтнаран. Батнайрамдал гишүүний асуусан асуулттай холбоотойгоор Оюу Толгой компанид Татварын албанаас нийт 6 удаагийн татварын хяналт шалгалт хийсэн байдаг 2009 оноос эхлүүлээд 2022 оныг дуустал. 2013-аас 20 оныг дуустал буюу 2018, 2020, 2023 онуудад хийгдсэн татварын актын төлбөрүүдийг Оюу Толгой компанид төлсөн. Гэхдээ татварын маргааны асуудал бол өнөөдөр Арбитрын шүүх дээр хэлэлцэгдээд явж байгаа бүрэн эцэслэн шийдэгдээгүй маргаан арбитрын маргаан үргэлжлээд явж байгаа.

2026 оны хувьд бол бид нар 2021-2022 оны татварын үйл ажиллагаанд нь шалгалт хийсэн. Тэгээд бас тодорхой төлбөр тавигдсан. Төлбөрийг бол Оюу Толгой компани төлсөн. Гэхдээ Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан байгаа. Төлбөрийн тухайн татвар төлөгчийн төлбөртэй холбоотой мэдээллийг Татварын ерөнхий хуулиараа нэг тодорхой хязгаарлалтай байдаг учраас би танд эргээгээд дүнг нь албан бичгээр холбогдох хууль тогтоомжийнх нь дагуу хэлье ээ.

С.Бямбацогт: Тодруулж асууя Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Наад дүнгүүд чинь бүгдээрээ надад Монголын татварын албанаас Улсын Их Хурлын гишүүний асуултаар ирчихсэн дүнгүүд юм аа. Олон нийтэд нээлттэй мэдээлэл шүү дээ. Улсын Их Хурлын гишүүнд асуултад хариулт өгсөн бол parliament.mn дээр олон нийтэд бүгд нээлттэй байдаг хуультай юм. Тэгээд сая Монголын татварын албанаас баталгаажууллаа шүү дээ. 2013 оноос хойш Оюу Толгой үйлдвэрлэлээ явуулж орлого олж эхлэхээс хойших нэг ч жилд маргаангүй жилд байхгүй байхгүй юу. Одоо хүртэл нэг ч жилийн татварын маргаан эцэслэгдээгүй өнөөдрийг хүрч байгаа юм. Бүгд арбитр дээр оччихсон. Авахгүй нь ойлгомжгүй. Гэхдээ Оюу Толгой компани тэр татварыг нь төлчихсөн юм шиг PR медиа хийж болохгүй байхгүй юу. Монголын татвар руу шилжүүлсэн тэр мөнгө арбитрын шийдвэр эцэслэгдэж байж Монголын талд очих уу үгүй юу гэдэг нь шийдэгдэнэ гэсэн үг.

Тэрийг Монгол Улсын Засгийн газар бас эцсийн шийдвэр гартал үрж болохгүй мөнгө байхгүй юу. 100 хувь буцаагдаж ч болох арбитрын шийдвэр гарч магадгүй ийм мөнгө явж байгаа юм.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Энэ Татварын ерөнхий хуулиар энэ олон жил маргалдаж байгаа томоохон гадаад дотоодын хөрөнгө оруулалттай компаниудын энэ татварын маргааны асуудлыг зохицуулж байгаа юм уу. Энэ олон жил маргалдсан хэнийх нь зөв, хэнийх нь буруу мэдэхгүй маргааны асгаа асуудлыг энэ Татварын энэ багц хуулиараа шийдчихмээр байгаа шүү дээ. Нэг талдаа гаргаад. Энэ тал дээр дараад нь асуултад хариулахдаа хэлээрэй.

Пүрэвжавын Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Татварын энэ багц хуулийн.

С.Бямбацогт: Уучлаарай зочин танилцуулчихъя. Нэлээн удаан суучихлаа. Дараа нь таны минут гүйцээгээд өгчихье.

Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн Байдраг сумын ЕБС-ийн 10 А, 10 Б ангийг 1986 онд төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа. Төрийн ордонтой танилцаж байна аа. Төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа иргэддээ

Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. Төгсөлтийнхөө ойг сайхан тэмдэглээрэй. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Энэ Татварын багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн асуудал 2024 оны парламент бүрдсэнээс хойш энэ 3 дахь удаагаа ажлын хэсэг гарч ажиллаж Засгийн газраас өргөн бариад энэ сүүлийн ажлын хэсэг маань төсвийнхөө орон зайн боломжит тултал нь буюу нийтдээ нэг 2.5 их наяд төгрөгийн татварын ачаа дарамтыг ард иргэд, ААН-үүдийн нуруунаас хөнгөлж чөлөөлж өгөхөөр оруулж ирж байгаа. Энэ агуулгынх нь хүрээнд дэмжиж байгаа. Тэгээд ялангуяа ажил хөдөлмөр эрхэлж байгаа нийт сая 50 мянган хүний хувь хүний орлогын албан татварыг үе шаттай хөнгөлж чөлөөлж 792 мянга хүртэл бүрэн чөлөөлж Хувь хүний орлогын албан татварыг 792 мянгаас 2 сая хүртэл нэг хувийн татвартай болгож ингэж ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн гар дээр авч байгаа бодит орлого цалинг өсгөж байгаа нь бол их чухал нөлөөтэй татвар болж байна гэж харж байгаа. Энэ дээр нийтдээ 1.9 орчим их наяд төгрөгийн татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлж байгаа.

Хоёрт ААНОАТ дээр тодорхой хэмжээний шатлал оруулж байгаа. Ялангуяа ашгаас төлдөг 10 хувь нь 25 болоод огцом өсдөг. 6 тэрбумаас дээшээ орлого дээрхийг дунд нь 6-10 тэрбум төгрөг дээр 15 хувийн шатлал оруулж ирж байгаа нь бас бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа томоохон байгууллагуудын ашгийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй гэж харж байна. Мөн жижиг, дунд бизнесүүд 1 тэрбум хүртэл борлуулалтаа бол одоо татварынхаа 90 хувийг буцааж авдаг хялбаршуулсан байдлаар тайлан гаргадаг. Энэ 1 тэрбумын босгыг нэмэгдүүлж 2.5 болгож жижиг, дунд бизнесүүдийн татварын хөнгөлөлтөд хамрагдах хүрээг нэмэгдүүлж энд 80 гаруй мянган ААН хамрагдаж байгаа нь чухал зүйл болж байгаа гэдгийг бас тодотгож хэлье. Харин санал нийлэхгүй эсэргүүцэж байгаа нэг зүйл байгааг хэлье ээ.

Энэ бол нэмэгдсэн өртгийн албан татварын 50 сая төгрөгийн босгыг 400 сая болгохоор Засгийн газраас өргөн барьсныг ажлын хэсэг унагаасан. Бид нар жижиг, дунд бизнесүүдээ дэмжинэ гэж ярьдаг. Бүх намын мөрийн хөтөлбөрт байгаа. МАН-ын мөрийн хөтөлбөрт 50 саяыг 400 сая болгоно гэсэн заалт байж байгаа. АН-ын мөрийн хөтөлбөрт байгаа, Хүн намын мөрийн хөтөлбөрт байгаа. Энэ амлалтаасаа буцаж ухралт хийж энэ босгыг ажлын хэсэг Төсвийн байнгын хороон дээр унагаасныг эсэргүүцэж байгаа болохоор Их Хурлын нийт гишүүд энийг санал хураалт дээр босгож ирэхийг дэмжиж өгөхийг хүсье ээ.

НӨАТ-ын 400 саяын босгыг 50 болгосноороо том ААН-үүд жижиг, дунд бизнесүүдээс худалдан авалт хийхгүй гэсэн үндэслэл тайлбар хийж байна лээ. Тийм юм бол байхгүй ээ. Ямар тооцоо үндэслэл байгаад байгаа юм бэ? Харин ч 400 саяын босгыг 50 болгосон тохиолдолд энэ хэсэгт НӨАТ төлөгчөөр бүртгэгдэж байгаа ААН-үүд чинь дахиад худалдаж байгаа бараа үйлчилгээн дээрээ 10 хувийн татвараа нэмээд үнэ өснө өө.

Тийм болохоор энэ асуудлыг бол бид нар бас эргэж харж энэ Их Хурлын эцсийн хэлэлцүүлэг дээр санал хураах дээр Их Хурлын гишүүдийг анхаарч ажиллахыг хүсье ээ. Тэгээд НӨАТ-ын асуудал дээр бол өнгөрсөн намрын чуулганаар бид нар НӨАТ-ын татварыг 5 хувь болгоё гээд Их Хурлаараа баталчихсан шүү дээ. Тэрнээсээ сая 10 хоногийн өмнө Их Хурал буцаад ялангуяа олонхыг бүрдүүлж байгаа МАН буцаад Их Хурал дээрээ унагаагаад 5 хувиар хүчин

төгөлдөр үйлчлэх байсан хуулиа буцаагаад 10 болгочихсон шүү дээ. Тэгээд ингээд НӨАТ дээр болохоор ард түмэн ААН-д хэлсэн амлалтаасаа байнгын ухарч эргэж буцаж байгааг эргэж харж энэ төсөв мөнгөн дээр үүсчхээд байгаа гажуудал. НӨАТ-ыг бол ерөөсөө үндсэндээ бүртгэлийн зорилгоор гарч ирсэн татварын хэрэгсэл. Гэтэл энийг бид нар төсвийн орлогынхоо үндсэн суурь болгочихсон. Тэгээд эндээсээ буцаж чаддаггүй. Энэ байдлаа засаж залруулж.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Ганхуяг: Ганзориг гишүүн манай ажлын хэсгийн гишүүн л дээ. Яах вэ тэгээд зарим юман дээр санал зөрөлдөж болно л доо. Тэр асуудал биш. Энэ удаагийн Татварын багц хуулиар нийтдээ 4.1 их наяд төгрөгийн татварын хөнгөлөлт болон төсвийн нөлөөлөлтэй байгаа. НӨАТ-ын хууль дээр би дахиад танд тайлбарлая. Өнөөдрийн байдлаар хэд хэдэн сөрөг үр дагавар гарахаар байгаа юм аа. Бид нар энэ НӨАТ-ын хуулийг ганцхан тоог нь оролдож ерөөсөө болохгүй хууль байгаа юм. Энэ чинь нөгөө бүртгэлийн зориулалттай болохоор. Заавал ч үгүй цогцоор нь оруулж ирэх хэрэгтэй. Хэрэвзээ тэр буцаалттай холбоотой заалт байсан бол 400 сая болоход ямар ч асуудал байхгүй. Гэтэл бид нар буцаалттай холбоотой заалтыг нь хүчингүй болгочхоод 400 сая болгонгуут ямар сөрөг үр дагавар авчрах гэж байна гэхээр нийт 69 мянган НӨАТ төлөгчийн 3-ны 1 нь НӨАТ төлөгч биш болгоод. Энийгээ дагаад далд эдийн засаг томроод өнөөдрийн НӨАТ хамрагдалтын 75 хувь 50, 60 хувь руу орохоор байгаа.

Гуравдугаарт, өчигдөрхөн бид нар Байнгын хороон дээр тамхины хууль хэлэлцсэн. Энэ тамхийг бол одоо тамхи, архийг ингээд түгээлтээр хүргэж өгдөг. Төлбөрийг нь дандаа хувь хүний дансаар авдаг. Хувь хүний дансаар авахдаа 50 сая хүртэлх төгрөгийн орлого аваад дараагийн хувь хүний дансыг ашиглаж өнөөдрийг хүртэл хүрч ирсэн байдаг. Тэгэхээр энэ 400 сая болгосноор эргээгээд сөрөг үр дагавар нь юу вэ гэхээр далд эдийн засгийг бий болгох, нөгөө онцгой татвартай бараа бүтээгдэхүүнд тавигдах ёстойг хяналтаа тавьж чадахаа болих гэх мэт сөрөг үр дагавар гарах гээд байгаа юм аа. Тэрнээс биш би одоо өөрийнхөө хувь хүнээ бодоод хувь гишүүнээ бодвол энийг чинь ингээд 2 гараа өргөөд 4 сая болгочихмоор байгаа юм. Гэхдээ энэ сөрөг үр дагаврын үр нөлөөг хэн хариуцах вэ? Далд эдийн засаг бий болж байгаа асуудлыг хэн хариуцах юм. Чөлөөт бүсээр баяр наадам болгон нь гарч ирж байгаа энэ хуурамч архины борлуулалтыг хэн зогсоох юм. Энийг ерөөсөө ганц бүртгэдэг тогтолцоо нь НӨАТ-ын тогтолцоо байхгүй юу. Тэгээд тэр 50 сая төгрөгөөр тогтоож байгаа босгыг нь 400 сая болохоор 10 хүний данс биш нэг хүний дансаар л тэр гүйлгээг авдаг болно гэсэн үг. Тэрнээс биш энэ чинь ЖДҮ гээд бид нар 1.5 тэрбумд ноогдох нэг хувийн татварыг бид нар 2.5 болгож байгаа шүү дээ. Ашигтай байвал нэг хувийн татвараа төл өө гэдэг л болгож байгаа шүү дээ. Тэрнээс биш зөвхөн би ингээд иргэдэд сайхан сонсогдох байдлаар бид нар хууль батлаад явах юм бол энэ татварын тогтолцоо, энэ хяналтын тогтолцоо, энэ шударга ёсны тогтолцоо бүгдээрээ байхгүй болох гээд байна шүү дээ. Энэ зах зээл дээр зарагдаж байгаа НӨАТ-тай, НӨАТ-гүй бараан дээр чинь бүгдээрээ л улам өдөөгдөх гээд байна шүү дээ. Энэ чинь хяналт тавьдаг юм нь юу вэ гэхээр буцаалт байсан байхгүй юу.

Иргэн өөрөө хяналтаа тавиад НӨАТ-ын падаан нь хаана байна гэж хяналт тавьдаг тогтолцоог нь бид нар байхгүй болгочхоод зөвхөн босгыг нь 50-аас 400 сая болохоор энэ тогтолцоо чинь нурж унах гээд байна аа. Тэрнээс биш бид нар хяналтын тогтолцоог нь байлгавал 1 тэрбум болгосон ч болно 2 тэрбум болгосон ч

болно. Асуудал нь юу гэхээр бид нар хяналтын тогтолцоог нь байхгүй болгоод нөгөө талдаа босгыг нь нэмэгдүүлэхээр энэ тогтолцоо өөрөө нурж унана.

С.Бямбацогт: Ганзориг гишүүн тодруулж асууя.

П.Ганзориг: НӨАТ-ын босгыг 50 саяыг 400 сая болгоё гэдгийг зөвхөн энэ би 3 дахь удаагаа энэ ажлын хэсэгт ажиллаж байна. Хувь гишүүнийхээ хувьд дангаараа байр суурь илэрхийлээд байгаа зүйл огтоос биш. МАН-ын мөрийн хөтөлбөрт байгаа шүү дээ. Та нар тэгээд анхнаасаа судалгаа тооцоогүй худлаа амлалт өгөөд явчихсан юм уу ард түмэнд. Тэгвэл энэ дээр хариулт өг. Бид нар буруу тооцоо судалгаатай болохгүй юмыг худлаа амласан юм гэдгээ хэлчих л дээ, нэг.

Хоёрт Засгийн газар энийг чинь өргөн барьсан шүү дээ. Сангийн сайд нь хаана байгаа юм. Сангийн сайд нь ямар тооцоо судалгаатай өргөн барьсан юм энийг тэр үндэслэлээ тайлбарлаач. Засгийн газар нь, Ерөнхий сайд нь өргөн барьчхаад үгүй Учрал Ерөнхий сайд саяхан өнгөрсөн 7 хоногт НӨАТ-ын 50 саяын босгыг 400 сая болгож байгаа энд 23500 ААН хамрагдана гээд л хэвлэлд мэдээлэл өгсөн байна лээ шүү дээ. Тэгээд яагаад ингээд Засгийн газрынхаа тэгвэл эсрэг ийм юу гаргаад байгаа юм.

С.Бямбацогт: Сангийн сайдыг дуудъя. Ажлын хэсгийн гишүүн. Ажлын хэсэг хууль санаачлагч хариулах ёстой.

Зочин танилцуулъя.

Баянхонгор аймгийн Байдраг сумын ЕБС-ийн 10^г ангийг 1986 онд төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. 40 жилийнхээ ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Ганбат гишүүн, Жаргалсайхан гишүүн, Цогтбаатар гишүүд маань хамт баяраа тэмдэглэж байна. Ажлын хэсгийн ахлагч хариулъя. Сангийн сайдыг дуудаарай.

Х.Ганхуяг: Ер нь яах вэ Ганзориг гишүүнээ бид нар энэ НӨАТ-ын энэ босгыг 400 сая болохыг буцаалттай нь хамт дараа нь өргөн барья битэгж санал гаргамаар байна. Тэгэхгүй бол яг дангаар бид нар буцаалтын хуулиа хүчингүй болгочоод тэгээд ганцхан энэ босго нэмэгдүүлэхээр чинь ингээд дэс баланс үүсэх гээд байна л гэдэг асуудал яриад байгаа шүү дээ. Бид нар хууль санаачлах эрх нь нээлттэй. Тэгэхээрээ тэр буцаалттай холбоотой заалттай нь уялдуулаад тэр босгыг нь 400 байх юм уу, 500 байх юм уу тооцоолж байгаад дараа нь өргөн барьж болно шүү дээ. Энэ асуудлыг л яриад байгаа юм. Тэрнээс биш энэ буруу юм гэдэг нь тэр буцаалттай холбогдуулаад явсан бол энэ зөв байхгүй юу. Буцаалттай нь холбогдуулвал. Тэгэхэд чинь бид нар буцаалтыг нь өөрсдөө хүчингүй болгочоод тэгээд 400 сая гэхихээр чинь өөрөө энэ чинь нөгөө нөгөө НӨАТ хамрагдалт нь байхгүй болоод нөгөө бүртгэлийн нь тогтолцоо нь байхгүй болох гээд байна л даа. Энэ энэ талын эрсдэлүүд нь бий болчихоод л таныг гуйгаад байгаа шүү дээ.

С.Бямбацогт: Сайд хариулна. Бүлгийн дарга хариулдаг дэг байхгүй. Ажлын хэсгийн гишүүд хариулна. Сангийн сайдыг орж ирээд хариулуулъя. Арвижихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя.

Р.Эрдэнэбүрэн: Өглөөний мэнд хүргэе. Гуравхан товч асуулт асууна аа. Энэ эцсийн хэлэлцүүлэг явахаас өмнө. Санал хураалт явахаас өмнө.

Нэгдүгээрт бол энэ татвар төлж байгаа компаниудад санхүүгийн тусламж үзүүлж байгаа, татвар төлөлтийн материал тайлан бүрдүүлж байгаа, бүрдүүлэлт хийж байгаа энэ ААН-үүд бол хиймэл оюун ухаан ашиглаж бид нар энэ ажлыг хийдэг боллоо, хийнэ гэж ингэж их ярьдаг боллоо. Үйлчилгээ үзүүлэхдээ.

Тэгэхээр энэ чиглэлээр энэ Татварын ерөнхий хууль дээр энэ татвар бүрдүүлэх тогтолцоогоо хиймэл оюун ухаантай холбох энэ чиглэлээр энд хуулийн төсөл дээр гарсан ахиц дэвшил нээсэн зүйл зохицуулалт юу байна вэ? Ийм зүйл болсон уу, болоогүй юу, орсон уу, ороогүй юу гэдгийг 1 дүгээрт асуух гэсэн юм.

Хоёрдугаарт нь энэ үзэл баримтлал нь анх орж ирэхдээ бол их хэмжээний алданги тооцох эрсдэлээс хамгаалах чиглэлээр энэ хуулийн төслийн үзэл баримтлалд ийм заалтууд орсон гэж ингэж орж ирсэн байсан. Энэ хэлэлцүүлгийн явцад энэ заалт ямархуу байдалтай болов орж чадав уу чадсангүй юу? Энгийг нэг жоохон тодорхой хэлээд өгөөч.

Гуравт энэ орон нутагт үйл ажиллагаа явуулдаг мөртөө Улаанбаатар хотод бүртгэлтэй ААН-үүд бай байдаг. Эд нарыг ингээд орон нутаг руу татвар төлөгчөөр бүртгүүлэх энэ чиглэл рүү шахах, энэ чиглэл рүү дэмжих ийм зайлшгүй шаардлагатай байдаг. Орон нутгаас хүсэлт ирдэг. Энэ чиглэлээр энэ Татварын ерөнхий хуульд ямар өөрчлөлт оров гэсэн ийм 3 асуулт асуух гэсэн юм.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс хариулъя. Сангийн яам Татварын бодлогын газрын дарга Чимэдсүрэн хариулъя.

Ч.Чимидсүрэн: Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя.

Сангийн яамны татварын бодлогын газар Чимидсүрэн. Татварын ерөнхий хууль дээр бол яг таны хэлсэн AI-тай холбоотой заалт бол энэ удаа орж ирээгүй. Гэхдээ ер нь бол татвар төлөгчдийнхөө хууль даган мөрдөлтийн түвшнийг нь тогтоох бүхэл бүтэн заалт орсон. Тэрийгээ бас гааль татварын мэдээллийн нэгдсэн системтэй холбох, өөрт байгаа мэдээллийн системээ илүү хөгжүүлж ашиглах талаас орж байгаа. Зүгээр татвар төлөгч талаасаа гарч байгаа тайлан тооцоон дээр энэ дэвшилтэт технологи ашиглах талаар нэмэлт заалт ороогүй байгаа.

С.Бямбацогт: Татварын Ерөнхий газар, Цогтнаран дарга хариулъя.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Цогтнаран. Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя.

Татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой асуулт асуулаа. Татварын алба 2020 оноос сегментэд үндэслэсэн татвар төлөгчийн бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлээд явж байгаа. Өөрөөр хэлбэл татвар төлөгчдөө бичил, жижиг, дунд, том сегментэд ангилж тухайн татвар төлөгчдөд хэрэгцээ шаардлагад нь үндэслэсэн татварын зөвлөгөө үйлчилгээг үзүүлээд явж байгаа. Энэ татвар төлөгчийг борлуулалтын орлогын дүнгээр нь ангилж байгаа. Өөрөөр хэлбэл 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой ААН-ийг бичил, 50-аас 2 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготойг нь жижиг, 2-40 тэрбум төгрөгийн борлуулалтын

орлоготойг нь дунд, 40-өөс дээш борлуулалтын орлоготой ААН-ийг нь том сегментэд ангилж ингэж явж байгаа. Том сегментийн ангилалд байгаа татвар төлөгчдийг бол том татвар төлөгчийн газар, дунд сегментийн татвар төлөгчдийг бол нийслэлийн Татварын газар хариуцсан байхаар ингэж татвар төлөгчийн.

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. 4 дүгээр микрофон.

Б.Цогтнаран: Татвар төлөгчийн бүртгэлийн хувьд ингэж татвар төлөгчдөө сегментэд үндэслэсэн бүртгэл хийгдээд явж байгаа. Орон нутагт үйл ажиллагаа явж байгаа юу? Улаанбаатар хотод үйл ажиллагаа явж байгаа юу гэдэг нь татвар төлөгч болон татварын албаны хувьд ялгаа байхгүй ээ. Холбогдох татварын төлбөрүүдээ төсвийн тухай хуулиараа орон нутгийн төсөвт орох ёстой төлбөрүүд нь орон нутгийн төсөвтөө орно. Улсын төсөвт орох ёстой татварын төлбөрүүд нь улсын төсөвтөө ороод явж байгаа. Өөрөөр хэлбэл хаана үйл ажиллагаа явуулж байгаа, хаана бүртгэлтэй нь бол яг нөгөө төсөвт огт нөлөө байхгүй.

Харин эсрэгээрээ сегментийн бодлогынхоо дагуу хэрэгжээд явснаараа зөвлөгөө үйлчилгээ талдаа татвар төлөх ёстой илүү боломжийг нь олгоод татвар төлөгчдөө ангилаад явж байгаа.

С.Бямбацогт: Чинбатын Ундррам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундррам: Татварын багц хуультай холбоотой асуулт асууя. Яах вэ шаталсан татварын бодлого олон улс л улсад л хэрэгждэг л дээ. Англи, франц, Герман гээд. Тэгэхдээ миний хувьд яг манай Монгол Улсад жоохон шударга татварын тогтолцоо байвал илүү зохимжтой юм шиг санагдаж байгаа юм. Жишээлбэл төмөр замын салбар ч юм уу, агаарын тээврийн салбар, уул уурхайн салбар гээд ростероор ажилладаг салбарууд. Ийм салбаруудын ажилтан гэр бүлд нэг л хүн ажиллаж байгаа юм. Нөгөөдөх нь үр хүүхдээ хараад, гэрээ хараад гэртээ байж байдаг. Тэгэхээр 1 ёсондоо өрхийн нийт орлогыг ганц хүн бүрдүүлж байгаа. Тэгээд ийм хүмүүст өндөр татвар ноогдуулчихаар энэ чинь 2 хүний өмнөөс л цалин хийгээд ингээд ажиллаад байгаа хүмүүс. Тэгэхээр шударга биш болоод байгаа юм л даа. Тэгээд энэ асуудлаар бас агаарын тээврийн салбарын зарим нэг хүмүүс хүртэл надад хандаж уулзаж байсан. Тэгэхээр энэ дээр ер нь та юу гэж бодож байна вэ? 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарт одоо ийм шаталсан татварын нэг сул тал нь татвараас зайлсхийлт нэмэгддэг. Одоо юу гэдэг юм 2 компани дээр бүртгүүлээд 2 талаас цалингаа хувааж аваад ингээд нэг хувийн татвар төлдөг ч юм уу ийм асуудал нэмэгддэг. Тэгэхээр энэнээс яаж манай Татварын ерөнхий газар сэргийлэх юм? Ямар арга хэмжээ авах юм гэдэг ийм, 2 дугаар асуулт.

Гуравдугаар дугаар асуулт нь ХХОАТ сумын төсвийг бүрдүүлдэг хамгийн гол татвар байдаг. Тухайн суманд амьдарч байгаа хүн амын орлогын албан татвараас нөгөө сум нь асуудлуудаа сумын иргэдийн хурлын төлөөлөгчдөөрөө дамжуулаад зардлаа шийдээд ингээд асуудлаа шийддэг. Одоо тэнд хогийн асуудал байна, жижиг сажиг сургууль, цэцэрлэг, эмнэлгийн засварын асуудал байна гэх гэх мэтчилэн. Тэгэхээр энэ орлогын албан татвар чинь нэг хувь болоод бүүр буурчихаар төрийн албан хаагчид ихэнх нь л 2 саяас доош цалинтай байгаа. Ингээд нэг хувь төлөөд тэгээд нөгөө сум чинь мөнгөгүй болно. Тэгэхээр буцаад л бүх сумаа татаастай болгох уу? Уул нь улсад татвар төвлөрүүлдэг 1 зургаахан аймаг байгаа.

Тэрний нэг нь жишээлбэл манай Сэлэнгэ аймаг. Энэ дотроо бас өөрөө өөрийгөө аваад явж байгаа. Бас татвар төвлөрүүлдэг ийм сумд байгаа байхгүй юу. Тэгээд тэд нар чинь буцаад санхүүгийн хувьд хараат байдалд ороод ингээд явчихна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого барих вэ хэдүүлээ? Ийм 3 асуулт байна.

С.Бямбацогт: Чимидсүрэн дарга. Сангийн яам хариулъя 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Ундрам гишүүний асуултад хариулъя. Сангийн яам татварын бодлогын газар Чимидсүрэн.

Тэгэхээр Хувь хүний орлогын албан татварт шаталсан татварыг бид нар 1990 оноос хойш ер нь хэрэглэж ирсэн. Тэгээд 2007 оноос бол 10 хувийн татвартай болоод үндсэндээ 2022 он хүртэл хэрэглэж байсан юм. Тэгээд 2022 оноос бол 10, 15, 20 гэсэн ийм шатлал руу оруулсан. Тэгээд 2022 онд тухайн үед ҮХЦ-д тодорхой иргэд энэ шаталсан татварыг эсэргүүцэж тийм мэдээлэл гаргаад тэгээд ҮХЦ-ээс дүгнэлт гарсан байдаг. Энэ их олж байгаа орлогоос нь илүү олгох нь шударга Үндсэн хуульд нийцэж байна гэдэг ийм дүгнэлтийг гаргаж байсан ийм практик бий. Дэлхий дээр байгаа улс орнуудын ер нь дийлэнх нь бол энэ шаталсан татварын тогтолцоогоор явж байгаа. Энэ удаагийн өөрчлөлтөөр бид нар 0 хувь, 1 хувь гэсэн 2 шатлалыг оруулж ирсэн. Тэгээд нийт иргэдэд бол энэ бол цалин хөлс авч байгаа иргэддээ л хамааралтай байгаа. Өөрөөр хэлбэл 792 мянга хүртэл 0 хувиар, 792 мянгаас 2 сая хүртэл нэг хувиар авч байгаа нь цалин хөлс хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүст бүгдээрэн дээр нь хамааралтай ийм шатлалыг нэмж оруулж зохицуулж байгаа.

ХХОАТ бол сум дүүргийн төсвийг бүрдүүлдэг, нийт сум дүүргүүдийн дунджаар аваад үзэх юм бол 40-өөс дээш хувийг эзэлдэг. Ингээд 330 сумаар аваад үзэх юм бол зарим сум нь 79 хувь хувь, зарим нь бүүр 19 хувь хүртэл энэ Хувь хүний орлогын албан татвараас сум, дүүрэг маань санхүүжээд тэгээд яваад байгаа юм. Тэгэхээр саяын бид нар 2 шатлал нэмсэнтэй холбоотойгоор жишээ нь 2027 онд гэхэд бол 840 тэрбумын төсөв бол багасах сум дүүргийн орлого орж ирэхгүй хэмжээнд багасаж ирж ирнэ. Тэгэхээр энийг бол улсын татаас хэлбэрээр л өгч энэ асуудлыг шийдвэрлэхээр ажлын хэсэг дээр ярилцсан байгаа гэдэг л ийм юм байна лээ.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ХАА-н техникумын агро 3^б ангийг 1986 онд төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Лувсаннъямын Гантөмөр гишүүн асуултаа асууя.

Л.Гантөмөр: Энэ Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Засгийн газар өргөн барихдаа захиргааны дарамтыг бууруулах их зоримог алхмыг хийж чадсан. Бид нар Засгийн газрын хийж чадаж байгаа сайн зүйлийг бол баяртайгаар хүлээж авч дэмжиж баталж байгаа. Наранбаатар аа, Наранбаатар гишүүн ээ, Энхбаяр аа би чамайг магтаад байна шүү дээ чи битгий хурал үймүүлээд бай. Тэгээд гол асуудал бол их сонин парадокс сая үүссэн. Ерөнхий сайд амаараа хаачихсан байгаа данснуудыг нээнэ гээд нээчихсэн. Яг ямар хуулиар хаагаад ямар хуулиар нээсэн бэ гэдэг нь бол их эргэлзээтэй үлдсэн байгаа. Зүгээр миний хувьд.

Яг энэн дээр Сангийн сайд өнөөдөр тайлбар хийх хэрэгтэй. Ийм хуулиар хаасан юм. Ийм хуулиар нээдэг юм байна лээ. Хэрвээ үнэхээр нээж болдог бол ингээд нээлттэй байлгамаар байгаа юм. Нээлттэй бид данс хаахгүй. Яг энэ нэмэлт, өөрчлөлтөөр хаадаггүй гэдэг хуулийн заалт ингээд батлагдаж байгаа юу. Наранбаатар дарга энэ дээр маш тодорхой хариултыг өгөх хэрэгтэй.

Бид бол татварын өртэй холбоотойгоор данс хаахгүй улс болсон шүү. Хуулийн төдийн төд дэх заалтын дагуу гэдгийг их тодорхой хэлж өгөөч гэдгийг 1 дүгээрт асуумаар байгаа юм. Энийг их тодорхой болгож байж бид нар цаашаа явна.

Хоёрдугаарт нэг сонин зүйл байгаа юм. Бизнес эрхлэх компани байгуулах энэ тэр бол ерөөсөө сайн дурын үндсэн дээр хийдэг ажил. Монгол Улсад Үндсэн хуулийн дагуу бол энэ сайн дурын үндсэн дээр хийж байгаа, нөгөө сайн дурын даатгал гэдэг шиг. Сайн дурын үндсэн дээр татвараа төлж байгаа. Гэтэл сайн дурын үндсэн дээр явж байгаа процессыг бид нар гэрээ хэлэлцээрийг зөрчсөн мэтээр алданги гэдэг зүйлийг өнөөдөр хүртэл ашиглаж ирсэн, алданги. Одоо ингээд Наранбаатар гишүүн бид 2 гэрээ хийгээд би төлбөрөө төлж чадахгүй бол шүүх дээр очоод алданги төлөх ёстой энийг ойлгож байгаа. Гэтэл орлогын албан татвараа хоцрогдуулсан буюу төлж амжаагүйн төлөө алданги руу орж байгаа юм.

Тэгээд энэ өөрөө их сонин тийм процесс болоод байгаа юм л даа. Тийм учраас би Сангийн сайдаас асуумаар байгаа юм. Ер нь цаашаагаа торгууль байж болно яагаад гэвэл цагтаа төлөөгүй байна аа. Энэ хуулийн дагуу тодорхой торгууль үүсэх нь ээ. Магадгүй бид татвараа цагт нь авахын тулд ийм арга хэрэгслийг ашиглаж болохоор байгаа юм. Алданги гэдэг чинь хэн алдаад байгаа юм бэ гэдэг асуудал байгаа. Хэн алдаад байгаа юм бэ, хаана алдаад байгаа юм бэ гэдэг асуудал. Тийм учраас бид нар одоо дахиж нэг алхаад энэ захиргааны дарамтыг арилгахын тулд алданги гэдэг зүйлийг татварын өрөн дээрээс авч хаях бололцоо бидэнд ер нь байгаа юу? Энэ рүүгээ нэг алхах уу? Бид бол ингээд юмыг сайжруулаад л яваад байх ёстой шүү дээ. Би орж ирсэн төслийг сайшааж байгаа шүү. Ингээд нэг алхах нь.

С.Бямбацогт: Үг хэллээ. Наранбаатар дарга Төсвийн байнгын хороо, эс үгүй бол Сангийн сайд Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Гантөмөр гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий хуулийн дагуу шаталсан арга хэмжээ аваад хуульчлагдсан татвараа төлж хугацаандаа төлөөгүй ААН-үүдийн дансыг хаасан байсан. Засгийн газрын чөлөөлөн аяны хүрээнд энэ ААН татвар төлөгчидтэй боломж олгох үүднээс нээсэн. Татварын ерөнхий хуулийн 76.1.3 дээр татвар төлөгчийн эрх хууль орчны сонирхол, ашиг сонирхлыг хүндэтгэх түүнийг хэрэгжүүлэх боломжийг хангах тэдэнд итгэл үзүүлэх гэдэг заалт байгаа. Энэ заалтыг үндэслээд тэр 12500 ААН-ийн дансыг сарын хугацаатай нээсэн. Энэ хуулийн нэмэлт өөрчлөлтөөр бол бид нар 30 хувийн дансанд нь үлдээгээд ирэх ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг нь 70 хувийн татаж авахаар ийм байдлаар зохицуулаад явъя. Цаашдаа ААН-ийн данс хаадаг үед энэ үйл ажиллагааг нь тасалдуулдаг асуудлыг больё, дэмждэг байя гэдэг энэ агуулгаар явж байгаа.

Нөгөө талдаа та түрүүн нөгөө юуг асууж байх шиг байна? Алдангийн асуудал. Тэгэхээр иргэний татварын хяналт шалгалтаар тогтоогдсон актаар торгуулийн хэмжээ хугацаандаа төлж чадаагүй бол алданги тооцогдоод явдаг. Энэ нь Иргэний

хуулиас одоо Иргэний хуулиар зохицуулсан арга хэмжээ бол энэний ямар ч алданги одоо 50 хувиас хэтэрч болохгүй гэдэг заалттай. Татварын хууль дээр энэ чинь даваад явчихдаг бараг үндсэн төлбөрөөсөө давдаг, хугацаа хэтрээд яваад байх юм бол. Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлтөөр бид нар татварын хяналт шалгалтаар тавигдсан алдангийн хэмжээ үндсэн төлбөрийн 50 хувиас хэтэрч болохгүй гэдэг заалтыг оруулж өгч байгаа юм. Иргэний хуультайгаа нийцүүлж.

С.Бямбацогт: Наранбаатар дарга нэмж хариулъя. Төсвийн байнгын хороо.

Н.Наранбаатар: Засгийн газраас энэ данс хаадаг асуудлыг хуулийн төсөл өргөн барихдаа орлогынх нь 80 хувиар нь хаагаад 20 хувийг нь үйл ажиллагаа явуулахад нь зориулж үлдээе гэдэг л ийм л санал орж ирсэн юм. Тэгээд ажлын хэсэг дээр яригдаж байгаад манай Байнгын хороо руу орж ирэхдээ 30, 70 болгоод 30 хувийг нь цаашаа үйл ажиллагаа явуулахад нь үлдээе, 70 хувийг нь татаж авъя гэдэг ийм л өөрчлөлтийг Байнгын хороон дээр танилцуулаад дэмжигдээд явж байгаа. Энэ болохоор Татварын ерөнхий хуулийн 63.2 дахь заалт.

Дараагийн нэг зохицуулалт нь 73.5 дээр алдангийн нийт дүн нь хугацаандаа төлөөгүй татвар эс үгүй бол татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварын үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй гэсэн нэг ийм 2 зохицуулалт орж ирээд Байнгын хороон дээр дэмжсэн.

С.Бямбацогт: Гантөмөр гишүүн тодруулъя.

Л.Гантөмөр: Ингээд одоо энэ хууль батлагдана аа. Хэдүүлээ батлаад нэмэлт, өөрчлөлтөө батлаад явахаар Монгол Улсад татварын өр авлагаас улбаатай данс хаах гэдэг зүйл алга болох нь байна аа. Дансанд орж ирсэн орлогынх нь 70 хувь татварынхаа өрийг барагдуулаад 30 хувиар нь өөр үйл ажиллагаагаа явуулаад явах нь гэдэг нь их тодорхой болж байна. Тэгэхээр хэдүүлээ дараагийн нэг алхам магадгүй намрын чуулганаар энэ алданги гэдэг зүйлийн тухай Мэндсайхан бизнес хийж байсан хийдэг. Уг нь бол бизнес талын байр суурийг мэддэг хүн учраас энэний суурь зарчмуудыг жоохон судлаач гэдэг ийм бодол байгаа юм. Санал байгаа юм. Жинхэнээсээ судалмаар байна. Яг алданги гэдэг нь хэн алдаад байгаа юм бэ гэдэг их сонин асуулт их олон жил явж байгаа. Энд намрын чуулганаараа хэдүүлээ хариулт өгөх.

С.Бямбацогт: Үг хэллээ. Манай Засгийн газар холбогдох сайд нар анхааралдаа авсан байх. Ажлын хэсэг.

Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Цемент шохой компанийн аж ахуйн хэлтсийн хамт олон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Болдын Жавхлан гишүүн асуултаа асууя.

Б.Жавхлан: Засгийн газраас оруулж ирсэн Татварын багц нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байгаа дэмжиж байгаа. Гагцхүү тэрэн дотор ганц нэг засах юмнууд байна. Тухайлбал тэр НӨАТ-ын босго 400 сая тай холбоотой бид нар тодруулж хэлэх гэсэн юм. Би ажлын хэсэгт орж ажилласан байгаа. Тэгэхээр уг нь

бол зорилго нь хэн нэгнийг хөнгөлөлт үзүүлэх гээд татварын тийм чөлөөлөлт хийх гээд байгаа зорилготой боловч шийдэл нь буруу болчихож байгаа юм аа. Шийдэл нь харин хөнгөвчлөх биш бүүр ингээд системээр нь хүндрүүлэх ийм төвөгтэй байдал руу оруулна. НӨАТ-ын татвар бол аж ахуй нэгжийн татвар болон хувь хүний орлогын албан татвараас арай өөр. Энэ ийм гинжин татвар байдаг. НӨАТ-ын татварын эцсийн төлөгч нь худалдан авагч иргэд байдаг. Харин ААН-үүд бол энэ НӨАТ-ыг анхнаас нь түүхий эдээс нь эхлүүлээд лангуун дээрээс худалдан авах хүртэл тэр дамжлага бүр дээр энэ НӨАТ-ын татварыг зөвхөн дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Дамжуулагч агентын үүрэг гүйцэтгэдэг. Гэтэл тэрэн дотроос нь дундаас нь ингээд ААН-үүдийг 400 сая төгрөг хүртэл босгож тавиад сая Ганхуяг гишүүний хэлснээр 69 мянган ААН-ээс 3-ны 1 буюу 23 мянган ААН-ийг нь НӨАТ-ын тайлан гаргадаггүй, мэдүүлэггүй, бүүр ингээд таг байхгүй болгочихоор өмнөх хойд талынх нь нөгөө дамжуулж байгаа ААН-үүд дээрээ энэ нь торгууль болж очно оо. Торгууль болж очно. Харин эцсийн худалдан авагч буюу эцсийн НӨАТ төлж байгаа иргэн дээр энэ юу ч мэдрэгдэхгүй. Тэнд хөнгөлөлт чөлөөлөлт ерөөсөө огт болохгүй. Харин ямар үр дүн гарах вэ гэхээр энэ 23 мянган ААН-үүд маань далд эдийн засаг руу ингээд бүр яах аргагүй хуулиараа ингээд бүр гулсаад орчихно. НӨАТ тайлагнах хэрэг байхгүй. Бүр эдийн засаг дээр ямар ч бүртгэлгүй болж ирнэ гэсэн үг. Ингээд татвар төлөгчийн суурь нь өөрөө ингээд алдагдаад дээрээс нь энэ ААН-үүдийгээ нэг хөнгөлөөд байгаа юм шиг мөртөө алсуур нь эд нарыгаа бүр ингээд зах зээлээс шахаж гаргах ийм юм руу явна аа. Ер нь бол НӨАТ тэр жижиг, дунд ААН-үүд дээр судалгааг нь хараад үзэхээр хувь хэмжээ гэхээсээ илүүтэйгээр энэ нөгөө тайлагналын бүртгэлийн тэр одоо механизм дээрээ их төвөгшөөдөг. Тэр нь их ААН-үүд дээрээ дарамт болж очдог. Ийм учраас эдгээрийг нь хөнгөвчлөх хялбарчлах ийм зохицуулалтуудыг бол уг нь 2 3 жилийн хугацаанд хийгдсэн байсан. Мөн ААН-үүд дээр маш олон хэлэлцүүлэг хийхэд ААН-үүдээс гарч ирсэн хамгийн өндөр санал бүх нийтээрээ НӨАТ төлөгч болъё. Энэ дундаас нь сугалдгаа бараг 50 гаран хуулиар 7, 8 мянган ААН-үүдийг ингээд дундаас нь суллаад авчихсан тэр нь буцаад бусад ААН-үүд дээрээ торгууль болж очоод байгаа дээр гомдолтой байна. Бүгдээрээ НӨАТ төлөгч болъё гэдэг ийм хүсэлт саналууд маш ихээр ирсэн байсан. Харин харамсалтай нь ингээд нөгөө нэг НӨАТ-ын хууль бүхэлдээ татагдсан учраас энэ заалтууд нь орж ирсэнгүй. Зүгээр цаашдаа энэ дахиж судлаад Засгийн газар энийгээ нөхөж намар төсөв өргөн барихдаа дагаж өргөн барих ийм боломжууд байгаа гэж ингэж харж байгаа.

Тийм учраас энэ удаадаа бол одоо 50 саяыг дахиад ямар ч бүртгэлгүйгээр НӨАТ-ын тайлагнал бүртгэл байхгүй, 400 сая болгоод энэ аягүй маш зохимжгүй ээ. Уг нь бол 50 саяыг 400 сая болгохдоо шийдэл нь НӨАТ төлдөг байна. Гэхдээ хялбаршуулснаар, 10 хувиар биш. Хялбаршуулсан тайлангаар нийт борлуулалтын орлогынхоо л зөвхөн нэг.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ тийм үү? Жавхлан дарга үг хэллээ, Их Хурлын гишүүн. Гишүүд асуулт асууж, үг хэлж байна. Жавхлан гишүүн асуултаа асууя.

Б.Жавхлан: Гантөмөр гишүүн ээ ийм юмаа.

Засгийн газраас өргөн барьж орж ирсэн дээр ажлын хэсэг ажилласан. Би ажлын хэсэгт орж ажилласан. Ажлын хэсгийнхээ шийдвэрийг дэмжиж би хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ удаа 400 болгоод өөрчлөөд хэрэггүй. 50 дээр нь байлгаж байя. Харин 400 болгохоор болвол хялбаршуулснаар арай өөр хэлбэрээр шийдэх хэрэгтэй. Хялбаршуулж НӨАТ-ын тайлангаа хялбаршуулж гаргадаг

энгийнээр биш. Тэгээд 1 хувийн татвараа төлдөг. 10 биш нэг хувиа төлдөг. Эсвэл ААН-ийнхээ 10 хувийг төлдөг, аль нь өөрт нь бага тийм, бага зардал багатайгаар тусаж байна тэрэн дээрээ сонголттой байдгаар уг нь судалгаа хийгдсэн байгаа. Тэгээд тэр хэлбэр рүүгээ явах нь зөв өө. Бидэнд хугацаа байна аа. Намар төсөв өргөн барихдаа дагуулаад энэ хувилбарыг нь өргөн барьчихвал Их Хурал дэмжээд явах бүрэн боломжтой байгаа. Мөн сая Ганзориг гишүүн асуусан. Тэр намын мөрийн хөтөлбөрт ч нийцнэ гишүүд маань бүгд энийг дэмжинэ байх. Би бүрэн итгэлтэй байна.

Ялангуяа бизнес хийж үзсэн ийм гишүүд бол.

С.Бямбацогт: Энэ чинь Татварын ерөнхий хууль ярьж байгаа араас нь бид нар НӨАТ-ын хууль ярина. ХХОАТ, ААНОАТ ярина гээд яг салбар салбарууд хуулиудаа. Энэ ерөнхийдөө Татварын ерөнхий хууль дээрээ бид нар ААН бизнес эрхэлж байгаа иргэд ААН-ээ илүү татварыг хөнгөлсөн, чөлөөлсөн, илүү дэмжсэн ийм агуулгатай хуулиуд орж ирсэн. Татвараар дарамталсан хүнд суртал тийм үү? Дарамт шахалт үзүүлсэн ийм заалтууд байхгүй ээ. Сая та бүхэн харж байгаа байх. Ер нь татвар бол зөвхөн төсөв бүрдүүлэх үүрэгтэй биш. Эдийн засгаар тэтгэх, нийгмийнхээ асуудлуудыг шийдэх, шударга ёсыг тогтоох ийм чиг үүрэгтэй. Энэ харилцааг л зөв зохицуулъя гэж байгаа юм. Хувийн хэвшлээ иргэд ААН-ээ эдийн засгийг хүндрэлтэй үед нь хэрхэн яаж дэмжих вэ? Карманд нь үлдэх хэдэн цаасыг нь яаж нэмэгдүүлэх вэ? ААН-ийнхээ бизнесийн идэвхжилийг яаж нэмэгдүүлэх вэ гэсэн агуулгаар л сая Засгийн газар энэ хуулиудыг оруулж ирсэн.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын ажлын хэсэг шуурхай хэлэлцээд эцсийн хэлэлцүүлэг хийж байна. Батлагдах байх. Сая Гантөмөр гишүүний ярьж байгаа урьд нь дансыг нь татвараа төлсөнгүй гээд татвараа төлөх боломжгүй болчихсон ААН, иргэдийг төлөхгүй байна гээд дансыг нь хаагаад ингээд улам сөхрүүлдэг, улам хүндрүүлдэг байсан бол одоо орлогынх нь 30 хувийг нь үлдээгээд тэрүүгээрээ үйл ажиллагаа тасралтгүй явуулаарай, харин 70 хувиараа татвараа төлчхөөрэй гэсэн уян хатан зохицуулалт орж ирж байгаа. Мөн татвараа хугацаанд нь төлж байгаа ААН иргэдээ дэмжсэн, урамшуулсан, бодлогууд орж ирж байгаа. Ийм юмнууд сайн заалтууд байгаа шүү. Энийг бид нар анхаарах ёстой. Одоо харин сая яригдсан нэг асуудал орхигдчихоод байна. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээрээс анхаарч байна. Ажлын хэсгийн ахлагч манай Сангийн яамныхан. Энэ олон жил ужгирсан, даамжирсан татварын маргааны асуудлууд. Петрой чайнагийн асуудал байна. Оюу Толгойн асуудал байна. Өөр гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай олон компаниуд байна. Үндэсний компаниуд гээд ярих юм бол одоо Монполимет компани. Хөрөнгө оруулалтын хуулиараа хөрөнгө оруулалт хийх юм бол татвараас хөнгөлнө чөлөөлнө гээд заачихсан. Гэтэл Татварын хуульдаа түүний эсрэг заалттай.

Хоёр хуулийн зөрчлөөс болоод хохирч байгаа олон компани ААН байгаа. Ийм ужгирсан, даамжирсан, хууль хоорондын зөрчил хийдлээс олоод ингээд тэр ААН-үүд буруутай биш төр буруутай, Их Хурал буруутай. Тэнд чинь зөрчилтэй хууль баталсан, хийдэлтэй хууль баталсан. Үүнээс болоод тэр иргэд ААН-үүд хохирч байгаа. Олон жилийн маргаан үргэлжлээд үүнээсээ болоод тэд нар буруутан болж байгаа энэ асуудлыг хэрхэн яаж шийдэх юм бэ? Энэ ерөөсөө яригдахгүй байна. Энийг та бүхэн нэг анхаараад ямар шийдэл байх юм нэг танилцуулаарай. Энэ бидний онцгой анхаарах асуудал шүү.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

11.12 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэг явуулна аа.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин танилцуулна аа. Таныг индэрт урьж байна аа.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 6 сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно оо. Нэгдсэн хуралдаанаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заасан заалтад заасныг баримтлан зарчмын зөрүүтэй нэг саналын томъёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүн Сангийн сайд Мэндсайхан болон Сангийн яам, Татварын ерөнхий газар, холбогдох албан тушаалтнууд оролцож байгаа. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандаж үнэн бодитой мэдээлэл өгөх, худал мэдээлэл өгөхгүй байхыг та бүхэнд сануулъя аа. Зочин танилцуулъя.

Ховд аймгийн Үенч сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа нутгийнхаа ах эгч нартаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

40 жилийнхээ ойг сайхан тэмдэглээрэй. Монгол Улсын алс баруун хязгаар хилийн бүсээс ирсэн байна даа. 2 мянган км-ийн алсаас.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя. Алга байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулсан энэ өөрчлөлтийг дэмжиж байгаа. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг гээд мэдээллийн технологийн салбарыг энд оруулж нээж өгч байгаа нь сайн гэж бодож байна.

Дээрээс нь Сайнзориг нарын гишүүний зарчмын зөрүүтэй саналаар олимп төрлийн спортын холбоо гэснийг олимп тивийн наадмын төрлийн спортын холбоо гээд аль алийг нь дэмжиж байгаа. Би зүгээр нэг ийм санал хэлээд цаашид анхаарахад болохгүй зүйл байгаа юу л гэж асуух гэсэн юм.

Усны нөөцийн талаар ус ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд яах ёстой вэ гэхээр усны хэрэглээний хэмнэлтэт технологи нэвтрүүлсэн ус дахин ашиглалт эргэлтийн систем хөгжүүлэх, усны алдагдлыг бууруулах гэсэн энэ тал дээр анхаарах хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр экологийн сэдвийг энэ усны сэдвийг энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн энэ заалтап ер нь цаашид оруулах боломж байгаа юу? Байгаль экологи энэ ус гэдэг л сэдэв нь алдагдчихаад байгаа юм л даа. Оруулахгүй байгаа юм л даа. Бусад нь бол байна. Одоо мэдээллийн технологийн салбарыг оруулж өгч нээж өгч дэмжиж байгаа юм байна. Тэгэхээр энэ байгаль экологи усны талын сэдвийг оруулж өгөх боломж ер нь байдаг уу? Хэрвээ энэ асуудлыг гаргаж ирвэл дэмжих үү л гэж асууя даа. Одоо бол санал оруулах нь нэгэнт оройтсон болохоор. Нөгөө нэг хувийн татвар л яриад байгаа шүү дээ би.

С.Бямбацогт: Ажлын хэсгийнхэн хариулъя. Эцсийн хэлэлцүүлэг явж байгаа боломжтой юу? Боломжгүй юу? Цаашид ямар шийдэл байж болох вэ? Ганхуяг гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Х.Ганхуяг: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 22.9.1-д ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, орчны бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах гэсэн байдлаар орсон байдаг юм. Тэгээд яг энэ дагаж мөрдөх журам нь бол одоо Байгаль орчны яамнаас гаргадаг байгаа. Тэгээд Байгаль орчны яамнаас яг тэр таны ярьж байгаа усны тарифтай холбоотой асуудал дээр журамдаа оруулах шаардлагатай. Ер нь бол бид нар усаа хамгаалах, усны орчноо хамгаалах, тэр байгаль орчны чиглэлээр авах нийгмийн хариуцлагын ажлуудыг аль болох сайн дэмжиж өгөх хэрэгтэй. Тэгэхгүй бол одоо тэр чинь дандаа л нөгөө төсвөөс мөнгө нь гарч байгаа байхгүй юу. Уг нь бол одоо болж өгвөл ингээд компаниуд, ААН-үүд нийгмийн хариуцлагын хүрээнд тэр асуудлуудаа шийдээд явдаг байх нь уг нь зөв байхгүй юу. Анх 22.9-ийг ер нь санаачилсан шалтгаан нь ч тэр шүү дээ. Ингээд дандаа нэг бол улс төрчид очиж попордог. Ингээд явдгийн оронд тэр компаниуд нь орон нутгийн компаниуд нь энэ хотын компаниуд нь өөрсдөө энэ нийгмийн хариуцлагын хүрээнд энэ ажлуудаа хийдэг байг ээ. Нутагтаа очоод нутгийнх нь тэр байгаль орчны нөхөн сэргээлт хийдэг байг, залуучуудаа дэмждэг байг. Сургалтын тэтгэлэг олгог. Энэ санаачилга энэ хууль анх батлагдсан шүү дээ.

Тэгээд хэрэгжилт тал дээрээ бол жоохон анхаарах ёстой. Энэ дээр одоо тухайн тухайн яамдуудын журмаар зохицуулж байгаа болохоор яамдуудаас гарч байгаа журам дээр жоохон анхаарал хандуулах хэрэгтэй. Тэгээд энэ Байгаль орчны яамнаас та журмыг нь аваад үзэх хэрэгтэй юм болов уу гэж бодож байна.

С.Бямбацогт: Тодруулах уу? Тодруулчихъя. Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: 22.9 дээр сая Ганхуяг гишүүний ярьсан дээр Байгаль орчны сайдаас хариулт авъя.

С.Бямбацогт: Нөгөө та Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтөөс устай холбоотой асуудал дээр хөрөнгө оруулалт хийвэл ААН-үүдэд тийшээ хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж хөнгөлөлт эдлүүлэх үү л гэж байна. Журамдаа тийм зохицуулалт хийх боломж байна уу гэж.

Сандаг-Очир сайд хариулъя.

Ц.Сандаг-Очир: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

Бид бүхэн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийг хэлэлцээд явж байгаа. Маргааш эхний хэлэлцүүлгээ хийх гэж байгаа. Энэн дээр бид нар ер нь бол энэ байгаль орчинтой холбоотой ой, ус, ан амьтан ургамалтай холбоотой энэ асуудлууд дээр ер нь ААН байгууллагуудыг байгаль орчинд ээлтэй хамгаалсан үйл ажиллагаа явуулбал тэнд нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын нэг хувиас нь хөнгөлөлт үзүүлэх энэ асуудлыг бол бид нар энэ хуулиараа суурийг тавьж өгч байгаа. Тэгээд одоогоор бид нар энэ хууль байгаа боловч яг хэрэгжилт дээрээ дорвитой хэрэгжсэн юм алга байна. Тэгэхээр цаашдаа бол хэдүүлээ та ч гэсэн усан дээр ажиллаж байгаа усны хууль дээр. Энэ хуулиудаа нэгтгээд ер нь цаашдаа байгаль орчныг хамгаалсан хайрласан ийм үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд нэг хувийн хөнгөлөлт үзүүлдэг байх асуудлыг аль аль талаасаа яриад явъя. Бид манай яам ч гэсэн журам талаасаа харж өөрчлөлт оруулах, манай яамнаас

хамааралтай юу байна, Татварын холбогдох хуулиуд дээр юу байна гэдэг талаасаа хамтарч ажиллая аа.

С.Бямбацогт: Яг энэ асуудал дээр би хэдэн үг хэлчихье.

2024 оны 8 сард бид нар боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, байгаль орчин, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд энэ чиглэлээр нийгмийн чиг хариуцлагын хүрээнд хийсэн бүтээн байгуулалтын юм уу дэмжлэг тусалцаанд ААН-үүдийн татварын нэг хувийн хөнгөлөлт үзүүлэх хууль баталсан. 2024 оны 8 сард. Одоо бараг 2 жил болох гэж байна. Гэтэл Улсын Их Хурлын баталсан хууль хэрэгжихгүй байна, дургүйд хүчгүй хандаж байна Засгийн газар. Энийг би 14 хоногийн өмнө байх аа Волейболын холбооны удирдлагуудтай тамирчидтай уулзаад ярьж байхад та нарын баталсан хууль чинь амьдрал дээр хэрэгжихгүй байна аа. Сагсны лигт, волейболын лигт оролцож байгаа тамирчид өнөөдрийг хүртэл тэр баг тамирчид урамшууллаа авч чадахгүй компаниуд нь зардлаа гаргачхаад хөнгөлөлтөө эдэлж чадахгүй байна гэж байгаа юм.

Ийм байдлаар ингээд хаана асуудал байна гээд судлаад шалгаад үзэхээр холбогдох яамдууд соёл спорттой холбоотой соёл спорт, Аялал, жуулчлалын яам, байгаль орчинтой бол Байгаль орчны яам, эрүүл мэндтэй холбоотой бол Эрүүл мэндийн яам, боловсролтой холбоотой бол Боловсролын яамныхан журмаа Татварын ерөнхий газартай нь нийцүүлж, Сангийн яамтайгаа нийцүүлж баталдаггүй. Тэгээд л төрийн байгууллагууд хоорондоо энэ чинь болж байна, энэ чинь болохгүй байна гээд л шалтаг заагаад удаасаар байгаад үндсэндээ 2 жил энэ хууль хэрэгжээгүй байна. Үүнийг би 14 хоногийн өмнө чуулганы хуралдаанд сануулсан шүү дээ. Энийгээ шийд гэж. Одоогийн байдлаар 300-аад ААН 100 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдлэх гээд хүлээгдэж байна аа.

Сангийн яам, Татварын ерөнхий газар энэ асуудлыг ойрын үед шийднэ шүү. Энийг ингэж удаашруулж болохгүй. Яагаад хууль хэрэгжихгүй байгаа юм. Энэ асуудлыг ойрын үед чи шийднэ шүү. Ийм байдалтай байж болохгүй шүү.

Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлын даргатай санал нэг. Хууль гаргачхаад хэрэгжүүлдэггүй юм байна лээ л дээ. Жишээ нь Малчны тухай хуульд малчин айлын хүүхдийг тэтгэлэгтэй сургуульд сургана гэдэг хууль сайхан хууль батлагдсан. Тэрэн дээр дагаж мөрдөх журам нь Боловсролын яамнаас гарахаараа малын эмчийг нь хасаад хаячихсан. Малчин айлын хүүхдүүдээс малын эмчээр сурах боломжгүй ийм журам гаргаж байгаа байхгүй юу. Энд ер нь яаж хариуцлага тооцох ёстой юм бол оо? Энэ огт хэрэгждэггүй хуулийн заалтууд дээр дээрээс нь энэ журмыг тийм сэтгэлгүй гаргаж байгаа тохиолдолд яаж хариуцлага тооцож яадаг юм бол оо. Ийм хууль аягүй олон байгаа. Малчны тухай хууль дээр маш олон заалтууд ерөөсөө хэрэгждэггүй м байна лээ. Одоо жишээ нь энэ юун дээр хэрэгждэггүй юм байна шүү дээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль дээр байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд ямар нэгэн нийгмийн хариуцлагын хүрээнд ажил хийхэд нэг хувийн татвараас чөлөөлөгддөггүй юм байна шүү дээ.

С.Бямбацогт: Хуулийн хэрэгжилтэд Улсын Их Хуралд хяналт тавих үүрэгтэй. Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх бол хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулийн

хэрэгжилтийн үнэлгээнд 5 жил тутамдаа үр дагаврын үнэлгээ хийж хэрэгжихгүй хуулиудыг хэрэгждэг болгох, хүчингүй болгосныг хүчингүй болгох, хэрэгжүүлэхгүй байгаа бол холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох ийм зохицуулалтууд байгаа. Тэгээд энэний механизм нь бол асуулт тавих, асуулга тавих, хяналтын сонсгол хийх, хянан шалгах түр хороо хийх үе шатууд байгаа. Энэ дээр манай Тамгын газар энэ дээр жаахан онцгой анхааръя аа. Хишигсүрэн дарга иймэрхүү хэрэгжихгүй хуулиудыг яаж хэрэгжүүлэх тал дээр та бүхэн нэг шийдэл энэ чуулганы завсарлагаар танилцуулна шүү. Энэ 6 дугаар сардаа багтаагаад Тамгын газарт чиглэл өгчихлөө шүү.

Зочин танилцуулъя.

Ховд аймгийн Булган, Алтай сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа.

Төрийн ордонтой танилцаж байгаа төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Манай нутгийн гишүүд энүүгээр байна. Пүрэвдорж дарга, Мэндсайхан сайд, Батнайрамдал гишүүн сая байсан, Сайнзориг гишүүн гэсэн хүмүүс байна аа. Мэндбаярын Мандухай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг явж байна. Би энэтэй холбоотойгоор нэг зүйл асууя аа. Монгол Улсад жилдээ 1.8 сая даатгалын гэрээг даатгуулагч иргэн ААН байгууллагууд бол одоо хийдэг. Одоо энэ даатгуулагчид байна аа. Үүний 338 мянга нь ААНБ даатгуулагч ААН байгууллагууд байгаа. Ингээд энэ нөхцөл байдлыг харах юм бол Монголд үйл ажиллагаа явуулж байгаа ААН байгууллагууд аливаа эрсдэлийг үндсэндээ өөрөөрөө даван туулж явж байгаа гэсэн үг.

Тэгэхээр энэ ийм байгаа учраас өнөөдөр Монгол Улсын энэ даатгалын тогтолцоо энэ хөгжиж байгаа орнуудтай харьцуулахад 5 дахин бага байгаад байгаа юм. Одоо энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйл дээр бусад орлогын зохицуулалт байгаа. Бусад орлогын талаарх татварын зохицуулалт байгаа. Үүний 11.1.6 дээр даатгалын нөхөн төлбөрт татвар ноогдуулсан зохицуулалт байгаа. Тэгэхээр энэ зохицуулалтаар хэдэн энэ компаниас ямар хэмжээний орлогыг бүрдүүлсэн бэ гэдэг асуултыг тавья.

Хоёрдугаарт одоо энэ даатгал бол эрсдэлээ хамгаалж чадахгүй байгаагаас үүдэж байгаа. Ялангуяа энэ маш олон бизнес ЖДҮ-лэл эрхлэгч иргэд хохирч байгаа маш олон кэйсүүд байгаа. Жил ирэх тусам энэ шүүх дээр даатгалтай холбоотой кэйсүүд нэмэгдэж байгаа. Тэгэхээр энэ худалдааны төвүүд шатсан нөгөө ачаа тээврийн машинууд шатсан, үер усанд агуулах саваа алдсан гээд маш олон иргэн ААН-үүдийн энэ сургамж бид нарт байгаа.

Тэгэхээр энэ даатгал одоо энэ эрсдэл хамгаалах чадамжийг үндэсний хэмжээнд өсгөх, нэмэгдүүлэх бодлого ер нь энэ Засгийн газрын түвшинд энэ хуулийн төсөлд яагаад багтаагүй вэ гэдэг асуултыг эхлээд асуучхаад тэгээд тодруулга явъя аа.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн дарга хариулъя.

Х.Ганхуяг: Ер нь Гамшгийн даатгалын хууль Сангийн яаман дээр болон ОБЕГ-тай хамтраад энэ гамшгийн даатгалын хуулийг санаачлаад явж байсан. Тэгээд одоогийн байдлаар өргөн баригдаагүй байна аа. Ер нь Гамшгийн даатгалын хуулийг бид нар шийдсэнээр энэ төсвөөс энэ хохирогч нарт мөнгө өгдөг асуудлыг бүгдийг нь шийдэх боломжтой юм байна лээ. Тэгэхгүй бол одоо жишээлбэл манайх чинь ер нь гол асуудал маань ер нь авлигал болчихоод байна шүү дээ. Дунд шатын дээд шатны. Тэгээд тэрнээсээ болоод энэ барилгуудыг нөгөө сайн материалаар нь барьдаггүй, галд тэсвэргүй материалаар барьдаг, комисс нь тэгээд тэрийг нь хүлээж авдаг тэрнээсээ болоод гал гардаг, стандарт бус зүйлүүд хэрэглэдэг. Энэ асуудлуудыг ер нь Гамшгийн даатгалын хуулиар шийдэх боломжтой юм билээ. Тэгж байж энэ даатгалын компани тэр комиссын бүрэлдэхүүнд нь ордог юм уу, яадаг юм, тэгээд нөгөө даатгалаа хийх, хийхгүй гэдгээрээ үнэлгээгээ хийдэг. Ингээд тодорхой хэмжээний энэ төсөв дээр гарах зардлуудыг ч гэсэн хэмнээд явах боломжтой. Тэгээд эргээгээд бас бид нар энэ янз янзын гал үер эд нарт автагдах асуудлуудыг төсвөөс гарах мөнгөнүүдийг хэмнэх, иргэдийн амьжиргааг, хөрөнгийг хамгаалах боломжууд нэмэгдэх юм байна лээ. Тэгээд энэ хэзээ өргөн барих нь бол яг шууд хэлж мэдэхгүй байна аа. Уг нь хуулийн төсөл нь бараг бэлэн болчихсон шахуу л байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн яам хариулъя.

4 номерын микрофон дээр. Сангийн яамнаас хүн байна уу? Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Энэ ААНОАТ дээр 11.1.6 дээр ерөөсөө энэ даатгалын нөхөн төлбөр, татвар ноогдуулаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ААНБ өөрийнхөө эрсдэлийг хамгаалахын төлөө шимтгэл төлж байгаа даатгагч байгууллага.

Үгүй тэрнийх нь төлөө эрсдэл үүслээ гэхэд даатгагч компаниас нөхөн төлбөр орж ирэхэд нь тухайн компаниас буюу даатгуулагчаас татвар ноогдуулаад байгаа юм аа. Үгүй тэгээд бид нар ингээд байхаар чинь яаж энэ даатгалын салбар дорвитой хөгжих юм бэ? Өнөөдөр хөгжсөн улс оронд бид нар 5 дахин энэ даатгалын салбар чинь уначихсан байна, сул байна. Тэгээд би эндээс тодорхой асуулт асуугаад байгаа шүү дээ. Энэ татварыг ноогдуулснаар хэдэн компаниас хэдэн төгрөгийн орлого өнөөдрийн байдлаар бүрдүүлчхээд байгаа юм бэ гэдгийг асуугаад байгаа юм аа. Эхлээд би хариултаа авчхаад тэгээд тодруулъя тэгэх үү?

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах юм? Энэ дээр татварын газраас хүн байгаа юм уу? 4 номер дээр.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар, Цогтнаран Мандухай гишүүний асуултад хариулъя.

2025 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар татвар төлөгчдөөс ирүүлсэн статистик тоон мэдээлэл дээр үндэслэхэд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11.1.6-д заасан даатгалын нөхөн төлбөрөөр 41 ААН, 18.9 тэрбум төгрөгийн төлбөр авсан гэж тайлан ирүүлсэн. 18.9 тэрбум

төгрөгийн нөхөн төлбөрт татвар ноогдуулж төлүүлсэн гэдэг ийм статистик мэдээ байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр энэ засаг ийм нөхцөл байдлыг засах, сайжруулах, энэ салбарын хөгжлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх байтал эсрэгээрээ энэ ААН-үүдээс ийм даатгалын нөхөн төлбөр олоод тухайн жилдээ өөрөө орж байгаа энэ татварын чинь орлого нь өөрөө хангалтгүй. Энэ өөрөө маш буруу татвар байгаад байхгүй юу. Тэгээд энэ ядаж энэ дэмжихгүй юм гэхэд энэ татварыг болимоор байна. Энэ засгаас оруулж ирж байгаа энэ хууль дээр энэ даатгалын энэ нөхөн төлбөрийг болимоор байна. Үгүй даатгуулаад эрсдэлээ хамгаалахын төлөө бид нар явдаг байтал эндээс нь татвар ноогдуулдаг тогтолцоо өөрөө хамгийн буруу тогтолцоо байгаа юм аа. Тэгэхээр бид нар энэ 30, 40 ААН-үүд даатгалын нөхөн төлбөр авахдаа энэ татварыг төлж нөхөн төлбөрөө бүрэн авч угаасаа чадахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ байдал нь өөрөө даатгалын энэ эрсдэл хамгаалах үндэсний чадамжийг өөрөө бууруулахаас гадна энэ ач холбогдлыг нь.

Ж.Бат-Эрдэнэ: Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Тэгэхээр энэ хууль санаачлагч яг тэр асуудлыг нөгөө хөндөж орж ирээгүй байгаа болохоор нөгөө ажлын хэсгийн хүрээнд болон Байнгын хорооны хэмжээнд энэ асуудал хөндөх боломжгүй байгаа яг өнөөдрийн барьсан байгаа хуулийн төслөөр бол.

Тэгэхээр энэ асуудлыг яах вэ чиглэл болгоод бид нар оруулж болно. Одоо нөгөө энэ хууль батлагдсантай холбоотойгоор Их Хурлын тогтоолд оруулъя ч гэдэг юм уу. Тэгээд тэрэн дээр та санал байвал гаргана биз. Тэгээд өнөөдрийн өргөн барьсан хуулийн хэмжээнд энэ асуудал хөндөгдөөгүй болохоор ажлын хэсгээс болон Байнгын хороон дээр ямар нэгэн өөрчлөлт оруулах боломж алга байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байна уу? Өнгөрсөн удаагийн чуулганы үеэр яг энэ хуультай холбоотой би нэг асуулт асуусан. Жилд дунджаар яг хэдэн хуулийн этгээдийн дансыг хааж үл маргах журмаар татварын орлогоос суутган авсан тоогоо гаргаач гэж асуусан. Тэгээд тэр нөгөө дансаа хаалгасан буюу нэг талдаа зарим нь дампуурсан ч юм уу асуудалтай ААН-үүдийн цаана ямар нийгэм хүн ам зүйн асуудал байсан юм болов уу? Тэр талаар ер нь та хэд судалсан уу гэж асуусан. Дараа нь яг нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэмшигч эцсийн өмчлөгч нь байхаар ААН ер нь хэр байсан бэ гэдэг ийм нийгэм, хүн ам зүйн шалтгааныг нь асуусан юм л даа. Тэгээд тэрэн дээр та хэд маань мэдээллээ бэлдэж ирсэн байх гэж найдаж байна. Тэр мэдээллийг авах гэсэн юм.

Дараа нь хуулийн төсөл дээр ингэж байгаа юм л даа. Энэ хуулийн төсөлд зааснаар татварын өрийг гаргуулсны дараа татвар төлөгчийн банкн дахь дансанд ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах татварын өрийн хэмжээ нь тухайн орлого нь 80 хувиас хэтрэхгүй байна гэж заасан байгаа. Энэ 80

хувь гэдэг тоо яаж гарч ирсэн юм бэ гэдэг тооцооллыг нь гаргаад өгөөч. Энэ 80 хувийн ард ямар тооцоолол байгаа бол гэдэг мэдээлэл авъя.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номер хариулъя. Та хэд энэ асуултуудаа асууж тэмдэглэж авч байгаа юм уу? Ер нь асуулт асуухаар тэгээд л хоорондоо яриад л хэн нь хариулах вэ л гээд байх юм.

Б.Цогтнاران: Татварын Ерөнхий газар Цогтнاران. Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үүсгэн байгуулсан хуулийн этгээдүүдийн талаарх мэдээллийг тодруулж асуусан. Энэ мэдээллүүдийг бид нар УБЕГ болон нийгмийн даатгалын байгууллагуудаас холбогдох мэдээллүүдийг аваад, албан бичгээр танд хүргүүлсэн байгаа. Одоо яг танд чуулганы хуралдаан дээр танилцуулахад бол 2025 оны жилийн эцсээр татварын албанд бүртгэлтэй 241 мянган хуулийн этгээд байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний үүсгэн байгуулсан аливаа хэлбэрээр хувьцаа эзэмшиж байгаа 13329 хуулийн этгээд байна аа. 13229 хуулийн этгээдийг дотор нь хувь эзэмшлээр нь ангилж үзвэл өөрөөр хэлбэл 50 хүртэл хувийн хувьцаа эзэмшдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэн 50 хүртэл хувийг нь эзэмшдэг хуулийн этгээд 7717, 50-аас дээш хувийг нь хувьцааг эзэмшдэг хуулийн этгээд 5612 гэсэн ийм статистик тоон мэдээ байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Наранцэцэгийн Алтаншагай.

Н.Алтаншагай: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе ээ.

Татвар төлөгчдийн ачааллыг бууруулахад чиглэсэн хуулийн төслийг дэмжиж байгаа. Төсөлтэй холбоотойгоор нэг дараах хэдэн тодруулах зүйлүүд байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ жижиг дунд бизнесүүдэд ямар өөрчлөлт дэмжлэг олгохоор тусгасан байгаа вэ?

Жижиг дунд бизнесүүд мэдээлэл дутмаг байдлаасаа шалтгаалан зарим хуульд заасан хөнгөлөлтүүдээ эдэлж чадахгүй, авч чадахгүй ийм нөхцөл байдал үүсдэг. Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт шинэчлэлтийн талаар сургалт сурталчилгаа хийж ААН-үүдэд мэдээлэл хүргэх шаардлагатай байгаа шүү гэдгийг захиж хэлье. Энэ жижиг дунд бизнесийн татварын ачаалал яг ямар байгаа вэ гэж үзэж байгаа юм. Ачаалал ямар байгаа гэж үзэж байгаа вэ? Энэ хуулийн үзэл баримтлал дээр байгаа нэг зүйлийг тодруулъя.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай татварын тайлан тушаах төсөв төлөх хугацааг хойшлуулна гэж байгаа юм. Ингэснээрээ энэ яг ямар үр дүн авчрах юм бэ?

Хууль шинэчлэгдээд сайжраад л явах ёстой. Хэт нөгөө нэг таалагдах гэдэг юм уу энэ өнцгөөсөө энэ яг стандарт энэ мөрдөгдөж байгаа хуулиудаа ийм өөрчлөлт ухралт орох вий дээ л гэж бодож байгаа.

Дээр нь энэ ААН-ийн данс хаадаг байдлыг хэрхэн зохицуулах юм. Бүгд л ярьж байх шиг байна. Түрүүн бас Гантөмөр гишүүн асууж байна лээ. Татварын байгууллага энэ татвар төлөгчдийг айлгах, шалгах, хорих, цагдах энэ арга барилаас ер нь маш том ухралт хийх хэрэгтэй. Ухралт хийх ёстой. Татвар төлөгч иргэн ААН-

үүдэд татварын албаны үйлчилгээний харилцаа хандлагад өөрчлөлт гарахыг ААН-үүд хувь хүмүүс шаардаж, хүсэж хүлээлт байгаа шүү. Нэг л өдөр өглөө босож ирээд л нээлээ гээд л унадаг, нэг болохоор бүгдийг нь хаалаа л гэдэг. Энэ дээр яг бодлогын ямар өөрчлөлт орж байгаа вэ?

Ж.Бат-Эрдэнэ: Зочид танилцуулаадахъя.

Ховд аймгийн Дарви сумын ЕБС-ийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс ажлын амжилт амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Наранбаатар гишүүн хариулъя. Наранбаатар гишүүний микрофон. Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: ЖДҮ эрхлэгчийн нөгөө хуультай нь уялдуулах байдлаар нэг хувийн татварыг 2.5 тэрбум борлуулалтын орлоготой ААН дээр нэг хувийн татвар ноогдуулахаар нэмэлт, өөрчлөлт орж байгаа энэ хуулиар. Мөн одоо НӨАТ-ыг төлөх хугацааг 2 сар хүртэлх хугацаагаар хойшлуулах боломжийг мөн олгож байгаа.

Гуравдугаарт дансыг нь хаадаг, битүүмжилдэг тэр нөгөө хоцрогдсон аргаас салах байдлаар энэ бүүр хуульчилж байгаа юм. Данс хаахгүй зүгээр тэр татварынхаа өр байвал татварынхаа өөрийнх нь анх хууль санаачлагчдаас 80 хувь гэж орж ирсэн, ажлын хэсгээс 70 хувь болгосон байгаа. Нэг ёсондоо дансан дээр орж ирж байгаа мөнгөнөөс нь 70 хувийг нь суутгадаг, 30 хувийг нь компанийн хэвийн үйл ажиллагааг явуулах, ажилчдынх нь цалинг өгөх боломжийг нь олгох үүднээс нэг ёсондоо дансыг нь хаахгүй, итгэмжлэхгүй, 70, 30-ийн харьцаатайгаар суутгах байдлаар явуулж байгаа.

Тайлан төлөх хугацааг тодорхой хэмжээгээр хойшлуулж өгч байгаа. Энэ бол сарын сүүлд байсныг нь дараа сарынхаа дараа сарынхаа 5 болгохоор явуулж байна гэсэн үг. ЖДҮ эрхлэгчийн татварын ачаалал нэг үндсэндээ 5 хувьтай байдаг юм байна. ЖДҮ-ийн хөнгөлөлтийг 2025 онд ашигтай ажилласан уг хөнгөлөлтийг эдэлсэн 4700 компани байна аа. Эндээс бол нийтдээ нэг хувийн татварт хамаарагдаж 84 тэрбум төгрөгийн татварын буцаалтыг авсан байдаг.

Тэгэхээр энэ тоо бол улам цаашдаа нэмэгдэнэ гэсэн үг. Тэгээд энэ чинь бол одоо зөвхөн 1 тэрбум борлуулалтын орлого дээр нэг хувь байсан бол одоо тэр 1.5 тэрбум дээр нэг хувь байсан одоо 2.5 дээр нэг хувь болж байгаа гэсэн үг. Тэгэхээр үндсэндээ компаниудыг томруулах боломжуудыг нь нээж байна гэсэн үг. Дансыг нь хаадаг битүүмжлэлийг нь болиулж байна гэсэн үг. Тэр алданги тооцдог байсан асуудлыг нь хязгаартай болгож байгаа гэх мэтчилэн байдлаар бид нар энэ татварын ачааллууд нэлээн бууруулж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Баярлалаа. Энэ хууль батлагдсанаар 2027 оны 1 сарын 1-ээс гэж байгаа юм. Энгийг хэрэгжих хугацааг наашлуулах боломж бий юу? ААН-үүд маань бол одоо яг жинхэнэ бор зүрхээрээ явж байгаа.

Дээр нь ажлын байрыг нэмэгдүүлж маш том хүнд ачааг үүрч яваа энэ хэсэг тэгэхээр энэ татварын багц хуулийг шинэчлэгдэхийг хүлээж саналуудаа илэрхийлж явж байсан ийм нөхцөл байдал ч үүссэн. Үүнтэй холбоотойгоор энэ багц хуулиуд шинэчлэгдээд явж байгаа гэж ойлгож болно. Тэгэхээр энэ хэрэгжих хугацааг нь наашлуулах тал дээр мөн энэ ААН-үүдээ яг энэ бодит дэмжлэг үзүүлэх энэ хууль орж ирж Засгийн газраас өргөн баригдаж байгаад одоо гишүүний хувьд талархалтай байгаа юм. Энэ хугацааг наашлуулах тал дээр нэг бодолцож үзээч гэж.

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Төсвийн жил үргэлжилж байгаа болохоор бид нар нөгөө төсвийн орлого бууруулах энэ хуулийг батлах боломж байдаггүй. Тийм учраас яг энэ нөгөө төсвийн орлого талдаа нөлөөлж байгаа, зарлага талдаа нөлөөлж байгаа асуудлуудыг бид нар дараа жилийн төсөв дээр тавьж тусгуулах шаардлага үүсдэг. Саяын ярьж байгаа тэр татварыг хаахгүй байх нөгөө битүүмжлэхгүй байх зохицуулалтыг бол баталсан өдрөөсөө хойш бид нар дагаад мөрдөөд явна. Хувь хүний орлогын албан татварын шаталсныг бид нар шат дараатайгаар 2027 оны 1 сарын 1-ээс зарим хэсгийг нь, зарим хэсэг нь 2028 оны 1 сарын 1-ээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хөнгөлөлтүүдийг шууд 2027 оны 1 сарын 1-ээс гэх мэтчилэн байдлаар хэрэгжүүлж явна аа. Тэгээд сарын 1-ээс хуулийн хэрэгжилтийг хангахын тулд бэлтгэл ажлуудыг явуулах шаардлагатай. Мөн Засгийн газар ирэх жилийн төсвөө өргөн барихдаа энэ саяын хөнгөлөлтүүдийг төсөлд суулгаж.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг 17 цагт явуулна аа.

11.50 цаг

Дараагийн асуудалд оръё.

Гурав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл эцсийн хэлэлцүүлэг.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг гишүүн танилцуулна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хуулийн нэгдсэн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хуулийн нэгдсэн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Хуулийн нэгдсэн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно оо.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасныг баримтлан санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийг 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлага гэж үзсэн тул 2 саналын томьёоллоор санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн нэгдсэн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгдсэн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг, бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын газрын даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн дарга. Ажлын хэсгийнхэн жоохон анхааралтай байгаарай гишүүдийн асуусан асуултыг тэмдэглэж байгаад хариулахад бэлдэж сууна шүү.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Асуултыг өгсөн байна. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

Х.Тэмүүжин: Хувь хүний орлогын татвартай холбоотой асуудлаар Баярмаа гишүүний санаачилсан хууль, Засгийн газрын гишүүний санаачилсан хууль, Засгийн газрын зүгээс санаачилсан хууль хоорондоо нэлээн зарчмын зөрүүтэй байсан. Тэгээд энэ зарчмын зөрүүтэй асуудлуудаа шийдээд орж дундын хувилбар байдлаар орж ирж байх шиг байна лээ. Гэхдээ энд 2 үгийг хэлмээр санагдаад байгаа юм.

Ер нь бид нэг философи үзэл санааныхаа нэг таагүй хуучинсаг хандлагаасаа салах хэрэгтэй юм байна гэж харагдаад байгаа юм. Иргэд хөдөлмөрлөөд иргэд авьяасаа, цаг хугацаагаа, амьдралд, хувийнхаа аз жаргалыг зарим хэсгийг нь золиослоод бизнес хийгээд орлого олж байгаа энэ үед тэр орлогын дийлэнхийг нь

иргэдийнхээ халаасанд үлдээж сурах ёстой гэдэг энэ нэг төрийн бодлого иргэндээ ээлтэй төрийн бодлого шүү дээ. Олсон бүх юмнаас нь яаж ийгээд л татаж аваадахъя өөртөө нэг хөөө цуглуулж байгаа юм шиг төсөв дээр цуглуулаад аваадахъя тэрүүгээрээ иргэдээс илүү ухаалаг юмыг шийдэж чадна гэж боддог, иргэдээсээ өөрсдийгөө ухаантай гэж эндүүрдэг албан тушаалтнуудын хандлага бол яг үндсэндээ иргэдээ ядуу, төрөө авлигатай л болгож хувиргаж байгаа.

Тийм учраас нэг зарчим төрд сул зарах мөнгө бага байна гэдэг чинь тэнд авлига үүсэхгүй л гэдэг логиктой. Иргэнд өөрөө өөртөө зарах мөнгө байна гэдэг чинь тэнд бизнес рүүгээ хөрөнгө оруулалт хийж болно, үр хүүхэд рүүгээ хөрөнгө оруулалт хийж болно, өөрийнхөө аз жаргалыг бүтээж болно гэдэг логиктой. Аль болох иргэддээ боломжийг нь үлдээж, аль болох албан тушаалтнуудад ажлыг нь хариуцлагыг нь үлдээж сурах гэдэг бол Монголын төрд их дутагдаж байгаа бодол санаа шүү. Ер нь болж өгвөл уул уурхайгаас бусад бизнес дээр иргэддээ бизнесийг нь хөнгөвчлөх орлогыг нь хувьд нь үлдээх тэр олсон мөнгөө өөрөө юунд зарах вэ гэдэг эрх чөлөөг нь гэр оронд нь, үр хүүхэдтэй нь, хамгийн хайртай тэр хүмүүстэй нь цуг үлдээх гэдэг бол төр өөрөө зөв байгаагийн нэг хэмжүүр гэдгийг бид бүгдээрээ бид ойлгоод аваасай гэж хүсэж байгаа юм.

Бид Хувь хүний орлогын албан татварыг нэг хувь гэж уул нь тэр бодлогоо боломжийн хэмжээгээр өргөтгөөд дэмжсэн бол зөв байсан. НӨАТ-ыг 5 хувь болговол уул нь зөв шүү дээ. 10 хувь болгож аваад буцаагаад тэдэн хувийг нь чамд өгнө. Тэгээд чи дунд нь сугалаа аваад өөрийнхөө мөнгөнөөс азтан болоод авч байвал бас чиний хувь заяа гэх мэтчилэн яг энэ бодлого чинь бол иргэнийг доромжилж байгаа доромжлол шүү дээ. Тэрний оронд НӨАТ-аа 5 болгоод буцааж өгөх хувиа 2 хэвээр нь байлгаад тэр НӨАТ-ын 5 хувь төрд биш иргэнд үлдэхээр иргэн дахиад л бизнес рүүгээ хөрөнгө оруулалт хийнэ шүү дээ. Ажлын байраа дахиад л нэмнэ шүү дээ. Үр хүүхдээ арай гайгүй боловсролтой болгох гэж оролдоно шүү дээ. Өөрийнхөө амьдарч байгаа орон сууцыг арай жоохон чанартай болгоод амьдралын чанараа чанараа дээшлүүлэх гэж бодно.

Тийм учраас бид аль нам байгаагаас үл шалтгаалаад Монгол Улсад уул уурхай байгаа нэг ийм байгалийн нөөц байгаа. Энэ нөөц дээр түшиглээд бусад эдийн засаг бизнесээ солонгоруулъя гэж бодох юм бол энэ чиглэлээс бусад салбарыг аль болох бизнесийг нь хөнгөвчилж, эрх чөлөө олгож, тийшээгээ хөрөнгө оруулалт хийх боломжийг нь нэмэгдүүлж тэнд ажлын байр бий болгох санаачилгуудыг нь урамшуулж.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ.

Пүрэвжавын Сайнзориг алга байна. Одсүрэнгийн. Номинчимэг гишүүн алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Чинбатын Ундрам гишүүн алга байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн алга байна. Гишүүд энэ асуулт асууна гэж нэрсээ өгчхөөд асуултаа асуух хэрэгтэй шүү. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан алга байна. Цаана чинь үг хэлье гэсэн гишүүд нэлээн байдаг шүү дээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Аан за уучлаарай ёстой уучлаарай. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Бид нар Хувь хүний орлогын албан татварыг нийтээрээ бүгдээрээ нэг хувь болохыг дэмжиж алга ташиж байгаад энэ хуулийг баталж байх шиг байна. Гэхдээ татварын бодлого гэдгийг бид нар аягүй сайн эргэж нэг хармаар

байна. Ер нь татварын бодлогын зорилго нь юу юм бэ? Төсөв бүрдүүлэхээс гадна нэг том зорилго байгаа. Энэ юу вэ гэвэл шударга ёсны татвар өөрөө шударга ёсны зарчмыг хангах төрийн нэг бодлого байх ёстой. Татвар өөрөө шударга ёсны илэрхийлэл байх ёстой. Татвар өөрөө айл өрх бүрийн хаалгаар орж байгаа тэр орлогод нь, зардалд нь, тэр өрхийн дэмжлэг байх ёстой. Энэ үүднээсээ нэг хувь бол хүн болгонд таалагдаж байж магадгүй. Гэхдээ яг төрийн түшээдийн зүгээс бодлого тодорхойлогчдын зүгээс ийм залхуу аргыг бид нар хэрэглэмээргүй байгаа юм. Ийм залхуу аргыг хэрэглэмээргүй. Энэ татварын чинь цаана дахиад тэгш бус байдал явах вий дээ. Орлого өндөртэй хүмүүсийн хувьд дахиад энэ шударга бус асуудал үүсэх вий дээ. Бид нарын энэ татварын бодлогын цаана байгаа олон хүүхэдтэй өрхийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй хүнээ асарч байгаа ээж аавын асуудал, хүүхдээ асарч байгаа ээжийн асуудал өндөр настай ээжийгээ аавыгаа асарж байгаа ийм өрхүүдийг бид нар яаж татварын бодлогоор дэмжих вэ? Ялангуяа ХХОАТ бол бас яг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэг төрлийн бодлого байдаг. Эдгээр өрхүүдийг дэмжих нэг чухал бодлого нь татвараар дамжиж хэчнээн гэр бүлийнхээ хэчнээн нийгмийн ачааллыг тэр хүн үүрч байгаа юм бэ гэдгээс нь хамаарч татварын уян хатан нөхцөл хөнгөлөлт дэмжлэг үзүүлдэг. Манай улс ерөөсөө ийм татварын бодлого ийм төрлийн хүчин зүйлийг харгалзах талаар ерөөсөө энэ төрийн түшээд Сангийн яам гэдэг юм уу энэ бодлого тодорхойлогчдын зүгээс огт гарахгүй байгаад байна. Энийг ер нь нэг бүгдээрээ дараа дараагийн татварын хуулиуд дээр эргэж харж энэ талаар яримаар байна. Энийг судалмаар байна. Энийг нийгмийн хэлэлцүүлэг эргэлтэд оруулмаар байна.

Өнөөдөр 2 хүүхэдтэй, 3 хүүхэдтэй, 4 хүүхэдтэй, 2 сая төгрөгийн орлого олж байгаа өрхийн орлого хэдийгээр 2 сая төгрөг боловч зарцуулалт нь шал өөр байгаа. Энэ нийгмийн баялгийн хуваарилалт шал өөр түвшинд байгаа. Энийг бид нар нарийн олж хармаар байгаа байхгүй юу. Ганц бие ээж ганц бие аавын хувьд нэг өөр байгаа. Ганцхан өөрөө ажил хийдэг 2 хүүхэдтэй ганц хөдөлмөр эрхэлдэг ээжийн хувьд хэдийгээр 2 сая төгрөгийн орлоготой нь адилхан 2 сая төгрөгийн орлоготой боловч дахиад тэр хүний үүрч байгаа нийгмийн ачаа дахиад нэг өөр түвшинд байгаа.

Тэгэхээр энэ бүхнийг харгалзаж үзсэн татварын бодлого хэзээ манай улс энэ бодлого руу ахиц дэвшил гаргах вэ гэдэг ийм асуултыг асуугаад байгаа юм. Тэгээд харамсалтай нь энэнтэй холбоотой яг тийм суурь судалгаа, мэдээлэл ийм зүйл ерөөсөө төдийлөн хэлэхгүй байгаа. Бид нар харьцангуй нэг үеэ бодвол бүгд цахимжаад байгаа. Хэн хэдэн хүүхэдтэй хэн хэчнээн хүнийг асран хамгаалж байгаа юм бэ гэдгийг бүгд цахим системээр төр мэдэхэд маш амархан байгаа. Тэгээд энийгээ бид нар энэ татварын бодлоготойгоо уях цаг нь болсон юм болов уу гэж харж байгаа. Тэгээд тийм учраас би зарчмын зөрүүтэй санал гаргасан. Гэхдээ харамсалтай нь үүнийг ойлгох гишүүд тун ховор байна. Эхлээд та бүхэн энийг ойлгож уншиж судалж үзээрэй. Олон улсад хүлээн зөвшөөрөгдчихсөн ийм татварын бодлого байгаа. Тэгээд энийг дараа дараагийн татварын хууль тогтоомж дээр Сангийн яам энийг бодлого болгож оруулж ирээсэй гэж хүсэж байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Асуулт асуугаадахъя дундуур нь. Асуулт асуусан бодлогод өөрчлөлт хэзээ оруулах юм бэ? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Тийм Баасанжаргал гишүүн бас зөв асуудлуудыг хөндөж байна аа. Ер нь татварын зорилго олон зорилготой байдаг. Шударга ёсыг тогтоох ч зорилготой байдаг хөрөнгийн тэгш хуваарилалтын ч зорилгууд байдаг. Хор

уршигтай зүйлийг их бага хэрэглүүлэх зорилгоор ч татварыг бий болгодог. Сая НӨАТ дээр бид нар ингээд өнөөдөр өчигдөр ингээд сүүлийн 7 хоног маргалдаж байна. Яагаад энэ 400 сая, 50 сая ингээд хэвээр нь үлдээе гээд байгаа юм. Яах вэ Тэмүүжин гишүүний зөв байхгүй юу. Бид нар НӨАТ төлөгч гэдэг маань эцсийн хэрэглэгч байдаг. Тэр хэрэглэгчид очих татварын ачааллыг л уг нь бууруулах асуудлыг бид нар тэр 400 саяын босготойгоо уг нь хамт хэлэлцэх ёстой байсан юм. Тэр нь буцаалт хэлбэрээр ч байж болно эсвэл тэр 10 хувийг нь 7, 8 хувь руу ч оруулах ч байдаг юм уу тэр ч тэр шийдлээр эргээгээд саяын ярьж байгаа ам бүлийн ам бүлд одоо тэр өрх толгойлсон аав байдаг юм уу, ээж байдаг юм уу эсвэл ам бүлийнх нь тоогоороо татварын хөнгөлөлтийг эдлэх тэр шийдлүүд нь олон янз байж болж байгаа юм.

Нэг хувийн татварыг бид нар 2 сая төгрөгийн шатлал руу оруулсан. Одоо 792 мянгаас 2 сая төгрөгийн хооронд нэг хувийн татварын ноогдуулахаар болж байгаа. Энд одоо нийтдээ 55 мянган иргэн хамрагдаж байгаа. Тэгэхдээ энэ бол одоо цалин авч байгаа бүх иргэд тэр 2 сая төгрөгийн шатлал дээрээ 0-1 хувийн татвар л төлнө гэсэн үг. Тэгэхдээ энэ одоо том реформ өмнөх хийж байгаа томоохон алхам мөн өө. Бид нар бол яг сүүлийн 36 жил яг энэ цалингаасаа татвар төлдөг иргэдээ ерөөсөө татварын хөнгөлөлт эдлүүлж чадаагүй юм. Одоо ингээд харах юм бол одоо бизнес бизнес дээр ЖДҮ эрхлэгч нар 1.5 тэрбум дээр нэг хувийн татвар төлж байгаа. Хувиараа бизнес эрхэлж байгаа иргэд тэрбум төгрөг дээр нэг хувийн татвар төлж байгаа. Тэгсэн мөртөө 1 сая 500 мянган төгрөгийн цалинтай 2 сая төгрөгийн цалинтай иргэд 10 хувийн татвар төлдөг л байсан байхгүй юу. Төлөөд л явж байгаа. Өнөөдөр тэгээд тэрийгээ нэг хувь руу оруулж байгаа нь зөв шүү дээ. Би Баярмаа гишүүнийг үүн дээр дэмжиж байгаа. Тэгээд энийг нэгтгэж явуулаад тэгээд 700 руу ердөө 0 болгоод нэг хувийг нь 2 сая болгоод энэ эхний алхам.

Тэгээд цааш цаашдаа энэ татвараараа бид нар шударга ёсыг бий болгох, орлогын тэгш хуваарилалтыг бий болгох, бизнес эрхлэлтийг дэмжих гээд цогцоор нь юмаа харах ёстой. Тийм ч учраас бид нар энэ НӨАТ-ын хуулийг намрын чуулганаар байдаг юм уу төсөв өргөн барихдаа цогцоор нь хараад өргөн бариач яг бүртгэлийн тэр юугаар нь утгаар нь өргөн бариач ээ. Яг тэр татварын хөнгөлөлт эдлүүлэх ёстой хүнд нь татварынхаа хөнгөлөлтийг эдлүүлээчээ. Зүгээр дунд нь татварыг шилжүүлдэг хүнд нь татварыг хөнгөлөлт эдлүүлнэ гээд яриад явах юм. Тэр чинь бол одоо үндсэндээ тогтолцоогоо эвдье гэсэн ийм санал яваад байна шүү дээ л гэдэг байдлаар ажлын хэсэг санаа зовниод л энэ хувилбаруудыг гаргаж ирээд Байнгын хороон дээр хураалгаад яваад байгаа юм. Тэгэхээрээ татвар зөв байх ёстой, шударга байх ёстой. Татвар төлдөг бол бүгдээрээ төлөх ёстой. Энэ чинь Үндсэн хуулиар хуулиар бид нарт олгогдсон хүлээх ёстой 3 үүрэг байдаг шүү дээ. Тэрний нэг нь татвар байхгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Тэмүүжин, Баярмаа гишүүн нэмэх үү? Хууль санаачлагч Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Нэг зөв зүйлийг хөндөж байна л даа Баасанжаргал гишүүн. Татвар, ХХОАТ янз бүрийн зорилготой, янз бүрийн төрөлтэй байгаа. Жишээ нь зорилго нь ямар байна вэ гэхээр орлогод суурилсан тухайн гэр бүлийн 5 хүүхэдтэй мөртөө 2 сая төгрөгийн цалинтай мөртөө хүүхэдгүй 2 сая төгрөгийн цалинтай 2-ын хооронд ямар ялгаа байх вэ гэдэг л цаад агуулгаараа асуудлыг хөндөөд байна гэж би харж байгаа юм. Тэгэхээр дэлхийн багагүй оронд энэ гэр бүлийнхэн орлогод суурилсан хэмжээгээр нь татвар ноогдуулдаг ийм хувь хэмжээ байгаа л даа. Тэгээд

би нэг юмыг зориуд хэлмээр байгаа юм. Манай Ардын намынхан ерөөсөө шударга ёсыг тогтоох хэрэгсэл гэж энэ татварыг хараад байгаа нь надад ерөөсөө таалагдахгүй. Энэ чинь ер нь эсрэгээрээ бүүр хүн ингээд өөрөө хөдөлмөрлөж, өдөр шөнөгүй хөдөлмөрлөж, тэр хөдөлмөрлөснийхөө үр дүнд авч байгаа мөнгө шүү дээ уг нь.

Ж.Бат-Эрдэнэ: Баярмаа гишүүн гүйцээе.

Ж.Баярмаа: Төр энд ямар ч үүрэггүй байгаад байгаа байхгүй юу уг нь болбол. Тэгэхээр ерөөсөө хамгийн гол тэрэн дээр л илүү их акцент өгөөд байгаа шударга ёсыг тогтоох хэрэгсэл гээд тэгж ярих юм бол хүн илүү их хөдөлмөрлөвөл илүү цалин авч илүү амьдрах нь энэ чинь зүй ёсны жам ёсны асуудал байхгүй юу. Тэгэхээр л ерөөсөө тэгэх ёсгүй тэр илүү хөдөлмөрлөж байгаа хүмүүсээс цалин авч бага орлоготой хүмүүст өгнө гээд байгаа энэ өнцгийг илүү их бариад байгааг би бол ерөөсөө хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм. Мэдээж Үндсэн хуульд иргэн болгон татвар төлөх ёстой татвар буй дор төр буй гэдгийг ойлгож байгаа.

Нөгөөтээгүүр энэ хөдөлмөрлөсөнд нь ногдуулж байгаа татвар шүү дээ. Хөдөлмөрлөсөнд нь. Тэгэхээр энэ зүгээр байж байгаад ийм илүү цалин аваад байгаа огт биш байгаад байгаа байхгүй юу. Тэгээд 3 сая, 4 сая төгрөгтэй хүмүүсийг амьдрал нь болж байна эд нарт хөнгөлөлт хэрэггүй гэж үзэж байгаа нь бол бас надад буруу санагдаж байгаа юм. Өнөөдөр Монгол Улсад энэ үнийн өсөлт энэ инфляц ямар түвшинд оччихсон билээ? 3, 4, 5.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь бол Ардын намын гэхээсээ илүү бид нар энийг чинь хэлэлцэж байгаад дэмжье гэсэн шүү дээ. Сая Ганхуяг гишүүн өөрөө хэллээ. Энэ саналыг дэмжиж байгаа түрүүний жишээ нь Тэмүүжин гишүүний хувь хүний олсон орлогын тэр аль болох бага аваач, аль болох өөрсдөд нь зарцуулаач, аль болох энэ хөгжлийн гол түлхүүр болсон хүнд нь өгөөч гэсэн шүү дээ. Энэ өнцгөөс хариулах гээд байх шиг байна. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Баярмаа гишүүнээ шударга ёсыг гэдэг маань Үндсэн хуульд зааснаар иргэн бүр татвар төлөх ёстой. Бүгдээрээ төлдөг байвал төлье. Төлөхгүй бол хэн ч татвараа төлөхгүй байя гэдэг л шударга ёсны зарчмыг яриад байгаа юм. Энэ хувь хүн дээр очиж байгаа татварын ачааллыг 3 сайд байна уу, 4 сайд байна уу бид нар ялгаа байхгүй бүгдийг нь татварын хөнгөлөлтөд хамруулъя гээд 2 талаасаа ажлынх нь хэсгээс гараад энэ татварынх нь юмнуудыг нэгтгээд явлаа шүү дээ. Сая бас Тэмүүжин гишүүний ярьж байгаа зөв. Тэгээд энэ дээр чинь энэ хууль бол энэ татварын хууль бол одоо АН-ын, Ардын намын татварын хууль гэж байхгүй шүү дээ. Энэ чинь Монгол Улсын татварын хууль ярьж байгаа шүү дээ. Тэгэхээрээ бид нар шударга ёсны өөдөөс хувь хүний орлогын албан татварыг бууруулъя тэр ААНОАТ-ыг бууруулъя. Боломжоор нь бууруулаад ингээд явъя. Энийгээ хөгжүүлээд явъя гэдэг л асуудлыг ярьж байгаа шүү дээ. Тэрнээс биш Ардын нам ийм байр суурьтай, АН ийм байр суурьтай гээд хүмүүс яриагүй шүү дээ бид нар.

Ж.Бат-Эрдэнэ: Зочид танилцуулъя.

Өвөрхангай аймгийн Баянгол сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна та бүхэн маань Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал дээр орж ирлээ. Тэгээд та

бүхэндээ хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. Гол асуудал ярьж байхад орж ирлээ гэрч болж байна баяр хүргэе та бүхэндээ. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Нэг зүйлийг ерөөсөө тодруулж хэлэхгүй бол болохгүй байна аа. Энэ төрлийн татвар өөрөө халамжийн бодлого ерөөсөө биш. Энийг халамжийн бодлоготой хольж хутгаж ойлгоод байх юм. Энэ төрлийн татвар чинь ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсээ 1 дүгээрт дэмжих.

Хоёрдугаарт хамгийн гол нь нийгмийн ачааллыг хуваалцаж байгаа буюу хүүхдээ өсгөж байгаа, хөдөлмөрийн чадваргүй хүмүүсийг асран халамжилж байгаа, өндөр настнуудаа асран халамжилж байгаа тэр хүмүүсийн ачааллыг төр хуваалцах үүргийг нь бид нар ингэж татварын бодлогоороо гаргаж ирээч тэрийг нь бид нар энэ бодлого болгож оруулж ирэх ёстой юм гэдэг ийм зүйл ярьж байгаа юм. Тэрнээс биш ерөөсөө халамжийн бодлого яриагүй. Тэгээд энийг яг нэг халамжийн бодлоготой хольж хутгаад гуйвуулаад ингээд байх юм. Тэгээд олон улсад энэ чинь өчнөөн олон улс оронд хүлээн зөвшөөрөгдөөд маш олон улсууд энийг чинь хэрэгжүүлээд энэ чинь гэр бүлийг дэмжих хамгийн чухал бодлого юм байна гээд гээд ингээд оруулаад ирчихсэн энэ зүйлийг халамжийн бодлого гэж гуйвуулахаа болимоор байна гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг 17 цаг хүртэл хойшлуулсан байгаа.

12.12 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хэлэлцье. Төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Батболд танилцуулна. Батболд гишүүнийг индэрт урьж байна.

Д.Батбаяр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 17, 18-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Нэгдсэн хуралдаанаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасныг баримтлан зарчмын зөрүүтэй нэг саналын томьёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулах зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийн орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн дарга.

Гишүүд асуулт асууна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа. Өнөөдөр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд ингээд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг явж байна. Эцсийн хэлэлцүүлэг учраас бас ерөнхийдөө цаашдаа анхаарах зүйлүүдийг л хэлмээр байгаа юм. НӨАТ-ын босгыг зүгээр яах вэ? Өндөр болгохын сөрөг болон давуу талууд байгаа. Тэгээд энэ дээрээ бас яг нэг тодорхой яг бодитой судалгааг сайтар хийгээд ер нь НӨАТ-ын татварын яг шударгаар бүгд л төлдөг болмоор байна. Тэгээд харин буцаалтын хувь хэмжээ байдаг юм уу? Ер нь НӨАТ-ын татварын хувь хэмжээ байдаг юм уу? Энийгээ нэг эргэж харах байдлаараа явахгүй бол 400 сая гээд явчихдаг. Тодорхой ААН байгууллагууд энэ хуулийн үйлчлэлээс гарна. Энэ худалдан авах, энэ бизнесийн харилцаан дахь НӨАТ-ын энэ ялгамжтай байдлаасаа болоод компани хоорондын харилцаанууд алсдаа харилцаанууд тасрах вий гэдэг бодлогууд байгаа байхгүй юу.

Тэгэхээр нөгөө компани жижиг компаниуд түүх үүсдэггүй тэгээд ийм зүйлүүд байхыг үгүйсгэхгүй учраас ер нь энэ босгыг өндөрсгөхөөс илүүтэйгээр жигд бүгд төлөх тэгээд буцаалтын хувь хэмжээн дээрээ харин энэ бодлогоо аль хэсэг дээрээ яаж дэмжиж өгөх вэ гэдэг л ийм суурь зүйл рүүгээ яваасай л гэж бодож энэ асуудлыг хандаасай гэж хүсэж байгаа юм. Тэгээд ер нь яах вэ зүгээр энэ удаагийн хуулийн өөрчлөлтийн гол зохицуулалт нь ер нь юу орж байгаа вэ ажлын хэсгийн ахлагч нэг тодорхой хэлээч. Би яах вэ зүгээр мэдэж байна. Тэгэхдээ эргээд энэ өнөөдөр нэр бүхий гишүүд маань гараад л энэ хуулийн хэлэлцүүлгээс өмнө л ингээд л мэдэгдлүүд хийгээд байна л даа. Одоо ингээд л ухарлаа гээд. Ухрах биш энэ бүүр эдийн засгаа цаашдаа бизнесийг улам жижгэрүүлээд ч гэдэг юм уу ийм зүйл рүү явчих байх. Тэгэхээр энийг сууриар нь л эргэж харж би бол энэ удаагийн нэмэлт өөрчлөлт бол косметик гэж ойлгож байгаа. Магадгүй намраас тодорхой хэмжээний Татварын хуулиудын нэлээн томоохон өөрчлөлтүүд хийгдэхийг үгүйсгэхгүй л гэж харж байгаа байхгүй юу.

Тийм учраас энийгээ нэг сууриар нь хараач ээ. Ер нь бол татварын хуулиудыг батлаад эргэж буцаад байх нь буруу. Энийг бол одоо гишүүдийн хэлээд байгаа энэ зарчим бодлоготой санал нэг байгаа. Тэгээд гол орж байгаа өөрчлөлтүүд олон нийтэд ямар мессеж хүрч байгаа, ямар зохицуулалтууд бий болж байгаа талаар ажлын хэсгийн ахлагч нэг тодорхой тайлбар олон нийтэд өгөөч гэж хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Тийм Сайнзориг гишүүн өмнөх яг Их Хурлын гишүүдийн хууль боловсруулах ажлын хэсэгт байсан. Тэгээд энэ НӨАТ-тай холбоотой асуудлаар бид нар нийтдээ 100, 70, 80 мянган иргэн ААН-ээс санал авсан байдаг юм аа. Тэгээд яагаад энэ 400 саяыг энэ удаа болохгүй байна вэ гэхээр бид нар энийг цогцоор нь оруулж ирмээр байгаа юм. Яагаад гэхээр НӨАТ төлөгч гэдэг маань яг энэ татварын ачаалал нь хэн дээр ирдэг вэ гэхээр яг эцсийн хэрэглэгч дээр л ирдэг юм. Тэгээд одоо энэ 400 саяыг хэрвээ бид нар оруулж ирье гэвэл би тэгээд энэ 400 саяын босгыг дэмжиж байгаа гишүүдэд уриалмаар байгаа юм.

Хамт өргөн барья эсвэл засгийн газраа өргөн бариулъя. Гэхдээ 400 саяыг өргөн барихдаа нэг бол НӨАТ-ын буцаалт байдаг юм уу эсвэл хувь хэмжээг нь тодорхой хэмжээнд бууруулах байдаг юм уу? Ийм байдлаар цогцоор нь өргөн барьж ирэхгүй бол ерөөсөө л яг иргэдийн аж ахуй нэгжүүдийн ярьж байгаа юм гэхээр бүгдээрээ л нэг бол бүгдээрээ НӨАТ-аа төлье. Эсвэл энэ НӨАТ гэдэг юм НӨАТ-ын энэ хуулиа хүчингүй болгож өгөөч гэж асуудал ярьж байгаа. Хагас нь НӨАТ төлдөг хагас нь төлдөггүй. Тэгээд тэрний яг дундаа энэ 400 саяын босго гэдэг маань эцсийн дүндээ эцсийн хэрэглэгчдэдээ ямар нэгэн хөнгөлөлт болохгүй. Яг тэр дунд нь шилжүүлдэг хүмүүсээ НӨАТ төлөгчийн бүртгэлийг хасаад хаячихаар нийтдээ энэ чинь 23 мянган ААН энэ НӨАТ төлөгчийн бүртгэлээс хасагдана гэсэн үг. 23 мянга гэдэг маань нийт Монгол Улсад байгаа НӨАТ төлөх 63 мянгын 34 хувь байгаа. Тэгээд энэ зах зээл дээр НӨАТ-тай, НӨАТ-гүй бараа гэж бий болно. Улам даамжирна.

Дээрээс нь далд эдийн засаг томорно. Тэгээд дараа жил, тэрний дараа жил бид нар төсөвтэй байх уу татвартай байх уу гэдэг асуудал тавигдана. Мөн одоо би нэг хэдхэн сарын өмнө Шадар сайдаар ажиллаж байлаа. Чөлөөт бүсүүдийг хариуцдаг байлаа. Чөлөөт бүсэд асар их хэмжээний архи тамхи зарагддаг. Тэгээд тэрийг ингээд баяр болгоны өмнө орон нутгаар ингээд зардаг, иргэдийн хувийн

дансыг ашиглаж тэрийг зардаг. Тэгээд 50 сая төгрөгийн босго дээрээ тулангуутаа өөр хүний дансыг аваад, тэгээд дахиад зардаг. Тэгээд энэ чинь бол үндсэндээ тэр архины бид нар лабораторийн шинжилгээ ч байхгүй нөгөө онцгой татвараа ч авахгүйгээр ингээд явчихдаг. Тэгэхээр энэ НӨАТ гэдэг маань, НӨАТ төлөгч гэдэг маань эргээгээд тэр бараанд тавигддаг хяналт, шалгалт, бүртгэл ингээд олон талын энэ чинь хяналт буюу бүрэн энэ чинь тогтолцооны асуудал байхгүй юу. Тэгээд бид нар эргээгээд энэ 400 сая дээр нөгөө хөшүүргүүдийг нь алга болгочихоор ямар асуудал үүсэж байна гэхээр НӨАТ хамрагдалт өндөр 75 хувь байвал тэр чинь 50 хувь руу орж ирэх гээд байна шүү дээ. 50 хувь руу орж ирнэ гэдэг маань үндсэндээ одоо бид нар энэ саяын ярьж байгаа хяналт шалгалт энэ далд эдийн засаг гээд бүх асуудал дээр энэ чинь сөрөг үр дагавар авчрах гээд байна аа.

Тийм учраас энэ удаадаа 400 саяа бид нар больё. 400 саяа та бүхэн маань одоо энэ намрын чуулганаар төсөв орж ирэхэд нь оруулж ир ээ. Тэгэхдээ буцаалт байдаг юм уу, хөнгөлөлт байдаг юм уу, яг эцсийн хэрэглэгчид ирдэг тэр хөнгөлөлт талаас нь харж байгаад ингээд цогцоор нь оруулж ирээч ээ. Тэгэхгүй бол одоо ингээд энэ асуудлууд дээр чинь.

Ж.Бат-Эрдэнэ: Зочид танилцуулъя.

ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон ашигт малтмалын баяжуулах технологийн ангийг төгсөж буй оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Оюутнууддаа сурлагын их амжилт, ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Тэгэхээр би яах вэ ажлын хэсгийн ахлагчийн саналыг дэмжээд байгаа юм. Тэгээд энийг яг нийтээрээ үр ашгийг нь л хүртдэг баймаар байна. Тэгээд яг жижиг дунд ААН байгууллагууд дэмжих гэж байна гэж байгаад улам бүр ингээд зөрүүтэй байдал эргээд энэ ААН байгууллагуудаасаа нөгөө томоохон ААН байгууллагууд буюу НӨАТ төлдөггүй худалдан авалт хийх болов уу? Энэ хэмжээ ингээд цаашдаа багасах вий гэдэг эрсдэлүүд байгаа. Бараг томчууд нь тэгээд жижгийнхээ өмнөөс л НӨАТ-ыг төлөх гэдэг юм уу энэ дарамт тэгээд яг эцсийн дүндээ хэрэглэгч дээр хэвээрээ байгаад байгааг л өөрчилье гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр энийг тодорхой хуваарь байдаг юм уу, буцаан олголтын бодлоготойгоо хамт оруулж ирэхгүй бол яг энэ асуудлаар нэг ийм хаачих гээд байгаа юм шиг зүйл яриад байж болохгүй байх.

Тийм учраас бас ажлын хэсгийн ахлагчийг бас энийг эцсийн хэлэлцүүлэг явж байна Засгийн газар тэр өгөх чиглэлийн тогтоол энэ тэрийг нь Байнгын хороо шаардлагатай бол санаачлаад яг энэ иж бүрнээр нь цогцоор нь оруулж ир гэдэг зүйлийг чиглэл болгох нь зөв болов уу гэж бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

М.Бадамсүрэн: Дэлхийн нийт улс орнуудаас 175 улс орон нэмэгдсэн өртгийн албан татвартай. Тэгээд үүнээс 83 хувь нь буюу 145 улс орон ийм босго тогтоодог

юм байна л даа, 83 хувь нь. Тэгэхээр Монгол Улс бол ингээд босго тогтоох нь зөв өө гэж ОУВС зөвлөсөн гэж би ойлгож байгаа. Мөн ОУВС зөвлөхдөө бол одоогийн энэ инфляцтай уялдуулаад одоогоос 11 жилийн өмнө 50 сая төгрөгөөр тогтоосон энэ босгыг одоо 400 орчим сая төгрөг байхад болно гэж зөвлөж байгаа юм байна гэж би одоо мэдээлэл авсан.

Тийм ч учраас улс төрийн намууд дийлэнх нь энэ НӨАТ-ын босгыг нэмэгдүүлнэ гээд сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрт амлалт өгсөн гэж ойлгож байгаа. МАН энэ 2024 оны сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөртөө бол одоо энэ НӨАТ-ын босгыг 400 сая төгрөг нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг олон улсын жишгийн дагуу шинэчилнэ гэж амлалт өгсөн.

Тийм учраас энэ 2 үндэслэлээр энэ 400 сая төгрөг болгохоор Учрал Ерөнхий сайдын тэргүүлсэн Засгийн газраас өргөн мэдүүлснийг одоо дэмжиж байгаа. Үндсэн 2 шалтгаан маань.

Нэгдүгээрт инфляцтай уялдуулаад 11 жилийн өмнө орон сууцын үнэ метр квадрат нь хэд байлаа. Бараа бүтээгдэхүүний үнэ хэдэн төгрөг байсан. Өнөөдөр тэгвэл хэдэн хувиар өссөн байгаа билээ, нэг.

Хоёрдугаарт тухайн үед Монгол Улсын ДНБ нэг 20 гаруй их наяд төгрөг байсан бол өнөөдөр бараг 100 шахам их наяд төгрөг болж байгаа. 4, 5 дахин нэмэгдсэн.

Валютын ханштай холбоотой нэмэлт.

Тэгээд ингээд бодохоор энэ бол ингээд 50 саяараа байна гэвэл энэ тухайн үеийн 2015 оны 50 сая төгрөг тухайн үедээ болж байсан байх. Өнөөдөр бол энэ үнийн өсөлт, ханшийн өөрчлөлттэй холбоотой энийг бол зайлшгүй 400 сая болгох нь зөв өө гэж үзэж байгаа юм.

Энэ бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд энэ НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэхгүй байх нь ямар хүндрэл үүсгэж байна вэ гэдэг асуудал байгаа.

Нэгдүгээрт бол энэ орлого багатай, ашгийн түвшин муу, тэгээд санхүүгийн мэдлэг багатай ийм дөнгөж хөл дээрээ босох гэж байгаа бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд одоо санхүүгийн бэрхшээл гарна. Татварын өр төлбөр нэмэгдэх эрсдэл үүсэж байгаа юм.

Хоёрдугаарт нь бол энэ бичил жижиг бизнес эрхлэгч дээр ийм тайлан гаргахтай холбоотой зардал бусад хүн хүчний зардал нэмэгдсэнээс болоод бараа бүтээгдэхүүний нийлүүлж байгаа бүтээгдэхүүний үнэ өснө. Энэ нь бол инфляцад нөлөөлөх үр дагавартай.

Гуравдугаарт нь бол 183 мянга орчим бичил жижиг бизнес эрхлэгчдэд энийг нэмэгдүүлэх нь одоогоор хамгийн үр дүнтэй зүйл. Би орон нутагт ажиллаж амьдарч байсан. Олон бичил жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр санал бодлыг нь сонсож байсан. Одоо ч бичил, жижиг, дунд, бизнес үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа хүний хувьд энэ бол одоо зайлшгүй босгыг өнөөгийн нөхцөлд одоо нэмэгдүүлэхээр Засгийн газрын оруулж ирсэн саналыг дэмжих ёстой гэж үзэж байгаа.

Харин дараа дараагийн бусад энэ татварын хуулиудад оруулах өөрчлөлтийг бол тухайн үед нь дэмжээд явах хэрэгтэй. Харин олзуурхууштай нь манай Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс энэ татварын ачааллыг иргэд ААН-д бууруулах чиглэлээр олон төслүүдийг чуулганаар амжилттай хэлэлцүүлж байгаад би баяртай байгаа. Ер нь төрийн зардлыг бууруулж татварын зардлыг бууруулаад тэгээд төрөө цомхон болгоод тэгээд татвар төлөгчид илүү ашигтай байх нь чухал шүү дээ. Тэгэхээр энэ яг энэ үзэл бодол дээр юу гэж үзэж байна гэдгийг би.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг.

Х.Ганхуяг: 2016 онд Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн шинэчилсэн найруулга Улсын Их Хурлаар батлагдсан байдаг юм. 2016 онд анх энэ 50 сая төгрөгийн босго гэдэг юм батлагдсан. 50 сая төгрөг батлагдахдаа тэр нь 20 хувийн буцаалт буюу нөгөө 10 хувиасаа 2 хувийг нь буцааж олгоё. Дээрээс нь и баримт гэдэг юм нэвтэрсэн байхгүй юу.

Тийм учраас тэр 50 сая төгрөгийн босго гэдэг юм чинь татварын тогтолцоогоо эвдэхгүйгээр ингээд явчихсан. Тэгээд яагаад энэ удаа биш байна энэ намрын чуулганаар өргөн барь цогцоор нь хараад өргөн барь гээд байхаар бид нар дөнгөж сая 10 хоногийн өмнө, 14 хоногийн өмнө нөгөө буцаалтын хуулиа цуцалчихсан байхгүй юу хүчингүй болгоод хаячихсан. Тэгэхээрээ тэр асуудлаа хамтад нь өргөн барихгүй бол зөвхөн босгыг нь хөдөлгөчихөөр нөгөө талдаа энэ тогтолцоо чинь нурах гээд байна шүү дээ. Энэ НӨАТ-ын татвар гэдэг чинь одоо нөгөө талаас нь харвал татвар нь зөвхөн эцсийн хэрэглэгчээс авдаг татвар байхгүй юу. Тэр чинь тэр дундын ААН-үүдэд төлдөг татвар биш. Тэр чинь зөв ингээд дамжуулсны л татвар байхгүй юу. Тэгээд яг явж явж байгаад ачаалал нь хэн дээр байдаг вэ гэхээр эцсийн хэрэглэгч дээр. НӨАТ-ын хяналт тавих үүрэг нь хэн дээр вэ эрх нь хэн дээр байдаг вэ гэхээр иргэн дээр байдаг байхгүй юу. Тэр нөгөө и баримтаа нэхэх, тэр эргээгээд тэр урамшууллаа авдаг ч байдаг юм уу яадаг ч юм тэр чинь иргэн дээр очиж байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ буцаалтыг нь байхгүй болчихсон байгаа тохиолдолд бид нар энэ босгыг нь ингээд хөдөлгөнгүүт чинь энэ тогтолцоо чинь нурах гээд байна шүү дээ л гэдэг асуудал яриад байгаа юм. Тэрнээс биш энэ энийг чинь эсэргүүцээд байгаа юм биш байхгүй юу. Би танд Бадамсүрэн гишүүн, түрүүн Ганзориг гишүүнд хэлсэнчлэн, Мөнхбаясгалан гишүүнд хэлсэнчлэн цөмөөрөө болохгүй байвал Засгийн газарт чиглэл өгье. Бүүр болохгүй бол гишүүдийнхээ зүгээс энэ 400 саяын босгыг чинь ч оруулъя. Гэхдээ тогтолцоогоор нь нураахгүйгээр цогцоор нь өргөн барья, цогцоор нь өргөн барья. Тэгэхгүй бол энэ чинь юм чинь нурах гээд байна аа. ОСТ-ийн оронд бүртгэлтэй байгаа энэ НӨАТ-ын энэ хуулиуд дотор бид нар судалгаа хийж үзсэн. Одоо бол хамгийн сүүлийн байдлаар энэ прогрессив НӨАТ гэдэг юм чинь нэлээн олон оронд батлагдаад явчихсан тэр чинь нөгөө эргээгээд нөгөө буцаалттай холбоотой заалтууд нь явж байгаа байхгүй юу. Одоо мянган доллар дээр НӨАТ-ыг нь 100 хувь буцаая, 500 доллар дээр 50 хувь буцаая ч гэдэг юм уу. Бид нарын нөгөө хүчингүй болгочихсон хууль чинь тэнд үйлчилж байгаа байхгүй юу.

Тийм учраас тэнд нөгөө тодорхой хэмжээний тэр 400 саяын босго байдаг юм уу, 300 саяын босго гэдэг юм чинь тэнд үйлчлээд байгаа юм. Тэнд ингээд хэрэгжүүлж болоод байгаа юм. Тэгэхгүй бол бид нар ингээд цогцоор нь харахгүй

зөвхөн нэг тоог аваад ингээд явах гэхээр энэ юм чинь нурж уначих гээд байна шүү дээ. Бид нар ажлын хэсэг дээр наад тэр 400 саяыг чинь оруулаад эргээгээд тэр хөнгөлөлт байдлаар шийдчихье гэж яах гэхээр нөгөө тэр заалт нь хөндөгдөөгүй болохоор засаж болохгүй байгаад байна. Яг одоо ингээд л нэг бол тавиараа байх юм байна. Нэг бол 400 байх юм уу эсвэл 100 байх юм уу, 200 байх юм уу. Тэр дүн л өөрчлөгдөхөөс өөрөөр тэрийг ерөөсөө найруулж болохгүй байгаад байна. Нөгөө хөндөгдөөгүй заалт болохоор.

Тийм учраас энэ удаадаа ингээд тайван үлдээгээд Засгийн газар энийгээ цогцоор нь оруулж ир гэдэг л асуудлыг л ярьж байгаа юм. Тэгээд бүр болохгүй бол гишүүд бид нар санаачлах эрхтэй.

Ж.Бат-Эрдэнэ: Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Тэгээд энэ удаагийн татварын энэ хуулиудын зорилго бол энэ бага орлоготой иргэдийг буюу 792 мянга хүртэлх энэ иргэний орлогыг чөлөөлөх, 792-оос 2 сая хүртэл нь нэг хувь болгох гээд энэ нөгөө анхан, шатанд бизнес эрхэлж байгаа болон бага орлоготой иргэдээ дэмжих бодлого явж байгаа гэж би ойлгож байгаа байхгүй юу. Тийм учраас ААН-ийн орлогын албан татварын хуулийн өөрчлөлт дээр ч гэсэн 1.5 тэрбумын борлуулалтын орлоготойгоос нэг хувь авдгийг 2.5 болгож босгыг нь нэмэгдүүлж байгаа. Яг энэнтэй адилхан НӨАТ дээрээ адилхан босгыг нь нэмэгдүүлээд явъя. Энэ өргөн мэдүүлсэн хуулийн үзэл баримтлал чинь өөрөө яг энэ чиглэл рүү явж байна аа.

Ялангуяа эдийн засгийн энэ хямралтай цаг үед бараа бүтээгдэхүүний үнэ өсөж байгаа. Гадаад дотоод зах зээл өсөж байгаа энэ хүндрэлтэй цаг үед нь бага орлоготой иргэд болон бичил жижиг бизнесээ дэмжье гэдэг бодлого явж байгаа гэж би ойлгоод тэгэхээр энэнээс энийг нь сугалж аваад яах юм бэ энэ дээр нь батлаад явчихъя. Харин дараа нь тэр.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ.

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Батлутын урилгаар Хөвсгөл аймгийн Тариалан сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Дараагийн гишүүн Баатаржавын Мөнхсоёл гишүүн.

Б.Мөнхсоёл: Энэ нийгмийн хүлээлттэй байгаа, энэ чухал асуудлаар хуулийн төсөл орж ирж байгаа. Тэгэхээр өнөөдрийг хүртэл хэрэгжиж байгаа нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт орсноор ажлын байрыг нэмэгдүүлэх, ажил олгогч даатгуулагчид харилцан өгөөжтэй байх, нийгмийн даатгалын сангийн үр ашгийг нэмэгдүүлэх засаглалыг сайжруулах чиглэлээр яг ямар шинэчлэлийн чанартай бодлого оруулж ирж байгаа вэ? Олон жил өндөр бүтээмжтэй өндөр цалинтай ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан иргэдийн, тэтгэвэр цалингийн түвшин багатай иргэдтэй адилхан болж тэгшитгэсэн жишээ их байгаа. Тэгээд ийм гомдол саналууд нэлээн ирдэг. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Гэнэт тэтгэвэрт гарах нас нь ойртохоор л. Айн өө тийм үү? Сая ажлын хэсгийн хурлаас орж ирээд гэнэт.

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль.

Б.Мөнхсоёл: Нэмэгдсэн өртгийн албан татвар дээр тэгвэл нэмж хэлэхэд яг асуудалтайгаа холбоод асуултаа тодруулчихъя. Өглөө бас Төсвийн байнгын хороо хуралдсан, өмнөх Төсвийн байнгын хороогоор ААН-д ноогдож байгаа нөгөө босго байна шүү дээ 50 сая төгрөгийг 400 сая төгрөг болгох энэ санал уг нь дэмжигдсэн байсан. Сая чуулганаар саналыг гүйцээн боловсруулах гэж аваад өнөөдөр өглөө Төсвийн байнгын хорооны хурал хуралдаад энэ саналыг унагачихлаа. Тэрэн дээр гишүүд зарим гишүүд сэтгэл дундуур байгаа учраас хэвлэл мэдээллийнхэнд энэ саналаа хуваалцаж мэдээлэл өгсөн. Тэгээд 17 цагт санал хураалт болох юм байна. Тэрэн дээр энэ асуудал тэгээд эцэслэгдэн шийдэгдэх байх. Гишүүд маань учрыг тунгаагаад энэ дээр бас жижиг, дунд, бичил ААН-үүдээ дэмжиж санал өгөх байх гэсэн бодолтой байна аа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Санал хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Болдын Жавхлан гишүүн алга байна. Хариулах юм уу? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Үгүй ээ энэ хэн ард түмэндээ хайртай юм, хэн ААН-үүддээ хайртай юм гэдэг уралдаан зарлачихсан юм уу хаашаа юм. Би татвар буулгамаар байна тэгэхдээ зөв буулгамаар байна шүү дээ. Цөмөөрөө шударга буулгамаар байна шүү дээ. Бүгдээрээ л татвар төлдөг баймаар байна. Эсвэл хэн нэгэн төлмөөргүй бол бүгдээрээ төлдөггүй баймаар байна. Тэгэхгүй одоо энэ чинь ингээд бараг хагас нь шахуу татвар төлөгч байхаа болих гээд байхад тэгээд тэр босгыг нэмэгдүүлье тэр тоог нь нэмэгдүүлье гээд байх юм. Тэгвэл хэрвээ тэр ингэж байгаад энэ НӨАТ-ын татварын хуулиа бүр хүчингүй болгоё. Тэгэхгүй бол одоо ингээд нэг Ганхуяг гэдэг хүн ингээд л нэг татвар буулгахыг л ингээд бүүр ингээд тэсэн ядан ингээд нэг яагаад байгаа юм шиг л ярьцгаагаад байх юм. Ингэж болохгүй шүү дээ. Зүгээр энийг хойшлуулъя. Засгийн газар энийг хаврын чуулган дээр төсөв өргөн барихдаа цогцоор нь хараад өргөн барьж оруулж ирэхгүй бол энэ чинь бүртгэлийн цорын ганц татвар нь байхгүй юу, бүртгэлийн. Энэ татвар төлдөг иргэн нь энэ чинь татварын ачааллыг үүрдэг юм. Тийм учраас энэ чинь буцаалттай нь холбоотой юм уу эсвэл хувь хэмжээтэй холбоотой заалтыг нь уялдуулж хамт өргөн барихгүй бол энэ татварын тогтолцоогоо эвдэх гээд байна л гэдэг санаа зовнил байгаа юм. Тэгэхгүй бол одоо энэ чинь ингээд нэг хэсэг нь энэ хүн татвар буулгахгүй байна гэдэг байдлаар л дайраад байдаг болчихлоо. Чадах хэмжээгээрээ л татвар.

Одоо энэ нийтдээ бид нар энэ Татварын хуулийн багц хуулийн шинэчлэлээр 4 их наяд төгрөгийн татвар буурч байгаа шүү, 4 их наяд. Энэ дээр энэ НӨАТ-ын хуулийн энэ босготой холбоотой 160 тэрбум л байх юм. Үгүй хамаа алга энэ 160 тэрбумыг нэмээд л оруулахад асуудал алга. Гэхдээ энэ чинь тогтолцоогоо эвдэх гээд байна шүү дээ. Төсөв бүрдэхээ боливол яах вэ? Татвар ингээд татварын орлого тасалдвал яах вэ? Энэ далд эдийн засаг томорвол яах вэ? Хариуцлага хэн хүлээ юм.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын чуулганы танхим гэдэг Улсын Их Хурлын гишүүдийн мэтгэлцээний нэг талбар байх ёстой. Тэгээд дэгийнхээ дагуу Мөнхсоёл гишүүнд нэг минут цаг өгье.

Мөнхсоёл гишүүний микрофоныг нээе.

Б.Мөнхсоёл: Маш сайхан мэтгэлцэж сурах хэрэгтэй гишүүд маань. Ганхуяг гишүүний хэлсэн дээр хариу хэлэхэд яг үнэн санал нэг байна. Ер нь аливаа энэ асуудлыг цогцоор нь оруулж ирэх ёстой. Бид нар болохоор төсвийн орлого зарлага орлогыг бүрдүүлж байгаа татварын багц хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулахаар ирсэн. Тэр тэрэн дотор мэдээж нэг нь нэмэгдсэн өртгийн албан татвар ингээд хэлэлцээд явж байна аа. Ажлын хэсэг үүссэн. Наана цаана ажилласан. Их Хурал дээр, Байнгын хороон дээр хэлэлцэгдэж байх завсар зуур нь процессын шинжтэй буцах, орж ирэх энэ тэр саналууд зөвшөөрөгдсөн саналууд унах гэх мэт асуудлууд байгаа дээр л гол нь акцент өгч байна шүү дээ. Тэгээд бид нар угаасаа иргэддээ томоохон хүлээлт үүсгээд 5 хувийн буцаан олголт хийж байснаа больсон. Тэр учраас зарим нэг хэсэг дээр нь хөнгөлж өгөхгүй бол болохгүй ээ. Ер нь эргээд цогц зургаар нь санал оруулах дээр би санал нэг байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Мэдээж ажлын хэсэг болоод Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад санал гарах, санал унах асуудал байх асуудал шүү дээ. Мэдээж олонхоороо асуудлуудаа шийдээд цаашаагаа явж байгаа.

Дараагийн гишүүн Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхбат: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг бид нар ярилцаж байна. Өнөөдөр Монгол Улсад мөнгөний ханшны уналт эдийн засгийн тэлэлт энэ олон л эдийн засгийн өөрчлөлтүүд ингээд явагдаж байгаа. Тэгээд энэ үед НӨАТ-ын босгыг тодорхой хэмжээнд арай өөрчлөх гэдэг ийм санал ингэж орж ирээд тэгээд уналаа л даа. Яах вэ ойлгож байгаа. Ер нь бид нар НӨАТ төлөгч биш ААН-үүд хэтэрхий олон болгох гэдэг нь өөрөө тийм сайн зүйл биш ээ. Энэн дээр НӨАТ төлөгч компаниудад төлж байгаа хэсэгт нь үр дагавар нь очоод байна гэдэг асуудлыг ойлгож байгаа. Гэхдээ бид нар өөр шийдэл хайх ийм бололцоо байхгүй юу. Хэрэвзээ НӨАТ-аа ингээд бүгдээрээ НӨАТ-аа төлдөг болъё. 400 хүртэл сая дээр чинь маш олон компани ААН-үүд НӨАТ-аас чөлөөлөгдөх гээд байна. Тэгэх юм бол бүгдээрээ төлдөг болоод тэр тодорхой анхан шатанд бизнес эрхэлж байгаа, дөнгөж нэг бойжиж байгаа ийм ААН-үүд нь хөнгөлөлтийн хувь хэмжээгээ арай ахиу буцааж авдаг байх ийм хувилбар байж болохгүй юу? Энэ дээр Сангийн яам, Татварын ерөнхий газраас юу гэж хэлэх байна гэдгийг 1 дүгээрт асуучихъя.

Хоёрдугаарт энэ бид нар ер нь ингээд бүх хүмүүс л татвар төлдөг болъё л доо гэдэг нэг зарчмыг яриад л их удаж байгаа. Энийг хэзээ хэрэгжүүлэх юм. Одоо тэр жижиг лангуу эрхлэгчид, гар дээрээсээ тооцоо хийдэг тэр бидний хэлдэг ченжүүд гэж нэрлэгдээд байдаг улсууд, худалдаа эрхлэгчид хэзээ төлдөг болох юм. Хэзээ бид нар энэ и баримтаа бүгдээрээ авдаг болох юм. И баримтыг зарим нь өгдөг, зарим нь өгдөггүй, амьдрал дээр тийм л байгаа шүү дээ. Тэгээд НӨАТ төлдөг улсууд нь болохлоор зэрэг энэ төлдөггүй хэсгээ хэдүүлээ төлдөг болгоё гээд байдаг. Гэтэл энэний төлөө манай энэ мэргэжлийн байгууллага нь хариуцаж байгаа агентлаг жишээ нь юу хийж байгаа вэ? Хэзээ энэ бүгдээрээ нэг хэл амгүй и баримтаа авдаг өгдөг болох вэ? НӨАТ-ын татварыг бүртгэлийн татвар гээд байгаа. Одоо ер нь энэ и баримт өгдөг болоод 2 хувийн буцаан олголт өгдөг болсноос хойш өнөөдөр ер нь хэдэн хувь бид нарын худалдааны үйл ажиллагаа ингээд бүртгэгдэж байгаа юм? Энийг хэлж өгөх ийм боломж байна уу? Энэ НӨАТ-ын татварыг тодорхой хэмжээнд жоохон босгыг нь өндөрсгөх юм уу, эсвэл НӨАТ-ын татварын хувь хэмжээг буулгах юм уу, эсвэл тэр буцаан олголтыг нь нэмэгдүүлэх юм уу? Энэний

үр дүнд уг нь нэг ААН-үүдийн тэр нэг бизнес эрхлээд эхлээд явж байгаа нэгэнт тогтворжчихсон компаниуд одоо шал өөр хэрэг. Тэд нартай одоо ярих юм алга. Энэ эхэлж байгаа бизнес эрхлэгчид, энэ старт апуудыг л хэдүүлээ яаж нэг бэхжүүлэх вэ? Яаж нэг 5, 3 ажлын байртай болгох вэ гэдэгт л нөлөөлөөд байгаа татвар учраас л бид нар энийг яриад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлууд дээр хариулт авъя даа.

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн яам, ажлын хэсэг хариулъя. 4 дугаартай индэр дээр. Сангийн яамнаас бодлого асуусан байх аа?

Ч.Чимидсүрэн: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Татварын бодлогын газар Чимидсүрэн.

НӨАТ дээр нэлээдгүй асуудлууд бий. Хуулийн түвшин зохицуулалтын түвшинд ч тэр. Хэрэгжилт тогтолцооны түвшинд ч гэсэн нэлээдгүй асуудлууд бий.

Тийм ч учраас бид нар сүүлийн 2 жил үндсэндээ жил хагас Татварын хуулийн шинэчлэл дээр нэлээдгүй хэсэг нь энэ НӨАТ-ын албан татвартай холбоотой байгаа. Нийт ирсэн 176 мянган санал бий. Тэрнээс 80 гаруй мянга нь нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой асуудлууд яригдсан. Тэгээд 2 ч төсөл яригдсан. Эхний төсөл нь татагдсан. Тэгээд тэр түвшинд та бүхний яриад байгаа ер нь бүх нийтээрээ татвараа шударгаар төлдөг больё тэгээд яг эцсийн НӨАТ буюу НӨАТ-ын агуулга нь эцсийн хэрэглэгч нь энэ хэрэглээний татвар, нэмүү өртөгт нь ноогддог татвар эцсийн хэрэглэгч нь төлдөг учраас түүнд нь тодорхой буцаалт олгоё гэдэг ийм асуудлууд яригдсан.

Тэгээд энэ хууль нь буцаалт олгохтой холбоотой асуудал нь өнгөрсөн оны төсөв дагаж батлагдчихсан байгаад сая ингээд энэ хууль нь хүчингүй болчихсон тогтолцооны юм байгаа юм. Эргээд НӨАТ-ын асуудлыг авч үзэхдээ ер нь иж бүрнээр нь авч үзэх ёстой. Тухайлбал энд НӨАТ-ын зөвхөн хуулиар зохицуулагдаж байгаа чөлөөлөлт гэхэд 50 гаруй 3 төрлийн чөлөөлөлт байгаа юм. Тэгээд энэ баримт олголтын асуудлууд дээр зохицсон арга хэмжээнүүд хийгдэх ёстой. Энэ дээр Татварын ерөнхий газар ч гэсэн ажиллаад явж байгаа.

Тэгэхээр өмнөх төслүүд дээр ч гэсэн бид ярихдаа хэрэв одоо бэлэн бусаар гүйцэтгэх юм бол НӨАТ-ын баримт олгогдсоноор ААНБ-д нь хасалтыг нь хийх боломжийг нь олгоё гэдэг хувилбарууд ч гэсэн ингээд яригдсан байгаа. Ингээд чөлөөлөлтүүд нь байхгүй болоод баримт олголтууд нь бэлэн бусын тогтолцоогоороо хийгдээд түүнийг хэрэгжүүлж хийгдээд байгаа банкны тооцоо, төлбөр тооцоо, түрүүнийх нь систем нийлүүлэгчдийнх нь хувьд энэ баримтаа олгох уу баримтаа олгохгүй юу гэдэг гэсэн асуудлыг системчлэлийнх нь хувьд ч гэсэн ингээд шийдээд тэгээд эцсийн хэрэглэгчид нь тодорхой хэмжээний буцаалт болгоод явах юм. Энэ цогц хэлбэрээрээ НӨАТ-ын асуудал хөндөгдөх ийм боломжтой зүйл байсан.

Тэгэхээр ер нь цаашид бид нар НӨАТ-ын асуудлыг цогц хэлбэрээр нь харах нь зүйтэй.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ бодлогын асуудлыг уг нь Сангийн сайд хариулах ёстой юм даа уг нь. Болсон уу? Мөнхбат гишүүн тодруулах уу?

Ц.Мөнхбат: Одоо бид нар тэр нэг и баримт өгдөг болоод 10 жил болж байна. Энэ бүртгэгд бүртгэгдээд байгаа баримтууд чинь ер нь хэдэн хувийг нь бид нар бүртгэж чаддаг юм бэ гэдэг асуусан. Энэ дээр Татварын ерөнхий газраас нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт нь цогц хэлбэрээр гээд байх юм. Цогц хэлбэрээр харах ёстой гээд. Одоо тэгээд яаж байгаа юм? Дагавар байдлаар оруулж ирж байгаа юм уу? Нэгэнт бид нар ирэх 2027 оны төсөв хэлэлцэхээс өмнө л энэ нэг гол гол хуулиуд дээр өөрчлөлтүүдийг хийгээд л Засгийн газраас өргөн барьж байгаа биз дээ. Тэгээд анхнаасаа оруулж ирэхдээ тэр цогц байдлаараа оруулж ирж болдоггүй юм уу? Тэгээд ингээд нэг өөх ч биш булчирхай ч биш байдалтай юмнууд оруулж ирээд тэгээд бид нар нөгөөхийг нь хэлэлцээд ингээд суугаад байгаа юм шиг ийм ойлголттойгоор ярьж болохгүй байх гэж ингэж бодогдож байна. Тэр нэг хувь хэмжээ нь.

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын индэр, ажлын хэсэг.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар, Цогтнаран Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Татварын алба Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д бол татвар үйл ажиллагааны орлого олж байгаа бүх татвар төлөгч цахим төлбөрийн баримт олгох үүрэгтэй. Өөрөөр хэлбэл бараа, ажил, үйлчилгээ үзүүлж байгаа бүх этгээд цахим төлбөрийн баримт олгох үүргийг Татварын ерөнхий хуулиар хуульчилсан.

Тэгэхээр энэ нь нөгөө талдаа орлогоо бүртгэх бас нэг гол хөшүүрэг нь юм аа. Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босго 50 сая төгрөг байгаа энэ цахим төлбөрийн баримтын системээрээ орлогоо бүртгээд 50 сая төгрөг хүрсэн тохиолдолд бид нар НӨАТ суутган төлөгчөөр бүртгээд явж байгаа. Өөрөөр хэлбэл цахим төлбөрийн баримтын системээрээ бид нар орлогын татварынхаа орлогыг бүртгэхээс гадна НӨАТ суутган төлөгчийнхөө орлогыг давхар ингээд бүртгээд явдаг ийм хуулийн зохицуулалттай. Яг өнөөдрийн байдлаар болбол.

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Б.Цогтнаран: Өнөөдрийн байдлаар НӨАТ-ын хуулийн НӨАТ-д хамрагдалтын түвшин бол 72 орчим хувьтай гэсэн нэг ийм мэдээлэлтэй байна. Өөрөөр хэлбэл иргэдийн эцсийн хэрэглээтэй харьцуулсан НӨАТ хамрагдалтын түвшин 72 хувь гэдэг ийм дүн мэдээ байна аа. Яах вэ 400 болговол суурь нь өөрөө багасаж байгаа учраас тодорхой хэмжээнд буурна. Гэхдээ шууд утгаараа нөгөө суутган төлөгчийн маань сайн дурын босго нь нөгөө талдаа 10 саяар доод хэмжээ нь бас сайн дурын босго маань 10 сая байгаа учраас яг ийм савлагаатай хэмжээгээр буурахгүй гэсэн ийм хүлээлттэй байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Арвижихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Түрүүчийнхээ хариултаа авч чадаагүй асуултаа нийлээд асуучихъя. Нэг багц хуультай холбоотой учраас. Хуулийн төслийн энэ би юу асууж байгаа шүү. Нөгөө Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор үл маргах журмаар гаргуулах татварын өрийн хэмжээ тухайн орлогын 80 хувиас

хэтрэхгүй байна гэсэн байгаа. Энэ 80 хувь гэдэг тооны ард ямар тооцоолол байсан юм бэ гэдэг тоо хариултыг авах хүсэлтэй байсан. Тэрийгээ тодруулъя.

Хоёрдугаарт нь НӨАТ-ын хөнгөлөлт дээр байдаг жагсаалт дотор тэр нөгөө туслах хэрэгсэлтэй холбоотой ямар ямар ангиллууд байдаг вэ гэж асуусан чинь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гаалийн татвар дээр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тохируулах тийм тоног төхөөрөмж автомашины асуудлыг л хариулсан. Өмнөх удаагийн хурал дээр. Тэгэхээр энэнээс өшөө давсан буюу эрүүл мэндийн туслах бүтээгдэхүүн гэж ангиллаар байж магадгүй. Ер нь ямар ангилалд нь таяг, тэргэнцэр, сонсголын аппарат, алхуулагч, мөн эрүүл мэндийн бусад багаж хэрэгслүүд тооцогддог вэ? Тэр жагсаалт нь ер нь хамгийн сүүлд хэзээ батлагдсан юм бэ? Энэ талаар мэдээлэл өгөөч? Яагаад гэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс НӨАТ шингэсэн үнээр тэр худалдаж авах гээд байгаа өөрийнхөө амьдралыг хялбарчлах гээд байгаа туслах технологиуд нь НӨАТ шингэсэн үнээр орох тусмаа өртөг нь өсөөд байдаг гэсэн үг.

Тэгэхээр л хүндрэлтэй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр ер нь манайх аль хавьцаа явж байгаа мэдээллийг авах зорилгоор би асууж байгаа. Тэгээд дараа нь эргэж хариулт дээр үндэслээд тодруулна гэсэн үг.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулах уу? Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Анх бол Засгийн газраас 80, 20 гэж өргөн барьсан нөгөө дансыг хаах нөгөө юун дээр зохицуулалтаар тэгээд тэрийг Төсвийн байнгын хороо болон ажлын хэсэг дээр 70, 30 болгосон байгаа. Нийт бол татварт үндсэндээ энэ чинь 30 хувийг нь нэмэгдүүлснээр дансанд үлдсэн мөнгөөрөө цалингаа тавих татвар төлөгчдийн тоо 31 мянгаас 47 мянга болж нэмэгдэх юм байна аа. Таны асуусан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал дээр хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс НӨАТ-аас чөлөөлж байгаа юм байна.

20 хувийг татвар төлөгчдийн дансанд үлдээсэн 31 мянган татвар төлөгч цалингаа бүрэн тавих боломжтой байсан бол 30 хувь болгосноор 47 мянга болох юм байна. Гаалийн тарифын хуулийн 38.1.1-ээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, хиймэл эд эрхтэн, тэдгээрийн эд ангийг гаалийн татвараас чөлөөлж байна аа.

Нэмээд хэн хариулчих уу? Чимидсүрэн хариулах уу?

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг.

Ч.Чимидсүрэн: Ганхуяг гишүүний хариулт дээр нэмж хариулъя.

Тэр тухайлсан тийм жагсаалт гардаггүй байгаа. Зүгээр яг хууль дээр түрүүний заасан нэр заасан тэр зүйл л чөлөөлөгдөж явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгэхээр ингэнэ гэсэн үг үү? Ер нь бол одоо туслах технологийн сэргээн засах туслах технологийн төвтэй болж байгаа. Одоо хуучин байсан протезын үйлдвэрийг тийм болгож засаад шинэчлэх гэж байгаа шүү

дээ. Гэр бүлийн яамны харьяа. Тэгэхээр тэрний харьяа ямар бүтэцтэй үйл ажиллагаа хийх гээд байгаа вэ гэхээр энэ туслах технологи гэдэг дотор чинь зөвхөн хиймэл хөл гараар хязгаарлагдахгүй олон төрлийн бүтээгдэхүүнүүд байгаа юм л даа. Жишээлбэл одоо хүнд ээлтэй нөгөө гараа чанга атгаж чаддаггүй хүнд халбага бариулахаас өгсүүлээд ойр зуурын амьдралын хэрэгслийн бараа бүтээгдэхүүн орж ирж байгаа гэсэн үг.

Тэгэхээр эдгээр бараа бүтээгдэхүүнүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даах чадварыг нь дэмжих зорилгоор татварын хөнгөлөлтөд хамруулдаг ийм бодлого байгаа гэсэн үг. Тэгэхээр энийг хийхийн тулд тусгай жагсаалт юм уу ямар төрлийн баримт бичиг гаргаж байж энэ баталгаажих юм. Одоо байгаа тэр тээврийн хэрэгсэл шиг ийм хуулийн заалт хэрэгтэй гэсэн үг үү? Эсвэл одоо сайдын тушаал журмын дагуу өөр баримт бичиг хэрэгтэй гэсэн үг үү. Энэ дээр мэдээлэл өгөөч?

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

Ч.Чимидсүрэн: Гаалийн тарифын тухай хуулийн 38.1.12-т энэ тахир дутуу, тэргэнцэртэй хүнийг суулгах, буулгах зам тавцан хөргүүртэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө жолоодох, удирдлага нь зөвхөн гар удирдлагатай.

Дээрхийн адил бүрэн тоноглогдсон, үйлдвэрлэгдсэн тусгай зориулалттай автомашиныг гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол яг энэ хуульд заагдсан зүйлээрээ л бид нар чөлөөлөлтийг гаргана. Тэрнээс нэмэлт юу гэдэг юм жагсаалт гаргаж явахааргүй байгаа юм. Хэрэв ингээд цаашид өргөжүүлэх шаардлагатай бол бид нар хуульдаа тодорхой энэ өөрчлөлтүүдийг оруулж байж л шийдвэрлэгдэх боломжтой болно. Тэгээд ерөнхий заалтаа аваад үзэхэд бас хуулийнхаа зохицуулалтаар л шийдэгдэхээр байгаа юм байна.

Ж.Бат-Эрдэнэ: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгэхээр яг хэдүүлээ харж байгаа биз дээ яг л одоо жишээлбэл тэр тусгай зориулалтын тоног төхөөрөмжтэй машин энэ тоног төхөөрөмж яг үнэндээ өдөр тутмын хэрэглээнд хэрэглэгддэг зүйл 1 дүгээрт биш.

Хоёрдугаарт тэр үнэтэй зүйлүүдийг группийн цөөхөн хэдэн төгрөг авч байгаа хүмүүс худалдаж авч чаддаггүй л байхгүй юу. Тэгэхээр машиныг оруулж ирээд өөрсдөө засаж янзлаад машиныг гар удирдлагатай болоод хувиргаад хэрэглэж байгаа Монголд жишээлбэл. Тэгэхээр ер нь бол эндээс юу харагдаж байна гэхээр цаашдаа энэ НӨАТ, гаалийн татварын зохицуулалт дотор шинэ жагсаалтыг хуульчлахаас өөр аргагүй юм байна гэдэг дүгнэлтийг би авлаа гэж ойлгож байна. Би энэ дээрээ яг баталгаатай хариулт авчихъя. Тэгэх юм бол бид нарын удахгүй яригдах энэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Халамжийн тухай хууль заалтууд дээр ийм агуулга орж ирэх нь байна шүү. Энэ дээр та бүхэн анхаарлаа хандуулж урьдчилж бэлдэх хэрэгтэй байх юм шүү гэдгийг л би хэлж ойлгуулах гээд асуугаад байгаа гэсэн үг. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сангийн яамныхан цаашдаа энэ Саранчулуун гишүүний хэлсэн дээр анхаарах хэрэгтэй байх аа.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би энэ нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой одоо намраас дахиад иж бүрэн шинэчлэлийн асуудал яригдаж байгаа юм байна гэж ойлголоо. Энэ удаагийн төслөөс гадна тэгээд л түрүүчийн ХХОАТ дээр хэлж байсан шиг дахиад нэмэгдсэн өртгийн албан татварыг бид нарт бодлогын хувьд нэг арай өөр өнцгөөс хараасай. Дараагийн өөрчлөлт шинэчлэлээ нэг үүнийг нэг харгалзаж үзээд оруулж ирээсэй гэж бодож саналаа хэлье. Тэгээд намрын чуулганаар би яг энэ асуултыг асууна. Та бүхнээс тэгэхээр хариултаа бэлдэх нь зөв байх.

Дэлхийн улс орнууд нэмэгдсэн өртгийн албан татварыг нэг талдаа өрхийн орлого, өрхийн зардлыг бас тодорхой хэмжээгээр хамгаалах зарим тохиолдолд ядуу өрхийн, орлого багатай өрхийн орлогыг хамгаалах бүүр зарим улс орнуудын хувьд жишээ нь суурь хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдсэн өртгийн албан татварыг жишээ нь тэглэх хүртэл ийм бодлогын арга хэмжээнүүд авч байна л даа. Жишээлбэл хүүхдийн сүү, сүүн тэжээлийн НӨАТ-ыг тэглэх, хүнсний бүтээгдэхүүн, өндөг, гурил, гурилан бүтээгдэхүүн ч гэдэг юм уу ингээд эдгээр бүтээгдэхүүний нэмэгдсэн өртгийг тэглэх замаар иргэдийнхээ суурь хүнсний хангамжийн асуудлыг яг энэ татварын бодлогоор дамжуулж шийдэж байна. Тэгэхээр бид нар яг нэг ийм талаас нь нэг арай өөр талаас нь энэ нэмэгдсэн өртгийн албан татварыг нэг яриасай нийгмийн ийм хэлэлцүүлэг өрнүүлээсэй гэж бодоод байгаа юм. Манай улсын хувьд жишээ нь эрүүл хүнс өрх айлын хүнсний эрүүл хэрэглээ рүү бид нар дэмжье гэвэл яг тухайн өрх айлын 1 сарын өрхийн 3 хүүхэдтэй өрхийн дундаж байдаг юм уу хамгийн суурь, хамгийн эрүүл ямар хүнсний суварга ямар бүтэц байж болох вэ гэдгийг жишээ нь ЭМЯ нь бодлогоороо гаргаад Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэйгээ хамт гаргаад түүнийг нь татварын бодлогоор буюу нэмэгдсэн өртгийн албан татварын бодлогоор дэмжээд эдгээр хүнсний бүтээгдэхүүнийг НӨАТ-ыг тэглэе гээд ингэж НӨАТ-ын бодлого маань өрх айлдаа мэдрэгдмээр байгаа гэсэн үг.

Хоёрдугаарт үүнийг дагаад нэг орж ирэх боломжтой бодлого нь юу вэ гэвэл гэртээ хоол хүнсээ хийж хэрэглэдэг тэр төрлийн бүтээгдэхүүнийг тэглэх нөгөө талаараа гадуур хоол иддэг илүү юу гэдэг юм нөгөө эрүүл бус хүнс хэрэглэдэг, бэлэн, хагас боловсруулсан, бэлэн бүтээгдэхүүн хэрэглэдэг ч гэдэг юм уу энэ хэрэглээг бууруулахын тулд энэ төрлийн НӨАТ-уудыг нь нэмдэг. Архины нэмэгдсэн өртгийн албан татварыг нэмэх гэх мэтээр ингэж нөгөө хүн амынхаа хүнсний хангамжийн бодлогыг сайжруулах, өрхийг илүү эрүүл хоол хүнсээр хангах энэ бодлогыг жишээ нь нэмэгдсэн өртгийн албан татвараар дамжуулж бид нар хэрэглэж болохоор байгаа байхгүй юу. Гэтэл яг ингээд НӨАТ-ын тухай маргаан мэтгэлцээн болохоор юун дээр очиж байна гэвэл босгыг нэмэх үү, бууруулах уу гээд ингээд дандаа хэдэн ААН-үүдийн дундах ийм яриа болоод байдаг. Яг өрх айл руу энэ бодлого өөрөө яаж орох юм бэ гэдэг энэ өнцгөөр бид нар энэ татварын бодлогыг хараад өгөөч ээ. Тэгээд дараа дараагийнхаа шинэчлэлийг энэ тал дээрээ тооцоо судалгаа хийгээд ороод ирээсэй гэж бодож байна.

Бид нар ирэх намар дахиад хүүхдүүдийн үдийн хоол, үдийн цайны хөтөлбөрийн том ажлыг манай энэ парламент Засгийн газар хийх ёстой. Дахиад энэ нь өөрөө нэмэгдсэн өртгийн албан татварын бодлоготойгоо яаж уялдах юм. Сургуулийн хүүхдийн үдийн хоол тухайн орон нутагт аж ахуй эрхэлж байгаа бизнес эрхлэгч жижиг дунд бизнес эрхлэлттэйгээ яаж холбох юм. Энэ 3-ын холбоос чинь өөрөө татварын бодлогоороо яаж илрэх юм гэдэг ийм хэмжээний ийм түвшний бодлого ярьдаг баймаар байна аа.

Тэрнээс 400 байх уу, 50 байх уу гээд энэ бол яг үнэндээ би бол бодлого биш гэж харж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Болдын Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Би хэлье гэж бодож байсан зүйлийг маань сая Баасанжаргал гишүүн бараг хэлчих шиг боллоо доо. Бид яг НӨАТ-ын бодлого дээр ААН рүүгээ чиглэсэн иргэд буюу яг эцсийн НӨАТ-ын татварыг төлөгч рүүгээ чиглэсэн энэ бодлогууд аягүй зөв зааглаж бодлогоо гаргаж ирэх ёстой. Энэ удаа хөндсөн нь ААН-үүд дээр гарч ирдэг тэр нэг жижиг ААН-үүд дээр гарч ирдэг энэ нэг тайлагналын зовлон байдаг юм. Тайлагнал нь өөрөө их зовлон. Том тайлан гаргадаг тэгсэн мөртөө жижиг ААН тэрэн дээр мэргэжлийн нягтлан хэрэгтэй эд нар гээд л 10 хувь эд нар гээд. Тэнд 10 хувийг байхгүй болгосноор сая Баасанжаргал гишүүний ярьсан яг тэр өрх гэр эцсийн худалдан авагчид ямар ч нөлөө байхгүй байхгүй юу. Ямар ч нөлөө байхгүй. Харин тэр ихэнх ААН-үүд дээрээ тэр чинь бараг буцаад нөгөө НӨАТ төлдөггүй ААН-үүдийн тэр хэсэг мөнгөн дүн чинь НӨАТ төлдөг ААН-үүд дээрээ торгууль болчхож байгаа байхгүй юу. Торгууль болчхож байна. Тэгээд НӨАТ төлдөггүйнүүд чинь одоо тэр бусад ААН-үүдтэйгээ хамт ингээд эргэлтэд орж чадахгүй, нөгөө гинжиндээ орж чадахгүй болж байна. Сугараад сугараад үлдчихнэ.

Тэгэхээр намар төсөв өргөн барихдаа уг нь Засгийн газар яг тэр ААН-үүд рүүгээ ч тэр, иргэд рүүгээ чиглэсэн эцсийн татварыг нь төлж байгаа тэр хэсэг рүүгээ чиглэсэн бодлогуудаа оруулж ирэх хэрэгтэй. Тэрэн дээр ямар шийдлүүд байгаа вэ гэхээр энэ 50 саяын босгыг 400 болгоод гэхдээ НӨАТ төлөгч хэвээрээ байна хэвээрээ байна. Тэгэхдээ хялбаршуулснаар нэг хувь л төлнө, нэг хувь л төлнө. НӨАТ төлөгч хэвээрээ. Тэгэхээр нөгөө сүлжээнээсээ нөгөө гинжнээсээ гарахгүй сугарч үлдэхгүй, хэн ч хохирохгүй, нөгөө томууд нь ч хохирохгүй, жижгүүд нь ч хохирохгүй. Ийм байдлаар шийдээд явчих боломж байгаа байхгүй юу. Харин яг тэр эцсийн татвар төлөгчийг сая энэ ХХОАТ дээр шаталж байгаа шигээ 2 хувь, 5 хувь, бүр 10 хувь, 100 хувь буцаан олгох ийм шатлалуудаар оруулж ирж болно. Тэр судалгаанууд хийгдсэн байгаа. Ингээд яг НӨАТ-ынхаа уг нь яг цогцоор нь том бодлого гээд байгаа нь энэ юм байгаа юм.

Дээрээс нь ААН дээр юу үлдчихээд байгаа вэ гэхээр манай НӨАТ бол ингээд шууд хугацаагаар нь шахчихдаг. Уг нь бол яг нөгөө мөнгөн суурьтай буюу борлуулалттай нь холбогдуулж НӨАТ-аа авдаг байх хэрэгтэй. Тэгэхийн тулд гааль дээр НӨАТ авахаа жишээ нь болих хэрэгтэй. Ямар ч борлуулалт хийгээгүй байхад нь гааль дээр борлуулалтынх нь НӨАТ-ыг авч болохгүй байхгүй юу. Оруулаад 2 сар өгөөд тайлан дээрээ борлуулалт нь ирсний дараа НӨАТ-аа авдаг байх жишээтэй. Мөнгөн суурьтай болгоё гээд. Энийгээ цогцоор гэж хэлээд байгаа юм.

Дээрээс нь түрүүн та асууж байсан Мөнхбат гишүүн хэдэн хувийн и баримт төлдөг вэ гээд. Тэгэхээр хэрвээ 400 болгоно гэдэг маань түрүүн хэллээ шүү дээ. Тэр 72 хувь хүрчхээд цаашаа 90 хувь болгоно гээд тэр зорилтыг бүр байхгүй болгоод бүр эсвэл эсрэгээрээ доошоо явчихна. Энэ чинь 2005 оноос хойш энэ чинь юу вэ 21 жилийн дараа нолиос дөнгөж 75 хүргэж дөхөж байгаа энэ үед буцаагаад явуулах гэж байгаа байхгүй юу. 2016 оных чинь НӨАТ-ыг и баримттай болсон. Энэ бол маш том ололт, маш том дэвшил байсан. И баримттай болгосон. Мөн 2 хувийн буцаан олголт буюу энэ урамшуулал сугалаа эд нар гээд маш зөв систем рүү орсон учраас энэ и баримт дээр суурилснаасаа хойш маш хурдтай нэмэгдсэн. 45-аас ерөөсөө 6 жилийн дотор 70 гараад явчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр дахиад уг нь нэг 4, 5

жилийн дараа бол манайх ингээд 90 хувиас дээш хүрэх татварын жинхэнэ суурь маань өөрөө тэлэх ийм бүрэн боломжтой болж ирэх юм.

Тэгэхээр ийм өөрчлөлтүүдээ хэдүүлээ энд мэтгэлцээд зөв болгоод Засгийн газар энийгээ дахиж оруулж ирээд хугацаа байна. Намар төсвөө өргөн барихдаа саяын яг НӨАТ-аа яг цогцоор нь оруулж ирээд ингээд явбал Их Хурал дэмжихээр байна гэж эндээс ингэж харж байгаа.

Тийм учраас энэ удаадаа тэр 50 саяыг 400 сая.

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Би бүүр илүү тодорхой нэг жишээн дээр ярьчихъя. Жишээ нь хүүхдийн шим тэжээлийг нэмэгдүүлэх маш хүчтэй бодлогын нэг нь жишээ нь татварын бодлого байж болохоор байгаа байхгүй юу. Шинэ өндөг, шинэ сүү, хүүхдийн шим тэжээлтэй тэжээлүүдийг нэмэлт хүнсүүдийг нэмэлт хүнсний ногоонуудыг бид нар НӨАТ-аас чөлөөлөх юм бол эсрэгээрээ сахар ихтэй ус ундаа жүүс ч гэдэг юм уу сахар ихтэй бүтээгдэхүүнүүдийн НӨАТ-ыг буцаагаад эсрэгээр нь нэмээд ингэж энэ НӨАТ-ын бодлогоор дамжуулаад хүүхдүүдийнхээ шим тэжээлийг сайжруулах ийм бодлого байж болно гэж хараад байгаа юм. Үүнийх нь цаана орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн маш том татварын бодлогын дэмжлэг үүснэ гэж. Тэгэхээр энэ яг НӨАТ-ыг түрүүн Жавхлан сайдын хэлдэг зөвхөн ААН-д зориулсан ийм байдлаар энийг битгий хараач. Яг хэрэглэгч талаас нь өрх айл талаас нь жижиг дунд бизнес эрхлэгчдэд үзүүлэх нөлөө талаас нь ингээд бүтэн экосистемээр нь энийг ингэж нэг том дүр зургаар нь.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Энэ сая Баасанжаргал гишүүний хэлсэн үг дээрээс нь сайд асан Жавхлан сайдын, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жавхлангийн хэлсэн үг эд нарыг нэгтгээд намар тийшээгээ энэ бодлогыг нь ер нь нэгтгэж оруулж ирсэн нь дээр байх аа.

Ерөнхий сайд үг хэлэх үү? Учрал сайд, Ерөнхий сайд.

Н.Учрал: Их Хурлын ажлын хэсэгт талархаж байна аа.

Энэ Татварын ерөнхий хууль болон бусад хуулиудыг Их Хурлаар баталж байгаа явдалд гүн талархалтай байна. Ганхуяг гишүүнтэй энэ ажлын хэсэгт талархаж байгаагаа илэрхийлье. Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг 400 сая болгоё гэдэг бодитой үндэслэлтэй. Ийм шинэчлэл яагаад вэ гэхээр нийтдээ 23 мянган ААН түүнээс чинь бараг энэ дотор чинь зөвхөн ААН-үүд биш иргэд байгаа байхгүй юу. Тэр суутган төлөгчийн босгын 50 саядаа тухайн НӨАТ төлөгч маань хүрчихээрээ түүнийгээ иргэд дээр бусад хамаарал бүхий гэр бүлийнхэндээ ч юм уу ингээд хуваарилаад тэр жижиглээд байгаа юм харин эсрэгээрээ. 400 сая гээд босгыг нь ингээд нэмэгдүүлчихсэн тохиолдолд бол ийм жижиглэх асуудал үүсэхгүй. Тэр яг хуулийнхаа хүрээнд тэр НӨАТ-аа төлөөд л явна л гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр бараг 23 мянган ААН иргэдийг дэмжих зөв бодлого энэ НӨАТ-ын суутган төлөгчийн босгыг 400 сая болгож байгаа явдал. Энийг иргэд аж ахуй нэгжүүд бол анхааралтай ажиглаад хараад сууж байгаа. Тийм учраас энэ НӨАТ-ын суутган төлөгчийн босгыг Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ 400 сая төгрөг болгож

нэмэгдүүлснээр нь би бол дэмжиж өгөх нь бид нарт өндөр ач холбогдолтой гэж ингэж үзэж байгаа юм аа.

Зүгээр и баримтаар бид нар бүгдийг нь бүртгэж аваад 100 хувь буцаагаад олгоод явж болно шүү дээ. Хэрвээ үнэхээр далд эдийн засаг дэмжинэ гэж ийм шүүмж байвал гэхдээ одоо ч гэсэн яг адилхан. Ерөөсөө 50 саяынхаа босгонд хүрээд л ирэхээрээ жижиглэхчхдэг байхгүй юу. 400 сая болгочихсон тохиолдолд ийм жижиглэх асуудал үүсэхгүй. Яг хуулийнхаа хүрээнд 23 мянган ААН-ийг бодит утгаар нь дэмжих ийм бодлого гэж бодоод байгаа юм. Тэгээд үүний хүрээнд бичил жижиг ААН-үүд, хувь хүн, бизнесээ өргөжүүлэх томруулах нөхцөл бүрдэнэ. Дээрээс нь ААНОАТ, хувь хүний орлогын албан татварын бааз суурийг нэмэгдүүлнэ. Харин ч эсрэгээрээ далд эдийн засгийг бууруулах эерэг нөлөөтэй ийм бодлого бол энэ 400 саяын босго юм гэж би бол одоо үзэж байгаа юм.

Тийм ч учраас Засгийн газар өргөн мэдүүлсэн энэ татварын хуулийн шинэчлэл бол нөгөө нэг хувь дээр бол 2.5 болгосон нь өөрөө бараг 180 мянган компанид байхгүй юу. Энэ НӨАТ-ын суутган төлөөлөгчийн босгын 400 сая чинь 23 мянган компанид 6-10 тэрбум дээр байгаа чинь бараг 300 компанид гээд бүлэг бүрд хүрсэн бодлого энэ юм гэж болж байна. 50 саяын бөөгнөрөл огт үүсэхээс болино. Энэ 400 сая болгочихвол.

Ж.Бат-Эрдэнэ: 13 цаг болсон байна. Чуулганы хуралдааныг үргэлжлүүлье. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Аан санал хураалтыг 17 цаг болгосон байгаа. Яах юм завсарлах гээд байгаа юм уу? 14 цаг хүртэл завсарлалаа.

ЗАВСАРЛАГА

14.39 цагт

Тав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Ж.Бат-Эрдэнэ: Үдээс хойших хуралдааныг эхлүүлье. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Хуулийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх талаар Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин танилцуулна. Энхтүвшин таныг урьж байна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нараас 2026 оны 3 сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 6 сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 сарын 18-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Доржсүрэнгийн Жаргалсайхан Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Биеийн тамир спортын залуучуудын газрын дарга, Цогтжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн дарга, Эрдэнэсайханы Билэгт Биеийн тамир спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон намын бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж хариулт авна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн алга байна, Гомбын Ганбаатар гишүүн алга байна. Байнгын хороо хуралдаад байгаа. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн нэрээ татаж байна аа. Одоо асуулт асуух гишүүд байхгүй тул асуултыг тасаллаа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах тухай батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

14.16 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Ж.Бат-Эрдэнэ: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдөр ажлын 5 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагатай холбогдуулан АН-ын бүлгийн даргаас санал алга байна.

Чуулганы хуралдааны 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар эрх бүхий албан тушаалтны саналыг сонссон. Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн

байгуулалтын байнгын хорооны дарга Жавхлан танилцуулахаар байгаа. Төрийн байгуулалтын байнгын хороо одоогоор хуралдаж байгаа тул энэ асуудлыг түр хойшлуулъя аа.

Дараагийн асуудалдаа оръё.

Зургаа.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Ж.Бат-Эрдэнэ: Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт батлах бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Тогтмолын Мөнхсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Т.Мөнхсайхан: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн нэг саналын томьёоллоор санал хураахад байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хувилбар болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Отгонзулын Онон ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн бодлого төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч, Хурцаагийн Цэрэнханд ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын салбарын бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн, Ядамын Хишигт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн зөвлөх. Ажлын хэсгийг урья.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж хариулт авна. Нэрсийг өгсөн байна. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн алга байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн алга байна, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна, Отгоны Саранчулуун гишүүн алга байна, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Ажлын хэсгийг оруулъя.

Х.Баасанжаргал: Хүнсний тухай хууль дээр миний гол асуугаад байр суурь илэрхийлээд байгаа нэг гол зүйл маань энэ хүүхдийн үдийн хоолны асуудал байгаа сургуулийн. Дунд анги, ахлах ангийнхан үдийн хоолонд хамрагдах ёстой бид нар хуулиа баталчихсан. Хэрэгжих хугацаагаа хойшлуулаад байгаа. Тэгэхээр энэ сургуулийн хүүхдийн үдийн хоолны хүнсний хангамжид энэ удаагийн Хүнсний тухай хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлт ямар эерэг өөрчлөлт үзүүлэх вэ? яаж харж байгаа вэ гэдэг ийм асуултыг асууя.

Хамгийн гол нь бид нар ялангуяа Улаанбаатар хотоос гадна хөдөө орон нутагт байгаа сурч байгаа хүүхдүүдийнхээ энийг зүгээр нэг удаагийн хоол гэж харж болохгүй. Хүүхдийн хамгийн гол нь шим тэжээл авч авах хамгийн чухал яг цаг дээр нь буюу яг өдрийн цагаар дээрээс нь яг өсвөр насных нь хөгжиж байгаа өсөж байгаа яг энэ цаг үед өгч байгаа ийм хоол хүнсний асуудал байгаа. Тэгэхээр энэ хүнсний хангамжийн асуудал, хүнсний эрүүл аюулгүй асуудал, хүнсний аюулгүй сүлжээний асуудал, хадгалалт хамгаалалтын асуудал гээд маш олон асуудлыг бид нар орон нутгийн түвшиндээ шийдэх ёстой байгаа. Тэгэхээр нөгөө асуудлыг зөвхөн Улаанбаатараар биш хөдөө орон нутгийн түвшинд нь харах хэрэгтэй байгаа учраас илүү яг том дүр зургаараа яг энэ Хүнсний тухай хууль дээр яг энэ асуултыг асуугаад байгаа.

Нөгөө талаараа ханган нийлүүлэгч гэж байгаа. Орон нутагт хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг жижиг дунд бизнес эрхлэгчдийг зах зээлийг дэмжих тэлэх маш том бас хөшүүрэг бодлого гэж бид нар энийг харах ёстой. Тэрэнд манай хүнсний ханган нийлүүлэгчид хэр бэлэн бэ? ХХААЯ-аас авсан судалгаагаар нөгөө хүнсний ногоо буюу хүнсний ногоо дотроо илүү дандаа нөгөө бүдүүн ногоо гэж ярьдаг бид нарын төмс, лууван, байцаа ч гэдэг юм уу ийм өргөн хэрэглээний ногоо, зарим нэг гурилын үйлдвэрүүд мах, махны ханган нийлүүлэлт эдгээр ханган нийлүүлэлт дээр бол тоо статистикууд гараад байгаа. Гэтэл зөвхөн бид нар хүүхдийн үдийн хоолыг зөвхөн мах, гурилаар ерөөсөө төсөөлж болохгүй. Маш нарийн шим тэжээлийн чанар стандартын өндөр шаардлага хангасан ийм хүнсийг өгөх ёстой.

Тэгэхээр яг ханган нийлүүлэгчид хэр энэ ханган нийлүүлэлтийн сүлжээнд бэлэн байгаа юу? Энэ хүнсний тухай хууль хамгийн гол нь энэ дээр ямар хөшүүрэг оруулж ирж байгаа вэ гэдэг ийм асуултыг асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Мөнхсайхан гишүүн хариулъя.

Т.Мөнхсайхан: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя аа. Ер нь энэ Хүнсний тухай хууль дээр ер нь ЕБС-ийн энэ хоол үйлдвэрлэл технологи хангамжийн талаар өөрчлөлтүүдийг оруулж тусгаагүй. Яагаад гэвэл ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хууль гээд тусдаа хууль байгаа. Энэ хуулийн зарим зүйл заалтууд бас хэрэгжихгүй тал байгаа. Энэ бүх ЕБС-ийн хүүхдүүдийг тэгш хүртээмжтэйгээр үдийн хоолоор хангана аа гэсэн энэ заалт бол өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байгаа. Бид нар цаашдаа энэ ирээдүй болсон хүүхэд залуучуудаа энэ өдрийн хоолоор нь хангадаг. Өнөөдөр 6 дугаар анги хүртэлх хүүхдүүдийг хангаж байгаа зүйлийг бүх ангийнханд хангадаг болдог энэ тогтолцоо зайлшгүй шаардлагатай.

1 дүгээрт энэ одоо байгаа хуулиа биелүүлэх хэрэгтэй байна. Ханган нийлүүлэлт тал дээрээ өнөөдөр үнэхээр ерөнхий боловсролын сургуулиудын хоолны чанар, хүртээмж, шим тэжээлээ авч байгаа байдал бол үнэхээр их учир дутагдалтай байгаа. Бодит байдал дээрээ хүүхэд бол авах ёстой шим тэжээлээ сургууль дээрээ өгч байгаа өдрийн хоолоор хангалттай авч чадахгүй. Энэ нь харилцан адилгүй эрүүл аюулгүй хүнсээр үнэхээр хангагдаж чадаж байна уу гэдэг маань төдийлөн бас төгс шийдэгдэхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулиа хэрэгжүүлэх энэ дээр томоохон хэмжээний өөрчлөлтүүдийг хийж байж үндэсний хэмжээнд хүнсээр хангадаг энэ сүлжээг бий болгож байж энэ тогтолцоондоо өөрчлөлт орж байж энэ зүйлүүд өөрчилнө өө.

Тэгэхээр энэ маань Хүнсний тухай хуулийн өөрчлөлтөөр биш түрүүний хэлсэн ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулиар илүү их шийдэгдэх ёстой гэж харж байгаа юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль санаачлагч Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Баасанжаргал гишүүн их чухал асуудлыг хөндөж байна. Тэгээд бас нөгөө ЕБС-ийн Хоол үйлдвэр, үйлчилгээний тухай хуулийн одоо бас ажлын хэсгийг байнгын хороон дээр ахлаад энэтэй холбоотой ажлуудыг явж байсан. Тэгээд ерөнхийдөө яах вэ Хүнсний тухай хууль өөрөө суурь хууль тэгээд. Тийм учраас суурь хуульдаа бид нар бас яг нэн шаардлагатай байгаа, бас хангагдахгүй байгаа зохицуулалтыг оруулах шаардлагатай гэж үзээд энэ 5 дугаар зүйл дээр бид нар бас энэ 5.8 дээр энэ хуулийн 5.5-д заасан цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгайлан хуулиар зохицуулна гэдгийг зааж өгсөн. Дээрээс нь 5.7 дээр болохоор хүнсний хангамжийг тодорхойлохдоо нэн тэргүүнд нялх балчир хүүхдийн хоол тэжээл цэцэрлэг, сургуулийн хүнсний хүртээмжийн асуудлыг тусгана аа гэдгийг нь зааж өгсөн байгаа. Тэгэхлээр энэ өөрөө хүнсний хангамж логистикийн тогтолцоо бүрдэж ирэхгүй байсан учраас бид нар суурь хуульдаа энэ хүнсний хүүхдэд хүүхдийн хоолны асуудлыг бол тусгай...

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

М.Мандхай: Дээрээс нь бид нар энэ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилготойгоор оруулж өгсөн юмаа. Ер нь бол одоо ингээд өөрөө зах зээл тодорхой байх ёстой. Тэгэхээр энэ нөгөө нэг хүүхдийн хоол үйлдвэрлэл бид нар дотоодын одоо хоол хүнсний үйлдвэрлэлээр хангаж өгнө өө гээд тусгайлан заагаад өгөхлээр ерөнхийдөө орон нутаг болон нийслэлийн энэ хоол үйлдвэрлэл өөрөө энэ одоо хүүхэд хүүхдийн хоолыг хангах зорилготойгоор үйлчилгээ сайжирна 1 дүгээрт.

2 дугаарт энгийн ялангуяа орон нутагт Засаг дарга өөрөө нэгдсэн төлөвлөгөө батлаад сургуулийн хоол үйлдвэрлэлийн хүнсний нөөцийг орон нутгийн байгалийн баялаг хөдөө аж ахуй үйлдвэрлэл, дэд бүтцийн талыг ашиглана, бүрдүүлнэ ээ гээд ерөнхий боловсролын хоол үйлдвэр үйлчилгээний хуульдаа заагаад өгчихсөн байгаа. Тэгэхлээр энэ өөрөө хангагдахын тулд хамгийн энгийн зохистой стандарт дадал өөрөө хэрэгжихгүй яваад байгаа юмаа. Тийм учраас энэ стандарт дадлыг хамгийн анхан шатны стандарт дадлыг нэвтрүүлдэг болохын тулд бас яг энэ хүнсний суурь хуульдаа хүүхдэд хоол өгөх гэж байгаа бол анхан наад захын стандарт...

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Би яагаад үдийн хоолыг Хүнсний тухай хуультай холбож асуусан бэ гэдгээ нэг тодруулчихъя. Энэ яалт ч үгүй суурь хууль учраас ЕБС-ийн хоол хүнсний тэжээл гээд ингээд тэр хууль бол тусдаа яг тэр салбар дээр хэрхэн менеж хийх юм, хэрхэн зохицуулалт хийх тухай л гэдэг хууль. Гэхдээ энэ Хүнсний тухай хууль чинь хүнснийхээ аюулгүй байдал, хангамж, хамгийн гол зүйл нь нөгөө 5 жил тутамд хийгддэг яг Монгол хүн баруун аймагт амьдарч байгаа бол зүүн аймагт амьдарч байгаа бол, хойд хэсэг Өмнөговьд амьдарч байгаа бол хүнс шим тэжээл нь ямар байх ёстой юм, байгаль цаг ууртайгаа хэрхэн дасан зохицож байгаа юм гэдэг судалгаанууд чинь өөрөө тогтмол хийгдээд энэ чинь өөрөө төрийн олон бодлогын суурь болох ёстой гэж би хувьдаа хараад байгаа байхгүй юу. Наад зах нь татварын бодлогын суурь болох ёстой шүү дээ.

Би түрүүн хэлж байсан. Нэмэгдсэн өртгийн албан татвар гэхэд жишээ нь суурь хүнсээ бид нар НӨАТ-аас чөлөөлөгдөх замаар хүнс чинь өөрөө хүний биед эрүүл орох тэр өрх рүү бид нар энэ татварын бодлого...

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн нэмэлт хариулт.

М.Мандхай: Яг тийм. Тийм болохоор энэ хүнсний суурь хуульдаа 5.5 дээр бид нар хүн бүрийн энэ эдийн засгийн боломж, газар зүйн байршил, нас, биеийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон тэр хүнсийг тогтмол хангалттай хэмжээнд нь авах боломжийг бүрдүүлэх замаар хүнсийг одоо хүртээмжтэй арга хэмжээг Засгийн газар авч хэрэгжүүлнэ ээ гээд Засгийн газарт нь бүүр үүрэг болгоод өгчихсөн байгаа. Тэгэхлээр бид нар одоо хэлсэн. Тухайн байршил, газар зүйн онцлог, нас, тэр хүртээмж хангамжийн асуудлыг Засгийн газар анхааралдаа авч ажиллах ёстой шүү гэдгийг энэ хуулиараа бас нарийн зохицуулж өгсөн. Тэгээд 5.5 дээр оруулсан араас нь дагаад 5.6 дээр бид нар хүнсний хангамж тодорхойлохдоо нэн тэргүүнд нялх балчир хүүхдийн хоол тэжээл цэцэрлэг, сургуулийн хүнсний хүртээмжийн асуудлыг тусгана аа гэдгээр нь бас оруулж өгсөн байгаа юмаа.

Ж.Бат-Эрдэнэ: Та бүхэндээ зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Тувааны урилгаар Төв аймгийн Баянчандмань сумын ЕБС-ийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг нийт гишүүдийнхээ өмнөөс өргөн мэндчилж дэвшүүлж байна аа.

Жанчивын Галбадрах гишүүн асуултаа асууя.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Хамгийн гол нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд зааснаар хүнсний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн гэсэн. Тэгээд энэ зорилгыг нь хангахад чиглэсэн гол хууль байна аа гэж харж байгаа. Тэгээд Хүнсний аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг гэж ингэж анх удаа хуульчилж байна гэж ингэж талархан хүлээж авч байгаа. Энэ бол том ахиц байна аа гэж үзэж байна. Тэгээд асуух зүйл байна.

Хүнсний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, хэрэгжилт, хүнсний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан гэж байна. Энэ тайлангийн 101 дүгээр хуудсанд дүгнэлт зөвлөмж гэсэн хэсэгт нь хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ 32.5 хувьтай байна гэж тэмдэглэсэн. Тэгэхээр энэ бол маш бага хувьтай байна. Тэгээд энэ цааш нь унших юм бол маш олон ийм дүгнэлтүүд байна лээ. Тэгэхдээ энэ төслийн нэмэлт, өөрчлөлт орсноор энэ үзүүлэлт хэрхэн сайжрах вэ? тийм тооцоо бий юу гэдгийг 1 дүгээрт асууя.

Дараа нь хууль батлагдсанаар импортын хүнс нь импортын ямар өөрчлөлт орох вэ? Импортоор орж ирдэг хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх үү? буурах уу? Мандхай гишүүний өгсөн ярилцлагыг уншиж байсан. Тэгээд хувийн хэвшлийн үйлдвэрлэж байгаа болон импортоор орж ирж байгаа бүтээгдэхүүний ялгаа арилахаа больчихсон байна аа гэдгийг та хэлж байсан. Тэгээд импортын хараат байдалд бид орсон. 46 хувьд хүрчихсэн гэсэн ийм зүйлийг хэлж байсан. Тэгэхээр хүнсний хангамжийн тэр импортын 49 хувийн хамаарлыг бид нар энэ хууль гарснаар бууруулах тийм алхам хийгдэх үү гэдгийг асууя.

Дараа нь 3 дахь асуулт бол энэ нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гэж гаргасан байгаа. Тэрэн дотроо та бүхэн маань сайн мэдэж байгаа. Цэцэрлэг 9 дүгээрт нь одоо ингэж бичсэн байгаа юм. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл хамгийн үнэтэй, хамгийн чанаргүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээр нийлүүлэгдэж байгаа нь хүнсний хангамжийн нэг хэсэг болсон хүүхдийн хүнсний хангамж ханган нийлүүлэлтийн асуудал нь эдгээр асуудал нь хүнсний болон боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дунд зохицуулалтгүй орхигдсонтой холбоотой гэсэн. Тэгээд энэ зохицуулалтыг яаж хийж байгаа вэ гэдгийг бас тайлбарлаж өгөөч ээ гэж хүсэж байна.

Ер нь тэгээд сая Баасанжаргал гишүүний асуулттай нэлээн давхцаж байгаа юмаа энэ. Тэгээд энэ ажилчид, тогооч гал тогоонд ажиллах хүмүүсийн орон тоо бол маш хангалтгүй байгаа. Сургууль одоо өөрөө аваад явъя гэхэд энэ асуудлууд бол маш их дарамт юунууд ирж байгаа. Хүнд түрээслэх гэхээр нөгөө түрээсэндээ мөнгө нь яваад хүүхдэдээ илчлэг илчлэгтэй хоол нь очиж чадахгүй байгаа. Үдийн хоолны мөнгө 2500 гэсэн байгаа ийм үнэтэй байна. Тэгэхээр энийг улсын төсөв энэ тэрд тусгахад энэ хуулийн заалтыг хэрэгжүүлснээр энийгээ бариад явахад бид нар сая

хариулж л байна. Улсын төсөвт хүүхэд үдийн цайны мөнгийг нэмэгдүүлэхэд юм байх уу? Тэгээд ер нь халдвар өвчлөл буурах уу? Тэр талын тооцоолол нь ямар байна?

Одоо энэ үдийн цай хөтөлбөр ингээд өгөгдсөнөөс болоод хүүхдүүдийн нөгөө аяга, халбага авч явж байгаа зүйлүүд тэрний цэвэрлэгээ ариун цэврээс болоод хеликобактер ихэссэн гэсэн ийм тоо байдаг. Энэ талаар та бүхэн маань яг сургууль дээрх энэ хүнс бүтээгдэхүүн би бас боловсролын салбарын хүн учраас үдийн цай хоолтой холбоотой ямар шинэчлэлүүд яг энэ ариун цэвэр талаасаа, тэр аюулгүй байдал талаас нь бол би асууж байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Мандхай гишүүн.

М.Мандхай: Маш чухал асуудал хөндлөө. Энэ хууль ер нь хэрэгжсэнээр ямар үр дагавар гарах вэ гэхлээр би нэг 4-5 асуудлыг тодорхой түвшинд бас хэлье гэж бодож байна. Ер нь яах вэ таны хэлсэн одоо энэ олон улсын бид нар хүлээгдэж байгаа түгээмэл тунхаглал, урт хугацааны Алсын хараа 2050, дээрээс нь энэ хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тогтоолд угаасаа хүн аюулгүй шим тэжээллэг хүнсээр тогтвортой хангах ёстой гэдэг зорилтыг бид нар хангахын төлөө явах ёстой. Тэгээд 1 дүгээрт биднүүс төрөөс энэ хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэлийг бид нар тодорхой болгож, хүнсний хангамж, хүртээмж, дотоодын үйлдвэрлэлийн тогтвортой байдал, хүнсний сүлжээний бүх энэ үе шатууд дахь энэ аюулгүй байдал зөв зохистой хооллолтыг дэмжих, салбарын эрсдэлийг даван туулах чадавхыг бид нар бүрдүүлэхээс гадна энийг хийхийн тулд гол хөшүүрэг болсон энэ хүнсний сүлжээний хүрээг өргөжүүлэх, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, тэр тээвэрлэлт, түгээлт, цахим худалдаа, хүргэлт зэрэг энэ хангалттай зохицуулагдаагүй байсан энэ үйл ажиллагааг бид нар хамруулан стандарт техникийн зохицуулалтыг мөрдүүлэх энэ эрх зүйн үндсийг бас бий болгож байгаа.

Тэгээд таны энэ дээр удаа дараа хэлж байгаа энэ асуудал маш чухал асуудлыг та хөндлөө. Үндсэндээ бол бид нар зохистой дадал гэдэг зүйл сүүлийн 14 жил сайн дурын жишгээр явж ирснийг хуульчилж өгч байгаа юм. Энгийн одоо энэ гал тогоо эрүүл ахуйн шаардлага хангасан зохистой дадлуудыг бид нар нэвтрүүлж ээ. Хуульдаа хэрэгжүүлэх энэ зохицуулалтыг оруулж өгсөн. Ингэснээр бид нар таны хэлээд байгаа одоо энэ үдийн хоол хүүхдийн энэ халдвар өвчлөл эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа энэ асуудлууд дээр илүү одоо энэ зохистой дадал хэрэгжсэнээр ариун цэвэр илүү их сайжрах энэ зохицуулалт гаргаж байгаа.

Мөн энэ шим тэжээлийн 6 дугаар судалгаагаар шим тэжээл сайжирснаар халдварт бус өвчлөл буурах байгааг бол тогтоосон байгаа. Тэгэхлээр бид нар энэ хүүхдүүдийн зүгээр хоолыг шим тэжээлгүй хоол гэхээсээ илүүтэй шим тэжээлтэй хоолоор баталгаат хүнсээр хангах асуудлыг бас хуульдаа зохицуулж тусгаж өгсөн. Ингэснээр энэ хүүхдүүдийн халдварын өвчлөл эрүүл ахуйн шаардлага хангасан анхан наад захын минимум шаардлага болох зохистой дадлыг ААН-үүд хэрэгжүүлэх ёстой. Бид нар өнөөдөр 200 ААН-ийн асуудал биш 3.5 сая хүний эрүүл хүнсний асуудлыг ярьж байгаа. Тэрэн дотроо нэн тэргүүнд тавигдах ёстой нялх балчир хүүхдүүдийн одоо энэ өвчлөлийг хамгаалах энэ зохицуулалтыг энэ хуульдаа оруулж өгснөөрөө бас тусгаж өгсөн байгаа гэдгийг нь бас хэлье ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Тийм эд нар импортын барааны талаар асуусан байж байгаа. Тэрэн дээр хариултаа авъя. Тэрнээс гадна бас энэ дотоодын хүнсний бүтээгдэхүүн бид нар төмс хүнсний ногоо бид нар 100 хувь төмсөө дотооддоо үйлдвэрлэж байна аа гээд ингээд ярьж байна тийм үү. Тэгэхээр яг үнэхээр ийм энэ хууль гарч ирээд дотоодын хүнсний бүтээгдэхүүнийгээ ингээд дэмжиж ингэж ирснээр ийм гаднаас ялангуяа бид нарт янз бүрийн бордоогоор химийн бүтээгдэхүүн орчихсон ийм төмс хүнсний ногооноос эхлээд энэ бүтээгдэхүүн гурил, будаанаас эхлээд байж байна. Тэрнээс гадна мах гэсэн ийм шаардлага байж байгаа. Энэ дотоодын мах махан бүтээгдэхүүн дээр тавигдах энэ шаардлагууд дээр ямар дэвшил өөрчлөлт гарах вэ гэдэг асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Тэгэхээр өнөөдөр таны хэлдгээр нөгөө хүнсний аюулгүй байдал би бол зөрчигдсөн гэж харж байгаа. Өнөөдөр 46 байтугай одоо бараг 50 орчим хувьд нь бид нар импортоор хүнсээ хангаж байгаа 1-д.

2 дугаарт бид нар хүнсний одоо энэ хяналтын тогтолцоо өөрөө маш сул байгааг энэ хуулийн хэрэгжилт өөрөө 32.5 хувьтай гэдгийг нь үр дагаврын үнэлгээгээр үзүүлчихсэн. Тэгэхлээр бид нар энэ импортыг дэмжих, хөхиүлэн дэмжихээс илүүтэй дотоодын үйлдвэрлэлд нь дотоодын үйлдвэрлэлийг дэмждэг, төрөөс олгож байгаа тэр дэмжлэг нь өөрөө дотоодын үйлдвэрлэлийг илүү баталгаатай аюулгүй хүнсээр хангадаг. Энийг нь зах зээлийг нь тэлж өгөх нэг том өөрөө зах зээл энэ ЕБС-ийн хоол үйлдвэрлэл байгаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ хуульд суурь хуульдаа бид нар импортыг бус эсрэгээрээ дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэмжих, ингэснээрээ эргээд нөгөө буух эзэнтэй, буцах хаягтай ийм...

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдал, түүний хяналт хүний нөөцийн тогтолцоо эд нар гэдгийг бол ингээд Хүнсний тухай хуулиараа нэгмөсөн багцлаад, хооронд нь уялдуулаад оруулаад ирж байгаа нь маш сайн хэрэг гэж үзэж байгаа учраас дэмжиж байгаа. Тэгэхдээ 5.7, 8.1.8 гэсэн заалтууд энэ бол хүүхдийн хоол тэжээлийн асуудлыг онцгойлон анхаарсан байна. Өнөөдөр яах вэ миний асуулт бол яах вэ энэ сургууль дахь, цэцэрлэг дэх энэ хоол хүнсний асуудлыг тойрч асуух боловч яг тэрэндээ ч бас биш гол нь үйлдвэрлэгч нарыг хэрхэн дэмжих, тэр дотроо орон нутгийн үйлдвэрлэгч нарыг хэрхэн дэмжих асуудлыг тойрч ярина. Өнөөдөр 716 сургууль төрийн өмчийн 221 цэцэрлэгт төсвөөс бол дунджаар нэг 330 орчим тэрбум төгрөгийг бол хоол хүнсэнд нь хоол үйлдвэрлэлд нь зориулж ингэж гаргаж байгаа.

Тэгэхээрээ энэ нэг хуулийн төслийн 8.1.8 дээр цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын үйлдвэрлэлийн хүнсний түүхий эд хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрийн аргаар боловсруулсан мах нийлүүлэх гээд заачихсан байгаа. Тэгээд би энэ дээр болохоороо зэрэг энэ ярих гээд байгаа нь энэ үйлдвэрийн аргаар боловсруулсан мах гэдэг энэ үг. Тэгэхээр энэ одоо ухаандаа нэг сумын төвийн сургууль байлаа гэхэд малчид нь ойр орчимд нь одоо ингээд бэлчээрийн аргаараа малаа ингээд боловсруулаад явж байгаа. Гэтэл энэ махаа сургуульд нь нийлүүлье гээд идэшний цагаар ч гэдэг юм уу, сургууль эхлэхээр ингээд хэлцэл хийгээд ороод ирэхээр энийг нь үйлдвэрлэлийн аргаар л боловсруулсан бол бид авна аа гээд. Тэгэхээр чинь тэр махаа одоо Улаанбаатар

луу үйлдвэрээр боловсруулдаг газар луу тууж аваачиж байж нийлүүлэх ийм болчихож байгаа. Тэгээд тээврийн зардал нь маш их гарна. Тэгэхээрээ энэ дээр яг энэ ийм үгээрээ байгаа юу би эсвэл жоохон андуураад байна уу тэрийг өөрчилсөн үү? Энэ тэгвэл хуучин юу байна? Тэгэхдээ юу ч гэсэн энэ дээр нэг тайлбар өгөөрэй. Яагаад гэвэл амьдрал дээр ийм юм гараад байдаг учраас асуугаад байгаа юм. Тэгэхээр энэ үгийг уг нь бол чадвал аюулгүй аргаар боловсруулсан мах нийлүүлэх гээд ингээд бас оруулчихвал орон нутгийн үйлдвэрлэгчдийн оролцоо, нийлүүлэлтийн эзлэх хувь, худалдан авалтын бодлогыг бол илүү сайн тусгаад өгнө өө гэж ингэж харж байгаа.

Түүний зэрэгцээ бас энэ Засаг даргын оролцоог бас энэ 5.2, 3-ын штрих 1 дээр бол тусгасан байгаа юм. Ханган нийлүүлэлтийн нэгдсэн төлөвлөгөө батална аа гээд. Энэний үр дүнг нь ер нь яаж тооцох гэж байна. Яг орон нутгийн үйлдвэрлэгчдийн оролцоог хэрхэн хангасан байна вэ гээд. Ер нь бол хүнс үйлдвэрлэл чинь яг орон нутагтаа үйлдвэрлэсэн зүйлээ л идэж уу, аюулгүй хүнсээ идэж уух юм бол 1 дүгээрт Фүүд Майл гээд ойлголт байдаг. Энэ нөгөө хүнс зөөж тээвэрлэхэд зарцуулсан энэ их малтмал түлшийн, өөрөөр хэлбэл бензиний зардал энэ бүх зүйлүүд ингээд хэмнэгддэг энэ нь бол байгаль орчиндоо ээлтэй байдаг. Түүний зэрэгцээ орон нутагтаа ургасан орон нутгийнхаа хөрсөнд бий болсон энэ хүнсний бүтээгдэхүүн мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүнийг ашиглах нь бол илүү сайн байдаг аа гэсэн ийм ойлголт байдаг. Энийг энэ одоо ямар тогтолцоо оруулав аа гээд энийг асуух гэсэн юм.

Тэгээд хамгийн эцэст нь болохоороо зэрэг миний зүгээс асуух зүйл бол ярих зүйл энэ НӨАТ-ын 13 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг дээр уг нь Монголд үйлдвэрлэсэн, бий болгосон, ургуулсан ийм хүнсний ногоо, сүү сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн эд нарыг бол Нэмүү өртгийн албан татвараас, НӨАТ-аас нь чөлөөлнө гэж заасан байдаг. Харамсалтай нь 13.10 дахь заалтад нь дамжуулан борлуулагч гэж хаана ч тодорхойлоогүй нэг ийм ойлголт оруулж ирээд, энэ дамжуулан борлуулагчаар зарж байвал 10 хувийг нь нэмж авна аа гэсэн ийм заалт байгаад байдаг. Тэгэхээрээ энэ хуулийнхаа хүрээнд энийгээ бас хөндөөд үндэсний үйлдвэрлэгчээ бодитой дэмжиж болоогүй байсан уу? Ялангуяа одоо жижиг, дунд үйлдвэрлэгч ийм...

Ж.Бат-Эрдэнэ: Та бүхэндээ зочид танилцуулъя. Увс аймгийн Цагаанхайрхан сумын ерөнхий боловсролын 8 жилийн сургуулийн 2001 оны багш төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Хууль санаачлагч Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Өргөн барьсан хууль дээр бол одоо үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг нийлүүлнэ ээ гэж заасныг ажлын хэсэг ажиллаад дахиж шинэчлэн найруулсан байгаа. Энэ дээр болохоор цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, дотоодын гарал үүсэл дээр түүхий эд ашиглан стандарт техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн ААН хоршоонд гэж зааж өгсөн байгаад байгаа. Одоо яаж байгаа вэ гэхлээр ер нь бол одоо бид нар энэ нөгөө сумын мах эхлэн боловсруулахад нядалсан байх, малчин өөрөө малаа цехэд аваачаад төхөөрүүлж болно, нядалбал зохистой дадлыг хангахгүй ийм нөхцөлүүд бол байгаад байгаа.

Ер нь бол бэлтгэхдээ өөрөө нөгөө нэг анхан наад захын тэр суурь стандартуудыг хэрэгжүүлж өгөхгүйгээс болоод халдварын бус өвчлөл нэмэгдэж байгаа ийм асуудал байгаа. Тэгэхээр гараа угаасан байх ч гэдэг юм уу энэ нөгөө зохистой дадлыг нэвтрүүлэх ийм шаардлага хэрэгцээ байсан. Тэгээд тийм учраас энийг ажлын хэсэг дээр ярьж байгаад дахиж найруулаад өөрчилж оруулж өгсөн байгаа. Хоршоонд гэдэг бас ийм зохицуулалтыг нэмж оруулж өгсөн. Засаг дарга бол өөрөө орон нутгийн үйлдвэрлэлийг тэр хоол үйлдвэрлэлийг бол хангах төлөвлөгөө гаргаад тэгээд хангах ийм зохицуулалттай байгаад байгаа төлөвлөгөөндөө. НӨАТ-тай холбоотой асуудлыг би бол тантай санал нэг байгаа.

Ер нь бид нар ялангуяа энэ гол стратегийн хүнсэн дээр ингэж аль болох НӨАТ тооцдоггүй байх нь зүйтэй гэдэг би байр суурьтай. Тэгэхдээ энэ НӨАТ-ын асуудлыг бол хөндөх боломжгүй энэ өөрөө татварын асуудал байгаа учраас Сангийн яаман дээр энэ асуудлыг хэлэх нь зүйтэй байх аа. Салбарын хүний нөөцийн эрэлт одоо энэ хэрэгцээний судалгааг тогтмол хийж, хүний нөөцийн төлөвлөх, бүрдүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэхэд тэр мэргэшүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг бол улсын хэмжээнд хүнс, хөдөө аж ахуйн асуудлууд хариуцсан хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн хэмжээнд тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга бас хэрэгжүүлнэ ээ гэдэг ийм зохицуулалттай хүүхдийн эрүүл мэнд чухал учраас энэ асуудлыг хуульд тусгаж оруулсан байгаа.

Тэгээд процессын нарийн хууль нь өөрөө ерөнхий боловсролын Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулиараа зохицуулагдана. Хүнсний бүүр аюулгүй байдалтай холбоотой бүтээгдэхүүний аюулгүй байдлыг Хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлын тухай хуулиараа ингээд процессын хуулиудаараа бол нарийвчлагдаад зохицуулагдаад явж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр гишүүн тодруулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ яах вэ энэ үйлдвэрлэлийн үйлдвэрийн аргаар гэдэг энэ үгээ нэлээн тодорхой болгоод хоршоонд өгөх яг тухайн одоо орон нутгийн иргэд нь энэ дээрээ өөрсдөө оролцоод явах боломжийг хангаж байгааг бол ойлгож байна аа. Ер нь бид амьдралдаа их ойр хуулиудыг гаргахгүй бол энэ нь ямар үр дүнд хүргээд байдаг вэ гэхээрээ жишээлбэл сургууль байлаа. Тийшээгээ мах нийлүүлэх сонирхолтой боловч чадахгүй. Тийм учраас тэр сургуулийг сонирхдог ч үгүй ийм малчид бий болно. Ингээд оролцоог нь хангаж чадахгүй байгаа, өөрсдөд нь ингээд нөгөө шууд хэлбэрээр янз бүрийн байдлаар маркетинг маркет буюу зах зээлийг өгөхгүй болохоор малчид их хөндий болчихдог. Ийм нэг жишээ байна л даа. Жуулчны баазууд өглөө тэр жуулчдадаа өндөг ингээд хайрч өгөөд л яг сосиск өгөөд байгаа. Гэтэл хөдөө байгаад байдаг. Тэгээд хажууд нь малтай хүмүүс байгаад энэ малчдын махнаас ингэж авч хэрэглэдэг үү гэхээр үгүй гэж. Тэгэхээрээ ийм нөхцөл байдлыг арилгахын тулд бид нар хүнсний аюулгүй байдал...

Ж.Бат-Эрдэнэ: Нэг минут дахиж өгье.

П.Наранбаяр: Хүнсний аюулгүй байдлыг улам сайжруулж, тогтолцоог нь сайжруулаад тэр хянадаг лаборатори юмнуудыг нь гаргаж өгөөд яг л одоо энэ малаа маллаж байгаа малчид өөрийнхөө хамгийн ойрын зах зээл дээр шууд

нийлүүлдэг энэ боломжуудыг л бий болгоод байвал сүүгээ нийлүүлдэг, махаа нийлүүлдэг. Мэдээж энэ чинь аюулгүй байдлыг нь хангасны үндсэн дээр. Энэ болгоныг бас бид энэ бодлогынхоо хүрээнд энэ хүнсний тухай хуульд бүрэн тусгаж байгаа гэж ойлгож байгаа. Энийгээ хэрэгжүүлнэ гэж ойлгож байгаа. Энэ миний ойлголт зөв. Яагаад гэвэл түрүүн миний дурдсанчлан тэр жуулчны баазууд бол яг тухайн газар нутгаас нь хэрэглэдэггүй учраас огт сонирхдоггүй, сонирхдоггүй учраас тэд бэлчээрээ булаацалдаж байна. Тэд бас энэ жуулчны баазыг нүд үзүүрлэх тал гаргадаг байхгүй юу. Ийм учраас бид энэ бүгдийг нь хамруулсан инклюзив гэдэг юм уу ийм бодлого руу л орж байж өнөөдөр энэ орон нутагт нь үйл ажиллагаа явуулж байгаа бүхий л ААН-үүд ямар нэгэн байдлаар орон нутагт нь ажлын байр бий болгодог, зах зээлийг бий болгож өгч байдаг энэ тогтолцоо руу оруулах нь зүйтэй...

Ж.Бат-Эрдэнэ: Мандхай гишүүн хариулъя.

М.Мандхай: Ажлын хэсгийн ажилласан одоо энэ яг энэ хүүхдийн хоол үйлдвэрлэлтэй холбоотойгоор тавигдах энэ хоолны түүхий эд ашиглах стандарт техникийн зохицуулалтыг бол дагаж мөрдөхтэй холбоотой зохицуулалтыг 8.1.8 дээр хуульчилж оруулж өгсөн байгаа. Ер нь нэг ийм бас нэг судалгаа хэлэхэд одоо энэ амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо халдвар ба шимэгч одоо энэ хорхойн халдвартай холбоотой зарим өвчин 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн тэргүүлэх 3 шалтгаан болж байгааг энэ шим тэжээлийн судалгаагаар бол гаргаж өгсөн байгаа. Тийм учраас бид нар хүүхдэд өгөх гэж байгаа хоол хүнс ялангуяа түүхий эдийн бэлтгэл, бэлтгэн нийлүүлж байгаа малчид дээрээс нь суурь одоо энэ хагас боловсруулсан юм уу түүхий эд бэлтгэж байгаа энэ бэлтгэн нийлүүлэгчдэд тавигдах энэ зохистой дадал стандартыг бид нар анхан шатны түвшинд нь заавал хуульчилж хэрэгжүүлдэг байхаар зохицуулахгүй бол сүүлийн...

Ж.Бат-Эрдэнэ: Зочин танилцуулъя. Улаанбаатар олон улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Оюутан залуучууддаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулах ёстой. Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Санал хураалтыг 17 цагаас явуулна аа. Үг байхгүй байна тийм.

Долоо.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/

Одоо Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцүүлъя.

Чуулганы хуралдаан чуулганы 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдааны эрх бүхий албан тушаалтны саналыг сонссон. Одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн Ганбаатар гишүүн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

А.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 6 сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дашживаагийн Ариунболд, Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Жамсрангийн Болд, Довдонгийн Давааням, Улсын Дээд шүүхээс нэр дэвшүүлсэн Доржсүрэнгийн Мөнхзориг нар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийг загварын дагуу материалаа бүрдүүлж байнгын хороонд ирүүлсэн болно оо.

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, 2-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 2-ыг Дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал дахь нэр дэвшигчийн сонсгол 6 жилийн дараа томилно оо гэж 4 дэх зүйлийн 5 дугаар хэсэгт Хорооны гишүүний бүрэн эрх түүнийг томилсон Улсын Их Хурлын шийдвэр гарснаар эхэлж дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу нэр дэвшигчийг сонсгол явуулах үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

1.2026 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 13 дахь заалт, Монгол Улсын чуулганы Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д хэсэгт заасныг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчдийн сонсголыг тогтоож, сонсгол даргалагчийг томилох тухай тогтоолыг баталж, 2026 оны 6 дугаар сарын 8-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Их Хурлын гишүүн Болдын Жавхланг томилсон.

Сонсголын бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн материалыг Улсын Их Хурал түүний цахим хуудаст парламент.мн-д байршуулсан. Сонсголын тов цаг хугацаа сонсголд оролцогчдыг бүртгэх хуудас бүхий зарыг Улсын Их Хурлын цахим хуудсанд 14 хоногийн хоногийн хугацаанд байршуулсан.

Мэдээллийн дагуу 3 оролцогч 2 ажиглагч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, мөн баталгаажуулсан.

3.2026 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 14 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооноос сонсголд Их Хурлын гишүүн Жавхлан, Алтангэрэл, Ариунзаяа, Батжаргал, Баярмаа, Бямбацогт, Ганбаатар, Гантөмөр, Даваасүрэн, Доржханд, Зулпхар, Найдалаа, Пүрэвдорж, Ундрал, Учрал, Хэрлэн, Цогтгэрэл, Энхбаяр нар буюу байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээс ирц бүрдэж нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 134 дүгээр зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тайлан гаргана. Тайлан сонсголын дүнг үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж холбогдох бусад мэдээллийг хавсаргаж тухайн тайланг нэр дэвшигч түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна гэж заасны дагуу 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд Их Хурлын гишүүн Жавхланд танилцуулсан.

Мөн байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно оо.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Дашживаагийн Ариунболд, Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Жамсранжавын Болд, Довдонгийн Давааням, Улсын Дээд шүүхээс нэр дэвшүүлсэн Доржсүрэнгийн Мөнхзориг нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилуулах саналыг байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэр дэвшигчдийн танилцуулга, байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, чөлөөлөх асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Нэр дэвшигчид чуулганы танхимд хүрэлцэн ирсэн байна. Сонгуулийн ерөнхий хорооны албан тушаалд гишүүний албан тушаалд нэр дэвшигч Дашживаагийн Ариунболд, нэр дэвшигч Доржсүрэнгийн Мөнхзориг, нэр дэвшигч Жамсранжавын Болд, нэр дэвшигч Дондовын Давааням нар хүрэлцэн ирсэн байна аа. Эрх бүхий албан тушаалтны санал, байнгын хорооны санал, дүгнэлттэй тань холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Пүрэвжавын Сайнзориг гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Би яах вэ зүгээр байнгын хорооноос асууж болно тиймээ дарга. Ер нь яах вэ энэ Сонгуулийн ерөнхий хорооны энэ орон тооны болон орон тооны бус гишүүнүүдийг зүгээр албан тушаалын байдлаар нь л уг нь энэ томилогддог томилогдсонд тооцоод явчихмаар байгаа юм. Яг үнэндээ хэлэхэд ЦЕГ-ын дарга, Улсын бүртгэлийн дарга, тэнд бас хүн өөрчлөгдлөө гэхэд дахиад яг л дахиад л нэг процесс болж байгаа байхгүй юу. Тэгээд л нэг Улсын Их Хурал хүн яриад байгаа ч юм шиг. Угаасаа л зохион байгуулахад энэ 2 байгууллага оролцоод л явж байгаа. Тэгэхээр яг тэнд хэн байна тэр хүн л энэ чиг үүргийг одоо орон тооны бус гишүүнийхээ хувьд хариуцаад явдаг. Энэ өөрчлөлт энэ тэрийг хийж болдоггүй юм уу. Зүгээр ингээд л нэг ийм процесс бас яваад байгаа юм л даа. Энэ хүмүүсээс өөр

хүн томилж болох ч юм шиг. Тэгээд нэг сонсгол энэ тэр гээд нэлээн тийм процесстой л яваад байгаа юм. Тэгэхээр энийг зүгээр байнгын хороо бас ярилцаж байгаа зүйл байгаа юу? Ер нь зүгээр яах вэ цаашдаа анхаараач ээ гэдэг 1 дүгээр санал.

2 дугаарт нэр дэвшигчдээс асууя. Бүгд л одоо намтрыг нь уншихаар доктор профессорууд байх юм. Сая Үндсэн хуулийн цэц дээр гарсан Улсын дээд шүүхийн хүсэлтийн дагуу нэг маргаан шийдлээ. Мэргэжлийн холбоодыг бол Улсын Дээд шүүх бүртгэх нь буруу гэж байна. Тэгэхээр энэний цаана юу вэ гэхээр аливаа хуулийн этгээдийг Улсын дээд шүүх бүртгэх нь буруу байна аа. Энэний цаана улс төрийн нам байгаа. Тэгэхээр улс төрийн намыг цаашдаа ер нь хэн бүртгэх вэ гэдэг асуудал Сонгуулийн ерөнхий хороон дээр л тулж ирж байна л даа. Тэгэхээр ер нь зүгээр Сонгуулийн ерөнхий хорооны чиг үүрэг одоо юу гэж боддог вэ? Юуг шинэчилье гэж бодож зорьж энд одоо албан тушаалд нэр дэвшиж байгаа вэ? Тэгээд энэ албан тушаалын шаардлагууд дээр мэдээж нэг тодорхой зүйл нь төрийн жинхэнэ албан хаагч л байгаа. Тэгэхээр энэ зүйлүүд дээр яах вэ зүгээр бодолцоход цаашдаа бас та хэдийн байр суурь зүгээр албан тушаалаараа ороод ажиллах нь зөв байна уу эсвэл одоо ингээд чиг үүрэгтэй нь хамаатуулаад нээлттэй сонгон шалгаруулалт орох нь зөв байна уу? Энэ дээр ямар байр суурьтай байна гэсэн ийм 3 асуултуудыг нэр дэвшигчээс, байнгын хорооноос нэг асуулт асууж байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалт хуралдаж байгаад бол Төрийн байгуулалтын байнгын хороо танилцуулах ёстой. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга одоогоор хуралтай байна. Нэр дэвшигчдээс гишүүн бүрээс үү?

За нэг нэгээрээ 4 номерын индэр дээрээс саяын Сайнзориг гишүүний асуултад хариулна уу. Нэрээ хэлээд танилцуулаад.

Д.Давааням: УБЕГ-ын дарга Давааням. Гишүүдийн энэ өдрийн мэндийг эрье. Сайнзориг гишүүний асуултад хариулъя аа. Сонгуулийн ерөнхий хороонд улсын бүртгэлийн байгууллага бол иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг хадгалдаг, хамгаалдаг. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн суурь сан дээр үндэслэж сонгуулийн ажлыг зохион байгуулж, улсын бүртгэлийн байгууллага, улс эх орон даяар сонгуулийн үеэр ажилладаг. Энэ Сонгуулийн ерөнхий хороонд улсын бүртгэлийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, удирдлага зохион байгуулалтын талаар мэдээллийг шуурхай өгөх, Сонгуулийн ерөнхий хорооноос гарсан шийдвэрийг улсын бүртгэлийн байгууллагад холбогдох шийдвэрийг нь шуурхай хэрэгжүүлж ажиллах зорилгоор албан тушаалаараа дэвшдэг. Энэ нь одоо практикаар нотлогдсон амжилттай хэрэгжиж байгаа ийм практик процесс гэж харж байгаа.

Улсын дээд шүүх дээр улс төрийн намуудыг бүртгэдэг асуудлыг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэх нь зүйтэй эсэх асуудал дээр бол миний тодорхой санал алга байна. Ямар ч байсан батлагдсан хууль тогтоомжийг аль аль түвшиндээ төрийн төв болон захиргааны байгууллагууд хэрэгжүүлэн ажиллах учраас зохион байгуулалтыг зөв зүйтэй хийвэл болчих байх аа гэдэг ийм үзэл бодол саналтай байна аа таны асуултад.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч.

Д.Мөнхзориг: Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Доржсүрэнгийн Мөнхзориг байна аа нэр дэвшигч. Улс төрийн намын

бүртгэлийн хувьд сая Үндсэн хуулийн цэц бол мэргэжлийн холбоодыг Дээд шүүх бүртгэх нь буруу гээд шийдсэн. Энэ нэг яг улс төрийн нам дээр бол Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаагүй учраас энийг бол одоо яаж шийдэх нь тодорхойгүй. Яг энэ жишгээр Дээд шүүх бол бүртгэхгүй юм байна аа гэж миний хувьд ойлгож байгаа. Тэгэхээр энэ бол цаашлаад Сонгуулийн ерөнхий хороо бүртгэдэг эсвэл Улсын бүртгэлийн байгууллага нь бүртгэдэг болох болов уу. Одоо Бүгд Найрамдах Солонгос Улс бол тийм юм байна лээ. Энэ асуулт нь тийм.

Цаашид юу хийх вэ гэдэг дээр бол миний хувьд энэ сонгуулийн зарчмууд байгаа. Энэ дээр бол бүх нийтээрээ гэдэг зарчим маань яваандаа алдагдах магадлалтай байна аа. Өөрөөр хэлбэл энэ ирц жилээс жилд буурч байна. 1992 оны сонгуульд бол 95 хувийн ирцтэй байсан бол жил бүрийн сонгуулиудаар буурсаар байгаад 2016 оны Улсын Их Хурлын сонгуулиар бага зэрэг өсөөд, 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар бага зэрэг өсөөд эргээд ингээд буусан. Өөрөөр хэлбэл нийт дүнгээрээ бол тасралтгүй буурч байгаа ирц. Тэгээд энэ бол бас л ирээдүйд эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл иргэд төрд итгэх итгэл буурна, цаашлаад нөгөө сонгон байгуулагдсан парламент нь иргэдийгээ бүх ард түмнийгээ төлөөлөх чадвар буурах ч юм уу ийм эрсдэл бол гарна аа.

Тийм учраас энэ ирц дээр анхаармаар байна. Ирц дээр яаж анхаарах вэ гэхээр мэдээж сонгуулийг зохион байгуулахаас гадна сонгогчийн боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг байгаа Сонгуулийн ерөнхий хороонд. Энийг бол сонгуулийн жил гэлтгүй бусад иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, бусад төрийн байгууллагуудтай хамтраад хэрэгжүүлнэ. Мөн Улс төрийн намын тухай энэ шинэ хуулиар тодорхой төрөөс авсан санхүүжилтийн 50 хүртэлх хувийг бол тодорхой бүлгүүдэд улс төрийн боловсролыг дээшлүүлэх гэдэг чиглэл рүү зарцуулчихсан байх ёстой тэр хяналт тавих үүрэгтэй байгаа. Энэний хүрээнд бол ирц бол ингээд тодорхой хэмжээнд дээшлэх байх.

Миний хувьд бол энэ залуучууд руу чиглэсэн энэ цахимаар санал өгөх энэ хувилбарыг судалж үзвэл яадаг юм бэ? Өөрөөр хэлбэл энэ бол цаг хугацааны асуудал аа. Тодорхой 4, 5 жилийн дараа ч юм уу энэ ойрын 2027, 2028 оны сонгууль дээр яригдах бол мэдээж боломжгүй. Тэгэхээр энэ бол цаасаар өгөхийг бол одоо залуучуудын оюун санаа бодол бол нэлээн цахим руугаа орчхоод байгаа шүү дээ. Тэгэхээр бол цаасаар өгөөд очерлоод ингээд өгч байгааг бас ойлгохгүй байж магадгүй. Тэгэхээр тэд нарт бол энэ цахимаар нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг танилцчихдаг, цахимаар саналаа өгчихдөг ийм болчихвол эрс оролцоо дээшлэх магадлалтай. Гэхдээ энийг бол тулгах биш сонголттойгоор.

Тэгэхээр зарим улсын жишгийг дагаад ингээд явбал ирц нэмэгдэх юм болов уу гэсэн бодолтой байна. Тэгэхээр энэ бол мэдээж хэрэг Сонгуулийн ерөнхий хорооны хэрвээ гишүүн дангаараа гарах санал биш л дээ. Тэгэхээр энэ тооцоо судалгаагаа хийгээд Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнээр дэмжигдэх юм бол Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн дагуу Улсын Их Хуралд санал тавих эрхийнхээ хүрээнд энийг хууль сонгуулийн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа гаргаад ингээд явах боломжтой. Миний хувьд ийм боломжтой байна аа. Түрүүн албан тушаалаар гэдэг дээр сайн хэлж мэдэхгүй байна аа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч.

Д.Ариунболд: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. ҮАБЗ-ийн ажлын албаны дарга Ариунболд. Сайнзориг гишүүний түрүүний асуусан хариултад хариулахад 1 дүгээрт, миний бие яагаад энэхүү албан тушаалыг хүлээж авсны дараа юу хийж бүтээх вэ гэдэг 1 дүгээр асуултад хариулахад мэдээж Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, Үндсэн хууль, үндэсний аюулгүй байдалд ийм үзэл баримтлал заагдсан Үндсэн хуульт байгууллагыг бэхжүүлэх ялангуяа сонгуультай холбогдсон үзэл баримтлалын заалтуудыг хэрэгжүүлэхэд бол хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бол мэдээж далайцтай оролцоно. Хяналт дүн шинжилгээ хийх чадвараа сайжруулахад бол анхаарна гэж бодож байгаа.

Дараагийн нэг гол анхаарах ёстой асуудал бол иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх энэ үйл ажиллагаан дээр бид нар нэлээн ахицтай ажиллая, анхаарал тавьж ажиллая гэж бодож байна. Сонгуулийн сонгогчийн боловсролын асуудал бол тасралтгүй үргэлжилж байх ёстой. Зөвхөн сонгуулийн жилд бид иргэдэд сонгууль болох гэж байна, хэзээ нь сонгууль өгнө гэдэг байдлаар мэдээлэл хүргэхээсээ илүүтэйгээр тасралтгүй системтэйгээр тогтмол олгож байх энэ үйл ажиллагаа руу илүү анхааралтай хандъя гэж бодож байгаа.

Мөн түүнчлэн орчин үеийн технологийн дэвшлийг сонгуулийн эрх зүйн орчинтой хослуулан хэрэгжүүлэх, сонгуульд иргэдийн бүх нийтийн бүх иргэдийн оролцоог дээшлүүлэх чиглэлээр техникийн дэвшлийг хангуулах зорилгоор иргэдийн сонгуулийг төрөл хэлбэрийг өргөжүүлэх, сонгох хэлбэрийг бол өргөжүүлэх энэ үйл ажиллагаан дээр нэлээн анхаарал тавьж үзье, анхааралтай ажиллая гэж бодож байна. Мөн түүнчлэн сонгуулийн үйл ажиллагаа зохион байгуулж оролцдог Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, мэдээ мэдээллээр хангах, хоорондын мэдээ мэдээллийг солилцоог сайжруулах чиглэл дээр нэлээд анхааралтай ажиллана гэсэн бодол байна аа.

Мөн түүнчлэн 2 дугаар асуулт нь хэлэхэд одоо улс төрийн намуудыг бүртгэх энэ үйл ажиллагааг бол одоо Монгол Улсын Их Хурлаар батлагдсан хуулийн хүрээнд явагдаж байгаа. Бид СЕХ шууд бүртгэх Дээд шүүх аль нь бүртгэх гэдэг дээр бол одоо хууль тогтоомжийнхоо хүрээнд шийдвэр гарсан тохиолдолд аль нэг нь явах байх гэж хувийн бодолтой байна аа. Мөн түүнчлэн албан тушаалын чиглэлээр шууд сонгогддог тодорхой хийх сонгуулийн хорооны гишүүд байгаа. Цагдаагийн ерөнхий цагдаагийн байгууллагын дарга мөн түүнчлэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нар бол одоо шууд сонгогддог энэхүү тогтолцоог хуульчилж хуульчилсан тохиолдолд энийг одоо сонгох ийм боломжтой гэж нэг хувийн бодол бол би хувьдаа бол байдаг аа. Хариулж дууслаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн.

Ж.Болд: Гишүүдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд Цагдаагийн ерөнхий газрын дарга Жамсранжавын Болд. Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн ерөнхий газрын дарга албан тушаалынхаа хувьд Сонгуулийн ерөнхий хорооны орон тооны бус гишүүнээр ажиллах нь ер нь өмнө 2020 оноос 2023 онд би ажиллаж байсан. Тэгээд 2023 онд ажлаа хүлээлгэж өгөхөд хүсэлтээ гаргаад чөлөөлөгддөг. Энэ бол албан тушаалаараа явдаг учраас гишүүний саналтай нэг байна аа.

Цагдаагийн байгууллага Сонгуулийн ерөнхий хороонд ажилласнаар яах вэ саналын хуудас хэвлэж хэвлэгдэж эхлэхээс эхлээд нэг 10 төрлийн хамгаалалт зохицуулалтыг төлөвлөж, Сонгуулийн ерөнхий хороотой байнгын хамтарч ажилладаг учраас энэ тал дээрээ бас тодорхой ажил арга хэмжээнүүд зохиож тэр Сонгуулийн ерөнхий хороонд бас Цагдаагийн ерөнхий газрын үе үеийн дарга нар санал юмаа хэлж ажилладаг аа. Тэгээд юуны сонгуульд юу улс төрийн намыг бүртгэх асуудлыг миний хувьд яг тодорхой Сонгуулийн ерөнхий хороо бүртгэнэ ч гэдэг юм уу энэ тодорхой санал дүгнэлт алга байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Нэр дэвшигчдийн хариултад баярлалаа. Тэгэхдээ нэг би бол ингэж бодоод байгаа юм. Одоо жишээ нь Сонгуулийн ерөнхий хороон дээр цагдаагийн дарга, бүртгэлийн дарга 2-ыг дэмжихгүй гэхивэл энэ 2 хүн тэр албан тушаал солигдохгүй, солигдох ёстой гэдэг ч юм шиг тийм логик гарах гээд байгаа байхгүй юу. Тийм учраас цагдаагийн дарга, бүртгэлийн дарга 2 бол шууд албан тушаалаараа энэ Улсын Их Хурлаар орохгүйгээр гэдэг юм уу ер нь танилцуулагдаад л дуусчихдаг баймаар байгаа юм. Өмнө нь бүртгэлийн дарга жишээ нь Баасандорж дарга байсан санаж байна. Албан тушаалаараа орчихоод тэгээд бас процесс нь ингээд хэдэн сар яваад дараагийн бүртгэлийн дарга орж ирэх гээд энэ тэр гээд явдаг. Бусад төрийн жинхэнэ албан хаагчдыг зүгээр санал болгож байгаа институцүүд нь ямар хүн дэвшүүлэх гэдэг боломжоосоо яагаад яах вэ. Тэр нь бол ингэж нээлттэй сонгон шалгаруулалт, сонсгол энэ томилогдох процессоор орох нь зөв юм шиг байгаа юм зүгээр.

Би бол зүгээр ийм байгаа шүү. Нэгэнт илэрхий байгаа юман дээр ингээд дахин дахин процесс гэдэг юм уу ийм зүйлүүд явах ер нь хэрэг байна уу гэдэг зүйлийг би зүгээр байнгын хороонд хандаж бас хэл...

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Бид нар одоо Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх тухай л ярьж байгаа л даа. Яах вэ сая Цагдаагийн ерөнхий газрын даргын мэдээллээс Цагдаагийн ерөнхий газрын яагаад оролцох тухай ойлголоо. Үгүй энэ Батлан хамгаалах яам яагаад дандаа ийм цэргийн улсууд ороод ирэв? Та 4-өөс чинь одоо 3 нь цэргийн цолтой хүн юм байна. Нэг нь бүүр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс цэргийн цол авсан хүн бололтой байх шиг байна тиймээ.

Ер нь цэрэг цагдаагийн энэ улсуудыг Сонгуулийн ерөнхий хороонд энэ олноор оруулна гэдэг бол том ухралт шүү. Хэдэн гишүүнээс хэд нь дараагийнх нь хэн хэн дэвшүүлж орж ирэх юм. Командаар явдаг цэргийн улсуудыг яагаад энэ холбогдох байнгын хороод нь болоод холбогдох газрууд нь дэвшүүлсэн юм бол би бол гайхаж байна. Ер нь цэргийн хүн чинь нэг тийм даргын үгнээс гарахгүй байгаад байх нэг тийм зам байдаг шүү дээ. Ер нь Сонгуулийн ерөнхий хороонд бол нэг төв шударга, төрийн албанд олон жил ажилласан мэргэшсэн улсууд байх ёстой гэж би хувь хүнийхээ хувьд боддог.

Асуулт нь улс төрийн намууд өнгөрсөн хугацаанд нэг намын гишүүндээ гишүүдээ л нэг өргөтгөх, гишүүнчлэлээ нэмэх, сонгуулийн үеэр нэг иргэдийг

хайрцаглах манай нам, танай нам гэж хайрцаглах ийм ажил хийж ирсэн болохоос биш энэ сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, дээрээс нь энэ сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах тал дээр маш учир дутагдалтай явж ирсэн. Аль ч үеийн Сонгуулийн ерөнхий хороог бол би тэгж шүүмжлэхээр. Тэгэхлээр энэ чиглэлээр яг юу хийх юм.

Ер нь Сонгуулийн ерөнхий хороо бол манай улсын хэмжээнд төрөл бүрийн Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн бүхий л сонгуулиудыг зохион байгуулах, сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сонгогчдын боловсролыг дээшлүүлэхэд ийм л чиг үүрэгтэй байгууллага гэж би ойлгож явдаг. Яг энэ чиглэлээр юу юу хийхээ маш тодорхой нэг 4 нэр дэвшигчид нэг хэлээдхээч.

Ж.Бат-Эрдэнэ: 4 нэр дэвшигч хариулъя. 4 номерын индэр.

Д.Давааням: Сонгуулийн ерөнхий хороо албан бус боловсролоор сонгогчийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сонгуулийн үйл ажиллагааг сурталчлах энэ чиглэлүүдэд ажилладаг юм байна лээ. Ажиллаад бас тодорхой үр дүнгүүдэд хүрсэн жишээ байгаа юм байна лээ. Жишээ нь гэхэд одоо Үндэсний төв номын сан болон аймаг, дүүргүүдийн төвлөрсөн номын сангуудад бол номын санч нарын сонгуулийн сурталчилгааны болон сургалтын сургагч багшаар бэлтгээд номын сангууд дээр булан нээгээд сонгох сонгуулийн тухай эрх зүйн боловсрол мэдээллийг албан бус хөтөлбөрөөр ингэж олгож байгаа. Энийг бас нэлээн үр дүнтэй арга гэж байгаа.

Миний хувьд бол ямар байр суурь энэ сургалтын хувьд барих юм бэ гэхээр бид нар өнгөрсөн жилүүдэд ерөнхийдөө сонгууль яаж өгөх тухай процессын сургалтуудыг нэлээн түлхүү орсон байна лээ. Түрүүн одоо нэр дэвшигч Мөнхзориг ярьж байна. Жилээс жилд 1992 оны сонгуулиас хойш сонгогчдын ирц гэдэг юм буурсан. Хамгийн сүүлийн 2024 оны Их Хурлын сонгуулиар бол нийт сонгууль өгөх иргэдийн 57 хувь нь сонгуульд оролцсон байна лээ.

Тэгэхээр би энэ дээр юу хэлээд байна гэхээр нөгөө сонгууль сонгогчдыг ялангуяа анх удаа сонгууль өгөх гэж байгаа залуучуудыг яагаад сонгууль өгөх ёстой вэ, таны өгөх сонгууль шударгаар, хараат бусаар өгсөн сонгууль чинь улс эх орны хөгжил дэвшил, өөрийн чинь болон үр хүүхдийн чинь ирээдүйд яаж нөлөөлөх юм бэ гэдэг талаар тийм соён гэгээрүүлэх нөлөөллийн сургалтуудыг түлхүү хийвэл чухал юм байна аа гэдэг байр суурьтай байгаа. Энэ тал дээр бодлого барьж саналаа дэвшүүлэн ажиллана аа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч.

Д.Мөнхзориг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь Сонгуулийн ерөнхий хорооны миний авсан мэдээллээр Сонгуулийн ерөнхий хорооны төсөв дээр хүний нөөц мөн санхүүгийн боломж их муу байдаг юм байна. Батлагдаж байгаа төсөв. Энэ хүрээндээ бол энэ сонгогчийн боловсролыг дээшлүүлэх ажил их хумигдмал, тогтмол явуулахад хүндрэлтэй байдаг. Энэ хүндрэлтэй энэ бусад сул орон зайг иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтраад хэрэгжүүлж ирсэн юм байна.

Тэгэхээр миний хувьд бол мөн энэ байгууллагуудтай хамтран цаашлаад бусад төрийн байгууллага жишээ нь Боловсролын яам, хүний эрхийн байгууллага гэх мэтчилэнгээр. Нэг жишээ гэх юм бол 2022 оны ЭЕШ-ын асуултад сонгуулийн

асуултууд нэлээн их орж ирсэн. Тэр хүрээндээ бол яг нөгөө 18 хүрсэн залуучууд сонгуулийн боловсролыг шалгалтаар дамжуулж нэлээн олж авсан гэсэн мэдээлэл гарч байсан. Гэх мэтчилэнгээр одоо энэ 10 жилийн ахлах ангийн сурагчид руу чиглэсэн энэ боловсрол дээшлүүлэх ажил хиймээр байна. Мөн түрүүний ярьсан мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж энэ залуучууд руу чиглэсэн рийл энэ сошиал медиаг ашиглаж энэ нам бус энэ инфлүенсерүүдийг ашиглаж сонгуулийн боловсролыг дээшлүүлэх чиглэл рүү анхаарч ажиллана гэж бодож байгаа.

Тэгээд ер нь бол саяын Улс төрийн намын тухай хуулийн шинэ хуулиар бол төрөөс авч байгаа санхүүжилтийн 50 хүртэлх хувийг одоо нийгмийн тодорхой бүлэг намын гишүүдэд улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн байх ёстой. Үүн дээр хяналт тавих ёстой Сонгуулийн ерөнхий хороо. Тэгээд энүүгээр дамжуулж одоо бас иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх боломжтой гэж харж байна. Энэ тодорхой хугацааны дараа бол үр дүнгээ өгнө өө гэж бодож байна.

Д.Ариунболд: Гишүүний асуултад хариулъя. Энэ 2024 оны сонгуулийн санал өгсөн байдлаас харахад залуучуудын ялангуяа 20-24 насны энэ залуучуудын бүлэг бол хамгийн сул идэвхтэй байдлаар хаагдсан байгаа. Үүн дээрээс үндэслээд бид харахад ер нь 18-19 насны залуучууд нэлээд идэвхтэй өгдөг. Яагаад гэвэл хамгийн анх удаагаа сонгууль өгч байгаа учраас сонгуулийн ирцийн хувьд ч гэсэн илүү байдаг.

Миний хувьд бол одоо сонгуулийн энэ иргэдийн сонгогчийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа тасралтгүй, байнгын циклтэй, системтэйгээр явах ёстой гэж бодож байгаа. Зөвхөн одоо нэг сонгуулийн үеэр биш сонгуулийн мөчлөг хооронд байнгын системтэйгээр явж байх ёстой. Энэ дээр бол зөвхөн Сонгуулийн ерөнхий хороо дангаараа болон дангаараа бол үйл ажиллагаа явуулахад бас хүндрэлтэй. Ийм учраас иргэний нийгмийн байгууллагууд ялангуяа энэ сонгуулийн боловсрол иргэдэд олгох чиглэлээр ажилладаг энэ төрийн бус байгууллагууд, иргэдийн байгууллагуудыг бол маш идэвхтэй татан оролцуулж явж байх ёстой.

Түрүүн нэр дэвшигч Мөнхзориг бас хэллээ. Энэ Сонгуулийн ерөнхий хорооны 2026 оны төсөв дээр суртал сурталчилгааны зардал гэж 570-аад сая төгрөг батлагдсан батлуулахад санал оруулсан боловч 97 хувь нь хасагдаад 17.3-хан сая төгрөг батлагдсан. Ийм хэмжээний зардлаар бүтэн 4 жилийн цикл сонгуулиас сонгуулийн хооронд сонгогчдын боловсролын бүрэн хэмжээгээр олох энэ асуудал явахад бас хүндрэлтэй. Ийм учраас Сонгуулийн ерөнхий хорооноос авсан мэдээллээр бол олон улсын байгууллагууд бол иргэний нийгмийн байгууллагуудтай маш сайн хамтран ажилладаг юм байна лээ. Энэ хүрээнд бол зөндөө олон хэмжээний арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг аа.

Бид бол би бодохдоо энэ сонгуулийн боловсрол олгох ажиллагааг бүүр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангиас нь эхэлж энэ сонгууль гэж юу байдаг юм, энэ яагаад сонгууль өгөх ач холбогдолтой гэдгийг ахлах ангиас нь эхэлж тодорхой хэмжээний мэдлэг мэдлэгүүдийг олгох, мөн түүнчлэн энэ иргэдэд хүргэх ялангуяа залууст энэ сонгуулийн боловсролыг олгох сувгуудыг орчин үеийн сошиал сувгуудыг, тэд нарын хэрэглэж байгаа энэ сувгуудыг маш түлхүү хэмжээгээр ашиглах ёстой юм байна гэж бодож байгаа. Мөн түүнчлэн иргэдийн сонгуулийн үед байнга гардаг цахим худал хуурмаг мэдээллийг шүүн тунгаах энэ чадварыг одоо сонгуулийн боловсролоор дамжуулж одоо суулгах ёстой гэдэг үзэл бодолтой байдаг аа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч.

Ж.Болд: Гишүүний асуултад хариулъя аа. Сонгогчийн боловсролыг Сонгуулийн ерөнхий хорооноос илүүтэйгээр саяын Ариунболд нэр дэвшигчийн хэлсэнчлэн олон салбар төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамтарч ажиллаж байж энийг дээшлүүлэх юм байна аа гэж ойлгодог. Тэгээд олон улсын болоод төрийн бус байгууллагуудтай хамтрах төрийн байгууллагуудыг бас энэ сонгогчийн боловсролыг дээшлүүлэх ажилд идэвхтэй хамтарч оролцуулах ийм бодолтой, саналтай байдаг аа.

Ж.Бат-Эрдэнэ: Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Энэ Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг томилох сонгох тухай асуудал Улсын Их Хурлаар хэлэлцэж байна. Сонгууль бол иргэдийн төлөөллийг төрд ингээд сонгуулийн шугамаар, ардчилсан сонгуулийн зарчмаар иргэдийн дуу хоолой төлөөллийг төрд ажиллуулах энэ хамгийн чухал зүйл байдаг. Тэгээд Сонгуулийн ерөнхий хороог харахад жил болгон ингээд төсөв батлуулаад байдаг юм. Тэгээд энэ сонгуулийн үед сонгуулийн жил гэнэт гарч ирээд л зөвхөн нэг сонгуулийн тухай ярьдаг. 4 жил ингээд цалин авч байгаа албан хаагч, төсөв авч байгаа албан хаагчид иргэдийн сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэх, сонгуулийнхаа хууль тогтоомжийг сайжруулах, хуулийн хэрэгжилтийн үр дүнг нь ингэж судалж ажиллах ёстой гэж бодож байна. Би бол үг хэлье гэж бодож байгаа.

2 дугаарт, Сонгуулийн ерөнхий хорооны энэ 9 гишүүний бүрэлдэхүүнд нь цаашдаа бол төрийн байгууллага улс төрийн намууд биш иргэдийн байгууллагын төлөөллийг оруулах бол зарчмын хувьд зөв юм байна аа гэж бодож байгаа.

2 дугаарт нь сонгуулийн хорооны дэргэд бол тогтмол ажилладаг хяналтын зөвлөлийг ажиллуулах нь зөв юм байна гэж бодож байгаа. Учир юу юм бэ гэхээр сонгуулийн дараа тухайн болсон сонгуульд сонгогчид иргэд энэ сонгууль шударга боллоо гэдэгт итгэл үнэмшилтэй үлдэх ёстой. Сонгууль шударга болох юм бол нийгэм хуваагддаг, төрийн нэр хүнд унадаг, иргэд төр хоорондоо зөрчилддөг хамгийн том одоо эв нэгдэлгүй байдал бий болгох эрсдэл чинь энд байгаа юмаа.

Тэгэхээр Сонгуулийн ерөнхий хорооны энэ 9 хүний 3-д нь нэр дэвшиж байгаа хүмүүс бол Монголын төрийн цаашдын эв нэгдлийг хангаж ажиллах ёстой шүү гэдэг ийм бол саналыг хэлье гэж бодож байна. Сонгууль бол тэнцвэртэй, хараат бус, шударга болох ёстой. Сонгуулийн хуульд нэг том өөрчлөлтийг хийх хэрэг байгаа юмаа. Энийг Улсын Их Хурлаараа хэлэлцүүлэх хэрэгтэй.

1 дүгээрт юу юм бэ гэхээр энэ төрийн нөөцийг улс төрийн сонгуульд ашигладаг болсон. Өнөөдөр бол энэ төрийн албаны цалин авч байгаа, төрийн албаны унаа тэрэг, төрийн албаны бүх нөөцийг ялсан нам нь ашигладаг ийм гажиг тогтолцоо бий болсон. Улаанбаатар хотын сонгууль гэхэд хорооны дарга нар тэр чигээрээ сонгуулийн менежер болдог. СЕХ нь бол нүдээ аниад, чихээ таглаад өнгөрүүлдэг ийм шударга бус байдлыг бол энэ Улсын Их Хурал та бүхэн бүгдээрээ хамтарч хэдүүлээ эцэслэх ёстой гэж бодож байна.

Хамгийн сүүлд нь иргэдийн дунд эргэлзээтэй байгаа нэг асуулт асуудал байна аа. Яаралтай оруулж ир ээ. Сонгуулийг зохион байгуулж байгаа, тооллого хийж байгаа энэ хар машины программын хугацаа дууссан эсэх дээр...

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт нэг минут. Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Тэгэхээр энэ программ хангамжийн аюулгүй байдал хөндлөнгийн аудит зөв тоолж байгаа эсэх технологийн хувьд хөндлөнгийн нөлөө орохгүй байгаа эсэх дээр мэргэжлийн дүгнэлт гаргаад, Улсын Их Хуралд яаралтай танилцуулж, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөлд энийг танилцуулах нь зөв байгаа юмаа. Тэгэхгүй бол олон хүмүүс сонгууль явуулж байгаа, зохион байгуулж байгаа, тоолж байгаа наад машины чинь программ хангамжийн хугацаа нь дуусчихсан шүү дээ энийгээ шийдэхгүй юм уу гэдэг ийм эргэлзээ байсаар байгаа учраас Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд энийг шуурхай зохион байгуулж ажиллаарай гэж хүсэж байна. Тэгээд хамгийн сүүлд нь нэр дэвшигчдэд амжилт хүсье ээ. Баярлалаа. Саналаа хэлчихлээ.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаярын урилгаар Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ЕБС-ийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа төгсөгчдөдөө Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: Сонгуулийн ерөнхий хорооны 4 гишүүний тухай асуудал ярьж байна аа. Удахгүй одоо нөхөн сонгууль ч явах гэж байна. Нэг жилийн дараа ч Ерөнхийлөгчийн сонгууль болох нь. Тэгэхээр энэ Сонгуулийн ерөнхий хорооны 9 гишүүнийхээ орон тоог нь гүйцээгээд ингээд сонгоод явуулах нь томилоод явуулах нь зүйтэй байх аа. Би бол бас нэг боломжийн хүмүүс орж ирсэн юм уу гэж харж байна. Энэ Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдсан юм байна. Энэ байнгын хороон дээр чинь одоо яагаад тийм асуулт, санал байхгүй байдаг юм бэ? Сонгууль бол одоо маш чухал шүү дээ. Энэ төр засгийн үндсийн үндэс шүү дээ. Тэрийг асуучихмаар байна.

Тэгээд сонгууль хуулийн дагуу зөв шударга явж байж энэ хүлээн зөвшөөрөгдөх гэдэг асуудал байна л даа. 2008 оны 7 сарын 1 шиг ийм юм болгочихгүй байх хэрэгтэй. Энэ Сонгуулийн ерөнхий хорооны очих гэж байгаа гишүүд бол маш анхаарч ажиллах хэрэгтэй. Энэ сонгуульд бас нөлөөлнө гэдэг үйл ажиллагаанууд байна аа. Энэ гадна дотнын улсууд иймэрхүү үйл ажиллагаанууд явж байна. Тэгээд сонгууль хүлээн зөвшөөрөгдөхдөө ард түмэн маань, иргэд маань, сонгогчид маань жилээс жилд энэ оролцоо нь багасаж байна. Та бүхэн сая сонгуульд боловсрол энэ тэр гээд нэлээн юм ярих шиг боллоо. Тэр тал дээр та нар ямар бодолтой байна вэ?

Энэ цагдаагаас нэлээн тийм хүмүүс орж ирсэн байна. Академи төгссөн. Энэ бол би зөв л гэж бодож байна. Аль болохоор энэ сонгуулийг ямар нэгэн оролцоо энд тэндхийн нөлөөлөлгүй ингэж хийх нь зүйтэй байх. Тэгэхгүй бол одоо сонгуулийн өмнөхөн л тэр бүх телевизээр эрүүгийн элемент реситивүүдийг гаргаж ирээд л ингээд л ард түмэнд нөлөөлөх гээд л ингээд л яриад байдаг шүү дээ. Энэ юмыг та

нар юу гэж боддог юм? Энэ одоо яаж байгаа асуудал вэ? Ингэж явуулсныхаа дараа энэ харж байхад энэ Улсын Их Хурал бүрэлдчихсэн байгаа энэ нийслэлийн иргэдийн хурлыг нь харж байхад бас хэцүүхэн л байна шүү дээ. Ардын нам бол гучин тавхан хувийн санал авсан. Одоо Хүн нам нь ингээд аравхан хувийн санал авсан. Эд нар нийлээд олонх болж чадахгүй ард түмний авсан саналаар. Тэгээд хүлээн зөвшөөрөгдөхгүй. Нөгөө Үндсэн хууль дээр чинь бүх төрийн эрх мэдэл ард түмнээс үүдэлтэй л гэж байгаа. Тэгээд ийм юманд одоо бас нийцэхгүй байгаа байхгүй юу.

Та бүхэн өөрсдөө иргэдэд сонгогчид сонгуулийн боловсрол олгоно оо л гэж яриад байх юм. Энэ одоо намуудаас эхэлсэн нь дээр байх аа. Тэгээд сонгууль явлаа гээд...

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүн нэр дэвшигч бүрээс үү? Гишүүд нэр дэвшигч бүрээс асуулт асуулж байна.

Д.Давааням: Гишүүний асуултад хариулъя. Гишүүний асуултад гарсан сонгуульд нөлөөлөх үйл ажиллагааны талаар юу гэж боддог вэ гэхээр дэлхийн геополитикийн нөхцөл байдал ингээд эрс хурдацтай энэ өөрчлөгдөж байгаа тохиолдолд гаднын ямар нэгэн байгууллагын нөлөө, зохион байгуулалтын хэсэг этгээд, бүлэг хүмүүс, иргэний нөлөөлөл сонгуульд нөлөөлж байгаа энэ асуудлууд дэлхий нийтийн хэмжээнд яригдаж, дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд зөндөө гарч байгааг та бүхэн мэдэж байгаа. Одоогийн байдлаар Монгол Улсын болсон сонгуулиудад албан ёсоор гаднын нөлөөлөл орсон, шүүх хууль хяналтын байгууллагаар асуудал шийдэгдсэн энэ тохиолдол одоогийн байдлаар бол байхгүй байгаа. Бид Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар бүлэгт заасан төрийн эрх мэдлийг үндсэн хуулийн бус аргаар авахаас сэргийлэх, дээрээс нь гадаадын зохион байгуулалттай хүчин зохион байгуулалттай улс орон иргэд сонгуульд нөлөөлөх энэ үйл ажиллагааг бол таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, тэмцэх, энэ чиглэлийг эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно гэдэг бол үзэл баримтлалд бол заасан байдаг.

Би бол одоо Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдээс сонгогдсон тохиолдолд энэхүү үзэл баримтлалынхаа заалтыг бол хэрэгжүүлэх энэ үйл ажиллагаа нэлээд анхаарал тавьж ажиллаж түрүүн гишүүний хэлсэн шиг 7 сарын 1-ний өдөр болсон энэ үйл явдал шиг ийм үйл явдлыг дахиж гаргахгүй байх талаар бол одоо төрийн албанд төрийн тусгай албанд 34 жил ажилласан туршлага, мэдлэг энэ бүхнээ зориулна, ажиллана гэж бодож байна аа.

Иргэдийн оролцооны хувьд бол жил ирэх тусам яав сонгууль болгоноор багасаж байгаа. Үүн дээр миний хувийн бодол бол одоо иргэдэд сонгуулийн боловсролыг ялангуяа залуу үеийнхэнд түлхүү олгох замаар иргэдийн оролцоог ялангуяа энэ 18-19, 18-24 насны энэ бүлэг залуу бүлэгт хамаарах залуучуудын боловсролыг дээшлүүлснээр илүү эх оронч, үндэсний эрх ашгаа дээдэлсэн эх оронч ийм сэтгэлгээнүүдийг суулгаж байж бид нар одоо сонгуулийн ирцийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх бас шаардлагатай байгаа.

Намуудад боловсрол бас энийг тусгайлан олгох шаардлагатай байна аа гэдэг гишүүний энэ саналтай бол би бүрэн нийцэж байгаа. Зөвхөн иргэдэд гэхгүй бас улс төрийн намуудад тусгайлсан сургалтуудыг СЕХ –ноос зохион байгуулж явуулдаг. Энэхүү үйл ажиллагааг бас илүү өргөтгөх, илүү хүртээмжтэй болгох талаар бид

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдсон тохиолдолд анхаарч, чиглүүлж ажиллая гэсэн бодол байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэр дэвшигч.

Ж.Болд: Гишүүний асуултад хариулъя. Тэгээд нэр дэвшигчийн хувьд бодож байгаа бодол болбол сонгуулийн үед бас сонгуульд нөлөөлөх янз янзын эрүүгийн элементүүд эд нар нөлөөлж байсан асуудал тухайн үедээ бас 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд гэхэд цагдаагийн байгууллагад 1217 гомдол мэдээлэл ирж энэний дагуу шалгаж байсан ийм статистик мэдээ байдаг. Яг өнөөдрийн байдлаар миний юугаар бол цагдаагийн байгууллагад байгаа мэдээллээр яг энэ нөлөөлөөд энэ сонгуульд нөлөөлчихсөн байна аа гэсэн шийтгэгдсэн шүүхээр шийдвэрлэгдсэн юм алга. Одоо бүүр цаашид Сонгуулийн ерөнхий хороонд нэр дэвшиж байгаа дээр нь бас цагдаагийн байгууллагын даргаар ажиллаж байгаагийн хувьд энэ Эрүүгийн хуульд бол сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэдэг зүйл анги хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Тэгээд энэ сонгуулийн үеэр худал мэдээлэл тараасан бол тэр нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдвол энийг бас шийдвэрлээд явах боломж бол байгаа.

Ер нь цаашлаад нөгөө Эрүүгийн хуулийн худал мэдээлэл тараах гэдэг зүйл анги 13.14 маань Цэцээр ингээд түдгэлзүүлчихсэн ийм байдалтай байгаа. Энэ асуудлыг бас Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр сонгогдвол мөн цагдаагийн байгууллагаасаа ХЗДХЯ-аараа дамжуулаад энийг нэг талд нь багтааж шийдэхгүй бол энэ 2 хуулийн зөрчилтэй заалт одоо яг мөрдөгдөөд явж байгаа гэдэг ийм бодол санаа байна аа.

Д.Ариунболд: Гишүүний асуултад хариулъя аа. 1 дүгээрт өнгөрсөн хугацааны сонгуулиудыг харахаар иргэдийн төрд төрийн албан хаагчдад итгэх итгэл нэлээн сул байгаа юм уу гэж харагддаг. Сонгуулийн бүх түвшний сонгуулийг зохион байгуулахад улсын бүртгэлийн байгууллагын бүх түвшний албан хаагчид өргөсөн тангараг, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилладаг. Сонгуулиудын хугацаанд улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчидтай холбоотой алдаа зөрчил гомдол хянан шийдвэрлэгдсэн тохиолдол тоо судалгаа байдаггүй юм байна лээ. Тэгэхээр энэ сонгууль зохион байгуулж байгаа сонгуулийн байгууллагын ажилчдад төрийн албан хаагчдад төрийн байгууллагууд буюу төрийн тусгай чиг үүргийн байгууллагууд бие биедээ харилцан хяналтыг бүх түвшинд нь тавьж байдаг.

Тэгэхээр энэ төрийн албан хаагчдад итгэх энэ сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа ажилтнуудад итгэх иргэдийн итгэлийг олж авах нь нэн чухал асуудал байна аа гэж үзэж байгаа. Гадаадын нөлөөнд автах асуудлаар бол одоо эрх нь хэвлэл мэдээлэл бусад түвшинд нөлөөллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл түгээх эрх нь хуулиар олгогдсон байгаа. Хариуцсан байгууллага улсын бүртгэлийн байгууллагын төрийн албан хаагчдыг сонгуулийн үеэр хэт олон нийтийн болон хэвлэл мэдээллийн нөлөөнд автахгүй, хуулиар хүлээсэн үүрэг, чиг үүргээ шударгаар хэрэгжүүлэх энэ тал дээр бодлого, анхаарал, хяналт, нэгдмэл арга зүйг барьж ажиллана аа гэдгээ илэрхийлж байна аа.

Д.Мөнхзориг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн үеэр гаднын нөлөө байх эсэх асуудал дээр ер нь энэ тал дээр байнга анхаарах ёстой. Ер нь өнгөрсөн хугацаанд бол гайгүй байна гэж би бодож байгаа. Өөрөөр хэлбэл саналыг цаасаар өгөөд санал авах, дүнг гаргах, дамжуулах нэгдсэн дүн гаргах энэ процесс

цахимаар явж байгаа. Энэний ард бүх хэсэг дээр хяналтын тооллого хийгдэж байгаа. Тэгэхээр энэ дээр бол ямар нэгэн байдлаар зөрөө нэг саналын зөрөө гараагүй учраас санал өгөх тэр гаднын нөлөө нь бол гайгүй байсан байна аа. Харин одоо саналаа чөлөөтэй илэрхийлэх байдал дээр ямар нэгэн захиргаадал хэн нэгний дарамт шахалт байх иймэрхүү асуудлууд байхыг үгүйсгэхгүй. Энэ дээр бас анхаарч ажиллах ёстой.

Энэ ирцийн хувьд багасаад байгаа. Энэ дээр түрүүний хэлсэн дээрээ нэмээд хэлэхэд энэ сонгуулийн тогтолцоо хуучин мажоритар тогтолцоо байж байгаад одоо холимог тогтолцоо руу орчихлоо. Тэгээд энэ бол тодорхой хугацааны дараа бид нар ирц сайжрах үндэс болж магадгүй ээ. Яагаад гэхээр өмнө нь болбол миний санал гээгдлээ гэдэг асуудал яригддаг байсан бол одоо саяын 2024 оны Их Хурлын сонгуулиар мажоритар тогтолцоогоор нэг ч суудал аваагүй хэрнээ пропорциональ тогтолцоогоор 4, 4 суудал авсан 2 нам, эвсэл байна.

Өөрөөр хэлбэл иргэдийн энэ санал гээгдэхгүй болж эхэлж байна л даа. Мөн одоо Улс төрийн намын тухай хуулиар шинэчилсэн найруулгаар бол улс төрийн нам өөрөө гишүүддээ үйлчлэх, гишүүдийгээ сонгуулийн юу улс төрийн боловсрол олгох мөн иргэд тодорхой нийгмийн бүлгүүдэд улс төрийн боловсрол олгох ийм үүрэгтэй байгаа. Түүнд нь одоо СЕХ хяналт тавих үүрэгтэй. Тэгэхээр энийгээ дагаад бас сонгогчийн боловсрол дээшлэх боломжтой гэж бодож байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Саяхан энэ Улаанбаатар хот нийслэл дээр сонсгол явлаа л даа. Тэгээд тэр байдлыг нь харж байхад 45 төлөөлөгчтэй юм байна. Тэгээд энэ нутгийн өөрөө удирдах ёс гэж байгаа. Тэр нь Засаг даргаа өөрсдөө сонгох ёстой байх л даа. Тэгэх гэж л тэр сонгуулийг явуулаад 45 төлөөлөгч томилсон байх. Нөгөө 45 төлөөлөгч нь одоо бас ТҮЦ-ийн дарга нар хийх юм. Төрийн өмчтэй компанийн гишүүн хийх юм. Бид нар иргэд чинь тэгээд иргэдийнхээ төлөөллөө сонгосон юм уу, ТҮЦ-ийн гишүүдийг сонгосон юм уу. Тэр нь тэгээд итгэл хүлээх чадваргүй болсон юм уу Ардын намын удирдах зөвлөл нь даргаа шууд тавиад байх шиг байна лээ. Тэгээд хэрэв тийм юм бол одоо сонгууль явах хэрэгтэй юм уу. Баахан мөнгө төгрөг үрээд ингэж байх. Энийг та нар юу гэж бодож байгаа юм бэ? Энэ одоо хууль журам хэрэгжиж байна уу, ямар байна вэ? Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн болж байгаа хүний хувьд одоо...

Ж.Бат-Эрдэнэ: Ганбат гишүүн ээ, энэ дөрвүүлэнгээс нь асууж байна уу? Уг нь бол байнгын хороо хариулчихвал зүгээр байгаа юм л даа энэ асуудал дээр тийм. За нэг 2 нь хариулчих уу? Тийм өөрсдийгөө бодож байгаад л 2 нь хариулчихъя.

Д.Давааням: Төрийн албан хаагчид албан хаагчийн хувьд бол төрийн батлагдсан хууль дүрмийг бол мөрдөж ажиллах үүрэгтэй. Гэхдээ зүгээр хувь хүнийхээ хувьд энэ иргэдийн төлөөлөгч нар засагт хяналт тавих Засаг даргынхаа аппаратад бөөнөөрөө орчхож байгаа нь буруу гэж бодож байгаа. Хяналт тавих боломжгүй. Одоо энэ дээр бол хуулийн өөрчлөлт хийгээд тодорхой хязгаар тогтоодог ч юм уу, 30 хувиас хэтрэхгүй аппаратад нь орно ч гэдэг юм уу эсвэл одоо орон тооны байдлаар ажиллаж цалинждаг ч юм уу ийм байдлаар өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж бодож байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийн нэг нь хариулъя. Хуралдаад байгаа юм.

Д.Мөнхзориг: Төрийн захиргааны байгууллага буюу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд бол бүх түвшиндээ батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлээд хэлбэрэлтгүй хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй. Улс төрийн сонгууль болон орон нутгийн өөрөө удирдах зарчмаар сонгогдож байгаа сонгуулийг бол сонгуулийн дагуу тэгээд эрх бүхий хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргадаг албан тушаалтнууд шийдвэр гаргаж байгаа асуудалд бол одоо хувийн дүгнэлт одоогоор хийгээгүй байна. Гэхдээ бол иргэдийн сонгох эрхийг хангах энэ зарчмыг баримтлан ажиллах нь зүйтэй гэдэг байр суурьтай байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: 2024 онд Улсын Их Хурлын сонгууль яваад дууссан. Энэ 126 гишүүн сонгогдоод ажиллаж байгаа. Гэтэл сая цагдаагийн дарга хэлэх шиг боллоо. 1126 зөрчил гаргасан, шүүхээр шийдсэн юм байхгүй, бүгд одоо хэрэгсэхгүй болоод дуусаж байгаа гэсэн тиймээ. Энэ чинь тэгээд юу юу манай Баянхонгор дээр гэхэд манай Баянхонгорын АН-ын дарга болох гэж байгаа нэг залууг бас дуудаад л асуугаад л янз бүр болоод байдаг гэнэ ээ. Тэгээд цагдаагаас бол хэрэгсэхгүй болгоод ингээд тийм санал гаргаад явуулсан юм байна. Тэгээд хаана ч гэнэ вэ прокурор нь ч гэнэ үү юу ч гэнэ вэ буцаагаад байдаг гэнэ ээ? Бас л нөгөө орон нутагт нэг хонгил үүсгэх гээд байгаа юм уу, яах гээд байгаа юм нэг. Энэ дээр яах ёстой юм бэ? Нэг сонгууль яваад дууссан бол тэгээд нэг цэглээд дуусдаг баймаар байна. Тэгэхгүй бол одоо...

Ж.Бат-Эрдэнэ: Цагдаагийн дарга Болд хариулах уу? Нэр дэвшигч.

Ж.Болд: Гишүүний асуултад хариулъя аа. Тэгээд 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үеэр сонгуулийн тэр цаг хугацаанд 1217 гомдол мэдээлэл ирсэн. Гэмт хэргийн шинжтэй нь эндээс 450, зөрчлийнх нь 797, тэгээд хэрэг нээгээд шалгасан хэрэг бүртгэлтийн дугаартай хэрэг нь 14, зөрчлийн хэрэг 43 ингээд бусад бас төрийн байгууллагуудад харьяаллаар шалгаж шийдүүлэхээр 5-ыг, ингээд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс ингээд татгалзсан нь 241 гэдэг юм уу ийм статистик тоо байна аа. Одоо энэ эрүүгийн хэргээс 23 хэргийг нь хаачихсан, хаах саналтайгаар прокурорын байгууллагад шилжүүлсэн. Нэг хэрэг ажиллагаанд байна гэдэг ийм статистик дүн мэдээ байна аа.

Тэгээд ер нь бол хуулийн шалгах процесс мөрдөн шалгах...

Ж.Бат-Эрдэнэ: Үргэлжлүүлъя.

Ж.Болд: Тэгээд хуулийнхаа дагуу явагддаг прокурорын хяналтад энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг аа. Тэгээд мөрдөн юуны цагдаагийн байгууллагад мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа одоогоор нэг хэрэгтэй байна.

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа болохоор Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос одоо тайлбар өгөх боломж бололцоо байхгүйг гишүүд анхаарна уу. Тэгээд асууж байгаа асуултаа болж өгвөл нэр дэвшигчдэд хандаж асуувал зүйтэй байна.

Дараагийн асуулт асуух гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Асуултаа асууж үг хэлье.

Х.Баасанжаргал: Би Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдээс 2008 оны 7 сарын 1-ний үйл явдалтай холбоотойгоор манай сонгуулийн байгууллага ямар сургамж авч, юуг засаж, юуг өөрчилсөн гэж боддог вэ? Дутуу хийсэн ажил тэрэн дээр байгаа юу?

2 дугаарт таныг энэ ажил албан тушаалаа хашиж байх явцад сонгуулийн үр дүнтэй холбоотой 2008 оны 7 сарын 1 шиг үйл явдал болбол та хамгийн түрүүнд ямар арга хэмжээ авах вэ? Хэнтэй зөвшилцөж, ямар шийдвэр гаргах вэ? Ямар зарчим баримтлах вэ? 2 дахь асуулт.

3 дахь асуулт. Таны гаргасан шийдвэр бодлого намын эрх ашигтай аль нэг намын эрх ашигтай зөрчилдвөл та ямар зарчим баримтлах вэ гэсэн ийм 3 асуултад хариулаад өгөөч. Тэгээд сонгуулийн байгууллагаас болоод сонгуульд ямарваа нэгэн асуудал сонгуулийн үр дүнд итгэх сэтгэл унах, ямар нэгэн асуудал үүсвэл та ямар хариуцлага хүлээж чадах вэ гэсэн ийм 4 асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн хэнээс хэнд асуултаа тавьж байна? Дөрвүүлэнд нь үү? Тодорхой асуултад дөрвүүлээ ээлжлээд товчхон хариулъя. 4 номерын индэр нэр дэвшигчид.

Д.Ариунболд: Гишүүний асуултад хариулъя. Эхний асуултын хувьд 2008 оны 7 дугаар сарын 1 сонгуулийн үр дүнгээс болж нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, эрдэнэт хүний амь нас хөнөөгдсөн ийм асуудал гарсан. Сонгуулийн ерөнхий хорооны яах вэ гишүүн би биш Сонгуулийн ерөнхий хороонд ажиллаж байгаагүй учраас СЕХ нь дотооддоо яг өдий хүртэл хугацаанд юу зохион байгуулсан гэдгийг бол нарийвчлан хэлж чадахгүй ч гэсэн сонгогчийн хувиар бас тодорхой хэмжээний тодорхой албан тушаалуудыг хариуцаж, сонгуулийн үйл ажиллагааг сүүлийн зохион байгуулалт аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг бас тодорхой хэмжээгээр ажигладгийн хувьд хэлэхэд СЕХ нэлээд ажлуудыг маш зөв зүйтэй зохион байгуулж байгаа гэж үзэж байгаа. Ялангуяа одоо хар хайрцаг буюу бид нарын ярьдгаар сонгуулийн автоматжуулсан системийг сайжруулах үйл ажиллагааг нэлээд хийж байна.

Одоогийн байдлаар IBBC 1 дүгээр үеийн төхөөрөмжүүдийг солих үйл ажиллагаануудыг эхэлсэн боловч санхүүжилтийн асуудлаас болж энэхүү үйл ажиллагаа хоцрогдолтой явж байгаа. Мөн түүнчлэн сонгуулийн хуулиудыг өөрчлөх Их Хурлын тухай хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, аймаг, нийслэлийн одоо сонгуулийн хуулиудыг өөрчлөх энэ үйл ажиллагаанд нэлээд Их Хурал болон одоо төр, засгийн зүгээс анхаарал тавьж, гишүүдийн зүгээс анхаарал тавьж энэхүү гаргасан алдааг засах чиглэлээр хуулийн өөрчлөлтүүдийг бол тодорхой хэмжээгээр оруулсан гэж бодож байгаа. Мөн түүнчлэн 2023 онд орсон энэ Сонгуулийн хуульд орсон өөрчлөлтөөр энэ цахим технологийг ашиглах энэ эрхийг тодорхой хэмжээгээр нээж өгсөн байгаа. Энэхүү үйл ажиллагаанаасаа 2024 оны сонгууль бол бүрэн хэмжээгээр явагдсаныг та бүхэн мэдэж байгаа.

Бид мэдээж ямар нэгэн асуудал миний алба Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр сонгогдсон тохиолдолд 7 сарын 1-тэй адилхан үйл явдал болсон үед мэдээж Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн хорооны дүрэмд заасныхаа дагуу бид

нар хариуцлага хүлээх ёстой байх. Мөн түүнчлэн өөрийнхөө эрхэлж байгаа албан тушаалын хувьд ч, мөн үйл ажиллагааны хувьд ч гэсэн төрийн тусгай албанд ажиллаж байсан энэ ажиллаж байгаа энэ хүнийхээ хувьд ч гэсэн бид бол тодорхой хэмжээгээр зарчимтай ажиллаж, энэ хариуцлагыг хүлээх ёстой гэдгээ бол ухамсарлаж байгаа. Төрийн тусгай албанд ажилладаг учраас ямар нэгэн улс төрийн байгууллага, ямар нэгэн нам эвсэлтэй холбоотой ажилладаггүй. Ямар нэгэн эвслийн намын гишүүн бус хүн. Ийм учраас ямар нэгэн байдлаар намын эрх ашигтай зохицогдсон үйлдэл бол гарахгүй байх гэж бодож байна аа.

Ж.Болд: Гишүүний асуусан асуултад хариулъя. 2008 оны 7 сарын 1-нд би өөрөө яг голд нь үүрэг гүйцэтгэж явсан. Энэ үед яг тодорхой шийдвэр эрх барьж байсан гэдэг юм уу төрийн албан тушаалтнууд гаргачихсан болов уу л гэж боддог. Энд их олон энгийн иргэд болоод цагдаагийн албан хаагчид маш олноор өртөж хохирсон энэ үймээн самуунаас. Энэний сургамж бол энэнээс хойш бас Онц байдлын тухай хууль одоо жагсаал цуглаан, эмх замбараагүй байдлын үед хэрхэн ажиллах вэ гэдэг журмууд бүгд өөрчлөгдөж энэ журам юу нь бол одоо хэрэгжээд шуурхай штабууд нь ажиллаад явдаг аа. Тэгээд одоо бол энэ сургамж тухайн үед бас Улсын Их Хурлаас ажлын хэсэг гарч шалгаад дүн шинжилгээ хийгээд дүгнэлтүүдийг өгч байсан байдаг. Энэнтэй бас танилцаж байсан.

Тэгээд одоо бол энэ сургамж дээр үндэслээд тодорхой арга хэмжээнүүдийг шуурхай авах ёстой юм байна гэж ойлгодог. Цаашид энийг бол шийдвэрлэх шийдэх ёстой. Хууль тогтоомжийн хүрээнд бас Сонгуулийн ерөнхий хороондоо болоод цагдаагийн байгууллага бол дээд шатны яамдаараа дамжуулаад энэ саналуудаа тавьдаг штабууд ажиллаж эхэлдэг. Энэ тодорхой ямар түвшинд ажиллах вэ гэдэг бас журмуудаа баталчихсан ингээд явж байгаа.

Намын эрх ашигтай зөрчилдвөл бид ийм асуудал намын ямар нэгэн харьяалал байхгүй. 34 жил төрд, төрийн албанд, төрийн тусгай албанд зүтгэж байгаа сая Ариунболд нэр дэвшигчийн хэлдгээр энд бол нэг их зөрчилдөөд байх юм миний хувьд гарахгүй ээ гэж ойлгож байгаа. Хариуцлагын хувьд төрийн ямар нэгэн хууль тогтоомж зөрчсөн бол энэ хариуцлагаа хүлээхэд бол бэлэн. Ингэж хариулъя.

Д.Давааням: Гишүүний асуултад хариулъя аа. Өнгөрсөн 7 сарын 1-ний үйл явдал гэж жишээ нь энэ дээр бол бас сонгуулийн байгууллагуудын хувьд олон нийтийг нээлттэй ил тод, бүх төрлийн мэдээллээр үнэн зөв мэдээллээр хангах энэ ажил жоохон орхигдсон юм болов уу гэж хувь хүнийхээ хувьд боддог.

2-т нь төрийн эрх барьж байгаа албан тушаалтнууд улс төрийн биш яг ийм нөхцөл байдал үүсвэл эв нэгдлийн үндэсний эрх ашгийг хамгаалсан ийм шийдвэрүүд гаргаасай гэж хүсдэг. 7 сарын 1-нийх шиг өнгөрсөн үйл явдал шиг үйл явдал давтагдах юм бол СЕХ олонхын зарчмаараа шийдвэр гаргадаг байх. Түрүүний хэлсэнчлэн үндэсний эв нэгдэл хууль тогтоомжид нийцсэн санал зөвлөмжүүдээ өгч үүнд таслах эрхээрээ шийдвэрлэлүүд гаргана аа гэж бас бодож байна.

Улс төрийн намын харьяаллын хувьд одоо мөн Болд нэр дэвшигчийн адил төрийн тусгай албанд 6 жил, төрийн захиргааны албанд 19 жил тасралтгүй ажиллаж байна. Энэ хугацаанд улс төрийн аль нэгэн намын гишүүнчлэл харьяалал байсангүй. Улс төрийн намын дэргэдэх олон нийтийн болон төрийн бус байгууллагуудад хамрагдаж явж байсан ийм үйл ажиллагаа түүх байхгүй. Улс

төрийн намд хамаарал бүхий шийдвэр гаргах юм бол одоо төрийн албаны зарчмаараа хууль тогтоомжид нийцсэн ийм шударга шийдвэрийг гаргахыг хичээж ажиллана аа. Хариуцлагын хувьд мөн алдаа дутагдал гаргах юм бол хууль тогтоомжид хүлээсэн заасан хариуцлагыг хүлээхэд бэлэн байна аа.

Д.Мөнхзориг: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. 2008 оны үймээнээс ямар сургамж авав гэж. Тэгэхээр ер нь жоохон асуудал тодорхойгүй байдлаас том асуудал болж хувирдгийн жишээ болсон. Тэгэхээр одоо 2008 оных шиг ийм үймээн самуун болбол хамгийн түрүүнд ямар арга хэмжээ авах вэ гэж. Тэгэхээр хамгийн түрүүнд ерөөсөө мэдээллээр хангах ёстой юм байна лээ. Тэгэхээр ийм ийм алдаа дутагдал, иймэрхүү фактууд гарлаа, энэ дээр ингэж ажиллаж байна, тайван замаар шийднэ шүү гэж иргэдийг уриалахаас эхлээд хамгийн түрүүнд мэдээллээр хангана. Дараа нь Сонгуулийн ерөнхий хороон дээр хамтын зарчмаараа асуудлаа шийдээд тэрийгээ тухай бүр нь танилцуулаад явна аа.

Миний үзэл бодол намын эрх ашигтай зөрчилдвөл яах вэ гэсэн асуулт байна. Тэгэхээр төрийн албанд төрийн жинхэнэ албан тушаалтнаар 20 гаруй жил ажилласан, зөрчилдөх тохиолдол байсан. Энэ тохиолдолд хууль дүрмийг баримталж ажиллаж байсан. Тэгэхээр мөн адил хууль журмыг баримталж төвийг сахиж ажиллана аа. Намууд бол мэдээж хэрэг өрсөлдөж байгаа учраас зөрчилдөөн бол үүснэ. Алдаа дутагдал гарсан тохиолдолд ажлаас албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх мөн цаашлаад тохирсон тэр сахилгын шийтгэл зөрчлийн арга хэмжээ, эрүүгийн хариуцлага хүлээхэд бол бэлэн.

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Яах вэ дөрвүүлээ заавал босохгүйгээр гараа өргөөд надаа харуулчхаарай Сонгуулийн ерөнхий хорооны ажилтан алба хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас сонгуулийн үр дүнд нөлөөлсөн тогтоогдох юм бол та бүхэн ажлаа өгч чадах уу? Ажлаа өгч чадах хүмүүс нь гараа өргөнө үү? За баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар СЕХ нь 9 гишүүнтэй. Тэдгээрийг бол Улсын Их Хурлаас сонсгол хийгээд 6 жилийн хугацаагаар томилно гэж заасан байдаг. Одоо хүчин төгөлдөр ажиллаж байгаа Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийн 7 гишүүний хугацаа нь дууссан байгаа. 2 гишүүний хугацаа бол энэ оны 8 сарын 28-ны өдөр дуусах юм байна. Тэгэхээр СЕХ бол одоо Улсын Их Хурлын харьяа байгууллага. Улсын Их Хурал томилгоог хийдэг. Тэгэхээр нэгэнт 7 гишүүний хугацаа нь дууссан байхад яагаад зөвхөн 4-ийг нь оруулж ирээд 3-ыг нь үлдээж байна аа гэдэг асуудал байна.

Ер нь Улсын Их Хурал энэ бүрэлдэхүүнийг нь бүтнээр нь харж байж тэгээд энэ энэ бүрэлдэхүүн бүтнээрээ ийм төвийг сахисан хараат бус шийдвэр гаргаж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр шийдвэр гаргах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр бол хугацаа нь дууссан гишүүдийг бид нар бол одоо бүрэлдэхүүнээр нь хаврын чуулгандаа багтааж томилох ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг бол одоо хэлье. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын удирдлага энийг анхааралдаа авна уу гэж хүсье ээ. Тэгж байж бид нар энэ Сонгуулийн ерөнхий хорооныхоо цаашдын чадамжийн асуудлыг ярина. Эс бөгөөс ҮХЦ дээр болж байгаа асуудал байна шүү дээ. Хугацаа нь дуусчхаад бүтэн жил

болж байхад их суудлын хуралдаанаа даргалаад байгаа ийм асуудлуудтай холбоотой улс төрийн асуудлууд ч гарч байна.

Сонгуулийн төв байгууллага СЕХ гэдэг бол Монголын ардчиллын амин сүнс ээ. Чөлөөт шударга сонгууль гэдэг бол одоо ардчилсан тогтолцооны бүүр хамгийн суурь багана аа. Тэгэхээр Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийн томилгоонд бол маш их ач холбогдол өгч байгаа. Энэ Монголын ардчиллыг хамгаалах ёстой хүмүүс бол одоо энэ Сонгуулийн ерөнхий хороонд ажиллаж байгаа хүмүүс ээ. Тэгэхээр нэр дэвшигч тус бүрээс асуух зүйл байна. Энэ өнгөрсөн хугацаанд бид сонгуулийн луйвар булхай энэ иргэдийн саналыг мөнгөөр худалдаж авах асуудалтай холбоотой маш олон гомдол саналууд гардаг, хэвлэл мэдээллээр яригддаг хэрнээ энэ нь шүүх цагдаагаар бас тодорхой шийдэгдээд явдаг зүйлүүд байхгүй. За эрх баригч нам бол одоо төрийн нөөцийг сонгуулиар дайчилж давуу тал олж авдаг энэ тэр гэсэн шүүмжлэлүүд бас байдаг аа. Тэгэхээр энэ төрийн сонгуулийг мөнгөний нөлөөллөөс ангижруулах тал дээр та бүхэн ямар бодолтой байдаг вэ? Бас тодорхой асуулт асууя.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нэр дэвшээд ороод ирж байна. Энэ царцааны асуудал дээр ямар байр суурьтай байгаа вэ? Ер нь жил болгон л царцаа гээд л яригддаг. Тэгээд энэ улсын бүртгэлтэй холбоотой ч гэсэндээ эргэлзээ тээнэгэлзээнүүд байдаг. Энэ царцааны асуудлаа хэрхэн яаж шийдэж байна вэ? ЦЕГ-ын газрын дарга нэр дэвшиж байгаа. Сонгуулийн үед цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн эрх баригч намын нэр дэвшигчдийг илт дэмжсэн. Цөөнхийн нэр дэвшигчдийн санал гомдлыг шийдвэрлэхгүй байх энэ тэр асуудлууд гардаг аа.

Ж.Бат-Эрдэнэ: Минутыг нь нэмж өгье. Жаргалан гишүүнд.

Б.Жаргалан: Энэ чиглэлээр ЦЕГ ер нь ямар үйл ажиллагаа явуулж байна вэ гэдэг асуулт байна. Тэгээд бас нийтлэг 4 нэр дэвшигчээс тодорхой асуултад Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд бол албан тушаалаараа орно гэсэн ийм тодорхой заасан зүйл байхгүй хэрнээ ийм жишиг байна гээд албан тушаалаараа бүртгэлийн газар ч гэдэг юм уу, цагдаагийн газрын дарга нар орж ирээд байдаг аа. Тэгэхээр энэ албан тушаалаар орж ирж байгаа гэдэг энэ албан тушаалыг сахиж байгаа хүмүүс та бүхэн албан тушаалаа өгөх юм бол өөрсдөө өргөдлөө өгөөд Сонгуулийн ерөнхий хорооноосоо гарах уу?

Төгсгөлд нь 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг сануулахыг хүсэж байна аа. Тухайн үед ковидтой байсан тэр үед юу болсон бэ гэхлээр УБЕГ АН-ын тамгыг хувилж өгөөд СЕХ тэр шийдвэр дээр үндэслээд АН-ын нэр дэвшигчийг бүртгэсэн. Энэ асуудлаар бол манай бүлгийн 8 гишүүн бас өлсгөлөн зарласан байдаг. Энэ асуудал дээр та нар ямар...

Ж.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигчдээс дэвшигч бүрээс асуулаа. Ээлжлээд хариулъя.

Д.Давааням: Гишүүний асуултад хариулъя. Мөнгөний болон мөнгө тараадаг луйвар хийдэг гэдэг энэ асуудлууд бол сүүлийн үеийн сонгуулиудад нэлээн яригдаж байгаа. Олон нийт энэ талаар үзэл бодлуудаа чөлөөтэй илэрхийлж ажиллаж байгаа. Энэ дээр нэг л зүйл байгаа юм. Энэ одоо түрүүний нэр дэвшигчийн дурдсанчлан улс төрийн намуудын санхүүжилтийн 50 хувь сонгуульд нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн санхүүжилтийн асуудал дээр тавих хяналтуудыг нэлээн

тодорхой түүнд хүлээлгэх хариуцлагыг чангахан зохион байгуулах. Энэ нь үр дүнтэй болов уу гэж бодож байна. Энэ царцааны асуудал энэ 2 дээр бас нэг ёс зүйн асуудал сүүлд нь би нэгтгээд хэлчихье.

УБЕГ иргэний оршин суух хаягийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийдэг. Монгол Улсын Их Хурлын сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгч, сум дүүргийн ИТХ-ын сонгуулиар иргэний шилжилт хөдөлгөөнийг хуулийн дагуу 60 хоногийн өмнө зогсоодог. Энэ шилжилт хөдөлгөөнийг шилжилт хөдөлгөөний эрх нь Монгол Улсын иргэнд Үндсэн хуулиар олгогдсон эрх байгаа. Монгол Улсын иргэн бүр оршин суух газраа чөлөөтэй суух энэ эрхтэй. Тэгэхээр энэ оршин суух хаягийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зөвхөн сонгуулийн эрх, сонгууль шударга явахтай бас холбон ойлгох нь өрөөсгөл юм уу гэж боддог. Энэ одоо Монгол Улсын иргэдийн оршин суух хаяг тойргийн харьяаллаар нийгмийн халамжууд үзүүлдэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг тэр битгий хэл хүүхдийн цэцэрлэг, сургуулийн харьяаллыг хүртэл тогтоож байгаа болохоор энэ хүрээнд бас иргэний бусад эрхүүд дээр нь анхаарч энэ шилжилт хөдөлгөөнийг гэхдээ сонгуулийг зөв явуулахын тулд, шударга явуулахын тулд хуулиар тогтоосон хугацаанд явуулж байгаа.

Энэ царцааны асуудал түрүүний мөнгөний асуудал дээр улс төрийн намуудын нэр дэвшигч нарын ёс зүйн асуудал, сонгогчдын ёс зүй, боловсролын асуудлууд дээр түлхүү соён гэгээрүүлэх нөлөөллийн асуудлуудыг тавих нь зүйтэй юм болов уу гэж байгаа юм. Энэ царцааг нэр дэвшигч нар нүүлгэдэг. Энэ царцаануудын асуудлуудыг бас тэр сонгогчид нь өөрсдөө ингэж шилжилт хөдөлгөөний хаягаа хийх хүсэлттэй.

Хуульд заасан Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасан 4 үндэслэл байгаа. Оршин суух хаягийн шилжилт хөдөлгөөн.

1-т нь газар болон үл хөдлөх хөрөнгийн өөрийн өмчлөх эрхийн эрхийн гэрчилгээг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг бүртгэж байгаа юм.

2-т нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч болон газар өмчлөгчийн зөвшөөрлөөр иргэний хаягийг шилжилт хөдөлгөөнийг бүртгэж байгаа юм.

3-т нь одоо түрээсийн гэрээ ялангуяа орон сууцын болон хашаа байшин үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ.

3-т нь үл хөдлөх хөрөнгийн захиалгын гэрээг үндэслэн шилжилт хөдөлгөөнийг бүртгэж байгаа.

Улсын бүртгэлийн байгууллагаас Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулаад ХЗДХЯ-ндаа хүргүүлээд байгаа юм. Энэ дээр бид нар энэ хаягийн шилжилт хөдөлгөөн дээр энэ захиалгын гэрээг үндэслэн бүртгэж байгаа асуудлыг үндсэндээ хасъя гэдэг санал өгсөн. Ашиглалтад ороогүй улсын комисс хүлээж аваагүй байгаа орон сууцыг гэрээг нь үндэслэн иргэний шилжилт хөдөлгөөнийг бүртгэх нь өрөөсгөл байна гэж харж байгаа.

Албан тушаалын тэр АН-ын тамга тэмдгийн тухай асуудлууд яригдаж байна. Одоо бол улсын бүртгэлийн байгууллагыг удирдан зохион байгуулж байгаа хуулиар

хүлээсэн чиг үүргээ биелүүлэн ажиллахдаа ийм асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж шударгаар ажиллана гэдгээ илэрхийлье.

Ж.Бат-Эрдэнэ: Албан тушаалаа өргөдлөө өгөх үү гэж асууж байна.

Д.Мөнхзориг: Өгнө өө. Энэ Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс үндсэн албан тушаал буюу улсын бүртгэлийн байгууллагын даргын тэргүүн түшмэлийн албан тушаалаас чөлөөлөгдвөл шууд өгнө.

Ж.Бат-Эрдэнэ: Дараагийнх нь.

Д.Давааням: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн хугацааны тэр сонгуулийн луйвар булхай, бэлэн мөнгө, бэлэг тараах энэ асуудлууд бол энэ Улс төрийн намын тухай хуулиараа ер нь гишүүний ёс зүйн асуудал намын үүргийн асуудал болж хувираад байгаа. Энэ дээр мэдээж ийм асуудал гарах юм бол санал гомдлоо гаргаад цагдаагийн байгууллага дээр шийдвэрлээд цаашлаад шүүхээр шийдвэрлэгдээд явна. Тухай бүрд нь арга хэмжээг аваад явна.

Царцааны асуудал дээр ярьж байна. Энэ сонгууль болохоос өмнө 20, 60 хоногийн өмнө шилжилт хөдөлгөөнийг зогсоодог. Тэгээд энэ сонгуулиас болоод шилжилт хөдөлгөөнийг хорьж болохгүй. Тийм учраас энэ дээр мөн л Давааням нэр дэвшигчтэй адилхан энэ дээр бол нэр дэвшигчид өөрсдөө ёс зүйтэй байж, мөрийн хөтөлбөрөөр өрсөлдөх, нэр хүндээрээ, хийсэн ажлаараа, хийх гэж байгаа ажлаараа өрсөлдөх шударга өрсөлдөх шаардлагатай гэдгийг уриалж ажиллана. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдвол улс төрийн намуудтай уулзалт хийж. Албан тушаалын хувьд болбол яах вэ энэ дээр хариулчихъя.

Ер нь энэ СЕХ бол ардчилсан нийгмийн хамгийн гол баталгаа болсон байгууллага. Тийм учраас энэ дээр гишүүд нь өөрөө тогтвортой байх, хараат бус байх бол чухал асуудал гэж бодож байгаа юм. Тэгээд энэ дээр миний хувьд үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдвөл Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөгдөхгүй 6 жилийн хугацаагаа дуусгана, тогтвортой ажиллана гэж бодож байгаа юм.

Тэр 2021 оны тамгатай холбоотой асуудал одоо бол Улсын дээд шүүх бол тамга бүртгэлийн асуудлыг шийдэж байгаа. Энийг бол одоо эцэслэгдчихсэн дахиад ийм асуудал бол гарахгүй юм байна гэж ойлгож байгаа.

Ж.Болд: Гишүүний сонгуулийн луйвар булхай маш их явагддаг. Ямар бодолтой байдаг вэ гэж. Сонгуулийн үед би түрүүнд хэлсэн. Цагдаагийн байгууллага сонгуулийн саналын хуудас хэвлэгдэхээс эхлээд сонгууль явагдаж дуусаад нөгөө хар машиныг хүлээлгэж өгөх хүртэл нийтдээ нэг 10 төрлийн үйл ажиллагаанд төлөвлөгөө юм гаргаж ажилладаг. Мөн дээр түрүүнд хариулсан олон гомдол мэдээлэл ирдэг. Энийг цагдаагийн байгууллага бас яг дангаараа энэ гомдол мэдээллүүдийг шийдвэрлэдэггүй гээд. Тэгээд энэ нийт ер нь цагдаагийн байгууллага 2024 оны сонгуульд 10684 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн. Ингээд бүрэн бүрэлдэхүүнээрээ өндөржүүлсэн бэлэн байдалд үүрэг гүйцэтгэдэг ээ. Ингээд бүх албан хаагчаа би бас буруу хууль бус ажиллагаа хийдэг гэж бодохгүй байна аа.

Тэгээд хууль тогтоомжийн хүрээнд цагдаагийн байгууллага прокурорын хяналт доор бүх хуулийн шийдвэр гардаг, прокурор дээр эцэслэж шийдвэрлэгдэн

шийдвэрлэгддэг, цаашлаад эцсийн шатад шүүх шийддэг ээ. Тэгээд цаашдаа бол цагдаагийн байгууллага сонгуулийн үеэр зөвхөн хуульд юу гэж заасан тэр хууль тогтоомжийн хүрээнд шударга, шуурхай, хамгийн гол юм бас энэ богино цаг хугацаанд шийдвэр нь хурдан гарч байх шаардлагатай гэж ойлгодог учраас энэ шуурхай ажиллана аа гэж бодож байна аа. Эрх баригчдын тэр эрхийг хамгаалдаг эд нар гээд энэ нийтдээ сая хэллээ. 11, 12 мянган цагдаагийн албан хаагч бүрэн бүрэлдэхүүнээрээ л эрвийх дэрвийхээрээ л нойр хоолоо хасаж ажилладаг. Тэгээд энэ хуулийг юу сонгуулийг шударга явуулахад бүхий л удирдлагаар хангаж цагдаагийн байгууллагын удирдлага бие бүрэлдэхүүн нь бүрэн бүрэлдэхүүнээр ингэж ажилладаг гэж ойлгож байна аа.

Тэгээд энэ албан тушаалыг өгвөл Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс 2023 онд хүсэлтээ өгөөд чөлөөлөгдөж байсан. Дахиад энэ албан тушаалыг өгөхөд шууд өгнө өө.

Д.Ариунболд: Гишүүний асуултад хариулъя. Мөнгө булхай луйвартай холбогдсон энэ асуудал дээр бол би хувь хүний зүгээс бодохдоо энэ 1 дүгээрт энэ нам өөрөө бас хариуцлагатай байх ёстой юм болов уу гэж боддог. Нам бол мэдээж нэр дэвшигчдээ сонгож байгаа, дэвшүүлж байгаа. Ийм учраас нам хэнийгээ сонгож байгаагаа энэ дээрээ зориулж тэр боловсролыг нь олгох, хариуцлагыг өндөржүүлэх энэ асуудал дээр нэлээд хариуцлагатай байх ёстой. Дээрээс нь намын томилж байгаа ухуулагчдын баг, нэр дэвшигчдийн ухуулагчдын баг эд нар бол хууль тогтоомжоо маш сайн судалсан ийм тэрийг байх ёстой гэсэн нэг хувийн бодол байдаг аа.

Мөн түүнчлэн энэ улс төрийн намын санхүүч улс төрийн намын тухай хуулийн дагуу энэ санхүүжилтийг хянах асуудал нэр дэвшигч нар мөн түрүүн хэллээ. Энэ асуудлыг мэдээж СЕХ хууль тогтоомжийн хүрээнд хариуцаж байгаа учраас энэ дээр нэлээн хатуу, нэлээд үнэнч шударга зөв зүйтэй байдлаар системчилсэн байдлаар санхүүжилтийн асуудлыг бол ялангуяа сонгуульд зарцуулсан зарцуулалтын асуудлыг бол хянах тал дээр илүү ахиц дэвшил гаргаж ажиллана гэж ер нь бодож байгаа. Албан тушаалын хувьд бол мэдээж би өргөсөн тангаргаасаа няцвал Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу бол одоо төрийн цээрлэл хууль ёсных нь дагуу хариуцлага хүлээхэд бол бэлэн байгаа.

Ер нь бол бүртгэлжүүлэлтийн системийг сайжруулах замаар цахим системийг сайжруулах замаар нэр дэвшигчдийн ялангуяа энэ сурталчилгаан дээр зарцуулагдаж байгаа мөнгийг бүртгэлжүүлэх ялангуяа энэ платформуудыг маш зөв зүйтэй ашиглах тал дээр илүү дэвшилттэй ажиллах ёстой гэсэн би бодол байна. Энэхүү бодол маань болохоор мэдээж энэ үндсэн хуулийн Үндсэн хууль болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус хувь үндсэн хуулийн бус аргаар авах энэ зарчимтай бол нийцэж байгаа учраас мэдээж энэ булхай луйврыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх энэ чиглэл рүү нэлээд албан үүргийнхээ ч хувьд ч гэсэн, хувь хүнийхээ хувьд ч гэсэн нэлээд түлхүү анхаарал тавьж ажиллах болно оо.

Ж.Бат-Эрдэнэ: Болсон байх аа. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууж үгээ хэлнэ.

Х.Ганхуяг: 4 нэр дэвшигчийг дэмжиж байна аа. Дөрвүүлэнтэй нь тодорхой хэмжээнд бас ажил хэргийн холбоотой байж үзсэн. Ер нь төрийн ажлыг бас саад

тотгоргүй хийчих болов уу гэж итгэж байна. Яах вэ Сонгуулийн ерөнхий хороон дээр бол нэг л асуудал байгаа. Ирэх жил 2027 онд Ерөнхийлөгчийн сонгуультай, 2028 онд дахиад Улсын Их Хурлын сонгуультай байгаа. Тэгээд тоног төхөөрөмжийн асуудал ерөөсөө шийдэж чадахгүй яваа. Нийтдээ энэ чинь нэг 47 тэрбум долларын тоног төхөөрөмж, 47 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж авах ёстой байгаа. Хуучин тоног төхөөрөмж нь баталгаат хугацаа нь хэтэрчихсэн, ашиглах хугацаа нь хэтэрчихсэн. Өнгөрсөн жил Улсын Их Хурал дээр оруулж ирээд энэ бол юугаар дэмжигдэж чадаагүй. Хэсэгчлэн мөнгө нь тавигдсан байгаа.

Тэгэхээр энэ 20 болохгүй бол зээлээр ч хамаагүй аваад яахгүй бол одоо энэ 27-ны төсвийг хүлээгээд бол бүтэхгүй байх. Тэгэхээрээ та бүхэн маань ажил томилогдсон одоо энэ тоног төхөөрөмжийн асуудал тэрний нөгөө найдвартай ажиллагааны асуудлуудыг сайтар шалгаж энийгээ хийхгүй бол. Тэгээд Сангийн сайдтай эд нартай ярьж байгаад тэр зээлээр хамаагүй аваад хэрэгжүүлэхгүй бол ер нь хугацаа бол их тулчихсан. 2027 оны төсвийг хараад бол тэр тусмаа тэр бас бүтэмж нэлээн муутай байх болов уу гэж харж байна. Тэр чинь 47 тэрбум нэгэн зэрэг нэг удаагийн юу санхүүжилтээр дээрээс нь нөгөө төрийн худалдан авах нөгөө хуулийн дагуу явбал наадах чинь тэгээд 5 сарын 31 хүртэл тендер нь явж байгаад нэг нь маргачихвал тэгээд нөгөө мөнгө нь буцааж татагдаад ер нь тэгээд нөгөө сонгуулиа ч хийж чадахгүй нөхцөл байдал үүсэх эрсдэл байгаа шүү.

Тэгэхээр энэ дээр бол одоо хороодын гишүүд маань онцгой анхаарал тавихгүй бол энэ тоног төхөөрөмжийн техникийн саатлаасаа болоод сонгууль хойшилж болохгүй. Энэ чинь 6 жилд нэг удаа болдог сонгууль байгаа. Одоо манай АН-аас бол одоо лидер алт мэт ах нар дэвшиж магадгүй байгаа. Тэгээд нэр дэвшигч нартаа бүгдэд нь амжилт хүсье.

Ж.Бат-Эрдэнэ: Үг хэллээ. Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар УБТЗ ХНН-ийн барилга засвар, ашиглалтын ангийн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. УБТЗ-ынхаа хамт олон та бүхэндээ ажилд нь амжилт, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. Үгтэй үг нь хамтдаа явчхаж байгаа юм. Тэгээрэй тийм.

Одоо Байнгын хорооны саналаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийг гишүүдээр томилох нууц санал хураалт явах ёстой. Нууц санал хураалтыг санал хураалтыг 17 цагт бүх санал хураалт явуулна. Тэрэнтэй нэгтгэе ээ.

16.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Найм.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Ж.Бат-Эрдэнэ: Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцье.

Засгийн газар 2025 оны 11 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг өргөн мэдүүлсэн хууль байгаа. Анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн танилцуулна аа. Баасанжаргал гишүүнийг индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 12 дугаар сарын 4, 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 23 дугаар захирамжаар дээрх хуулийн төслүүдийг байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргалаар ахлуулж, ажлын хэсгийн дэд ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа, Гончигдоржийн Уянгахишиг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл, Аюушийн Ариунзаяа, Дашдондогийн Ганбат, Лхагвын Мөнхбаатар, Сархадын Зулпхар, Даваахүүгийн Пүрэвдаваа, Отгоны Саранчулуун, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Буяагийн Тулга, Сүхбаатарын Эрдэнэбат нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна аа.

Нэг. Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн тухай конвенцод нийцүүлэн гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа болон эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрх дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж ажиллах.

2 дугаарт, Гэрлэлт цуцлах хүүхдийн асрамж эцэг эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоох, тэжээн тэтгэх тэтгүүлэх, хүүхэд үрчлэлтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хүүхдийн эрх дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шууд дамжуулах болон олон нийтэд дуу дүрсний бичлэгээр хүргэхийг хориглох.

3.Хүүхдийн асрамж тогтоох эцэг эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоох, тэжээн тэтгэх асуудлыг шүүх гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж хүүхэд буюу хүүхэд 7 буюу түүнээс дээш настай бол түүний санал болон энэ хуульд заасан хүүхэд гэр бүлийн мэргэжилтний тайланг харгалзан үзэх.

4.Шаардлагатай тохиолдолд шүүгчийн захирамжаар хүүхдийн эрх дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих зарчмын дагуу эцэг эх, хүүхэд хоорондын харилцаа, хүүхдийн асрамж, хүүхэдтэй уулзах хуваарь тогтооход шаардлагатай хүчин зүйл, хүүхдийн цаашдын хүмүүжил, төлөвшилд эцэг, эхээс анхаарвал зохих асуудал зэрэг

хүүхэд гэр бүлийн нөхцөл байдлыг тал бүрээс нь судалж тайлан гаргах. Хүүхэд гэр бүлийн мэргэжилтнийг томилж, шүүгч шийдвэр гаргахдаа уг тайланг харгалзан үзнэ.

5.Шүүгч шаардлагатай гэж үзвэл эсхүл хүүхэд гэр бүлийн мэргэжилтний тайланд үндэслэн гэрлэгчдийг эвлэрүүлэх боломжтой гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэн эвлэрүүлэн зуучлах багт шилжүүлэхээр шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлах тогтолцоог бий болголоо.

6.Өсвөр насны хүн холбогдсон гэмт хэрэг түүнд холбогдуулан авах таслан сэргийлэх арга хэмжээ, баривчлах ажиллагааг нийслэл дэх гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх, сум, сум дундын хуульд заасан бол дүүргийн анхан шатын журмаар нийслэл дэх гэр бүл хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх сум, сум дундын дүүргийн харьяалах давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх.

7.Шүүх гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй. Гэрлэгчид бие биеэсээ тусдаа амьдраад 5 жил болсон бөгөөд 0-14 хүртэлх насны хүүхэдгүй гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн эсхүл хөрөнгийн маргаантай боловч 18 буюу түүнээс доош насны хүүхэдгүй гэрлэгчид гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн бол гэрлэлтийг шууд цуцалж болох зэрэг зарчмын болон найруулгын нийт 73 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Нямдаваагийн Баярмаа Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах ШЕЗ-ийн гишүүн, Лхагвадоржийн Энхбилэг Баянхангай, Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, Нямдоржийн Ононтуул дүүргийн Эрүү иргэний хялбар хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, Отгонбаярын Мөнхбаатар УЕПГ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга, Гантөмөрийн Эрдэнэ УЕПГ-ын эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга ахлах прокурор, Доржсүрэнгийн Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Дондогийн Давааням УБЕГ-ын дарга, Оюунбаатарын Оюунзул ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын Хуулийн хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, Нямдагийн Наранцэцэг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Эрдэнэбаярын Баярбаясгалан ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Батсайханы Тэнүүн Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, Батсуурийн Нарангэрэл УБЕГ-ын Иргэний бүртгэлийн

газрын улсын ахлах байцаагч, Бямба-Юугийн Отгон УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын улсын ахлах байцаагч ахлах бүртгэгч, Алтангэрэлийн Батбаатар Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч, Чулуунгэрэлийн Анар хуульч судлаач.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй. Тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гэж тооцож тухайн этгээдэд Төрийн албаны тухай хуулийн болон бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Нэрс өгсөн байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Энэ Гэр бүлийн процессын хуулийг бол дэмжиж байгаа. Тэгээд Баасанжаргал гишүүн маань энэ Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр ажилласан. Тэгэхээр 2 хуулийн маань хоорондын холбоо тиймээ уялдаж ажиллах асуудал дээр ер нь анхаарах зүйлс нь юу байгаа вэ? Та өөрөө бас энэ Гэр бүлийн энэ шүүхээр хянан шийдвэрлэх хуулийн төсөл дээр ахалж ажилласан. Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга дээр ажлын хэсгээр ахалсан. Тэгэхээр энэ 2-ын уялдаа холбоон дээр хамгийн гол анхаарах зүйл нь юу гэж харж байна вэ гэж асуух гэсэн юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн дарга Баасанжаргал гишүүн хариулъя.

Х.Баасанжаргал: Монгол Улс анх удаагаа Хүүхэд гэр бүлийн шүүхтэй буюу дагнасан нэг шинэ шүүхийг байгуулж байна. Урьд нь бид нар Захиргааны хэргийн дагнасан шүүхийг байгуулж байсан туршлагатай. Гэхдээ энэ удаагийн шүүх бол хүүхэд мөн гэр бүлийн хэргийг гэж байгаа. Тэгээд энэ удаа бид нар хуулийн төслөөрөө гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг шинэчилж анхдагч хуулийн төслийг ингэж ХЗДХЯ-аас өргөн мэдүүлсэн дээр манай ажлын хэсэг ажилласан. Түүнээс гадна бид нарын бас нэг анхаарах ёстой юм Эрүүгийн хэрэг болоод зөрчлийн хэрэгт холбогдож шалгуулж байгаа хүүхдүүдийн асуудал, мөн хохирогч хүүхдийн эрхийн асуудлыг эрх зүйн байдлын асуудлыг мөн дээрдүүлэх, сайжруулах олон ийм дэвшилттэй зохицуулалт энэ хуульд орсон.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр орж байгаа бас хэд хэдэн гол чухал амин сүнс болсон зохицуулалтууд байгаа. Түүний нэг нь гэр бүл хэрвээ цуцлахаар бол хүүхдийн асрамж, хүүхдийн тэтгэмж, хүүхэдтэй уулзах хуваарь, хүүхдийн талаар шийдвэр гаргалтын асуудал байгаа. Бид нар энийг

бүгдээрэнг нь нийлүүлээд нэг л том ойлголт буюу зөвхөн хүүхдийн асрамж гэж олон жил ойлгож хэрэглэж ирсэн. Үүнийг бид нар бол маш нарийн байдлаар задалж байгаа. Гэхдээ бас дэлхийн бусад улс орнууд шиг бүр айхтар зарим зүйлүүдийг нарийвчилж задлаагүй. Яагаад гэвэл тодорхой хэмжээгээр үе шаттайгаар шилжих ёстой ийм процесс ажиллагаанууд байгаа учраас бид нар эхний ээлжид хүүхдийн асрамж, хүүхдийн шийдвэр гаргалт, дээрээс нь хамгийн гол нь хүүхэдтэй уулзах хуваарийг ингэж шүүгч шийдвэрээрээ тогтоодог болох ийм өөрчлөлтийг оруулж байгаа юм. Тэгээд хүүхдийн талаарх шийдвэр гаргалт гэдэг чинь юу юм бэ гэдгийг бас тодруулаад хэлчихье.

Хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, шашин шүтэх, эс шүтэх, хүүхэд гадаад улсад зорчихтой холбоотой өдөр тутмын болон томоохон шийдвэрийн гаргалтын асуудлууд байгаа. Тэгээд эдгээр шийдвэр гаргах асуудлыг үндсэндээ асрамжийг авч байгаа тал нь хариуцаж явна. Гэхдээ энэ талаарх мэдээллийг нөгөө тал эхнэр юм уу нөхөр нөгөө тал бол заавал мэдэх мэдээллийг өгөх үүрэгтэй гэх мэтээр ингэж материаллаг хуультайгаа маш их уялдаа холбоотой ийм зохицуулалт орж байгаа.

Мөн манай шүүхийн системд орж ирж байгаа нэг том механизм бол хүүхэд гэр бүлийн мэргэжилтэн гэдэг ийм мэргэшсэн хүнийг энэ шүүхийн систем анх удаагаа авч ажиллуулна. Өөрөөр хэлбэл шүүх аливаа шийдвэр гаргахдаа яг энэ мэргэжлийн хүний дүгнэлтийг нь тайланг үндэслээд шийдвэр харгалзаж үзээд шийдвэр гаргадаг болно оо гэсэн үг. Өнөөдөр бид нар олон хүүхдүүд гэмт хэрэг зөрчилд холбогдож байгааг харж байгаа. Гэхдээ энэ хүүхдэд яг ямар ял шийтгэл тохирох юм бэ гэдэг мэргэжлийн дүгнэлтийг урьд өмнө бид нар хэзээ ч гаргуулж байгаагүй. Тэгэхээр ийм шинэ шинэ системүүд бол энэ процесс хуульд уялдаж орж ирж байгаа. Мөн Гэр бүлийн хуулийнхаа шинэчилсэн найруулгатай салшгүй уялдаа холбоотой хамтдаа ингэж амилах маш чухал институцийн ийм шинжтэй хууль байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Соронзонболд гишүүн нэмэлт асуулт.

Л.Соронзонболд: Одоо энэ одоогийн тухай хуулиар ч тэр ер нь бол одоо энэ хүүхдийн тэтгэлгийн асуудал нэлээн төлөгддөггүй нэлээн асуудал болдог гэж ойлгоод байгаа. Тэгэхээр одоо энэ гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар болохоор шүүх болохоор бол энэ тэтгэлгийн асуудлуудыг тодорхой нөхцөл байдал үүсэх болгонд авч хэлэлцэхээр байгаа. Тэгэхээр 1 удаадаа болохоор бол одоо тэтгэлгийн хэмжээг ингээд баталчихдаг, батлаад шүүх шийдвэр гаргачихдаг. Дараагаар нь тодорхой хугацааны дараагаар тэрийгээ өөрчлөх ийм хэрэгцээ гарна аа. Энэн дээр яг шүүх дээр процессын хувьд бол нэлээн асуудал гарахаар юм шиг санагдаад байгаа юм л даа. Тэгээд энэ дээр та энэ талаар ямар шийдэл байгаа талаараа тайлбарлаач?

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн хариулъя.

Х.Баасанжаргал: Тэтгэлгийн хэмжээг хэрхэн, яаж ямар үзүүлэлтийг харгалзаж тогтоож ирсэн бэ гэдэг бид нарын өнгөрсөн хугацааны туршлага үндсэндээ бол ганцхан хүчин зүйл байгаа. Тухайн бүс нутаг дахь амьжиргааны түвшингээр л ерөөсөө хүүхдийн тэтгэлгийг тогтоож ирсэн байгаа. Тэгээд энэ удаа Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгаар энд бол концепцын томоохон өөрчлөлт орж байгаа буюу тэтгэлэг төлөгчийн орлого, дээрээс нь тэтгэлэг төлөгч

хэчнээн хүүхдийн тэтгэлгийг төлөх юм, бас ямар хүмүүсийг гэр бүлдээ асардаг юм гэдэг энэ асран хамгааллынх нь үүргийг нь 1 дүгээрт харгалзаж үзэж байгаа.

Нөгөө талаараа тэтгэлэг авагчийн өөрийнх нь хэрэгцээ шаардлага юу юм, онцлог, хэрэгцээ шаардлагууд байгаа юу, хөгжлийн бэрхшээлтэй юу, ямарваа нэгэн нэмэлт асаргаа эмнэлгийн үйлчилгээний зардал шаардлагатай юу гэх мэтээр маш олон нөхцөл байдлыг харгалзаж үзэж энэ тэтгэлгийн хэмжээг тогтоох, тэтгэлгийг хэрхэн тогтоох вэ гэдэг хэмжээг Засгийн газар мөн энэ дүрэм журмыг сайжруулаад, шинэчлээд батлах үүргийг бас энэ хуулиар хүлээж байгаа гэсэн үг. 2 дугаарт...

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт хариулт өгье Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Ингээд харахлаар тэтгэлгийн хэмжээ үндсэндээ өөрчлөгдөгч шинэчилж ингэж тэтгэлгийг бид нар шинээр тогтоох ийм хэрэгцээ шаардлага үүсэж байгаа. Үүнийг дагалдуулаад яг таны асуусан шиг дахиж энэ тэтгэлгийнхээ хэмжээг өөрчлүүлэх ийм одоо хэрэгцээ шаардлага шүүхийн шатад болоод нэгэнт шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тухайд ч гэсэндээ мөн гарах байх. Энэ нь бол бас тодорхой хэмжээнд шүүх байгуулагдсаны дараах тодорхой хугацаанд бол нэг хэсэг ачаалал нэмж магадгүй. Гэсэн хэдий ч гэсэндээ энэ хүүхэд гэр бүлийн шүүхийн хамгийн гол амин сүнс нь аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ ямагт төвд нь нэн тэргүүнд хүүхдийг бид нар бодож байгаад энэ шийдвэрийг гаргах ёстой. Тэрнээс биш гэр бүлийн 2-ыг зөвхөн тэр гэр бүлийн 2 хүний насанд хүрсэн 2 хүний байр сууриар бол энэ шийдвэрийг огт гаргахгүй гэсэн үг. Тийм учраас бид нар хүүхдийн нөхцөл байдлыг ямагт харгалзаж үзэж энэ тэтгэлгийн хэмжээг бол өөрчлөх ийм боломжтой байдлаар оруулж ирж байгаа.

Бас нэг зүйл нь шүүхийн шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхээс...

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн гүйцэд хариулъя.

Х.Баасанжаргал: Бас нэг зүйл нь ерөөсөө шүүхийн шийдвэр гарах хүртэл хугацаанд ингээд тухайн шийдвэр юу гэдэг юм 6 сар болох нэг жил болтол хэргийн шийдвэрлэж дуусах хүртэлх хугацаанд ингээд юу ч шийдэгддэггүй. Одоогийн нөхцөл байдал бол ийм байгаа. Энэ бүх зүйл бол өөрчлөгдөөд шүүх үндсэндээ шийдвэрээ гаргахаасаа өмнө явцын дунд ингэж шийдвэр гаргадаг, захирамжаараа шийддэг асуудлуудыг бага багаар шийдээд явдаг ийм механизм тогтолцоо орж ирж байгаа.

Тэгэхээр үндсэндээ шүүхийн шийдвэр гарахаас өмнө хүүхэдтэй холбоотой зардал, хүүхэдтэй холбоотой сургалтын төлбөр, хүүхэдтэй холбоотой тэтгэлгийн асуудлуудыг үндсэндээ шүүх үндсэн шүүх хурлаа хүлээхгүйгээр наана нь захирамжаар шийдвэрлээд ингээд явах бүрэн боломжтой. Ийм болж байгаагаараа бас энэ онцлог байгаа. Тэгэхээр тэтгэлгийн асуудал бол маш олон хувилбартай шийдвэрлэх боломж бий болж байгаа гэж харж байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна, Жанчивын Галбадрах гишүүн асуултаа асууя.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Сая Баасанжаргал гишүүн маань хэллээ. Шинэ шүүх бие даасан шүүх байгуулж байгаа гэж хэлж байна. Тэгээд гэр бүлийн хэргийг өмнө нь Иргэний хэрэг шүүхэд хянан

шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар бүлгээр л ингээд шийддэг байсан байна. Тэгэхдээ энэ хуульд бол гэр бүлийн холбогдолтой хэрэг, гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан ч гэдэг юм уу ийм байдлаар нэр томьёоны ийм тодорхойгүй ийм ойлгомжгүй зүйлүүд байсныг ингээд нэгтгээд хууль болгож байгаа нь их сайшаалтай байна аа.

Ингээд асуултууд байна. Гэр бүлийн хэрэгт тийм нэлээн их тодорхой заасан байна. Ямар хэргийг авч үзэх вэ? Гэрлэлт цуцлалт, хүүхдийн тэтгэлэг, хүүхдийн асрамжийг хэнд үлдээх, эд хөрөнгө дундын эд хөрөнгийг хуваах зэргээс гадна үрчлэлт, асран хамгаалах, харгалзан дэмжлэг тогтоох, хүчингүй болгох зэрэг хүүхдийн эцэг эхийг тогтоох зэрэг өргөн хүрээгээр гэхдээ яг тодорхой хүүхдэдээ ингээд чиглэсэн чиглэлээр авч үзэж байгаа нь бас их ойлгомжтой болж байна гэж ингэж бодож байна. Тэгээд ер нь ард иргэдэд ямар гол мессеж өгч байгаа вэ? Тэрийгээ бас нэг олон хүн сонсож байгаа энд хэлж өгөөч гэж байна. Ингээд миний хувьд ер нь 4.1 гэдэг заалт энэ хүүхдийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчим баримтална гэж ингэж заасан нь их том дэвшил болжээ.

Ингээд 4.3 дээр бол нэг ийм зүйл байна. Хүүхдийн суралцдаг сургууль нь тэгээд мэдээж олон газрыг хэлсэн байсан. Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр тэр эцэг эхчүүд байна уу хэн байна тэр нь зөвшөөрөлгүйгээр шүүх шийдвэрээ гаргахаас өмнө шүүхэд гомдол хүсэлт гаргах хэрэгтэй гэж ингэж зааж өгсөн байгаа юм. Тэгэхээр энэ их сайн заалт байна гэж харж байгаа. Тэгээд үүнийг хэрхэн ямар арга замаар хэрэгжүүлэхээр бодож байгаа вэ? Жишээлбэл сургууль багш нар нь ингээд оролцоод нэмэгдэж байгаа нь сайн. Гэхдээ тэд нар маань гэрч болох нь байна, нотлох баримт хэлэх нь байна. Тэгээд энийг хэлсэн энэ багш ажилтныг хэрхэн хамгаалах ямар зохицуулалт байгаа вэ гэсэн талаар бас тодруулж асууя.

Нөгөө талаас эцэг эх байх эрх хасах, үрчлэлтийг хүчингүй болгох гээд 13.1-д гэх зэрэг ийм том асуудлыг шийдэх гээд байгаа юман дээр дан ганц шүүгч дангаар шийдвэр гаргаад оролцоно гэсэн ийм зүйл дээр жишээлбэл нэг шүүгч биш шүүх бүрэлдэхүүнээр хэргийг шийдвэрлэх талаар заалт оруулах тийм санал одоо бас заалт тийм боломж байхгүй юу?

Мөн 19 дүгээр зүйлд тэр чигтээ гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах шинжээчийн талаар ингээд дурдсан байгаа юм. Нөхцөл байдлын үнэлгээг ямар зүй арга зүйгээр хийх вэ? Тэр үнэлгээ гэдэг дотор нөхцөл байдлын үнэлгээ гэхээр бас тийм яг шууд ойлгогдохгүй байна. Тэгээд нөхцөл байдлын шинжээч гээд ийм ийм зүйлийг хангасан насанд хүрсэн ийм сургууль мэргэжлээр төгссөн хүн байна гээд нэг шаардлага хангасан шүүхийн ажилтан хэлнэ гэсэн байгаа юм. Тэгээд энэ ийм бэлтгэгдсэн хүмүүс ер нь одоо хэд байдаг юм? Таны сая яриад байгаа энэ мэргэжлийн хүн гээд байгаа нь энэ шинжээчийг хэлээд байна уу? Тэгээд энэ шинжээч нар маань үнэхээр ингээд мэргэжлийн байж чадах уу? Одоо сургууль дээр нийгмийн ажилтан гэж хүн байдаг л даа. Би одоо сургуульд тэгээд тэр нийгмийн ажилтан хүүхдэд онош тавьж байгаа юм шиг мэргэжлийг нь хүртэл шийдээд, өөрийнх нь тэр хөнгөн аутизм ч гэдэг юм уу энэ шийд гаргахад эцэг эх энийг хүлээн зөвшөөрдөггүй л дээ. Тэгвэл шүүгч нь энэ шинжээчийн гаргасан үнэлгээ дүгнэлтийг үнэхээр л энэ чинь одоо янз бүрийн шинжээчид байх болов уу. Шүүх болгон дээр байх нь тиймээ. Тэгээд энийг хүлээж авах эсэх дээр ийм ойлгомжгүй байдал өөрөөр хэлбэл шүүгч, шинжээч 2-ын хооронд юм уу ийм байдал үүсвэл энэ нь энэ хууль дээр хэрхэн зохицуулагдаж байгаа вэ гэдэг асуудал. Тэгээд ер нь жилд гарч байгаа

нийт хэргийн 10 орчим хувийг гэр бүлийн хэрэг эзэлж байна гэдэг бол их том тоотой хэрэг байна л даа энэ...

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн хариулъя.

Х.Баасанжаргал: ХЗДХЯ-наас хуулийн төслийг өргөн барихдаа анх шинжээч гэдэг ийм нэр томъёотой өргөн барьсан. Тэгээд хуулийн ажлын хэсэг нэлээн ажиллаж байгаад энийг яг шинжээч гэдэг нэр томъёо нь өөрөө тохирохгүй юм байна аа. Шинжээч гэхлээр хөндлөнгийн бие даасан хараат бус байх тэгээд Шүүхийн шинжилгээний тухай хууль гээд эрх зүйн орчин нь маш өөр байдаг. Тийм учраас энэ хүн бол яг шинжээчийн статустай бол ажиллахгүй юм байна. Харин хүүхэд гэр бүлийн мэргэжилтэн гэдэг ийм статусаар ажиллах ёстой юм байна нэг.

Тэгээд энэ хүн өөрөө яг шүүхийн байгууллагын захиргааны ажилтан ийм байдлаар ажиллана. Цэвэр энэ хүний гаргах дүгнэлт санал маш мэргэжлийн ийм санал, дүгнэлт байна. Хуулиар бол бид нар бас 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, социологич гэсэн эдгээр ийм 3 ажил мэргэжлийн ийм хүмүүс шүүхэд яг ингээд бүтэн цагаар яг шүүхэд шүүгчид шаардлагатай мэдлэг мэдээлэл, тайлан гаргаж өгөх ийм мэргэжлийн хүн байна гэж харж байгаа. Түүнээс гадна яг энэ тайлан буюу хүүхэд гэр бүлийн мэргэжилтний өөрийнх нь бүрэн эрхийн асуудлыг бас хуулиар нэлээн нарийвчилсан. Энэ хүн дүгнэлт гаргахдаа ганцхан хүүхэдтэй уулзахгүй, хүүхдээс гадна багштай, хүүхдийн амьдарч байгаа орчин, бүүр ээнэгшин дассан байдал, шаардлагатай бол өвөө эмээтэй нь уулзах гэх мэтээр маш нарийн ийм судалгаа явуулахаар бүрэн эрх дээр нь заасан байгаа.

Тэгээд эдгээрийг бас арга зүйн хувьд маш харилцан адилгүй ийм арга зүйгээр явуулна. Зарим тохиолдолд магадгүй ажиглалт явуулах шаардлагатай бол эсвэл ярилцлага хийх ч гэдэг юм уу, сургууль, бусад шаардлагатай мэргэжлийн байгууллагуудаас нөхцөл байдлын дүгнэлт гаргуулж авах ч гэдэг юм уу гэх мэтээр ингээд маш олон төрлийн арга зүйгээр ийм мэргэжлийн дүгнэлтийг гаргана гэдэг ийм байдлаар томъёолж өгсөн. Гэхдээ энэ мэргэжилтний дүгнэлт бол дүгнэлтийг бол шүүгч харгалзаж үзэж шийдвэрээ гаргана. Гол нь энэ мэргэжилтний дүгнэлт өөрөө маш чухал нотлох баримт учраас эдгээр энэ баримттай зарим тохиолдолд бол эцэг эхийг танилцуулахгүй хураангуй байдлаар гаргах хэрэгцээ шаардлага бас гарч болзошгүй байдаг.

Тэгээд бусад улс орны туршлагыг харахаар ч гэсэндээ дэлгэрэнгүй, хураангуй зарим тохиолдолд шүүгч нар тухайн гэр бүлийн нөхцөл байдалтай бүхэлд нь биш яг ганцхан асуудлаар жишээ нь дүгнэлт гаргуулахаар бас тухайн мэргэжилтнээ жишээ нь томилж болно. Юу гэдэг юм хүүхдийн аавтайгаа ээнэгшин дассан байдал дээр дүгнэлт гаргаад өгөөч ээ ч гэдэг юм уу тиймээ гэх мэтээр ингээд маш олон ийм асуудлуудаар шүүгч өөрөө захирамжаа гаргаад, шийдвэрээ гаргаад тухайн ажилтандаа даалгаад ингээд энэ мэргэжилтэн бол шийдвэр тухайн мэргэжлийнхээ тайлан дүгнэлтийг гаргана гэж ингэж харж байгаа юм.

2 дугаарт таны тэр асуусан багш нар орж ирэх боломжтой болж байгаа гэдэг энэ бол энэ хуулийн бас нэг чухал ололттой тал. Ер нь бол иргэний хэрэг дээр бид нар эрх ашиг нь хөндөгдсөн талууд л энэ шүүх хуралдаанд оролцдог, шүүхэд хүсэлт гаргадаг. Харин хүүхдийн тухайд хүүхэд өөрөө өөрийнхөө эрх ашгийг хамгаалах эрх зүйн чадамжийн хувьд төдийлөн харилцан адилгүй байх учраас шаардлагатай

тохиолдолд багш нь хэрвээ энэ асуудлыг мэдэх юм бол тухайн шүүхэд хүсэлт гомдол хүртэл гаргах ийм бүрэн эрхтэй байхаар хуульд оруулж ирж байгаа юм. Бодит амьдралаас ч гэсэн энэ заалт өөрөө урган гарсан. Шүүгч нарын дунд хийсэн бас яриа, судалгаа, мөн гаднын бусад улс орны туршлагыг ингээд харахад хүүхэдтэй хамгийн ойр ажилладаг хүмүүсийн нэг бол яалт ч үгүй багш, сурган хүмүүжүүлэгчид байдаг. Хүүхдийн нөхцөл байдлын талаар хамгийн сайн мэддэг хүмүүсийн нэг байдаг.

Гэтэл маргаанд оролцож байгаа 2 талын хувьд бол хоёулаа шал 2 өөр юу гэдэг юм эсрэг тэсрэг ийм эсрэг байр суурьтай байгаа тохиолдолд хүүхдийн эрх ашгийн асуудлыг шийдвэрлэхэд бол бас яг энэ багш нар сурган хүмүүжүүлэгчдийн ийм байр суурь нөхцөл байдлын үнэн бодит мэдээлэл маш чухал үүрэгтэй байдаг, үнэ цэнтэй байдаг.

С.Бямбацогт: Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Тийм. Тэгэхээр энэ зүйлүүд их давуу байдлыг бий болгоод байгаа л даа. Тэгэхдээ энэ хүмүүсийг ийм мэргэжлийн байлгах, айдасгүй байх гэдэг байдлыг яаж хангах вэ? Одоо тэгээд юу гэдэг юм нийгмийн ажилтан социологич гээд хүмүүс чинь одоо их сургуульд үзэж байгаа хөтөлбөр нь бол энэ чиглэл рүү ороогүй байгаа шүү дээ. Тэгэхээр одоо их, дээд сургуульд үздэг хөтөлбөрт хүртэл тиймээ оруулах ажлыг энэ шүүхийн мэдлэгтэй болгох энэ тэр чинь бол их чухал шүү дээ. Тэгэхгүй бол ийм хүмүүс энэ их чухал санаа нь бол их зөв байгаад байгаа юм. Тэгээд сая багш нарыг ярилаа. Багш нарыг бас оруулах асуудал дээр ч гэж байна.

Тэгээд би түрүүн бас юу асуусан байж байгаа. Нийт энэ хэрэг тийм багш нарын талаар бол хэлчихсэн байж байгаа. Энэ дээр ер нь бол Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд ингээд тусгай нэг бүлэг болчихсон байгаа шүү дээ. 4 дүгээр бүлэг гээд тиймээ. Энэ чинь өөрөө эвлэрүүлэн зуучлалын хууль байгаад байгаа. Энэ хуулиас юугаараа ялгаатай юм? Яг одоо ингэснээр ямар дэвшил гарч ирэх вэ? Жишээлбэл дөнгөж 3 мянга гаруй хэргээс 12 хувь нь л амжилттай шийдэгдсэн байдаг. Эвлэрсэн байдаг.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Эвлэрүүлэн зуучлалын ажиллагааны хувьд одоогийн бид нарын явж ирсэн эвлэрүүлэн зуучлалаас энэ шүүхийн шатан дахь эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа гээд бас нэг ийм онцлог ийм бүлэг зохицуулалт орж ирж байгаа. Тухайн хэргийг хүлээж авч байгаа шүүгч өөрөө хэрвээ энэ гэр бүл бол эвлэрэх боломжтой гэж үзэх юм бол эвлэрүүлэн зуучлалын багц шилжүүлнэ гэж байгаа юм. Гэхдээ бид нар энэ дээр нэг зүйлийг аягүй сайн бас ойлголцох хэрэгтэй байгаа. Ер нь эвлэрүүлэн зуучлал гэж юу юм бэ? Тэр 2 эхнэр нөхөр 2-ын хувьд салахаа болихыг бид нар эвлэрлээ гэж ойлгох юм уу эсвэл маргаантай асуудал бүрээрээ харилцан тохиролцохыг эвлэрэл гэж ойлгох юм уу гэдэг дээрээ бид нар бас их зөв ойлголттой болох хэрэгтэй.

Асуудал бүрээрээ талууд харилцан тохиролцоод ингээд асуудлаа шийдэж чадах юм бол энэ бол амжилттай эвлэрэл гэж явах ёстой. Түүнээс гадна бид нарын бас нэг ойлголт байдаг. Энэ гэр бүлийн шүүх чинь цаашид хүүхэд гэр бүлийг эрүүл харилцааг аварч үлдэх ийм шүүх байх ёстой. Тэрнээс биш гэр...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Гэр бүлийн харилцааг эрүүл саруул хэдийгээр гэр бүл цуцлагдсан ч гэсэн хүүхэд аавтайгаа харилцаад ямарваа нэгэн айдасгүй, ямарваа нэгэн асуудалгүй харилцаа авч байх ёстой. Хүүхэд ээжтэйгээ бас ямар нэгэн асуудалгүй харилцдаг байх ёстой гэх мэтээр ингээд хүүхэд аав, хүүхэд эцэг эхийн хоорондын харилцааг маш ингэж зөөлөн аргаар энийг авч үлдэх нь бид нарын хувьд энэ шүүхийн хамгийн гол бас нэг том сорилт болно гэж харж байгаа. Нөгөө талаараа би таны тэр асуусан багш нарт ямарваа нэгэн айдас, ямарваа нэгэн асуудал үүсэх вий гэдэг дээр мөн энийг бас бид нар нэлээн ярилцаж байгаад шаардлагатай тохиолдолд шүүх энэ нотлох баримт болоод шүүхийн нэхэмжлэлийг гардуулж өгөхдөө хүртэл шаардлагатай бүх мэдээллийг нууцалж дарж байгаад гардуулж өгөх ийм боломжтой байхаар хуулийн төсөлдөө бичиж, шинээр нэмж оруулсан байгаа.

С.Бямбацогт: Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Ингээд өөд өөдөөсөө харж байгаад ярьж байна гэдэг шиг. Тэгэхээр гэр бүлийн хүрээнд ингээд хүчирхийлэл эхлээд ингээд явагдаад байгааг хамгийн сайн мэдэж эхэлж ажигладаг хүмүүс бол багш нар байдаг. Тэгээд сургууль дээрээ ярьж эхэлдэг байхгүй юу. Энэ хүүхдийн гэр бүл болохгүй байна аа, аав нь болохгүй байна аа, ээж нь болохгүй байна аа ч гэдэг юм уу, энэ хүүхэд маань ийм байна аа гээд байдаг. Тэгээд тэр мэдээлэл авдаг эх үүсвэрийгээ эхлээд өгөхгүй байна л даа. Хэрэг мэрэг дуудагдаад л ингээд л явсных нь дараа өгөх гээд байна шүү дээ. Тэгээд урьдчилж эхэлж л энэ сургуулиудтай холбоотой ажилладаг энэ талын судалгаа авдаг ийм юман дээрээ бас энэ хууль дээр оруулж ирвэл их зүгээр байна аа гэж бодож байна.

Тэгээд багш нар хүчийг ингээд хүүхдийн шавь нарынхаа төлөө явдаг гэдэг тал дээр нь ингээд оруулж ирэх энэ ажлыг ойлгуулж, боловсролын байгууллагын хүмүүст бас нэг хэлж ярьж, энэнээс урьдчилан сэргийлэх, зүгээр гарсан хойно нь араас нь яваад асуудал хүндэрчихсэн хойно нь биш. Тэгээд сургуулиар дамжуулаад бас гэр бүлийн боловсрол олгох ийм төвөг орохгүй байх талаар арга хэмжээ авах талаар дуусгах зүйтэй байна аа. Санал хэллээ.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Хариулт авч. Байнгын хорооноос хураалгахаар зарчмын зөрүүтэй саналуудын томъёолол хэлэлцсэн 72 санал байгаа. Дэмжсэн, дэмжээгүй 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Санал хураалтыг 17 цагаас нэгтгэж явуулна. Хойшлууллаа.

16.44 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Ес.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Үг нөгөө санал дээрээ зарчмын зөрүүтэй санал дээрээ хэлнэ. Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна аа.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг гишүүн танилцуулна аа. Таныг индэрт урьж байна аа.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 4 дүгээр сарын 3, 4-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

ХЗБХ-ны 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Х.Алдаржавхлан, М.Нарантуяа-Нара, Ц.Сандаг-Очир, О.Номинчимэг, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулсан талаарх дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

1.Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хууль зүйн туслалцаа авах эрх бүхий этгээдийн хүрээг тодорхой болгож, хамгаалалтад байгаа гэрч хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгох. Хувийн өмгөөлөгчөөр хууль зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааг Өмгөөлөгчдийн холбооны оролцоотой хэрэгжүүлж, өмгөөлөгч томилох гэрээ байгуулах харилцааг тодорхой болгох.

2.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны агуулга, зохион байгуулалтыг тодорхой болгож хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийг мэргэшсэн чиглэлд зөвшилцлийн үндсэн дээр томилох зохицуулалтыг боловсронгуй болгох.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл, хөдөлмөрийн харилцаа, үйлдвэрчний эвлэлийн эрх, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалттай холбоотой зөрчлийн бүрэлдэхүүн болон хариуцлагын зохицуулалтыг боловсронгуй болгож, хүний эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд ажилтны эрхийг хамгаалах, ажил олгогчийн хариуцлагыг тодорхой болгох.

4.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хуульчийн үргэлжилсэн сургалтын зорилго, агуулга заавал хамруулах

сэдвийг тодорхой болгож, хүний эрх, Үндсэн хууль, олон улсын гэрээ, хуульчийн ёс зүй, хууль тогтоомжийн шинэчлэлийн асуудлыг сургалтын үндсэн агуулгад тусгах.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрх бүхий албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллын талаарх зохицуулалтыг тодорхой болгож, зөрчил хийдлийг арилгах.

6.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зарчмыг тодорхой тусгах замаар хүний эрхэд суурилсан төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх.

7.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах зэрэг зарчмын болон найруулгын нийт 61 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Уянгахишиг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Шагдарын Үйлстөгөлдөр ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга. Энэ хааччихсан байна? Баатаржавын Эрхэмбаяр УЕП-ын туслах прокурор Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга, Ганзоригийн Эрдэнэбулган ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, Бүргэдийн Шинэбаатар Гэмт хэрэг зөрчил шалгах албаны хэлтсийн дарга, Баатарын Оюутболд Экологийн цагдаагийн албаны дарга, Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд Хууль зүй дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Батсайханы Буяннэмэх Экологийн цагдаагийн албаны Хүрээлэн буй орчны гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн чиглэлийн ахлах мөрдөгч. Ажлын хэсгийн ирээгүй гишүүд чуулганы хуралдаанд хүрэлцэн ирэхийг хүсэж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21.24-т нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ажлын хэсгийн гишүүд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбарлах албан тушаалтан өөрсдийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцна. Мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх танилцуулахыг хориглоно. Эдгээрийг зөрчих юм бол чуулганы хуралдаанд

хүндэтгэн үзэх шалтгаан хүрэлцэн ирээгүй бол Төрийн албаны тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцдог болохыг сануулъя аа.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураах ёстой. 61 санал байгаа. Санал хураалтыг 17 цагаас болгож хойшлууллаа.

16.50 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арав. *“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

С.Бямбацогт: Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулна аа.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна аа. Таныг индэрт урьж байна аа.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 4 дүгээр сарын 16, 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэгт бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Б.Бейсен, М.Ганхүлэг, Ж.Чинбүрэн, А.Ундраа нар ажиллалаа.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотгол хийх ажлын цар хүрээ хугацааны талаар асуулт асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг газар зүйн нэрийн кирилл үсгийн латин хөрвүүлгийг холбогдох стандарт шинэчлэгдэх бүрд даган өөрчлөх, газар зүйн нэрийг олон нийтэд таниулах цахим систем нэвтрүүлэн мэдээлэл солилцдог байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен ажлын хэсгийн хүрээнд Баян-Өлгий аймагт хамаарах зарим газар зүйн нэрийн талаар Монголын Тувачуудын нийгэмлэгээс гарсан саналыг хүлээн авч уулзсан талаар үг хэлсэн болно оо.

Ажлын хэсгээс тогтоолын төслийн 1, 2 дахь заалтын зарим дэвсгэр нэрд хамаарах газар зүйн нэрийг нийцүүлж холбогдох засварыг хийх. Тогтоолоор баталсан газар зүйн нэрийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх. Монгол Улсын Их Хурлаас баталсан газар зүйн нэрийг батлагдсан стандартад нийцүүлэн латин үсэгт галиглан хэрэглэх. Газар зүйн нэрийг судлах, сурталчлах, хамгаалах, мөрдүүлэх, цахим системээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах.

Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотголыг хийж, сумдын хилийн цэсийг албан ёсны газар зүйн нэрийн дагуу шинэчлэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, 2027 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зэрэг асуудлыг Монгол Улсын Засгийн газарт даалгах.

Төслийн нэр томъёог жигдлэх. Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөн, бүтэц найруулга, латин хөрвүүлэгт холбогдох хууль зүйн техникийн засварыг хийх зэрэг зарчмын зөрүүтэй 7 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Уянга гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Далхаагийн Мөнхцэцэг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Геодези зураг зүйн хэлтсийн дарга, Цэгмэдийн Цэрэндорж ШУА-ийн Нийгмийн шинжлэх ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч, ШУА-ийн шинжлэх ухааны доктор, академич, Нямхүүгийн Нарангэрэл Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны дарга доктор, Цэрэнгийн Наранцацрал ШУА-ийн Газар зүй, гео экологийн хүрээлэнгийн газар зүйн мэдээллийн систем, зураг зүйн салбарын дарга, Дурангийн Оюунчимэг Монгол Улсын гавьяат барилгачин зөвлөх инженер.

Ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын үйл ажиллагаанаас хүндэтгэлтэй хандах, гишүүдийн асуусан асуултад бүрэн үнэн зөв бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй, худлаа мэдээлэл өгөхийг хориглодгийг сануулж байна аа.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй 7 санал байгаа. Энэ санал хураалтыг эхний асуудлуудын дараа араас залгуулж хураана аа, хойшлууллаа санал хураалтыг.

16.55 цаг

Одоо 17 цаг болох гэж байна. 5 минут дутуу байна. Гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урья аа. Санал хураалтууд явуулна аа.

Дараагийн асуудал. Нэлээн олон гишүүд асуулт асууж, үг хэлэхээр байгаа. Тийм болохоор санал хураалтуудаа явуулчихаад араас нь явчих уу. Гишүүдийг танхимдаа цуглалал дараагийн асуудлаа танилцуулга хийж байя. Гишүүдийг танхимдаа урьж байгаа шүү. Санал хураалтууд явна.

Арван нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна аа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулна аа. Индэрт урьж байна аа.

Н.Учрал: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны баримт бичгүүдэд тэтгэврийн даатгалыг олон давхаргад тогтолцоонд шилжүүлэх, ахмад настан бүрийг орлогын баталгаагаар хангах, нийгмийн даатгалын тогтолцооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хамрагдах хүрээг нэмэгдүүлэх, ажил олгогч болон даатгуулагчийн эрх ашигт нийцсэн харилцан өгөөжтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг тус тус дэвшүүлсэн.

Нийгмийн даатгалын тогтолцоо нь улсын нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, хүн ам зүйн насны бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлттэй уялдан шинэчлэгдэх шаардлагатай байдаг аа. Монгол Улсын хувьд 1995 онд шимтгэлд суурилсан нийгмийн даатгалын тогтолцоог бий болгож, 1999 онд нэрийн дансны

тогтолцоог нэвтрүүлж, 2015 онд төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогыг Улсын Их Хурлаас тус тус баталсан.

Түүнчлэн 2017 онд нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тэтгэврийн даатгалын тогтолцооны параметрийг өөрчилж, 2023 онд нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаас баталсан. Ийнхүү нийгмийн даатгалын тогтолцоонд шинэчлэл хийх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж ирсэн боловч өнгөрсөн хугацаанд тэтгэврийн шинэчлэлийг тууштай үргэлжлүүлэхэд төсөв санхүүгийн болон улс төрийн сорилтууд бидэнд тулгарсаар ирсэн. Тэтгэвэр шударга биш байгаа тухай хүний хөдөлмөрийн үр шимийн үнэлэмж ирээдүйн баталгаа болохгүй байгаа талаар олон жил ярьсаар ирсэн боловч дорвитой өөрчлөлт шинэчлэлт хийж бид чадсангүй ээ.

Өнөөдрийн алга ташилтын төлөө сонгуулийн мөчлөг бүрд тооцоо судалгаагүй том шийдвэрүүд гаргаж, тэтгэврийн сангийн алдагдлыг улам нэмсээр ирсэн боловч тэтгэвэр авагч шимтгэл төлөгч ажил олгогчид сэтгэл ханамжгүй хэвээр байна аа. Өнөөдөр мөрдөгдөж байгаа тэтгэврийн даатгалын хуваарилалтын тогтолцоо орлогоороо зарлагаа бүрэн нөхөж чадахгүйд хүрч, улсын төсвөөс тэтгэврийн санд олгох санхүүжилт жилээс жилд өсөн нэмэгдэж байна аа. Дэлхий дахинд түүний дотор Монгол Улсад ч тохиолдож байгаа дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэй насжилтын үзэгдэл хүн амын төрөлтийн бууралт, тэтгэврийн сангийн зарлагыг хурдацтай өсгөх гол хүчин зүйл болж байна аа.

Тэтгэврийн тогтолцооны үндсэн параметрууд болох тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэврийн нас, тэтгэвэр бодох хувь хэмжээний үзүүлэлтүүдийг даатгалын активаар тооцоололт үндэслээгүйгээс сангийн зарлагад сөрөг нөлөө үзүүлж, даатгуулагчийг олон жил тогтвортой шимтгэл төлөхийг урамшуулахгүй байна аа. Илүү олон жил НДШ төлснөөс эрт тэтгэвэрт гарсан нь ашигтай гэж даатгуулагчид үзэж байна. Тэтгэвэр бол хүний хөдөлмөрийн шударга үнэлэмж байх ёстой. Тэтгэврийн тогтолцоо зөвхөн ахмадуудын асуудал биш шимтгэл төлөгч хэн бүрийн ирээдүйд залуучуудад итгэл төрүүлсэн баталгаа, ажил олгогчдоо урамшуулсан илүү олон талтай. Өчигдөр, өнөөдөр маргаашийг холбосон тооцоо судалгаатай тогтолцоо байх ёстой юмаа.

Өнөөгийн тэтгэврийн даатгалын санд бага хэсэг нь их хувь нэмэр оруулж харин бага хувь нэмэр оруулсан нь ихийг хүртэж болдог шударга бус тогтолцоо бий болоод байна аа. 10 хүний 6 нь сард 769 мянга түүнээс бага тэтгэвэр авч байна. Энэ нь ҮСХ-ноос мэдээлсэн 2025 оны улсын дундаж нэрлэсэн цалингийн 28 хувийг бүрдүүлж байна аа.

Цаашид ахмад настны орлогын баталгаа алдагдаж ядууралд өртөх эрсдэл өсөхөөр байна. Хэрэв тэтгэврийн даатгалын өнөөгийн тогтолцоонд тодорхой өөрчлөлт хийхгүй бол ирээдүйд ахмад настуудад зохистой хэмжээний тэтгэвэр олгоход хүндрэл үүсэж, тэтгэдэг биш тэтгүүлдэг тэтгэврийн сангийн өрийг хойч үе төлөх шаардлага үүсэх болно оо.

Иймд хүн ам зүйн цонх үе нээгдэж, харьцангуй залуу хүн амтай байгаа энэ цаг үедээ нийгмийн даатгалын хамрах хүрээ, бааз сууриа өргөтгөж, хөдөлмөрлөж байгаа хэн бүрийг шимтгэл төлөхийг урамшуулж, ахмад настан болсон хойноо өөрийн хөлсний дусал шингэсэн үр шим болсон шударга тэтгэвэр авах тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас нийгмийн даатгалын

багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулж та бүхэнд танилцуулж байна аа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон дагалдах хуулийн төслүүдэд олон давхаргад тэтгэврийн тогтолцооны суурь давхарга болох баталгаат тэтгэврийг шинээр бий болгох, тэтгэврийн тогтолцоонд параметрийн өөрчлөлт хийх, нэрийн данснаас бодит хагас хуримтлалын тогтолцоонд сонголттойгоор үе шаттайгаар шилжих, хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх зорилгоор тодорхой нөхцөл хязгаартайгаар шимтгэлийн чөлөөлөлт хөнгөлөлт үзүүлэх зохицуулалтуудыг тус тус тусгалаа.

Тухайлбал ажил олгогчийн НДШ төлөх цалин хөлсний дээд хязгаарыг тогтоож, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай бууруулах. Монгол Улсын эдийн засгийн бүтцэд албан бус салбарын эзлэх хувь өндөр буюу нийт ажиллагчдын 41 хувь нь албан бус хөдөлмөр эрхлэгч байгаатай холбогдуулж тэдний 68 хувь нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа дээр үндэслэн албан бус хөдөлмөр эрхлэгчийг албан бүртгэлтэй болгож, НДШ төлж эхэлбэл шимтгэлийн хөнгөлөлтийг үзүүлэх. Шинээр бизнес эхлүүлсэн бичил жижиг ААН-үүдийг зарим төрлийн НДШ-ээс тодорхой хугацаанд чөлөөлөх, оюутан суралцагчид болон тэднийг ажиллуулж байгаа ажил олгогчийг зарим НДШ-ээс чөлөөлөх, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах хэд хэдэн гэрээгээр давхар ажил эрхэлж байгаа даатгуулагчийн бүх гэрээнээс давхар шимтгэл авч байгааг өөрчилж, даатгуулагчийн сонголтоор 2 хүртэлх гэрээнд шимтгэл ноогдуулдаг болох.

Олон жил шимтгэл төлсөн ч бага цалинтай байгаа хүмүүс, бусдыг асарч байсны улмаас хөдөлмөрийн зах зээлд цөөн жил ажилласан иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, албан бус салбарынхан зэрэг тогтмол бус орлоготой байсан ахмад настны орлогын баталгааг сайжруулах зорилгоор баталгаат тэтгэврийг нэвтрүүлэх, хийсвэр нэрийн дансны аргыг өөрчилж хуваарилалтаас хагас хуримтлалд үе шаттай шилжих суурийг тавьж, даатгуулагчийн сонголтод үндэслэн тэтгэврийн бодит мөнгөн хуримтлал үүсгэн түүнд Засгийн газраас дэмжлэг үзүүлж эхлэх. Ажил олгогч даатгуулагчийн сайн дурын санаачилгаар тэтгэврийн нэмэлт хуримтлал үүсгэх хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцооны хяналт, зохицуулалтыг бий болгож, даатгуулагчийн ирээдүйн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах эрх зүйн орчныг тус тус бүрдүүлж байна аа.

Ийнхүү тэтгэврийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, НДШ-ийн уян хатан тогтолцооны эрх зүйн орчин бүрдүүлснээр хөдөлмөр эрхэлж байгаа хэн бүрийг нийгмийн даатгалд хамруулахыг урамшуулж эхэлнэ ээ. Олон жил тогтвортой шимтгэл төлсөн хүний хөдөлмөрийн үнэ цэнийг шударгаар үнэлнэ ээ. Ахмад настнаа болсных нь дараа төлсөн шимтгэлтэй нь уялдсан хэмжээний тэтгэвэр олгох, ажил олгогчийн хөдөлмөрийн зардлыг бууруулж, ажлын байраа хадгалах, ажилтныхаа цалин хөлсийг нэмэх боломжийг бүрдүүлэх юмаа. Илүү олон жил

шимтгэл төлөхийг үнэлдэг, урамшуулдаг, хүний хөдөлмөрийн үр шимийг хамгаалдаг шударга тогтолцооны шинэчлэлийн тухай дуусдаггүй яриаг дуусгацгаая аа.

Тэтгэвэр бол халамж биш даатгал юмаа. Тэтгэвэр бол даатгуулагчийн ирээдүйн орлогын баталгаа. Хөдөлмөрийн хөлснийхөө хуримтлуулсны үр дүнд үүссэн хуримтлал юмаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэн дэмжиж өгөхийг Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнээсээ хүсье ээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна аа. Индэрт урьж байна.

А.Ариунзаяа: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөрт амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх, тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлж, ахмад настан бүрийг орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангах, өндөр насны тэтгэврийн хэмжээ нь даатгуулагчийн авч байсан цалин хөлс, төлсөн шимтгэлийн хэмжээ, хугацаатай уялдаатай байх, ажил гүйцэтгэх хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасныг үндэслэн хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг баталснаар нийгмийн даатгалын сангийн орлого 2027 онд 170.6 тэрбум төгрөгөөр буурч, улсын төсвийн санхүүжилт 1 их наяд 314.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт улсын төсөвт 1 их наяд 485.2 тэрбум төгрөгийн зардал шинээр үүснэ ээ гэж хууль санаачлагчид үзсэн байна аа.

Хуулийн төслийг ди парламент цэг мн цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийн санал авч байгаа авсан байна. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал баталгаат тэтгэвэр даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэг хувийн мөнгөн хуримтлал, тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлох дараалсан 5 жилийг хэрхэн үе шаттайгаар нэмэгдүүлэн 10 жил болгож байгаа талаар, 15-22 насны оюутан суралцагчдын НДШ-ээс чөлөөлж байгаа зохицуулалт, хуулийн төслийн хүрээнд шүүх, прокурорын байгууллагын ажилтны тэтгэврийн асуудлыг

хөндсөн нь хараат бус байдалд нөлөөлж буй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун ажил хөдөлмөр эрхлээд өндөр насны тэтгэвэрт гарсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон судалгаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийн насыг наашлуулах тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа Тэтгэврийн мөнгөн хуримтлалд даатгуулагч сайн дураар хамрагдах эсэх, түүний санхүүгийн тооцоолол, улсын төсөвт үзүүлэх ачааллын талаар, багш нарын тэтгэврийн насыг хойшлуулж байгаа нь үндэслэлтэй эсэх. Оюутнуудыг нийгмийн даатгалын зарим шимтгэлээс чөлөөлж байгаа нь нийгмийн хамгааллыг нь бууруулж болзошгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг тэтгэврийн зөрүүг арилгах тэтгэвэр тогтоолгох дундаж цалин хөлсийг тодорхойлох хугацааг 10 жил болгон нэмэгдүүлж байгаа зохицуулалтын талаар болон нэрийн данс, малчдын тэтгэврийн даатгалын шимтгэл төлөлтийн зохицуулалт, оюутан, залуучуудын НДШ-ийн хөнгөлөлтийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно оо.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр хуулийн төслийн хүрээнд тэтгэврийн зөрүүг арилгах, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг олгож байгаа нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг тэтгэврийн нөөц санд байршуулж мөнгөжүүлэх асуудал хэрэгжээгүй байгааг анхаарч, тэтгэврийн мөнгөнд хуримтлалтай нэгтгэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг туслах технологийн тусламжтайгаар хөдөлмөр эрхлэхийг дэмжих, нийгмийн даатгалын уян хатан зохицуулалтыг бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа багш мэргэжил нь бусад мэргэжилтэй харьцуулахад ажлын ачаалал ихтэй, тэвчээр шаарддагийг анхаарч тэтгэврийн насыг ул суурьтай авч үзэх, баталгаат тэтгэврийн хэмжээг Засгийн газар биш Улсын Их Хурал тогтоодог байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар нийгмийн даатгалын тогтолцоо нь 35 жилийн турш нийгмийн хамгааллыг зохих түвшинд хангаж ирсэн талаар, 2023 оны нийгмийн даатгалын шинэчлэл нь нийгмийн даатгалын харилцаанд улс төрчдийн нөлөөллийг багасгаж, мэргэжлийн удирдлагатай болгож, одоогийн өөрчлөлтийн суурийг тавьсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг иргэд 50 настайдаа тэтгэвэрт гарах нь эрт байгаа талаар, ААН байгууллагууд 45 наснаас дээш ажилтнуудаа тэтгэвэрт гаргахад бэлтгэх, тэтгэвэрт гараад ажил хөдөлмөр эрхлэх талаар сургалт зохион байгуулах, тухайн зардлыг татвараас чөлөөлөх, малчдын НДШ-ийн хөнгөлөлт нь оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа 2023 оны нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд тэтгэврийг жил бүр инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг хуримтлуулж тэтгэврийн нөөц санг мөнгөжүүлэх, нас барсан даатгуулагчийн эхнэр нөхрийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтыг хийсэн бөгөөд төсөв санхүүгийн байдлаас шалтгаалан орхигдуулсан зарим заалтуудыг одоогийн хуулийн төслийн хүрээнд шийдэж байгаа талаар тус тус санал хэллээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 87.5 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар, Цэргийн алба хаагчийн тэтгэврийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 81.3 хувийн саналаар, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 87.5 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүнд баярлалаа. 17 цагаас санал хураалт гээд зарлачихсан. Танхимд гишүүд нэлээн цугласан байна.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа сууцгаана уу. Ирц бүртгэлийн санал хураалт санал хураалтад бэлтгэе гишүүд ээ. Бүгд санал хураалтдаа бэлдсэн үү? Алдаржавхлан сайд суучихъя. Их Хурлын дэд дарга Бат-Эрдэн, Шадар сайд Энхбаяр нар хуулийн төсөл хүлээж авч нэг нь өргөн мэдүүлж, нөгөөдөх нь хүлээж авч байгаа. Тэр 2 хүндэтгэн үзэх шалтгаантай байна.

Ирц бүртгэлийн санал хураалт.

91 гишүүнээс 70 гишүүн чуулганы хуралдаанд хүрэлцэн ирсэн байна. Ирц бүртгэлд яг одоо танхимд сууж байна. 21 гишүүн ирээгүй одоо энэ 21 гишүүн бол ажил дээрээ ирээгүй байна. Чуулганы хуралдаанд хүрэлцэн ирээгүй байна гэж ойлгож болно. Энэ татгалзсан нь гарч байгаа 21 гишүүдийн зөвлөх туслахууд гишүүд чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Одоо тодорхой мэдээлэл олон нийтэд ингээд бодит цагийн горимоор ил явдаг болсон байгаа. Хэн хэн ирсэн, хэн хэн ирээгүй байгааг эндээс харж болно оо. Татгалзсан ч гарч байгаа 21 гишүүнээс Шадар сайд Энхбаяр, Их хурлын дэд дарга Бат-Эрдэнэ нар хүндэтгэн үзэх шалтгаантай байгаа бусад хүмүүс 19 гишүүн чуулган танхимдаа хүрэлцэн ирэх ёстой. Гишүүд болон гишүүд нь татгалзсан гарч байгаа гишүүд болон гишүүдийн зөвлөх туслахууд чуулган танхимд хүрэлцэн ирцгээнэ үү зохион байгуулна уу.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “1.5 тэрбум” гэснийг “2.5 тэрбум” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “25-ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12 дахь хэсгийн “20- ны” гэснийг “сүүлийн өдрийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсгийн “07” гэснийг “08” гэж, 26.2 дахь хэсэг, 30.12 дахь хэсгийн “20-ны” гэснийг “05-ны” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.12, 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “02” гэснийг “03” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 26.8 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.13 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.12 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.8, 31.9 дэх хэсгийн “10-ны” гэснийг “05-ны” гэж тус тус өөрчилсүгэй.” санал гаргасан. Төсвийн байнгын хороо.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. Сандаг-Очир гишүүнийг дэмжсэнд тооцъё. 72 гишүүн дэмжлээ.

Одбаяр гишүүн Жаргалан гишүүд хүрэлцэн ирж байна чуулганы танхимдаа баярлалаа.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

17.20 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтын “албан татвар төлөгчийн” гэснийг “иргэний” гэж, “аялал жуулчлалын бүс” гэснийг “, улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд баригдсанаас бусад” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтдаа бэлтгэе. 74 гишүүн байгаа байх.

Санал хураалтад 75 гишүүн байсан байх шиг байна.

Дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 81 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалтын 21.2 дахь хэсгийг хасаж, 7 дугаар зүйл болгох.

“7 дугаар зүйл.Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Төсвийн байнгын хороо.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн санал хураалт байгаа нэг санал байгаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёолол санал хураалт. Уучлаарай хуруугаа уншуулаарай санал хураалтдаа бэлтгэе.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе хурууны хээгээ.

Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйл 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгасан санал.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах санал гаргасан Төсвийн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

19 гишүүн дэмжсэн 20.9 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

17.26 цаг

Долоо.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал /үргэлжилнэ/

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох эсэх асуудлыг нууц санал хураалтаар явуулна аа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Зарим гишүүд санал хураалтдаа бэлтгээгүй байна шүү. Нууц санал хураалт учраас гишүүд хариуцлагатай хандана уу.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчдийг чуулгын танхимд урьж байна. Тэр тал зүүн талд очоод суучих уу? Зүүн талд.

Санал хураалт явуулъя.

1.Дашживаагийн Ариунболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна аа.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 65.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Доржсүрэнгийн Мөнхзоригийг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна аа.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Жамсранжавын Болдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна.

Санал хураалт

Санал хураалтад 90 гишүүн оролцсоны 59 гишүүн буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Довдонгийн Даваанямыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалт явуулна аа.

Санал хураалтад 91 гишүүн орсны 57 гишүүн буюу 62 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо Байнгын хорооны саналаар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлөх нууц санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Санал хураалт

Бүрэн эрхийн хугацаа дууссантай нь холбогдуулан Мажигийн Амгаланбаатар, Гочоосүрэнгийн Байгальмаа нарыг болон гаргасан хүсэлтийнх нь дагуу Төмөрбаатарын Сүхболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлөх саналыг дэмжье гэсэн томьёоллоор нууц санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 62 гишүүн буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол.

2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Дашживаагийн Ариунболд, Жамсранжавын Болд, Довдонгийн Давааням, Доржсүрэнгийн Мөнхзориг нарыг тус тус томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Одонмажигийн Амгаланбаатар, Гочоосүрэнгийн Байгалмаа нарыг, мөн өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Төмөрбаатарын Сүхболдыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдсон нэр дэвшигчид Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт хүсье ээ.

Монголчууд чөлөөт ардчилсан сонгуулиар төр барих Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, орон нутгийн сонгуулийг олон удаа зохион байгуулсан. Энэ олон удаа зохион байгуулахад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд маш өндөр хариуцлагатай маш хариуцлагатай албан тушаалд томилогдож байгаа. Ирэх жил Ерөнхийлөгчийн сонгууль болно, 28 онд Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль болно оо. Тэгээд энэхүү сонгуулийг амжилттай, шударга, хараат бус, хариуцлагатай, зохион байгуулах хариуцлагатай үүрэг та бүхэнд ноогдож байгаа шүү. Тэгээд хариуцлагатай ажлаа нэр төртэй хийгээрэй.

Төр байгуулах ард түмэн төрийн эрхээ 4 жилдээ нэг удаа эдэлдэг эрхийг шударга эдлүүлэх тал дээр нь та бүхэн хуулийн дагуу анхаарах ёстой шүү гэдгийг сануулж хэлье. Амжилт хүсье ээ.

17.36 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Зургаа.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалт явуулна. Нэг санал байгаа.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураалгасан санал.

1.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, 4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” гэснийг “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд” гэж, 13.1.4 дэх заалтын “энэ хуулийн 6.8-д заасан” гэснийг “энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан” гэж тус тус өөрчилсүгэй.”

Санал гаргасан Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо.

Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 74 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

17.36 цаг

Найм.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Одоо Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн санал хураалтыг явуулна.

Нийтдээ 73 санал байна. Нэлээн олон гүйцээн боловсруулах чиглэл авах юм байна лээ гучаад санал дээр. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль” гэсний дараа “Иргэний хууль, Гэр бүлийн хүчирхийлэлд тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль гэж тус тус нэмэх”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал, Одонтуяа, Уянгахишиг, Алтангэрэл, Ариунзаяа, Ганбат, Мөнхбаатар, Зулпхар Пүрэвдаваа, Сайнзориг, Саранчулуун, Тулга, Эрдэнэбат. Цаашид ажлын хэсэг гэх. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцож, 75 гишүүн буюу 82 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ нийгмийн даатгалын хуулийн ажлын хэсэг төр байх уу та хэд энд суугаад яах вэ. Өөр асуудал хэлэлцэж байгаа болохоор. Бусад хуулийн холбогдох ажлын хэсэг байвал орж болно

2.Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэх” гэснийг “дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих” гэж, 4.1 дэх хэсгийн “насанд хүрээгүй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах” гэснийг “Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хүүхэд хамгааллын” гэж, 4.2 дахь хэсгийн “хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн” гэснийг “эрх ашиг нь хөндөгдсөн” гэж, 4.3 дахь хэсгийн “сум, хорооны Засаг дарга, гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Хүүхэд хамгааллын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан байгууллага” гэж өөрчилж, 4.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.4.Гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй байх зарчмыг баримтална.” Санал гаргасан Ажлын хэсэг.

Санал хураалт.

91 гишүүн буюу 79 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “хүүхдийн асрамжийн” гэснийг “хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоох” гэж өөрчилж, 5.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.11.гэрлэлтийн бүртгэлгүй хамтын амьдралаас үүсэх хөрөнгийн харилцаатай холбоотой маргаан.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91 гишүүн буюу 79 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.6.гэрлэлт сэргээх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 72 буюу, 79 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“6.2.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.2-т заасан хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд шилжсэн хүүхдийн хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах.

6.2.7.асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний хөрөнгийг эрхлэн хамгаалагчид хариуцуулах.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 67 гишүүн буюу, 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 7.1, 7.2, 7.3 дахь хэсэг болгох:

“7.1.Гэр бүлийн хэргийг Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх, сум, сум дундын шүүх, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

7.2.Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны шүүх, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн гэр бүлийн хэргийг Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

7.3.Энэ хуулийн 7.2-т зааснаас бусад тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн давж заалдах шатны шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 72 гишүүн буюу, 79 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “бага насны” гэснийг “0-14 нас хүрээгүй” гэж, мөн дугаарыг “9.1” болгон тус тус өөрчилж, төслийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйл, энэ хуулийн 9.1-д заасны дагуу нэхэмжлэгч шүүхийг сонгосон бол энэ хуулийн 7.1-д заасан нэхэмжлэгчийн сонгон авсан нутаг дэвсгэрийн харьяаллын шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 71 гишүүн буюу, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 11 дүгээр зүйл нэмэх:

“11 дүгээр зүйл.Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах

11.1.Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын хаягаар баталгаат шуудангаар, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн гардуулна.

11.2.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүх энэ хуулийн 11.1-д заасны дагуу дараах нэхэмжлэлийг хүргүүлсэн боловч хариуцагч тухайн хаягт оршин суудаггүй бол хариуцагчийн ажлын газрын хаягаар, хариуцагчийн албан ёсны хаягийг улсын бүртгэлийн байгууллагаас тодруулах ажиллагааг шүүх санаачилгаараа 30 хоногийн дотор хийж, тодруулж ирүүлсэн хаягаар тус тус гардуулна:

11.2.1.гэрлэлт цуцлуулах;

11.2.2.хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоолгох;

11.2.3.тэжээн тэтгэх, тэтгүүлэх;

11.2.4.хүүхдийн эцэг, эхийг тогтоолгох;

11.2.5.эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасуулах, эсхүл сэргээлгэх;

11.2.6.хүүхэд үрчлэлт;

11.2.7.асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах.

11.3.Шүүх энэ хуулийн 11.2-т заасны дагуу холбогдох нэхэмжлэлийг хариуцагчид хүргүүлсэн боловч тухайн хаягт оршин суудаггүй бол Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаарх мэдээллийн сүлжээ, сангаар дамжуулан хариуцагчийг эрэн сурвалжлах арга хэмжээ авхуулна.

11.4.Энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд шүүх нэхэмжлэлийг гардуулах болон хэргийн оролцогчид хэргийн материал танилцуулахдаа эрсдэлд орсон гэрлэгч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүний нэхэмжлэлд тусгасан хувийн мэдээллийг уншигдах боломжгүй байдлаар нууцална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 68 гишүүн буюу, 74 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Хэргийн оролцогч, хүүхэд хамгааллын байгууллага, ажилтны хамтран ажиллах үүрэг

11.1.Хэргийн оролцогч үйл баримтын талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөх бөгөөд үйл баримтыг тогтооход хамтран ажиллах үүрэгтэй.

11.2.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтан, хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ажиллах, энэ талаар гаргасан шүүгчийн захирамжийг биелүүлэх үүрэгтэй.

11.3.Шүүхээс гарах шийдвэр нь маргааны зүйлийн талаар бие даасан шаардлага гаргаагүй этгээдийн эрх, үүрэгт сөргөөр нөлөөлөхөөр байвал, эсхүл хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах шаардлагын үүднээс шүүхийн шийдвэр гарахаас өмнө уг этгээдийн өөрийнх нь, эсхүл зохигчийн хүсэлтээр, эсхүл шүүх санаачилгаараа бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.

11.4.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх явцад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрвэл шүүгч энэ талаар эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

11.5.Шаардлагатай тохиолдолд шүүх гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх мэдээлэл өгөх, холбон зуучлах ажиллагааг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 71 гишүүн буюу, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “хэргийн материалтай” гэснийг “хэргийн материал, нотлох баримттай” гэж өөрчилж, 12.3 дахь хэсгийн “энэ хуулийн 6.1-д заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх хэргээс бусад” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 67 гишүүн буюу, 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.2, 12.1.3 дахь заалт, 12.3 дахь хэсэг нэмэх:

“12.1.2.хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоолгох;

12.1.3.тэжээн тэтгэх, тэтгүүлэх;”

“12.3.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шууд дамжуулах болон олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэхийг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 71 гишүүн буюу, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “14.1-д” гэснийг “14.1, 14.2-т” гэж, 14.6 дахь хэсгийн “Нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд шүүгч нэхэмжлэлийг

буцаана.” гэснийг “Нэхэмжлэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй, энэ хуулийн 14.3-т заасны дагуу албадан ирүүлэх боломжгүй бол шүүгч нэхэмжлэлийг буцаах эрхтэй.” гэж, 14.9 дэх хэсгийн “Эрх ашиг нь хөндөгдсөн этгээд энэ хуулийн 14.3-т заасан захирамжийн торгууль ногдуулсан хэсэгт” гэснийг “Энэ хуулийн 14.3-т заасан үндэслэлээр торгуулсан зохигч, түүний төлөөлөгч” гэж өөрчилж, 14.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулан 14.1, 14.2 дахь хэсэг болгон 14.3 дахь хэсгийн “Энэ зөрчлийг давтан гаргасан бол шүүгч зөрчил бүрд арга хэмжээ авах эрхтэй.” гэснийг хасах:

“14.1.Өмгөөлөгч оролцож байгаа эсэхээс үл хамааран зохигч шүүх хуралдаанд өөрөө хүрэлцэн ирж оролцох үүрэгтэй. Зохигч хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд шүүх хуралдаанд өөрөө оролцох үүргээ цахим хэлбэрээр хэрэгжүүлж болно.

14.2.Шүүх хуралдаанд оролцох үүргээ шүүхийн байрнаас бусад газарт цахим хэлбэрээр хэрэгжүүлж байгаа тохиолдолд шүүгч шаардлагатай гэж үзсэн нөхцөлд зохигч Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71.1.14-т заасан шүүх хуралдаан хийх шаардлага хангасан байрнаас шүүх хуралдаанд оролцоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 71 гишүүн буюу, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Төслийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам” гэснийг “Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаа” гэж өөрчилж, 15.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.Энэ хуулийн 25.4-т зааснаас бусад гэрлэлт цуцлуулах маргаанд шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааг явуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 67 гишүүн буюу, 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “насанд хүрээгүй хүүхдийг хүмүүжүүлэх, түүнд асрамж тогтоох” гэснийг “хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоолгох” гэж өөрчилж, 16.2, 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.Хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтоох, тэжээн тэтгэх асуудлыг шүүх гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэж, шийдвэртээ энэ талаар тусгана.

16.4.Хүүхэд 7 буюу түүнээс дээш настай бол хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтооход түүний санал болон энэ хуульд заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайланг харгалзан үзнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 70 гишүүн буюу, 76 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.5 дахь хэсэг нэмж, 16.5 дахь хэсгийн дугаарыг “16.6” болгон өөрчлөх:

“16.5.Нэхэмжлэл нь хуульд заасан бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно. Нэхэмжлэгч тогтоосон хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол шүүгч уг нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 70 гишүүн буюу, 76 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18 дугаар зүйл.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ

18.1.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүгч шаардлагатай гэж үзвэл өөрийн санаачилгаар, эсхүл талуудын хүсэлтээр дараах арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно:

18.1.1.насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, нэмэлт зардлыг гаргуулах;

18.1.2.хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах;

18.1.3.хүүхдийг эцэг, эсхүл эхтэй хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, шүүхээс томилсон бусад этгээдийн хяналтад, эсхүл дангаар уулзуулах түр хуваарь гаргах;

18.1.4.энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд аюул учруулж болзошгүй гэрлэгчийг гэрээсээ өөр газарт байхыг даалгах;

18.1.5.энэ хуулийн 25.4.1-д заасан тохиолдолд гэрлэгчид уулзах, ойртох болон аливаа хэлбэрээр харилцаа тогтоохыг хориглох;

18.1.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.2-т заасан үүргээ биелүүлж, тохирсон арга хэмжээ авахыг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтанд даалгах;

18.1.7.гэрлэгч хэн нэгийгээ тэжээн тэтгүүлэх;

18.1.8.орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, барьцаалах, захиран зарцуулахыг хориглох;

18.1.9.шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх.

18.2.Шүүх холбогдох этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр энэ хуулийн 18.1.2, 18.1.3, 18.1.4, 18.1.5, 18.1.8, 18.1.9-д заасан урьдчилсан арга хэмжээг авч болох

боловч урьдчилсан арга хэмжээ авснаас хойш 14 хоногийн дотор эрх ашиг нь хөндөгдсөн хэргийн оролцогчийн тайлбарыг авна. Шаардлагатай тохиолдолд шүүх хуралдааныг зарлан хуралдуулж болно.

18.3.Шүүх энэ хуулийн 18.1-д заасан захирамж гаргасан бол уг захирамжийг холбогдох этгээдэд нэн даруй хүргүүлнэ.

18.4.Урьдчилсан арга хэмжээ тогтоосон шүүгчийн захирамжийг зөрчсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн санал, эсхүл талуудын хүсэлтээр шүүгч хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шийтгэвэр гарган зөрчил гаргасан зохигч, түүний төлөөлөгчийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хүртэл хэмжээний төгрөгөөр торгож, албадан ирүүлэх захирамж гаргаж болно.

18.5.Шаардлагатай тохиолдолд гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл гаргасан эцэг, эхийг шүүх өөрийн санаачилгаараа, эсхүл талуудын хүсэлтээр гэрлэлт цуцлуулах, түүний үр дагавар, хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь, хүүхдээ тэжээн тэтгэх зэрэг гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх сургалт, хөтөлбөрт хамруулж болно.

Тайлбар: Энэ зүйлийн 18.1.3 дахь заалтад заасан “бусад этгээд” гэж сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг ойлгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 67 гишүүн буюу, 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 19 дүгээр зүйлийн гарчгийн “Гэр бүлийн нөхцөл байдлыг шинжлэн судлах” гэснийг “Хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судлах” гэж өөрчилж, 19.1.1, 19.1.3 дахь заалт, 19.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19.1.3 дахь заалтын дугаарыг “19.1.2.” гэж, 24 дүгээр зүйлийн дугаарыг “19” болгон өөрчлөх:

“19.1.1.хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судалж, тайлан гаргахыг энэ хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэнд даалгах тухай захирамж гаргах;

19.1.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан аюулын зэргийн, 32 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын үнэлгээ болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.2.3-т заасан эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээг хийлгүүлэхээр даалгах тухай захирамж гаргах.”

“19.4.Энэ хуулийн 19.1.2-т заасан холбогдох дүгнэлтийг шүүгчид ирүүлсэн, эсхүл дүгнэлт гаргах боломжгүй нөхцөл байдал үүссэн, эсхүл захирамжаар тогтоосон хугацаа өнгөрсөн бол шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80.3-т заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх бөгөөд энэ захирамжид гомдол гаргахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 71 гишүүн буюу, 78 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 20 дугаар зүйлийн гарчгийн “Гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч” гэснийг “Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн” гэж өөрчилж, 20.1, 20.2, 20.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.1.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг судлах чиг үүрэг бүхий шүүхийн захиргааны ажилтан байна.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 88¹-д заасан шаардлагыг хангасан байна.

20.3.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь дараах бүрэн эрхтэй:

20.3.1.зохигч болон холбогдох бусад этгээдээс асуулт асуух;

20.3.2.эцэг, эх, хүүхэд болон холбогдох бусад этгээдтэй ганцаарчилсан болон хамтарсан ярилцлага хийх;

20.3.3.гэр бүлийн нөхцөл байдал, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, нийгмийн бүх орчинд ажиглалт явуулах;

20.3.4.холбогдох байгууллагаас лавлагаа, тодорхойлолт, баримт гаргуулах;

20.3.5.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн байгууллагад нэвтрэх, албан тушаалтнаас шаардлагатай асуудлаар мэдээлэл, тайлбар авах;

20.3.6.хүүхэд 7 буюу түүнээс дээш настай бол түүний саналыг авах.”
Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 69 гишүүн буюу, 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн 23 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайлан

23.1.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь энэ хуулийн 19.1.1-д заасны дагуу хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг 21 хүртэл хоногийн дотор судалж, тайланг шүүхэд хүргүүлнэ.

23.2.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг тал бүрээс нь судалж, тайлан гаргах бөгөөд тайланд дараах асуудлыг тусгаж болно:

23.2.1.маргааны шалтгаан, нөхцөл, талуудын хүсэл зориг, байр суурь;

23.2.2.гэрлэгчдийн эрүүл мэнд, сэтгэлзүй, зан үйл, нийгэмшилт, хөдөлмөр эрхлэлт;

23.2.3.хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь тогтооход шаардлагатай хүүхдийн нөхцөл байдалтай холбоотой хүчин зүйлийг Гэр бүлийн тухай хуулийн 14¹.4-т заасны дагуу тодорхойлох;

23.2.4.эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах боломжит хувилбар;

23.2.5.хүүхдийн онцлог байдал, хүүхдийн цаашдын хүмүүжил, төлөвшилд эцэг, эхээс анхаарвал зохих асуудал;

23.2.6.талууд эвлэрэх боломжтой эсэх талаарх санал.

23.3.Энэ хуулийн 23.1-д заасан тайлан гаргах аргачлалыг Улсын дээд шүүх батална.

23.4.Энэ хуулийн 23.1-д заасан тайлангаас тодруулах, нэмэлт дүгнэлт гаргуулах шаардлагатай гэж үзвэл шүүх энэ талаар асуулт, шаардлага тавьж мэргэжилтэнд дахин хугацаа тогтоон хүргүүлж болно. Шүүгч шийдвэр гаргахдаа тайланг харгалзан үзнэ.

23.5.Хүүхэдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд үл нийцэх бусад баримтыг түүний эцэг, эх тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулахыг хориглоно.

23.6.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн энэ хуулийн 23.2-т заасан бүх асуудлыг болон хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг бүхэлд нь хамарсан иж бүрэн, эсхүл маргааны зүйлээс шалтгаалан шүүгчийн тавьсан асуулт, шаардлагын хүрээнд хэсэгчлэн тайлан гаргаж болно.

23.7.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 23.1-д заасан тайланг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрээр хүргэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 67 гишүүн буюу, 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Төслийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 67 гишүүн буюу, 73 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.8, 25.9 дэх хэсэг нэмэх:

“25.8.Хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарийг зөрчсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчийн санал, эсхүл 14 насанд хүрсэн хүүхэд, эсхүл хүүхдийн эцэг, эсхүл эхийн хүсэлтээр шүүгч хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шийтгэвэр гарган зөрчил гаргасан эцэг, эсхүл эхийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хүртэл хэмжээний төгрөгөөр торгож, албадан ирүүлэх захирамж гаргаж болно.

25.9.Гэрлэлт цуцалсан тухай болон бусад шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш тухайн шүүх ажлын гурван өдрийн дотор уг шийдвэрийн хувийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 65 гишүүн буюу, 71 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Төслийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.3.Хүнийг нас барсан гэж зарласан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш шүүх ажлын гурван өдрийн дотор уг шийдвэрийн хувийг улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 60 гишүүн буюу, 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.2.Энэ хуулийн 29.1-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш шүүх тухайн хүний хөрөнгөд тогтоосон эрхлэн хамгаалалтыг өөрчилж, уг шийдвэрийн хувийг ажлын гурван өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 65 гишүүн буюу, 71 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.2.Сэтгэцийн хувьд эрүүл гэдгийг мэдсээр байж хүнийг эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцуулахаар энэ хуулийн 30.1-д заасан хүсэлт гаргасан нь тогтоогдвол шүүхийн бүх зардлыг буруутай этгээдээс гаргуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 66 гишүүн буюу, 72 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“34 дүгээр зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлт гаргах түүнийг хянан шийдвэрлэх

34.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтэд шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

34.2.Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

34.3.Шүүх хүсэлтийг хангавал асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүйд тооцох тухай шийдвэр гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 66 гишүүн буюу, 72 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Төслийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.5.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайлан гарсан тохиолдолд хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах үүднээс эцэг, эхээс нууцалбал зохих хэсгээс бусдыг энэ хуулийн 35.3-т заасан шүүгчийн захирамжид хавсаргана.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 60 гишүүн буюу, 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 35.6 дахь хэсэг нэмэх:

“35.6.Шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, хадмал бичвэр, дуун тайлбар бүхий хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 61 гишүүн буюу, 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.1.Эвлэрүүлэн зуучлах баг нь шүүгч, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, сэтгэл зүйчээс бүрдэнэ.Шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 62 гишүүн буюу, 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Сайд нар гарч байна. Бат-Амгалан сайд, Мэндсайхан сайд, Алдаржавхлан сайд нар гарч байна. Энхбаяр сайдаа. Засгийн газраас өргөн барьсан хууль. Засгийн газар өөрсдийн өргөн барьсан хуульдаа бас гишүүд дэмжээд суугаад саналаа өгч байхад сайд нар гараад явж байгаа нь зохимжгүй байна шүү. Байсен гишүүнийг дэмжсэнээр авъя. 69 гишүүн боллоо.

29.Төслийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“36.4.Эвлэрүүлэн зуучлах баг эвлэрүүлэх ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

36.4.1.эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах;

36.4.2.маргаанд ямар нэг хувийн ашиг сонирхолгүйгээр төвийг сахисан байр суурьтай байх;

36.4.3.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 10.1-д заасан Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлөөс баталсан эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрмийг чандлан сахих.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 63 гишүүн буюу, 69 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Төслийн 37 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Ажлын хэсэг. Баасанжаргал гишүүнд ажлын хэсгийн микрофон өгье.

Х.Баасанжаргал: Энэ 30 дугаар санал дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

С.Бямбацогт: 30 дугаар саналыг гүйцээн боловсруулах чиглэлийг Хууль зүйн байнгын хороо, ажлын хэсэгт өглөө.

18 цаг болсон байна. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаа дуустал чуулган хуралдана.

Тийм болохоор гишүүд сайд нарыг чуулганы хуралдаанд идэвхтэй оролцохыг хүсэж байна.

Эсрэг гарч байгаа гишүүдээс байхгүй байгаа гишүүд татгалзсан гараад байгаа гишүүд чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Гишүүдийн зөвлөх туслахууд гишүүддээ хэлээрэй.

31.Төслийн 38 дугаар зүйлийн гарчгийн “Эвлэрүүлэх хуралдааны” гэснийг “Эвлэрүүлэх уулзалтын” гэж, 38.2 дахь хэсгийн “хуралдаан даргалагчийг” гэснийг “уулзалт чиглүүлэгчийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 66 гишүүн буюу, 72 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

32.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “танилцуулахыг хориглоно” гэснийг “танилцуулах эсэхийг шүүгч, хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний саналыг үндэслэн шийдвэрлэнэ” гэж өөрчилж, 39.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 39.3, 39.4 дэх хэсэг болгох:

“39.3.Эвлэрүүлэх уулзалтаас дэлгэрэнгүй тэмдэглэл гарна. Дэлгэрэнгүй тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлнө.

39.4.Энэ хуулийн 39.2-т заасан сүүлчийн уулзалтаас дэлгэрэнгүй ба хураангуй тэмдэглэл гарна. Хураангуй тэмдэглэлд гагцхүү гэрлэгч аль нэг асуудлаар эвлэрсэн, эсхүл эвлэрээгүй талаар дурдсан байна. Хураангуй тэмдэглэлийг эвлэрүүлэх уулзалтын чиглүүлэгч үйлдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 62 гишүүн буюу, 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

33.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“40.1.Энэ хуулийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар.

Санал хураалт.

91-ээс 65 гишүүн буюу, 71хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ингээд үндсэндээ гэр бүлийн шүүх байгуулагдах нь байна. Олон жил дуншсан, олон жил яригдсан Гэр бүлийн маргаанаас болж хүүхэд хохирдог асуудлыг шийдвэрлэх шүүхтэй болох хууль 2026 оны 11 сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлнэ. Улсын Их Хурал төсвийг нь батлаад өгсөн байгаа.

Найруулгын санал

1.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Гэр бүлийн хэргийн” гэсний өмнө “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын “эцэг” гэсний дараа “, эх” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “бүрэлдэхүүнтэй” гэсний өмнө “шүүх” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “гэр бүлийн” гэсний өмнө “хүүхэд,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “зохигчийн хүсэлтээр” гэсний өмнө “өөрийн санаачилгаар, эсхүл” гэж, 25 дугаар зүйлийн 25.4.2 дахь хэсгийн “гэрлэлт” гэсний өмнө “гэрлэгчид” гэж, 30 дугаар зүйлийн гарчгийн “хязгаарлагдмал чадамжтай” гэсний өмнө “эрх зүйн” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “30 хоногоос” гэсний өмнө “шүүгчийн захирамж гарснаас хойш” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “багийн” гэсний өмнө “эвлэрүүлэн зуучлах” гэж, 39.5 дахь хэсгийн “хэргийг” гэсний өмнө “холбогдох” гэж тус тус нэмэх.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх” гэснийг “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт” гэж, 6.2 дахь хэсгийн “тогтоохдоо онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ” гэснийг “тогтооно” гэж, 6.2.6 дахь заалтын “гэрлэлтийг хүчин төгөлдөр бус” гэснийг “гэрлэлт болон” гэж, 6.4 дэх хэсгийн “гэм хор, нөхөн төлбөр гаргуулах” гэснийг “гэм хорыг арилгуулах” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “хүүхдэд асрамж” гэснийг “хүүхдийн асрамж, эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь” гэж, 10.3 дахь хэсгийн “үрчлэлттэй холбоотой” гэснийг “үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай” гэж, 10.5 дахь хэсгийн “Иргэнийг” гэснийг “Хүнийг” гэж, 10.6 дахь хэсгийн “уг иргэний” гэснийг “тухайн хүний”

гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “шүүхийн журмаар эцэг, эх” гэснийг “хүүхдийн эцэг, эхийг” гэж, 12.1.3 дахь заалтын “эцэг, эх байх эрхийг хасах, эсхүл сэргээх тухай нэхэмжлэлтэй холбоотой хэрэг” гэснийг “эсхүл сэргээх” гэж, 12.1.4 дэх заалтын “үрчлэлттэй холбоотой нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг” гэснийг “үрчлэлт” гэж, 12.1.5 дахь заалтын “дэмжихтэй холбоотой нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг” гэснийг “дэмжих” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “цуцлах” гэснийг “цуцлуулах” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “цахимаар оролцохгүй” гэснийг “оролцох үүргээ цахим хэлбэрээр хэрэгжүүлэхгүй” гэж, 14.6 дахь хэсгийн “хариуцагчийн” гэснийг “түүний” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “эцгийн нэр” гэснийг “эцэг/эх-ийн нэр” гэж, “гэрээ байгаа эсэхийг” гэснийг “гэрээ байгуулсан эсэхийг” гэж, 16.3 дахь хэсгийн “шаардлагатайгаас тэтгэвэр” гэснийг “шаардлагатай тохиолдолд тэтгэлэг” гэж, “эд хөрөнгийн талаар гарсан” гэснийг “хөрөнгөтэй холбоотой” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “гэрээний биелэлттэй” гэснийг “гэрээтэй” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “тодорхойлолтыг” гэснийг “тодорхойлолт, баримт” гэж, 19.2 дахь хэсгийн “19.1.1-д” гэснийг “19.1.2-т” гэж, 19.3 дахь хэсгийн “19.1.1-д” гэснийг “19.1.1, 19.1.2-т” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 20.1-д заасан гэр бүлийн нөхцөл байдлын шинжээч нь” гэснийг “Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн нь хүүхэд,” гэж, 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтын “шийдвэр гарсан” гэснийг “шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “иргэний хэрэг” гэснийг “гэр бүлийн хэрэг” гэж, 25.6 дахь хэсгийн “нэхэмжлэлийг үндэслэн” гэснийг “нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд” гэж, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “29.1-д” гэснийг “30.1-д” гэж, 34 дүгээр зүйлийн гарчгийн “Хүүхэд үрчлэлттэй холбоотой” гэснийг “Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах” гэж, 34.1 дэх хэсгийн “хэргийг” гэснийг “хүсэлтийг” гэж, 34.2 дахь хэсгийн “нэхэмжлэлийг” гэснийг “хүсэлтийг” гэж, 34.3 дахь хэсгийн “хүүхэд асран хүмүүжүүлэх” гэснийг “хүүхдийг асрамж, халамжийн” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “30 хоногоос илүүгүй хугацаанд” гэснийг “30 хоногийн дотор” гэж, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “дүнд” гэснийг “үр дүнд” гэж, мөн хэсгийн “эвлэрсэн” гэснийг “харилцан тохиролцсон” гэж, 39.5 дахь хэсгийн “хүсэлтээ дэмжиж байгаа бол” гэснийг “хүсэлттэй бол” гэж, 39.6 дахь хэсгийн “хүүхэдтэйгээ уулзах уулзалт” гэснийг “хүүхэдтэй уулзах хуваарь” гэж тус тус өөрчлөх.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “тэдгээрийн аль нэгний асрамжид байгаа” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалтын “эд” гэснийг, 8 дугаар зүйлийн гарчгийн “/оршин байгаа/” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2 дахь заалтын “нэхэмжлэлтэй хэрэг” гэснийг, 12.4 дэх хэсгийн “энэ хуулийн 12.3-т заасан хэргийн материалтай” гэснийг, 14.3 дахь хэсгийн “энэ хуулийн 14.1, 14.2-т заасан” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “холбогдох этгээдээс” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “журмын” гэснийг, мөн хэсгийн болон 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “гэр бүлийн хэрэгт” гэснийг, 25.4.1 дэх заалтын “байнгын” гэснийг, 39.6 дахь хэсгийн “тусдаа амьдрах” гэснийг тус тус хасаж, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 66 гишүүн буюу, 72.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай “1.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэсэн 1 дэх заалт нэмэх:

“2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүртээмжтэй байх бөгөөд эрх ашгаа хамгаалахад шаардагдах хүртээмжийн зардлыг тухайн шатны байгууллага хариуцна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 62 гишүүн буюу, 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.2 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн “1.2” гэснийг “1.1” гэж, “тойргийн шүүх” гэснийг “шүүх, сум, сум дундын, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар” гэж, 15, 18 дахь хэсгийн “Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн” гэснийг “Эрүүгийн хэргийн танхим” гэж, 15 дахь хэсгийн “прокурор, оролцогчийн” гэснийг “прокурорын” гэж, 16 дахь хэсгийн “тойргийн шүүхийн” гэснийг “шүүх, хуульд заасан бол дүүргийн анхан шатны шүүхийн” гэж, “бусад нутаг дэвсгэр дэх” гэснийг “сум, сум дундын” гэж, 17 дахь хэсгийн “өсвөр насны яллагдагч, шүүгдэгчид” гэснийг “өсвөр насны хүнд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 59 гишүүн буюу, 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Дээрх 2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан Төслийн “өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч” гэснийг “өсвөр насны хүн” гэж агуулгад нь тохируулан тухай бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 62 гишүүн буюу, 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу “14.15 дугаар зүйл” гэснийг “14.16 дугаар зүйл” гэж өөрчилж, мөн зүйлийн 2 дахь хэсэг болон 3 дахь хэсгийн “Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэж” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай “6.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэг” гэсэн 2 дахь заалт нэмэх:

“9.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, эрх бүхий албан тушаалтан гэмт хэрэгт холбогдсон өсвөр насны хүн, хэргийн хохирогч, гэрч хүүхдийн мэдээллийг харьяа хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд даруй мэдэгдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 64 гишүүн буюу, 70 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай “18.12 дугаар зүйл” гэсэн 7 дахь заалт нэмэх:

**“18.12 дугаар зүйл.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг
хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх журам**

1.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд энэ хуулийн Арвандолдугаар бүлэгт заасан тусгай журмаас гадна энэ зүйлд заасан журмыг баримтална.

2.Өсвөр насны хүн гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн бол хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг мөрдөгч, эсхүл прокурорт гаргаж болно.

3.Өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлтийг прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө гаргана.

4.Өсвөр насны хүн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлтийг гаргахад энэ хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг хамаарахгүй.

5.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөс гадна хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.

6.Прокурор, мөрдөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан өсвөр насны хүн, хууль ёсны төлөөлөгчид Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 8.8 дугаар зүйл, 8.4 дүгээр зүйлд заасныг үндэслэн ял хөнгөрүүлж оногдуулах, ялаас чөлөөлөх, 8.6 дугаар зүйлд заасныг үндэслэн хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, 8.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай энэ зүйл болон энэ хуулийн Арвандолдугаар бүлэгт заасан журмаар хэрэг хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг танилцуулна.

7.Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн бол мөрдөгч 14 хоногийн дотор мөрдөн байцаалт явуулна. Хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагааг 14 хоногийн дотор дуусгах боломжгүй бол прокурор энэ хуулийн 31.13 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгана.

8.Прокурор хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчид энэ хуулийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, энэ хуулийн Наймдугаар бүлэгт заасан эрх, үүргийг танилцуулна.

9.Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь мөрдөн шалгах ажиллагааны явцад гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 8.8 дугаар зүйл, 8.4 дүгээр зүйлд заасныг үндэслэн ял хөнгөрүүлж оногдуулах, ялаас чөлөөлөх, 8.6 дугаар зүйлд заасныг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол

биелүүлэхийг хойшлуулах, 8.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд саад болохгүй.

10.Прокурор хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн материалтай даруй танилцаж, дараах нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг хянана:

10.1.гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсэх;

10.2.энэ хуулийн 18.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан нөхцөл байдал;

10.3.гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар тогтоогдсон эсэх.

11.Өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлтээсээ татгалзсан, хэргийн зүйлчлэл, хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар санал зөрсөн, эсхүл энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан нөхцөл байдал тогтоогдоогүй бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр прокурор тогтоол гаргана.

12.Прокурор өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хохирол нөхөн төлсөн, эсхүл хохирол нөхөн төлөхөө илэрхийлсэн байдал, түүний хувийн байдал, хохирогчийн гаргасан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх талаарх санал, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний талаар гаргасан саналыг харгалзан түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчид танилцуулж, зөвшөөрвөл гарын үсэг зуруулж, яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд даруй шилжүүлнэ.

13.Өсвөр насны хүн, түүний хууль ёсны төлөөлөгч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хүлээн зөвшөөрч нөхөн төлөхөө илэрхийлсэн бол шүүх уг хохирлыг эрүүгийн хэрэгтэй хамт шийдвэрлэнэ. Сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөр болон бусад тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчийн гаргасан иргэний нэхэмжлэлийг хэлэлцэхгүй орхиж, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

14.Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл тогтоогдвол өсвөр насны хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, прокурорын саналын хүрээнд өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай шийдвэр гаргана.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90-ээс 61 гишүүн буюу, 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 25.3 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.Арван зургаан насанд хүрээгүй хүнээс тусгай өрөөнд ярилцлагын аргаар мэдүүлэг авна. Мэдүүлэг авах ажиллагааг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90-ээс 61 гишүүн буюу, 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 25.3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 9 дэх хэсэг нэмэх:

“9.Арван зургаан насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг хоёроос илүүгүй удаа явуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд шүүгч, прокурорын зөвшөөрлөөр тус бүр нэг удаа мэдүүлэг авч болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Үг хэлэх дэг байгаа билүү. Нэр чинь ирсэн үү. Тэгвэл дэг байхгүй юм байна.

Санал хураалт.

90-ээс 59 гишүүн буюу, 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалт буюу 35.10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “дуу-дүрсний төхөөрөмж” гэсний өмнө “шүүгчийн захирамжаар” гэж нэмж, “Бага насны” гэснийг “Арван зургаан насанд хүрээгүй” гэж өөрчилж, 8 дахь заалт буюу 33.3 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.4.өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр үйлдсэн хэргүүдийг нь нэгтгэх үндэслэл илэрсэн.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90-ээс 58 гишүүн буюу, 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар зүйлийн “14.11 дүгээр зүйлийн” гэсний өмнөх “12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “өсвөр насны” гэсний дараа “сэжигтэн,” гэж,” гэснийг, “25.2 дугаар зүйлийн” гэсний өмнөх “18.3 дугаар зүйлийн 1.5 дахь заалтын “төрвөл” гэсний дараа “энэ талаар болон тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараах сэтгэл санааны байдал, гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсныг тогтоох зорилгоор” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90-ээс 60 гишүүн буюу, 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дүгээр зүйлийн” гэсний өмнө “8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “мөрдөгч” гэсний дараа “шүүгч,” гэж,” гэж, “18.3 дугаар зүйлийн” гэсний өмнө “18.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ердийн журмаас гадна” гэсний дараа “Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журам болон” гэж,” гэж, “35.15 дугаар зүйлийн” гэсний өмнө “28.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “...тус бүрд гарын үсэг зурна.” гэсний

дараа “Арван зургаан насанд хүрээгүй хүн гарын үсэг зурахгүй байж болно.” гэж,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90-ээс 59 гишүүн буюу, 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 18.2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2 дугаар зүйл.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага

1.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа түүний эрх, дээд ашиг сонирхлыг хангана.

2.Өсвөр насны хүнтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгоход анхаарч ажиллана.

3.Өсвөр насны хүний хувийн мэдээлэл, түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэсэн прокурор, шүүхийн шийдвэрийн агуулгыг олон нийтэд мэдээлэхгүй.

4.Өсвөр насны хүний эрх, дээд ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг харгалзан ял шийтгэлийн талаарх лавлагаа, мэдээллийг хуульд тусгайлан заасан үндэслэл, журмаас гадуур задруулахгүй байх нөхцөлийг шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллага, хуулиар үүрэг хүлээсэн бусад этгээд хангаж ажиллана.

5.Өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг хангаж ажиллана.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90-ээс 59 гишүүн буюу, 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай “18.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэсэн 3 дахь заалт нэмэх:

“5.Шүүх өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх явцад Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтнийг томилж, өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараах сэтгэлзүйн болон бусад нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээний талаар дүгнэлт гаргуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Даваагийн Цогтбаатар гишүүний орж ирэх хугацаа болж байгаа байхаа. Хэлээрэй манай Хуралдаан зохион байгуулах, зөвлөхүүд.

90-ээс 57 гишүүн буюу, 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 25.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гэрчээс” гэснийг “хүнээс” гэж, “хүүхдийн асуудал эрхэлсэн” гэснийг “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан” гэж, 4 дэх заалт буюу 25.5 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “гэрч, хохирогчид” гэснийг “хүнд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай “37.5 дугаар зүйл” гэсэн 6 дахь заалт нэмэх:

“37.5 дугаар зүйл.Хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1.Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлд зааснаар өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлд зааснаар ял оногдуулахгүйгээр тэнсэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29.6-д заасан журмын дагуу хамтран хэрэгжүүлнэ.

2.Шүүх Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийн талаар улиралд нэг удаа хяналт тавьсан прокурорын газар, шийдвэр гаргасан шүүхэд тайлан хүргүүлнэ.

4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй ба цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй гэж прокурор үзвэл шүүхээс тогтоосон хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай дүгнэлтийг шүүхэд хүргүүлж болно.

5.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурор 14 хоногийн дотор эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай дүгнэлтийг шүүхэд хүргүүлнэ.

6.Шүүх прокурорын дүгнэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхийн хэлэлцүүлэг товлон явуулна. Шүүхийн хэлэлцүүлэгт өсвөр насны хүн, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, прокурор, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны төлөөлөл оролцоно.

7.Өсвөр насны хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн шийдвэр гаргана.

8.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, эсхүл ял оногдуулахгүйгээр тэнссэн хугацаанд өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол

прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

9.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

10.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан этгээд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

11.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг үйлдвэл шүүх Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 58 гишүүн буюу, 63.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Саяын ярьж байгаа юмнуудыг манай ажлын хэсэг дээр Энхбаяр сайд, Баасанжаргал гишүүд бас нэг ярьчихаарай. Бас нэг тодотгоод бидэнд бас эцсийн хэлэлцүүлэг дээр хоёр дахь хэлэлцүүлэг дээр бас 3-ны 2-оор өөрчилж болно шүү. Чиглэл өглөө шүү.

14.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “танхимын тэргүүн” гэснийг “танхим” гэж, 8.3 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу” гэснийг “өмгөөлөгчид” гэж, 15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч” гэснийг “шийдвэрийг гаргасан шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр” гэж, 18.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын “хэрэг үүсгэж яллагдагчаар татах” гэснийг “хэрэг үүсгэсэн талаарх” гэж, 2.3 дахь заалтын “яллагдагч” гэснийг “өсвөр насны хүн” гэж, 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ.” гэснийг “өмгөөлөгчид нь даруй мэдэгдэнэ.” гэж, 5 дахь хэсгийн “өсвөр насны сэжигтэн, цагдан хоригдсон өсвөр насны яллагдагчийг” гэснийг “болон хоригдсон өсвөр насны хүнийг” гэж, 18.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “өмгөөлөгч, эсхүл” гэснийг “өмгөөлөгчөөс гадна” гэж, 2 дахь хэсгийн “гэмт хэргийн яллагдагчид” гэснийг “өсвөр насны хүнд” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “яллагдагч, өсвөр насны шүүгдэгч” гэснийг, 9.5 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гэснийг, 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “яллагдагч, шүүгдэгч,” гэснийг, 14.11 дүгээр зүйлийн “яллагдагч” гэснийг, 18.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч” гэснийг, 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “сэжигтэн” гэснийг, 18.9 дүгээр зүйлийн гарчгийн “яллагдагч” гэснийг, 34.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “яллагдагч, өсвөр насны шүүгдэгч” гэснийг тус тус “хүн” гэж, 18 дугаар бүлгийн болон 18.1 дүгээр зүйлийн гарчгийн “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид” гэснийг, 18.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “яллагдагчид” гэснийг, 18.7 дугаар зүйлийн гарчгийн болон 1 дэх хэсгийн

“яллагдагчид” гэснийг, 18.9 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “яллагдагчид” гэснийг, 18.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “шүүгдэгчид” гэснийг тус тус “хүнд” гэж, 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн” гэснийг, 18.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн “сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн” гэснийг, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “яллагдагчийн” гэснийг, 18.3 дугаар зүйлийн гарчгийн болон мөн зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгийн “яллагдагч, шүүгдэгчийн” гэснийг, 18.4 дүгээр зүйлийн гарчгийн болон 2 дахь хэсгийн “яллагдагчийн” гэснийг, 18.5 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “сэжигтэн, яллагдагчийн” гэснийг, 18.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “яллагдагчийн” гэснийг, 18.10 дугаар зүйлийн гарчгийн болон 1, 2, 3, 4, 5 дахь хэсгийн “шүүгдэгчийн” гэснийг, 34.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн” гэснийг тус тус “хүний” гэж, 18.5 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын “сэжигтэн, яллагдагчийг” гэснийг, 18.6 дугаар зүйлийн гарчгийн болон 2, 4 дэх хэсгийн “сэжигтэн, яллагдагчийг” гэснийг, 18.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “яллагдагчийг” гэснийг, 18.11 дүгээр зүйлийн гарчгийн “шүүгдэгчийг” гэснийг, 31.12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “сэжигтнийг” гэснийг тус тус “хүнийг” гэж, 18.5 дугаар зүйлийн 2.3 дахь заалтын “сэжигтэн, яллагдагчаас” гэснийг, 31.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “сэжигтнээс” гэснийг, 35.9 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн “шүүгдэгчээс” гэснийг, 35.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гэрчээс” гэснийг тус тус “хүнээс” гэж, 14.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “1.3” гэснийг “1.3, 1.4-т” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 58 гишүүн буюу, 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 5 дугаар зүйлийн “18.3 дугаар зүйлийн” гэсний дараах “5,” гэснийг хасаж, “тус тус хүчингүй” гэсний өмнө “18.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “1.5, 1.6-д” гэсний өмнөх “1.4, ” гэснийг, 18.5 дугаар зүйлийн 2.3 дахь заалтын “мөрдөгч, прокурорын зөвшөөрснөөр” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

91-ээс 54 гишүүн буюу, 59 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Асуулт үг хэлэх дэг байхгүй. Манай Хууль зүйн байнгын хороо, зөвлөхүүд энэ Цогтбаатар дарга хаачсан юм. Улсын Их Хурлын Тамгын газар ажлын хэсэг дээрээ нэлээд анхаарч ажилласан байхаа. Мэдээж дэгийн хууль болон бусад хууль зөрчөөгүй байхаа. Дэгийн хууль зөрчүүлэхгүй байх, Улсын Их Хурлын тухай хууль зөрчүүлэхгүй байх үүргийг Тамгын газар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж байгаа. Тийм болохоор эцсийн хэлэлцүүлэг дээр энэ асуудлууд дээрээ хууль санаачлах үед Засгийн газрыг төлөөлж нэг хуулийн төслийг өргөн барьсан боловсруулсан Энхбаяр гишүүн, Энхбаяр сайд ажлын хэсгийн ахалж ажилласан манай Баасанжаргал ажлын хэсгийн гишүүн ахлагч, Хууль зүйн байнгын хороо эдгээр асуудал дээр ярилцаад тодорхой чиглэл гаргаарай. Тийм болохоор зарим заалтууд дээр гүйцээн боловсруулах, 3-ны 2-оор босгох ийм шаардлага гарч болзошгүй гэсэн чиглэл өгч байна шүү. Тийм болохоор танилцаарай.

Гурав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/6.12 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Өсвөр насны хүн зан байдлаараа нийтэд аюулгүй болсноо нотлон харуулж ял эдлэх хугацаандаа ноцтой зөрчил гаргаагүй, оногдуулсан ялыг дараах байдлаар эдэлсэн бол прокурорын дүгнэлтийг харгалзан шүүх хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохоор шийдвэрлэж болно:

1.1.таван жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны нэгээс доошгүй хувийг;

1.2.таван жилээс дээш арван хоёр жил хүртэл хугацаагаар оногдуулсан хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг;

1.3.арван хоёр жилээс дээш хугацаагаар оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг эдэлсэн бол.”

2/8.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж хянан хүмүүжүүлэх хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.”

3/8.8 дугаар зүйл: “8.8 дугаар зүйл.Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

1.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан дараах байдлаар эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж, эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно:

1.1.энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй, эсхүл хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх;

1.2.энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй, эсхүл хорих ялын дээд хэмжээг найман жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хорихоос өөр төрлийн ялыг сонгон оногдуулах, эсхүл энэ хуулийн 8.7 дугаар зүйлд

заасны дагуу хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах;

1.3.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг арван хоёр жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний хоёрны нэгээс хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах;

1.4.энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн хохирогчоос уучлалт гуйсан, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлөгдсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний гуравны хоёроос хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний гуравны хоёроос багагүй ял оногдуулах.

4/16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Энэ гэмт хэргийг хүүхдийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх Золжаргал тайлбар. Болж байгаа юм уу, болохгүй байгаа юм уу? Хэн эх барьсан юм? Эх баригч нь хэн юм? Тамгын газар. Гишүүдэд ойлголтын зөрүү үүсээд байна. Дэг байхгүй болоод байна. Тамгын газар тайлбар өгөх үүрэгтэй.

Ж.Бямбадулам: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлээр Байнгын хороо хуулийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах хүрээ хязгаарыг заасан байгаа. Энэ зүйлийн 40.1-д Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхдээ шинэ бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмэх, эсвэл өргөн мэдүүлсэн хуулийн төслөөс холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтыг хасах, бүтэц, найруулга, үг хэллэгийг өөрчлөх, засварлах тухай санал, дүгнэлт гаргана.

40.2-т энэ хуулийн 40.1-д заасан хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн талаар санал, дүгнэлт гаргахад энэ хуулийн 40.3-д заасан хүрээ хязгаар хамаарахгүй ээ гэсэн. Тэгэхээр 40.3-д ямар хүрээ хязгаар байсан бэ гэвэл 40.3.1 хууль санаачлагчийн өргөн мэдүүлээгүй хуульд өөрчлөлт оруулах, 40.3.2 хуулийн төсөлд хөндөгдөөгүй зүйл, хэсэг, заалт, дэд заалтад өөрчлөлт оруулах, 40.3.3 хуулийн төсөлд найруулгын саналаас бусад зүйл, хэсэг, заалт, дэд заалт нэмэх гээд. Эд нараас бусад нь энэ өөрөөр хэлбэл энэ анхдагч хуулийн төсөл шинэчилсэн найруулгын төсөл учраас энэ хязгаарлалт хамаарахгүй ээ гэсэн ийм зохицуулалттай байгаа.

С.Бямбацогт: Тэгэхээр энэ бүлэг зүйл заалт нэмэгдэж байгаа болж байгаа юм байна тийм үү? Болж байгаа болж байгаа юм байна. Тэгээд Тамгын газар санал хэлчихлээ.

Горимын санал. Мөнхсоёл гишүүн горимын санал гаргая.

Энэ бол бас чухал хууль шүү. Гэр бүлийн шүүх байгуулах тухай, Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль шүү олон жил дуншсан. Мөнхсоёл гишүүн горимын санал. Мөнхсоёл гишүүн горимын санал хүчингүй болгох горимын санал гэж ойлголоо.

Б.Мөнхсоёл: Түрүүний саналыг хүчингүй болгож өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна. Төхөөрөмж ажилласангүй ээ.

С.Бямбацогт: Мөнхсоёл гишүүний санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд ээ суугаарай суугаарай. Чойжилсүрэн гишүүн, Мэндсайхан сайд.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 46 гишүүн буюу 50.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүдээ энэ чухал хуулиа явуулчихъя. Ажлын хэсэг зөндөө ажилласан. Сая Тамгын газар хууль тайлбарлалаа. Анхдагч хууль шинэчилсэн найруулга дээр тийм үү зүйл заалт, бүлэг нэмэх бол нээлттэй гэж Тамгын газар тайлбарлалаа. Тийм болохоор эргэлзээд байх хэрэггүй. Энэ олон жил дуншсан хүлээсэн хуйлаа ажлын хэсэг зөндөө ажилласан байхад нь мэргэжлийн Байнгын хороо ажиллаад оруулаад ирсэн юмыг дэмжээд явуулчихъя. Гишүүд сууцгаа саналаа хураая.

Сая Мөнхсоёл гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн тул саяын санал хураалтаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “2 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “баривчлагдсан” гэсний өмнө “саатуулагдсан,” гэж, 8.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “ял дээр нэмж” гэсний дараа “энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураая.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Үүдээр байгаа гишүүд орж ирээрэй. Бүртгэлийн санал хураалт явуулна шүү нөхөд өө.

3.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, “3 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8.6 дугаар зүйл: “8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

1.Шүүх энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жил дээд хэмжээг арван хоёр жил хүртэл хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн, эсхүл түүнээс доош хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

2.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан бол энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоох хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авна.

3.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийг хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллага хамтран хэрэгжүүлэх талаар шүүхийн шийдвэрт тусгана.

4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацааны 50 хувь өнгөрсөн, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж, эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол цаашид хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагагүй талаарх прокурорын дүгнэлтийг үндэслэн хугацаанаас өмнө эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

5.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

6.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

7.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны хүн санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

8.Шүүх прокурорын дүгнэлтийг үндэслэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоолыг хойшлуулсан хугацаанд хүлээлгэсэн энэ хуулийн 8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтыг өөрчилж болно.”

2/8.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2,

3 дахь хэсэгт заасан үүрэг, хязгаарлалтаас гадна дараах үүрэг, хязгаарлалтыг хүлээлгэнэ:

2.1.өсвөр насны хүнд болон түүний гэр бүлд сэтгэл зүйчээс зөвөлгөө, эмчилгээ авахыг даалгах;

2.2.нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд хамруулах;

2.3.хичээлийн ирцээ тогтмол хүргүүлэхийг даалгах;

2.4.хохирогчоос уучлал хүсэхийг даалгах;

2.5.шөнийн цагаар гэртээ байхыг даалгах;

2.6.өсвөр насны хүнийг хүмүүжүүлэхэд шаардлагатай бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нара гишүүн дэмжлээ, 59 гишүүн дэмжлээ.

4.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Баривчлагдсан” гэснийг “Баривчлагдсан, саатуулагдсан” гэж, 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүх” гэснийг дараах “анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн,” гэснийг “хөнгөн гэмт хэрэг үйлдсэн” гэж, 8.7 дугаар зүйлийн гарчгийн “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” гэснийг “Ял оногдуулахгүйгээр тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авах” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “ял оногдуулахыг тэнсэж хүмүүжлийн нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно” гэснийг “ял оногдуулахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч болно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой 35.6” гэж, 16.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хоёр жилээс найман жил” гэснийг “таван жилээс арван хоёр жил” гэж, дугаарыг “3” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Пунсалмаа гишүүн ороод ирсэн байна. Мөнхбат гишүүн ороод ирсэн байна. Эрдэнэболд гишүүн хаачив. Уг нь эртэч гишүүндээ бас.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг “ӨӨРЧЛӨЛТ” гэж өөрчилж, 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хуулийн этгээдэд” гэсний дараа “нэг зуугаас” гэснийг “тавиас” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тав.зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.8 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн “Арван зургаагаас арван найм хүртэлх насны хүний” гэснийг “Хүүхэд” гэж, “тойргийн шүүх” гэснийг “шүүх, сум, сум дундын, хуульд заасан бол дүүргийн шүүх анхан шатны журмаар” гэж, 13 дахь хэсгийн “танхимын тэргүүн” гэснийг “танхим” гэж, 13 дахь хэсгийн “прокурор, оролцогчийн” гэснийг “прокурорын” гэж, 14 дэх хэсгийн “арван зургаагаас арван найм хүртэлх насны хүний” гэснийг “хүүхэд” гэж , мөн хэсгийн “тойргийн шүүхийн” гэснийг “шүүх, хуульд заасан бол дүүргийн шүүхийн” гэж, мөн хэсгийн “бусад нутаг дэвсгэр дэх” гэснийг “сум, сум дундын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн “15.7” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зургаа.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан саналын томьёолол.

1.Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэн 1 дүгээр зүйлийг “2 дугаар зүйл” болгон өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай **88¹ дүгээр зүйл нэмсүгэй:**

“88¹ дүгээр зүйл.Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн

88¹.1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэнд дараах шаардлага тавигдана:

88¹.1.1.25 насанд хүрсэн;

88¹.1.2.сэтгэл судлал, боловсрол, нийгмийн ажил, эсхүл социологийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй;

88¹.1.3.энэ хуулийн 88¹.1.2-т заасан мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан байх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/71 дүгээр зүйлийн 71.1.14 дэх заалт:

“71.1.14.шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах болон шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам, шүүхийн шаардлага хангасан байрны жагсаалтыг хуульд заасны дагуу батлах;”

2/88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг:

88.1.Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1-д заасан Хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн Тамгын газрын ажилтан нь шүүхийн захиргааны ажилтан байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 69 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Долоо.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйлийн “135.2.2,” гэсний дараа “135.2.3,” гэж нэмэх:

“1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 179.1.4 дэх заалт нэмсүгэй:

“179.1.4.шүүхийн санаачилгаар, эсхүл зайлшгүй оролцуулбал зохих этгээдийг гуравдагч этгээдээр оролцуулалгүйгээр гэр бүлийн хэргийг, эсхүл хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 64 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Найм.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “тусдаа амьдрах эцэг, эсхүл эх нь хүүхэдтэйгээ уулзах уулзалт” гэснийг “эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь” гэж өөрчилж, төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаанд” гэснийг гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаанд” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны” гэснийг Гэр бүлийн тухай хуулийн 14.4-т зааснаас бусад гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаанд” гэж, 32 дугаар зүйлийн гарчгийн “Гэр бүлийн холбогдолтой маргааныг” гэснийг “Гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргааныг” гэж, мөн зүйлийн 32.1 дэх хэсгийн “гэр бүлийн холбогдолтой маргаанд” гэснийг “гэрлэлт цуцлуулахтай холбоотой маргаанд” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 63 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Ес.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томьёолол.

1.Төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмж, 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гэр бүлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/14¹ дүгээр зүйл:

“14¹ дүгээр зүйл.Хүүхдийн асрамж, хүүхдийн талаар шийдвэр гаргах болон эцэг, эсхүл эх хүүхэдтэй уулзах хуваарь

14¹.1.Шүүх гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэлтэй хамт болон гэрлэлт цуцлуулснаас хойш 14 насанд хүрсэн хүүхэд, эсхүл хүүхдийн эцэг, эсхүл эхийн аль нэгний гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр дараах асуудлыг шийдвэрлэнэ:

14¹.1.1.хүүхдийн асрамж;

14¹.1.2.эцэг, эсхүл эхийн хүүхэдтэй уулзах хуваарь.

Тайлбар: Энэ хуулийн 14¹.1.1-д заасан “хүүхдийн асрамж” гэдэгт хүүхдийг хэний асрамжид үлдээх буюу амьдрах газрыг ойлгоно.

14¹.2.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд нийцсэн байдлаар талууд өөрөөр тохиролцоогүй бол шүүх энэ хуулийн 14¹.1.1-д заасан хүүхдийн асрамжийг авсан талд хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрхийг олгох бөгөөд тусдаа амьдрах эцэг, эсхүл эх хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй.

14¹.3.Шүүх энэ хуулийн 14¹.1-д заасан асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавина.

14¹.4.Шүүх хүүхдийн нөхцөл байдалтай дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ:

14¹.4.1.хүүхдийн бие махбод, оюун санаа, сэтгэлзүй, нас, хөгжлийн онцлогт нийцсэн хэрэгцээ;

14¹.4.2.хүүхдийн эцэг, эх, ах, эгч, дүү, эмээ, өвөө болон хүүхдийн амьдралд чухал нөлөө бүхий бусад хүнтэй тогтоосон харилцаа;

14¹.4.3.эцэг, эхийн хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэхэд оролцож байсан оролцооны байдал, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл бололцоо;

14¹.4.4.хүүхдийг асран хамгаалж, хүмүүжүүлэх төлөвлөгөө, хүүхэдтэй харилцах чадвар, эцэг, эхийн амьдралын хэв маяг, эрүүл мэнд, эрхэлсэн ажил, ажлын цаг;

14¹.4.5.ёс зүй, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдэд үзүүлэх нөлөө.

14¹.5.Энэ хуулийн 14¹.4.5-д заасан гэр бүлийн хүчирхийлэл болон түүний хүүхдэд үзүүлэх нөлөөг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан холбогдох үнэлгээний дүгнэлт болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүүхэд, гэр бүлийн мэргэжилтний тайлангаар тодорхойлно.

14¹.6.Хүүхдийг эцэг, эсхүл эхтэй хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, шүүхээс томилсон бусад этгээдийн хяналтад, эсхүл хяналтгүйгээр уулзуулах хуваарийг шүүх тогтооно.

14¹.7.Хүүхдийн эрх, дээд ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл хүүхдийн асрамж, хүүхэдтэй уулзах хуваарь тогтоосон шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр хүүхдийн эцэг, эсхүл эх энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.”

Тайлбар: Энэ хуулийн 14¹.2-т заасан “хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах эрх” гэдэгт хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хүүхэд гадаад улсад удаан хугацаагаар зорчих, шашин шүтэх, эс шүтэх, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх дугуйланд сургах зэрэг хүүхдийн хөгжил, хүүхдийн хуваарьт хөрөнгийг хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиран зарцуулах талаар шийдвэр гаргах эрхийг ойлгоно.

2/14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг:

“14.2.Хүүхдийн асрамж, хүүхэдтэй уулзах хуваарь тогтоосон шийдвэрийг өөрчлөн шийдвэрлэсэн бол шүүх холбогдох шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор гэрлэлтийг бүртгэсэн улсын бүртгэлийн байгууллагад болон аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.”

3/27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг:

“27.3.Эцэг, эх байх эрх хязгаарласан тухай шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүх ажлын гурван өдрийн дотор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

4/29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг:

“29.3.Эцэг, эх байх эрх хязгаарласныг хүчингүй болсонд тооцох тухай шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүх ажлын гурван өдрийн дотор аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

5/32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэг:

“32.4.Эцэг, эх байх эрхийг сэргээх тухай шийдвэрийн хувийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш шүүх ажлын гурван өдрийн дотор шүүх аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Одбаяр гишүүн ирнэ гэсэн хааччихав.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсгийн “гурван өдрийн дотор” гэсний дараа “аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад” гэж, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн “шүүх”

гэсний дараа “аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага болон” гэж тус тус нэмсүгэй.”

“3 дугаар зүйл. Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.4. Гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон, эсхүл гэрлэгчид сүүлийн таваас доошгүй жилийн хугацаанд хамтран амьдраагүй бөгөөд бага насны хүүхэдгүй, гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, эсхүл эд хөрөнгийн маргаантай боловч 18-аас доош насны хүүхэдгүй гэрлэгчид гэрлэлт цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн бол шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.

14.5. Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдийг хэн нэгний асрамжид үлдээх, хүүхэд эцэг, эхтэйгээ өнгөрүүлэх цаг, хүүхдийн талаар шийдвэр гаргах хуваарилалт, хүүхдийн тэтгэлэг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.

14.6. Гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол эдгээр асуудлыг шүүх шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гэр бүл цуцлахтай холбоотой чухал харилцаанууд явж байна шүү нөхөд өө.

Арав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1. Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт:

“6.2.7. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамж.”

2/201 дүгээр зүйлийн 201.5-201.10 дахь хэсэг:

“201.5. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэд өсвөр насны хүнд ерөнхий боловсрол олгох ерөнхий боловсролын сургууль, амьдрах ухааны дадал олгох мэргэжлийн сургалтын төв байна.

201.6.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ирсэн өсвөр насны хүнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

201.7.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дэргэдэх ерөнхий боловсролын сургууль өсвөр насны хүнийг Боловсролын ерөнхий хуульд заасан суралцагчийн нийгмийн баталгаа, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан суралцагчийн эрхээр хангагдах боломжийг бүрдүүлнэ.

201.8.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дотоод журмыг Улсын ерөнхий прокурор, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

201.9.Өсвөр насны хүн дараах эрх зүйн баталгаагаар хангагдана:

201.9.1.сургалт, нийгэмшүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэх зорилго бүхий өөрсдийн хүсэл санаачилгаар дугуйлан, секц, клуб байгуулах, уралдаан, тэмцээн зохион байгуулах, оролцох;

201.9.2.байгууллагын захиргаанд ерөнхий боловсролын сургалтад шаардлагатай ном, сурах бичиг, сургалтын орчныг шаардах;

201.9.3.элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, шалгалт өгөх;

201.9.4.энэ хуульд заасны дагуу чөлөө авах.

201.10.Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нийгмийн ажилтан шинээр ирсэн өсвөр насны хүнд байгууллагын дотоод журам, цагийн хуваарь, нийгэмшүүлэх хөтөлбөр, түүний үр дагавар, эрх, үүргийн талаар мэдээлэл өгнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2, 3, 4, 5 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:

“18.4.Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой, эсхүл төлбөр төлөгчид тодорхой хугацааны туршид давтамжтай төлбөр төлөх болон бусад үүрэг хүлээлгэсэн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхэд энэ хуулийн 18.1.4, 18.5-д заасан хугацаа хамаарахгүй бөгөөд үүрэг хүлээлгэсэн бүхий л хугацааны туршид албадан гүйцэтгэж болно.”

2/90 дүгээр зүйлийн 90.2 дахь хэсэг:

“90.2.Хүүхдийн тэтгэлгийг төлбөр төлөгчийн цалин хөлс, бусад орлого, мөнгөн болон бусад эд хөрөнгөөс гаргуулахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл болон татварт ногдох хэсгийг хассан үнийн дүнгээс тэргүүн ээлжид олгоно.”

3/201 дүгээр зүйлийн 201.3 дахь хэсэг:

“201.3.Өсвөр насны хүн арван найман насанд хүрсэн тохиолдолд ялыг нь сургалт-хүмүүжлийн байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсхүл ялыг нь нээлттэй хорих ангид шилжүүлэн эдлүүлэх эсэх асуудлаар өсвөр насны хүнийг арван найман насанд хүрэхээс 3 сарын өмнө сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах бөгөөд прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.”

3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 201 дүгээр зүйлийн 201.1, 201.6 дахь хэсгийн “хоригдлын” гэснийг “хүний” гэж, 220.1 дэх хэсгийн “хоригдлыг” гэснийг “хүнийг” гэж, 201.6 дахь хэсгийн дугаарыг “201.4” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 236 дугаар зүйлийн 236.1 дэх хэсгийн “хорих ялын 50-иас доошгүй хувийг эдэлсэн,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 201 дүгээр зүйлийн 201.4, 201.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүд анхааралтай байцгаая. Батчимэг гишүүнийг дэмжсэнээр авъя. Хүмүүнлэг хууль л яваад байна гэж харж байгаа шүү. Гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг хамгаалах талаар ийм энэрэнгүй хүмүүнлэг хуулийг хариуцлагатай баталчих нь зөв байхоо.

Арван нэг.Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж, мөн төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтын “Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх” гэсний өмнө “Нийслэл дэх” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 63 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дугаар зүйл болгон өөрчлөх:

“2 дугаар зүйл.Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Гурав дахь хэсгийн 1 дэх заалтын “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэж, 2 дугаар зүйлийн Дөрөв дэх хэсгийн 1 дэх заалтын “Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж” гэснийг “Нийслэлийн Багануур дүүргээс бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж” гэж, мөн заалтын “анхан шатны тойргийн шүүх” гэснийг “анхан шатны шүүх” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван хоёр. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүлгийг” гэснийг “бүлэг болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1.11 дэх заалтыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Арван хоёр.Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Ажлын хэсэгт микрофон өгье. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Энэ хууль батлагдсантай холбогдуулан авах Улсын Их Хурлын тогтоол дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя. Бүтнээр нь тогтоолын төсөл дээрээ.

С.Бямбацогт: Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн ажлын хэсгийн саналын томьёоллууд 5 санал байх шиг байна. Энэ дээр гүйцээн болосруулах чиглэл авч байна. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

19.12 цаг

Одоо хүний эрхийн хуультай холбоотой санал хураалтууд байгаа. Энэ санал хураалтуудаа үргэлжлүүлээд явуулчих уу?

Саяын санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 58 гишүүн дэмжиж, 63 хувийн саналаар дэмжигдсэн танилцуулаагүй байна. 10 минут завсарлаад орцгооч. 10 минут завсарлаад хүүхдийн эрхтэй холбоотой асуудлаар санал хураалтууд явуулна. Бас нэг хэдэн санал байгаа. Өнөөдөр хойшлуулах юм бол маргааш хойшлох юм бол ирэх долоо хоногт хойшилно гээд ингээд асуудлууд хойшлох гээд байгаа. Тийм болохоор Гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхтэй, хүний эрхтэй холбоотой асуудлуудаа хэлэлцээд шийдчихье. Араас нь Нийгмийн даатгалын хуулиудын хэлэлцүүлэг явагдана. Өнөөдөр хэлэлцэх асуудлуудаа хэлэлцэж дуусах ёстой бид.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Одоо Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна аа. 10 минут завсарлаад гишүүд орж ирнэ үү.

Бүлгийн дарга нар, Бүлгийн ажлын алба, Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ чуулганы танхим руу явуулна уу. Санал хураалтууд явагдана. Их Хурлын тухай баталчихвал санал хураалт явуулахад хонх дуугардаг болчихвол заавал ингэж зарлах шаардлагагүй болно.

Одоо ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. 17 цагийн санал хураалтад өнөөдрийн ирцэд орсон 91 гишүүнээс 70 гишүүн хүрэлцэн ирсэн. 76 хувийн ирцтэй байсан байна. Алтанхуяг, Дэлгэрсайхан, Лодойсамбуу, Энх-Амгалан, Амгаланбаатар, Ганбат, Мөнхбаатар, Сэддорж, Баатархүү, Гантөмөр, Жаргалсайхан, Эрдэнэбүрэн нарын гишүүд 17 цагийн санал хураалтад байхгүй байна.

Ирц бүртгэлийн санал хураалт. Номин гишүүн ээ.

Татгалзсан гарч байгаа гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Булгантуяа гишүүн байна. Сая дарж амжсангүй. Зулпхар гишүүн байна. Дарж амжсангүй, Бат-Эрдэнэ дарга дарж амжаагүй байна. Бусад татгалзсан гарч байгаа гишүүд ажилдаа ирнэ үү. Гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүддээ хэл. Бүлгийн ажлын алба, хуралдаан зохион байгуулах.

Гишүүд суудалдаа сууцгаая. Ирц бүртгэлийн санал хураалт явуулна.

Сүүлд орж ирсэн гишүүд хурууны хээг уншуулаарай. Одбаяр гишүүн, Баярбаатар гишүүн суудалдаа суучихъя. Мөнхбаясгалан гишүүн, Мөнхтуяа гишүүн. Хүний эрх, эрх чөлөөний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт байгаа. Ирц бүртгэлийн санал хураалт.

Санал хураалтуудаа явуулъя. Татгалзсан гарч байгаа гишүүд чуулган танхимдаа хүрэлцэн ирээрэй. Манай Хуралдаан зохион байгуулах, бүлгийн ажлын алба, гишүүдийн зөвлөх, туслахууд анхааралдаа авна уу.

Ес.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

61 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Хүний эрх эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 2 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг хасах:

“6.1.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтад байгаа гэрч, хохирогч.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал, Нарантуяа-Нара, Номинчимэг, Сайнзориг, Тэмүүжин, Уянга цаашид ажлын хэсэг гэх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ. Ажлын хэсэгт сая Уянгахишиг гишүүн байсан шүү. Уянга гишүүн гээд андуураад хэлчихлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн “туслалцааны” гэснийг “туслалцаа үзүүлэх” гэж, “мэдээ, мэдээлэл баримт” гэснийг “мэдээлэл, баримт бичиг” гэж тус тус өөрчлөх.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалтад 90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.7.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага энэ хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлсэн хувийн өмгөөлөгчийн гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг Өмгөөлөгчдийн Холбоонд хагас жил тутамд хүргүүлнэ. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалтад 90 гишүүн орсноос 50 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмж, “Тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол” гэснийг хасаж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.3.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь энэ зүйлийн 20.1-д заасан үндэслэлээр өмгөөлөгч томилуулах тухай хүсэлтийг Өмгөөлөгчдийн Холбоонд хүргүүлэх бөгөөд тус холбооноос өмгөөлөгчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр хувийн өмгөөлөгчийг ажиллуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Батчимэг гишүүн, Баярмаа гишүүддээ баярлалаа.

Санал хураалтад 90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 5 дугаар зүйлээс “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг,” гэснийг, “, 6.7” гэснийг, “10 дугаар зүйлийн 10.12 дахь хэсэг,” гэснийг, “14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалтад 90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 6 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “нийтэд тустай” гэсний өмнө “Өмгөөлөгчийн” гэж нэмж, 29.3 дахь хэсгийн “төрийн байгууллага,” гэснийг “төрийн байгууллагад өргөдөл, гомдол,” гэж өөрчилж, мөн зүйлийн зүйлийн гарчгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн
үйл ажиллагаа”

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.4.Өмгөөлөгч энэ хууль болон Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан журмын дагуу дараах хэлбэрээр хууль зүйн мэргэжлийн туслалцааг үзүүлнэ:

29.4.1.Хууль зүйн туслалцааны хуульд заасан хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн үйлчилгээний жишиг хөлсөөр;

29.4.2.сайн дурын үндсэн дээр үнэ төлбөргүйгээр.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.5.Өмгөөлөгчдийн Холбоо нь хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн энэ хуулийн 29.4-д заасан хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийг түүний мэргэшсэн эрх зүйн салбарыг харгалзан саналыг нь авч, зөвшилцсөний үндсэн дээр томилно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.6.Энэ хуулийн 29.5-д заасны дагуу томилогдсон өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн буюу 29 дүгээр зүйлийн 29.7, 29.8 дахь хэсгийг хасаж, 29.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.9.Өмгөөлөгчдийн Холбоо өмгөөлөгчдөөс нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх санал, санаачилгыг дэмжих, тэдгээрийг уялдуулан зохион байгуулах, уг үйл ажиллагаанд нийт өмгөөлөгчдийн оролцоог хангах үүрэгтэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 49 гишүүн буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 50 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, 0-3 насны хүүхэдтэй эх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, арван найм хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч байгаа хүн, баривчлах шийтгэлээс чөлөөлөх өвчний жагсаалтад байгаа өвчтэй хүнд оногдуулахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 50 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 5.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл, эсхүл эдийн засгийн хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 5.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “биед халдсан нь” гэснийг “эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдэж халдсан нь” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 55 гишүүн буюу 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалтын 10.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Хуульд заасны дагуу гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлөөгүй, эсхүл хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй гадаад ажилтныг зөвшөөрөлгүйгээр өөр байгууллагад шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлсэн, эсхүл хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл авснаас өөр зорилго, байршилд ажил үүрэг гүйцэтгүүлсэн бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “үүргээ биелүүлээгүй” гэсний дараа “бол зөрчлийг арилгуулж” гэж нэмэх, “тавин” гэснийг “гурван зуун” гэж, “таван зуун” гэснийг “гурван мянган” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “Зуучлагч нь” гэж, “нэг мянган” гэснийг “дөрвөн мянган” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 2 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 10.13 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Тусгай зөвшөөрөлгүй этгээд Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ үзүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “ажилтны төлөөллийн байгууллагын” гэснийг “ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын” гэж өөрчилж, 10.16 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.3.ажилтныг үйлдвэрчний эвлэлийн гишүүнээр элссэн, үйл ажиллагаанд оролцсонтой нь холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг нь дордуулсан;” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13. Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 1.5 дахь заалтын “хамтын хэлэлцээ хийх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 3.4 дэх заалтын “Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас” гэснийг “ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан /хоёр ба түүнээс дээш/ гаргасан, эсхүл хөдөлмөр эрхлэлтийн харилцааг шууд цуцлахаар хөдөлмөрийн гэрээнд тусгайлан заасан ноцтой зөрчил гаргасан, эсхүл ажил олгогчийн мөнгө болон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцах, эсхүл захиран зарцуулах эрх бүхий ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон, эсхүл ажилтан ажилд орох үедээ боловсрол, мэргэжил, мэргэшлийн түвшнийг нотлох баримт бичгээ хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсоноос” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын 10.16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.Ажил олгогч ажилтантай хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хөдөлмөрийн гэрээг байгуулаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээ байгуулаагүй бол ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээс хуульд заасан хугацаанд хөдөлмөрийн гэрээг нөхөн байгуулаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Ажил олгогч ажилтанд хууль тогтоомжийн дагуу олговол зохих цалин хөлс, олговрыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй, эсхүл хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээгээр тогтоосноос доогуур хэмжээгээр олгосон, эсхүл ажилтны цалин хөлснөөс хуульд зааснаас бусад үндэслэлээр суутгал хийсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 49 гишүүн буюу 54 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын “ажилд авахдаа болон” гэснийг хасаж, мөн зүйлийн 6.4 дэх заалтын “зөвшөөрөгдсөнөөс” гэснийг “зөвшөөрснөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 48 гишүүн буюу 53 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “хөдөлмөр эрхлүүлсэн” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” гэж нэмж, 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын 10.16 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн “өөрөө зөвшөөрөөгүй” гэсний дараа “бол” гэж, “Эмнэлэг хөдөлмөрийн” гэсний өмнө “эсхүл” гэж тус тус нэмж, “насанд хүрээгүй ажилтан,” гэснийг, 10.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 50 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “дуусгавар болгосон,” гэсний дараа “эсхүл ажлын байрны шаардлага хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан” гэж нэмж, “ажиллуулах үүргээ биелүүлээгүй” гэснийг “ажиллуулаагүй бол зохих орон тоо тутамд ногдох хуульд заасан төлбөрийг төлөөгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “бол хүнийг” гэсний өмнө “хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлд өөрчлөлт оруулахыг хориглосныг зөрчсөн” гэж нэмж, “цуцалсан” гэснийг “цуцлах зэргээр” гэж өөрчилж, 10.16 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.Ажил олгогч хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулсан, эсхүл өдрийн, долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаарыг зөрчиж ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.Ажил олгогч дараалсан хоёр ажлын өдөр хоорондын тасралтгүй амралтын хугацааг зөрчиж ажиллуулсан, эсхүл ажлын хоёр ээлжинд дараалуулан ажиллуулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.Ажил олгогч ажилтныг нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулах хязгаарлалтыг зөрчиж ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 50 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг хасаж, 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлийн 16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.Ажил олгогч ажилд орох гэж байгаа хүн болон ажилтнаас мөнгө, эд зүйл, эсхүл боловсролын баримт бичиг, мэргэжлийн үнэмлэх, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний эх хувийг шаардан авч барьцаалсан бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17 дахь хэсэг нэмэх:

“17.Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд ялгаварлан гадуурхалтаас ангид байх, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг дотоод журамд тусгаагүй, эсхүл ажлын байрны дарамт, хүчирхийллийн талаарх гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах, утас, цахим шуудангийн хаягийг нийт ажилтанд харагдахуйц газар байршуулаагүй бол зөрчлийг арилгуулж, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 10.16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18 дахь хэсэг нэмэх:

“18.Хамтын хэлэлцээ хийх явцад шашны байгууллага, улс төрийн нам, төрийн бус байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн хөндлөнгөөс оролцсон, нөлөөлсөн, аливаа хэлбэрээр саад учруулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “6.8 дахь заалтын” гэсний дараа ““6.5 дугаар зүйлийн 1, 2, 5, 9, 10, 11, 16 дахь хэсэг,” гэсний дараа “6.6 дугаар зүйлийн 13,17, 18 дахь хэсэг,” гэж, мөн заалтын” гэж, “мөн зүйлийн 6.17 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.16 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.6 дугаар зүйлийн 15, 21, 25 дахь хэсэг,” гэж,” гэж, “мөн зүйлийн 6.55 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.53 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “10.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж,” гэж, ““6.26 дугаар зүйл,” гэсний дараа “7.18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж,” гэсний дараа “мөн хэсгийн “14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12” гэсний дараа “дугаар зүйл, 15.29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэж,” гэж, “тус тус” гэсний өмнө “, мөн хэсгийн “8.6, 8.7 дугаар зүйл,” гэсний дараа “10.16 дугаар зүйлийн 18 дахь хэсэг” гэж, мөн хэсгийн “14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг,” гэсний дараа “15.4,” гэж, мөн хэсгийн “15.33 дугаар зүйл” гэсний өмнө “дугаар зүйл, 15.29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, мөн хэсгийн “18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь” гэсний дараа “хэсэг, 17.2 дугаар зүйлийн 3, 4 дэх” гэж” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн ““15.29 дүгээр зүйл,”” гэснийг ““15.29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг”” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлээс ““15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараа “15.4,” гэж, мөн заалтын” гэснийг, “мөн заалтын “15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараа “15.4,” гэж,” гэснийг, “мөн зүйлийн 6.57 дахь заалтын “6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12” гэсний дараа “, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30” гэж,” гэснийг, “7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “мэдээлэх” гэсний ард “, тээврийн хэрэгслийг саатуулах, тусгай талбайд хүргэх” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 4 дүгээр зүйлийн “6.7 дахь заалтын” гэсний дараа ““5.13 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6,” гэснийг “5.13,” гэж, мөн заалтын” гэж, “мөн зүйлийн 6.8 дахь заалтын” гэсний дараа ““5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь,” гэснийг “5.13 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэж, мөн заалтын” гэж, “мөн зүйлийн 6.14 дэх заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.11 дэх заалтын “6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.2 дахь заалт” гэснийг “6.6 дугаар зүйлийн 4, 14 дэх хэсэг,” гэж” гэж, “мөн зүйлийн 6.14 дэх заалтын” гэсний дараа ““6.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг” гэснийг “6.6 дугаар зүйлийн 15, 16 дахь хэсэг,” гэж,” гэж, “мөн зүйлийн 6.53 дахь заалтын” гэсний өмнө “мөн заалтын “10.16” гэснийг “10.16 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 6.2, 6.3, 6.4 дэх заалт, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17 дахь хэсэг” гэж, мөн заалтын 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт” гэж,” гэж, “6.53 дахь заалтын” гэсний дараа ““10.15,” гэснийг “10.15 дугаар зүйл, 10.16 дугаар зүйлийн 6.1 дэх заалт,” гэж, мөн зүйлийн 6.57 дахь заалтын “эм, био бэлдмэлийн хяналтын улсын байцаагч” гэснийг “эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын байцаагч” гэж, мөн заалтын “6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12” гэснийг “6.6” гэж” гэж, “2.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 7 дахь хэсгийн “5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг” гэснийг “5.4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг” гэж, мөн хэсгийн “6.26 дугаар зүйл” гэснийг “6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг” гэж,” гэж, “тус тус” гэсний өмнө “, 9.1 дүгээр зүйлийн “5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг” гэснийг “5.4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг,” гэж, “6.26 дугаар зүйл” гэснийг “6.26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг” гэж, “17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг,” гэснийг “17.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэг,” гэж” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн ““7.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 7.6 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйл, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.15, 7.17 дугаар зүйл,” гэснийг ““7.6 дугаар зүйлийн 1, 4, 5, 8 дахь хэсэг, 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 5, 7, 8 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дэх хэсгийн 4.2, 4.3 дахь заалт, 7.11 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 7.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэж, ““10.15 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэснийг ““10.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг,” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 4 дүгээр зүйлээс “мөн зүйлийн 6.48 дахь заалтын “7.8,” гэснийг “7.8 дугаар зүйл, 7.18 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 4.3 дахь заалт,” гэж,” гэснийг, ““10.15,” гэснийг “10.15 дугаар зүйлийн 1, 2, 4, 5 дахь хэсэг,” гэснийг, “2.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх; гэж, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх

хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд” гэж, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.” гэж, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлнэ” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд даруй бүртгэнэ.” гэж, 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлж,” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд даруй бүртгэж,” гэж” гэснийг, “6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “6.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт” гэж, 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “3.8 дугаар зүйлийн” гэснийг “3.10 дугаар зүйлийн” гэж, 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “7.6 дугаар зүйлийн” гэснийг “7.7 дугаар зүйлийн” гэж,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 5 дугаар зүйлийн “мөн зүйлийн 6.27 дахь заалтын” гэсний өмнө “мөн зүйлийн 6.13 дахь заалтын “16.3,” гэснийг,” гэж, “6.60 дахь заалтын “10.14, 10.29” гэснийг,” гэсний дараа “мөн зүйлийн 7 дахь хэсгийн “5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэснийг” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 6 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол%

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 55 дугаар зүйлийн гарчгийн “сургалт зохион байгуулах” гэснийг “сургалтын зорилго, агуулга, зохион байгуулах хугацаа” гэж өөрчилж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийг 55.4 дэх хэсэг болгох. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 55.1, 55.2 дахь хэсэг болгох:

“55.1.Хуульчийн сургалтын зорилго нь хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуульч нь мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бусаар ажиллах чадварыг төлөвшүүлэхэд чиглэнэ.

55.2.Хуульчийн сургалтын хөтөлбөр нь энэ хуулийн 55.1-д заасан зорилгод чиглэсэн, хуульчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тодорхой үе шат, дараалалтай, уялдаа холбоотой боловсруулсан агуулгатай байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйл буюу 55 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 55.3 дахь хэсэг нэмэх:

“55.3.Хуульчийн сургалтын хөтөлбөр нь хууль зүйн шинжлэх ухаан, бусад шинжлэх ухааны холбогдох сэдвийг агуулсан байх бөгөөд уг хөтөлбөрт дараах сэдвийг заавал тусгасан байна:

55.3.1.Монгол Улсын Үндсэн хууль;

55.3.2.Монгол Улсын олон гэрээ;

55.3.3.хүний эрх;

55.3.4.хуульчийн ёс зүй;

55.3.5.хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэл.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5 дугаар зүйлийн 5.1.18 заалтын “дээдэлсэн байх” гэснийг “дээдлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5 дугаар зүйлийн 5.2.18 заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.18.“хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, хүндэтгэхэд чиглэсэн байхыг.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 54 гишүүн буюу 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3 дугаар санал дээр Баасанжаргал ажлын хэсгийн ахлагч.

Х.Баасанжаргал: Энэ 3 дугаар заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя дарга.

С.Бямбацогт: Гүйцээн боловсруулах чиглэл 3 дугаар санал дээр өглөө.

4.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ес.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1. Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 46 гишүүн буюу 51 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арав.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

1.Төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар эшлэлийг нийцүүлж, өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүн орсноос 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зүйтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

20.44 цаг

Одоо газар зүйн нэршил дээр нэг долоохон санал хураалт байгаа юм.

Нөгөө Монгол нэрээр газар нутгаа нэрлэх тэрийгээ явуулчихъя.

Арав.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Газар зүйн нэрийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Их Хурлын тогтоолын төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

Тогтоолын төслийн

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Гатлага,” гэсний дараах “Говь”, “ гэснийг, “Толгой,” гэсний дараах “Тохой”, “ гэснийг, “Хад,” гэсний дараах “Харгайт,” гэснийг, “Цав,” гэсний дараах “Чулуу” гэсэн дэвсгэр нэрийг хасаж, эдгээрт хамаарах газар зүйн нэрийг “Салаа”, “Бөөрөг”, “Хаалга”, “Хөтөл”, “Уул”, “Товог”, “Бэлчир”, “Даваа”, “Тал” хэсэгт тус тус харгалзуулж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Н.Алтаншагай, Б.Бейсен, М.Ганхүлэг, А.Ундраа, Ж.Чинбүрэн /цаашид “Ажлын хэсэг” гэх/. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтдаа бэлтгэе. Уучлаарай. Энэ бол газарзүйн нэршлийг Монголоор нэрлэх ийм тогтоол байгаа. Нэршил нь өөрчлөгдчихсөн. Өөр нэрээр

нэрлэгдсэн асуудлууд байгаа. Сая саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

90 гишүүнээс 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дэх заалтын “Уул” хэсгийн “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Сагсай” гэснийг “Арал Толгой уул, Aral Tolgoi uul, Баян-Өлгий, Алтай” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүнээс 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дахь заалтын “Ам” гэсний дараа ““Ар”, гэж, “Шанд” гэсний дараа ““Ширээ”,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүнээс 52 гишүүн буюу 57 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/Энэ тогтоолоор баталсан газар зүйн нэрийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх;

2/Монгол Улсын Их Хурлаас баталсан газар зүйн нэрийг батлагдсан стандартад нийцүүлэн латин үсэгт галиглан хэрэглэх, газар зүйн нэрийг судлах, сурталчлах, хамгаалах, мөрдүүлэх, газар зүйн нэрийн цахим системээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

3/Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодотголыг хийж, сумдын хилийн цэсийг албан ёсны газар зүйн нэрийн дагуу шинэчлэн холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж 2027 оны Намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. . Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүнээс 51 гишүүн буюу 56 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Тогтоолын төсөлд доор дурдсан 4 дэх заалт нэмэх:

“4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Бейсен/-д даалгасугай.” . Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүнээс 50 гишүүн буюу 55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тогтоолын төслийн 1 дэх заалтыг 2 дахь заалт болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90 гишүүнээс 53 гишүүн буюу 58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх, бүтэц найруулга, латин хөрвүүлгэд холбогдох хууль зүйн техникийн засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

20.51 цаг

Хүний эрх, эрх чөлөөг хангах тухай хууль, тогтоолын зарим хуулиудыг буцаасантай холбоотойгоор 41.12-т Байнгын хороо энэ хуулийн 39.25-д заасан үндэслэлээр хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно. Тогтоолыг баталсанд тооцлоо.

Дараагийн асуудалдаа оръё.

Арван нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж байгаа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал танилцуулсан. Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Лхагвасүрэнгийн Мөнхзул мөн Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Адьяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Басангийн Батжаргал НДЕГ-ын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын дарга. Ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандаж Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв бодитой хариулт гүйцэд хариулт өгөхийг та бүхнээс хүсье. Худлаа мэдээлэл өгөх, Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандах, чуулганы

хуралдаанд хүрэлцэн ирээгүй бол хуулийн дагуу хариуцлага тооцдог болохыг сануулж анхааруулъя аа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлалын илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя. Алга байна. Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Би ер нь бол мэдээж дэмжиж байгаа. Тэгээд би яг энэ боломжийг ашиглаад Ерөнхий сайд яг ямар ямар зарчмын өөрчлөлтүүдийг оруулж байгаа вэ гэдгийг нэг хэлсэн нь зүйтэй болов уу гэж бодож байна. Ялангуяа яг одоо нийгэмд тулгамдаад байгаа гэдэг юм уу, нийгмийн хүлээлт үүссэн байгаа асуудал дээр яах вэ яг энэ хуулиар сая 400-аар хязгаарласан 2 сая 400-аар хязгаарласан гээд бас нэг ахмадууд маань яриад байдаг шүү дээ. Энэ нөгөө индексжүүлсэн энэ тэтгэвэр нэмэгдүүлж байгаа энэ асуудал энэ хуулиар бол шийдвэрлэгдэхгүй. Энэ чинь тусдаа Засгийн газрын тогтоолоор тусдаа явагдана. Тэгэхээр энэ асуудал хэзээнээс орж шийдвэрлэгдэх вэ гэдгийг та бас нэг амлалт өг ч гэдэг юм уу энэ талаар мэдээлэл өгч энэ хуулиар шийдэгдсэнгүй шүү дээ гэдэг ийм шүүмжээс гарахын тулд гэдэг юм уу энэ асуудлыг ямар ч байсан бид нар шийдвэрлэнэ. Гэхдээ энэ бол тэдэн сарын тэдэнд тэгж шийдвэрлэгдэнэ гэдэг ийм мэдээлэл өгчихвөл зөв байна гэж.

Мөн түүнчлэн цэргийн тэтгэврийн энэ асуудалтай цэргийн гэр бүлд нь гэдэг юм уу цэргийн тэтгэвэр өвлөгдөх энэ асуудал шийдвэрлэгдээгүй байдаг. Энийг биднийг бас ялгаварла гэдэг ийм асуудлыг цэргийн тэтгэвэр авч байгаа ахмадууд санал гаргадаг учраас энийг хэрхэн яаж шийдвэрлэж байгаа вэ гэдгийг бас онцлоод хэлсэн нь зүйтэй байх гэж үзэж байна.

Ер нь бас одоо тэтгэвэр тогтоодог 2 төрлийн л аргачлал хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Нэг нь бол цалин суурьтай, нэг нь бол хуримтлал суурьтай. Цалин суурьтай гэдэг нь өөрөө юу юм бэ гэхээр тухайн одоо хамгийн өндөр төлөлттэй дараалсан 5 жил одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Дараалсан 5 жилийн 1 сарын дундаж үндсэн нэг цалинг гаргаж ирж байгаад тэгээд түүнээсээ хамгийн багадаа 45 хувиар тэтгэвэр нь тогтоогддог. Цалин хөлснөөсөө бол ажилтанд тэтгэврийн шимтгэлийг 17 хувийг төлдөг. Ажил олгогч 8.5, ажилтан 8.5 ингээд нийлээд 17 хувийг төлөөд тэгээд 45 хувиар цалингаасаа бодогдож тэтгэврээ бодогддог байх нь байна аа. Нөгөө талын бодолт нь болохоор нэрийн дансны суурьтай буюу та хөдөлмөр эрхлэхдээ нийт хэчнээн төгрөгийн шимтгэлийг та болон ажил олгогч нийлээд төвлөрүүлсэн юм. Тэрнээсээ цаашид амьдрах магадлал болон нэг сард оногдох бодолтоороо 1 сарын тэтгэвэр тэтгэмж нь бодогддог ийм 2 хувилбартай байгаа.

Манай улсад 60 оноос өмнөх нь дандаа цалин суурьтай бодолттой, 60-79 оны хооронд сонголттой аль нэгээр нь байж болно. 79 оноос хойш төрсөн хүмүүс ямар ч сонголтгүй зөвхөн та хэдий хэмжээний шимтгэлийг нийтдээ төлж байсан юм буюу нэрийн дансны аргаар тэтгэврээ тогтоолгодог одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль байгаа 79 оноос хойш төрсөн хүмүүсийн хувьд бол энэ бодолт нь

тэтгэвэр нь маш багаар бодогдох ийм хувилбар. Тэгэхээр энийг өөрчилж бүгдийг нь юу гэдэг юм цалин суурьтай бодолттой байна гэдэг ийм өөрчлөлтийг оруулж ирж байгаад 1979 оноос хойш төрсөн нөгөө ахмад гэдэг шиг 1979 оноос хойш төрсөн хүний хувьд бол туйлын баяртай байгаа.

Яагаад гэхээр би 4, 5 дахин өндөр тэтгэвэр тогтоолгох боломжтой байхгүй юу. Яагаад гэхээр нэрийн данснаас бодогдохоор маш бага бодогдоно оо. Тэгэхээр энийг нэмэгдүүлээд, нөгөө талдаа 5 жилийн дундаж гэдгийг бол үе шаттайгаар 10 жил хүртэл нэмэгдүүлнэ ээ. Тэгэхээр энэ шударга зарчмыг яагаад оруулж байгаа юм. Яагаад энэ нэрийн дансны аргыг халаад цалин суурьтай бодолт нь илүү чухал юм бэ гэдгийг үзэж байгааг тайлбарлаж хэлж өгөхийг хүсэж байна аа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын алдагдал бол жил ирэх тусам өсөж байна аа. Тэгэхээр нийгмийн даатгалын сангийн хүрээг тэлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрлөсөн хөлснийхөө тодорхой хувийг шимтгэлд өгснөөрөө өндөр насны тэтгэвэр тогтоолгоход надад төдий хэмжээгээрээ өндөр тэтгэвэр бодогдох юм байна гэдэг сэдлийг төрүүлэхгүйгээр цаашаа энэ орлого зарлагын алдагдлыг бууруулж чадахгүй. Тэгээд жил ирэх тусам алдагдал нэмэгдэж байна аа.

Тийм ч учраас нөгөө илүү олон жил төлбөл илүү өндөр тэтгэвэр тогтоолгоно гэдэг үндсэн энэ зарчим дээр энэ удаагийн нийгмийн даатгалын хуулийг энэ тэтгэврийн реформыг өргөн барилаа. 2020 онд тухайн үед би Их Хурлын ажлын хэсгийг ахалж байсан. Тухайн үед хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг 10 дугаар сард нь өргөн мэдүүлсэн. Одоо та бид хамтдаа хэлэлцэж байна.

Тэгэхээр энэ тэтгэврийн реформыг хийснээр олон давхаргад болно. Хувийн нэмэлт тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг хуулийн хүрээнд бүрдүүлнэ. Тэнд шимтгэлээсээ төлөх юм бол тэр ААНОАТ, бусад татвараас хөнгөлнө.

Хоёрт бол ерөөсөө өнгөрсөн хугацаанд бид нэг зүйлийг орхиж ирсэн. Тэр нь юу вэ гэвэл нөгөө нэг ажилласан жилийг урамшуулах тогтолцоо. Тэгэхээр 57 настай эмэгтэй жартайдаа тэтгэвэрт гаръя гэвэл жил тутамд 4, 4 хувиар нэмэгдүүлээд явах энэ хөшүүргийг хийж өгч байгаа.

Тэгэхээр өндөр насанд хүрлээ 55, 60 нас хүрлээ гэвэл тэр хүнд эхлээд олон жил төлсөн шимтгэлээс нь харгалзаад 100-аас 300 мянган төгрөгийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ гэсэн үг. 100-аас 300 мянган төгрөг. Энд бол 504 мянган тэтгэвэр авагч хамаарагдаж байна. Тэгэхээр таны хэлж байгаа цэргийн албан хаагч нар хүртэл энэ баталгаат тэтгэврийг авна. Тэр all dad security гээд байгаа бол олон жил хөдөлмөрлөснийх нь юуг нь үндэслээд тухайн хүн 15 жил ажилласан уу, 10 жил ажилласан уу, 20 жил ажилласан уу, 25 жил ажилласан уу гэдээс шалтгаалаад 100-аас 300 мянга гэхээр өнөөдрийн тэтгэвэр авч байгаа нийт 504 мянган ахмадуудад бүгдэд нь баталгаат тэтгэврийг ажилласан жилээс шалтгаалж ялгаатайгаар тогтооно оо. Мөн 2013 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон ахмадууд бол 1 сая 400 мянгын цалингаас тэтгэврээ тооцуулсан байна. Гэтэл 2018 оноос хойш болохоор 2 сая 400 мянгаас тэтгэврээ бодуулсан байна.

Гэтэл 5 жилийн зөрүүтэй тэтгэвэрт гарсан хүний тэтгэвэр хооронд зөрүүтэй байгааг арилгаж өгөөч гэдэг асуудлыг ахмадууд байнга тавьдаг. Тийм учраас бид ахмадуудын тэтгэврийг 2 сая 400 мянган төгрөгийн цалингаас нь шинээр тооцогдож байна гэсэн үг. Тэгэхээр тэр 140 мянга нь тэр тэтгэврийн зөрүүтэй байгаа ахмадуудын тэтгэвэр арилна. Тэгэхээр энэ бол одоо бодитой өөрчлөлт болно.

Дээрээс нь хагас хуримтлалыг бол энд оруулж өгч байгаа. Хагас хуримтлалыг оруулаад Засгийн газар ч гэсэн үүн дээр хариуцлага хүлээе. Даатгуулагч бол өөрөө 1 хувийн хагас хуримтлалд би шимтгэлээсээ төлье гэдэг.

С.Бямбацогт: Ерөнхий сайдын хариултыг гүйцээлгэе, минут нэмье.

Н.Учрал: Тэгэхээр шимтгэлээсээ нэг хувийгаа даатгуулагч төлье өө гэвэл Засгийн газар 0.5 хувийг нь төлөхөд бид их олон жил ярьсан. Нөгөө хуримтлалд нь нөгөө ассет менежмент хийгээд, тэр бонд авах уу, үнэт цаас авах уу, хувьцаа авах уу гэдгийг нь өөрөө удирддаг ийм платформыг нэвтрүүлэе. Энэ бол таны тэтгэвэр, таны хөдөлмөр тэгэхээр та өөрөө хяна гэдэг зарчим. Ингэж тэтгэврийн шударга тогтолцоо руу шилжиж байж, 2024 оны Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн дагуу инфляцтай уялдуулж тэтгэвэр нэмэхийг шийдэхгүй бол өнөөдөр 10 хувь нэмлээ гээд 769 мянгын тэтгэврийн доод хэмжээгээр авч байгаа ахмадууд чинь бараг 57 хувийг эзэлчхээд байна шүү дээ.

Гэтэл эд нарын бараг 3-ны 1 нь 25 жил ажиллачихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ахмадуудыгаа бид нар энэ зөрөөг нь арилгаж байж баталгаат тэтгэвэр өгч байж ажилласан жилийг урамшуулж байж жил болгон инфляцтай нийлж уялдуулж нэмнэ гэдэг энэ зарчмаа барихаар хүн бүрд хүрсэн ийм тэтгэвэр.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Ер нь манай улсын хувьд эв санааны нэгдэл дээр суурилсан хуримтлалын системээс илүүтэй юу гэдэг юм нөгөө хуваарилалтын буюу яг энэ эв санааны нэгдэл дээр суурилсан хуваарилалтын систем нь хамаагүй илүү иргэндээ ээлтэй манайд илүү оновчтой систем юм гэдгийг онцолж энэ хуримтлалын системийг тодорхой хэмжээнд юу гэдэг юм шилжүүлж байгаа гэдэг юм уу, хагас хуримтлалын энэ системийг бол бүрэн нэвтрүүлэхээ хойшлуулж байгаа юм байна гэдгийг бид нар ойлгох ёстой.

Тэгэхээр энүүгээрээ бас энэ орж ирж байгаа реформын шинж чанартай маш сайн хуулийн төсөл орж ирж байгаа гэдгийг онцолмоор байна аа. Тэгээд миний нэг минутыг өгчихвөл би энэ баялгийн сантай холбоотой ганцхан зүйл хэлэх гэсэн юм. Их Хурлын дарга аа.

С.Бямбацогт: Асуултаа асуучихъя 1 минут.

А.Ариунзаяа: Манай улс Баялгийн сангийн хуулийг бас батлаад яг одоо хүн бүрийн нэрийн данс дээр хэдэн төгрөг байгаа вэ гэдгийгээ и монголоор дамжуулаад харах боломжтой. Тэгэхээр яг одоо Чингис хаан Үндэсний баялгийн сан дээр миний нэр дээр байгаа эцсийн үлдэгдэл бол 306 мянган төгрөг байгаа байхгүй юу. Энэ бол улсаас хуваарилагдаж өгсөн энэ өгөөж. 306 мянган төгрөг байгаа байгалийн баялгаасаа. Тэгээд энэ мэдээж ингээд өсөн нэмэгдэнэ тиймээ. Энийгээ зарцуулах гуравхан боломж байгаад байгаа байхгүй юу. Эрүүл мэнд, боловсрол, орон сууц.

Тэгэхээр энийг би хэрэвзээ эрүүл боловсролтой орон сууцтай болоод би тэтгэвэртээ авмаар байгаа байхгүй юу. Тэгэхээр би баялгийн сангаас тэтгэврийн санд мөнгө авах гээд байгаа юм биш. Би энэ надад хуваарилагдсан мөнгийг ирээдүйд тэтгэвэртээ гарахаараа өөртөө авмаар байгаа юм аа. Тэгэхээр энэ агуулгаар нь баялгийн сандаа энэ тэтгэвэр гэдэг үгийг л нэммээр байгаа юм.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Чингис хаан баялгийн сан иргэн болгонд хуримтлагдсан хуримтлал бол 306 мянга орчим байна. Хуулиараа боловсрол, эрүүл мэнд, орон сууцад зарцуулах л ийм л хуультай. Тэгэхээр үүнийг тэтгэвэр гэдэг үгийг нэмэх буюу тэтгэвэртээ хуримтлуулж болно гэдгийг нэмбэл бид нар энэ дээр бол хөрөнгийн менежмент хийж болно 306000-ыг чинь бид нар бонд авч болох уу, үнэт цаас авч болох уу хувьцаа авч болох уу гэдгийг иргэнээс өөрөөр нь шийдүүлбэл магадгүй жилд нэг 10 хувь багадаа өгөөж тооцох бололцоо байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 306000-ыг тэтгэвэрт тавьчихаж болно гэдэг асуудлыг ер нь би шийдэх ёстой гэдэг байр суурьтай байдаг.

Тэгэхээр энэ удаа хуулийг батлаад Их Хурал баталчихвал намар ирэх оны төсөв болоод төсвийн тодотгол хийх үеэр бол төсөв дагуулаад энэ асуудлыг тусгаж болно. Зардлыг нь бас бид нар тэтгэврийнхээ энэ зардлыг шийднэ.

С.Бямбацогт: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Хууль их гоё супер хууль байна. Тэгээд ер нь яах вэ ингээд хараад байхаар манай Ерөнхий сайдаас өөр ер нь ажил хийж байгаа хүн надаа ер нь олж харагдахгүй байгаа. Мэдээж хэрэг энэ хуулийг оруулж ирсэн энэ хамгаалал юуных нь салбарын сайд нь сайн ажиллаж байх шиг байна. Энэ Сангийн сайдыг ерөөсөө олж харахаа байлаа. Одоо Татвараа бид нар чинь ингээд сая батлаад явуулчихлаа. 2.2 их наяд 2027 онд, намар гэхэд бид нарын төсвийн алдагдал, төрийн сангийн алдагдал гээд нэлээн тоо гарч ирнэ. Энэ хуулийг батлахаар нэлээн алдагдал нэмэгдэнэ. Тэгээд ирэх жилийн би энэ төсөв ер нь яаж боох гэж байгаа юм, орлогоо хаанаас олох гэж байгаа юм, мөнгө олдог бид нар хуулиа баталсангүй. Сая тэгээд хойшлуулаад ингээд дотооддоо ч гэсэн нэг ийм улс төржилттэй. Тэгэхээр надад мөнгө хаанаас олох гэж байгаа вэ гэдэг асуулт дээр Сангийн сайд хариулмаар байна.

Ерөнхий концепц бол болж байгаа юм. Энэ нөгөө баталгаат энэ нэлээн олон улсын түвшний Шинэ Зеланд, Австрали, Английн энэ юугаар стандартаар хийсэн байна л даа. Баталгаат тэтгэврийн юу гээд. Гэхдээ нийгмийн даатгалын сан гэдэг нэг зарчмын сан л байгаад байгаа юм л даа. Нийгмийн даатгалын сан гэдэг сан маань өөрөө нийгмийн даатгал шимтгэл төлсөн хүмүүсийн сан байхгүй юу.

Тэгэхээр энийгээ төсвөөсөө хэмнэлт гаргаад яг тэр сан байдлаар нь удирдаад тэгээд тэр нь өөрөө эргээгээд тэр тэтгэврээ яаж нэмж явах вэ гэдэг юугаа бодлогоо бодож явдаг. Тэгээд тэрэн дээр нь Засгийн газар баталдаг ч байдаг юм уу, дэмждэг ч байдаг юм уу иймэрхүү байдлаар менежмент явбал уг нь жишиг рүүгээ явчих байсан байх. Одоо тэгээд бид нар чинь ингээд төсөвтэйгөө ингээд бүх юмаа хольж хаяад, тэгээд энэ дотор чинь нөгөө халамжийн ч тэтгэвэр байгаад байгаа юм, халамжийн ингээд баталгаат эд нар гээд л болоод явах юм шиг байгаа юм. Тэгэхдээ

энд чинь нөгөө малчин ингээд нөгөө НДШ төлдөг асар олон сегмент ороод байна. Манай хүчний байгууллага ч гэдэг юм уу. Тэгээд энэ сан маань өөрөө тэрийгээ даахгүй, тэрийг нь ингээд төсвөөс ингээд нэлээн өндөр санхүүжилттэйгээр ингээд хийгээд явчихаар зүгээр миний тоо зүгээр бүдүүн бараг тооцоо шүү. Ирэх жил би Төсвийн байнгын хороог ахалж байсан болохоороо л ингээд л төсөв дээр их санаа зовоод байх шиг байх юм. Зүгээр миний бүдүүн бараг тооцоогоор бараг арваад их наяд төгрөг бид нар ирэх жил хэрэгтэй. Энэ татвар, энэ цалин тэтгэвэр гээд явахаар тэгээд энэ мөнгө маань яг хаана байгаа юм бэ? Би Сангийн сайд ерөөсөө олж харсангүй. Энэ дээр Сангийн сайдаас би хариу авмаар байна. Яг тодорхой хариу авмаар байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Тэтгэврийг инфляцтай уялдуулж жил болгон нэмнэ гэдэг заалт 2024 онд Нийгмийн даатгалын хуульд хийчихсэн тийм үүрэгтэй Засгийн газар. Ирэх оны төсөв барихад тэтгэврийг инфляцтай уялдуулаад л нэмэх шаардлагатай. Инфляц чинь 11 хувьд хүрчхээд байна шүү дээ. Тэгэхээр инфляцтай уялдуулж нэмэх гэхээр тэтгэврийн доод хэмжээ авч байгаа 769 дээр 10 хувь, 20 хувь нэмлээ гээд бага дээр нь 10 хувь нэмэгддэг. Өндөр тогтоолтоос дээш нь 10 хувь л нэмэгддэг.

Тэгэхээр энэ өөрөө шударга биш байна л гэдэг. Дээрээс нь ерөөсөө энэ нийгмийн даатгалын сан өөрөө нөгөө хүрээгээ тэлж цаашдаа нөгөө нийгмийн даатгалд шимтгэл төлөх хөшүүргийг энэ өнөөдрийн хөдөлмөр эрхэлж байгаа залуучуудад бий болгохгүй бол шимтгэл төлөх ямар ч сонирхолгүй болчихсон. Яг энэ татвар шиг сонсогддог болчихсон. Жишээ нь өндөр төлсөн 5 жилээрээ тэтгэвэр тогтоолгох гэхээр тэр хүн 30 жил төлж яах юм бэ, 5 жил өндрөөрөө тогтоолгоод гаръя л гэдэг ийм бодолтой. Гэтэл олон жил төлсөн хүмүүс хохироод байгаа.

Тэгэхээр шударга энэ тогтолцооны шинэчлэлийг хийж байж цаашид тэр инфляцтай уялдуулж явах нь зүйтэй гэдэг олон жилийг ур урамшуулсан ийм тогтолцооны том шинэчлэл. Энэ олон жил яригдлаа. 58 оны тогтолцоогоор өнөөдрийг хүртэл явлаа. 1995 онд шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоонд шилжсэн. 1990-1995 оныг яах вэ? Тэгээд нэг нэрийн данс нээгээд хоосон хийсвэр нэрийн данс биччихсэн. Дийлэхээ болиод нөгөөдөх чинь 1979 оноос хойш гээд тавьчихсан чинь 1978 оны иргэд тэтгэвэрт гарвал 40 хувь өндөр, 79 оных нь нэрийн дансаар бодвол 40 хувь бага гэхээр энэ шударга биш.

Тийм учраас тогтолцоо өөрөө шударга болох зарчмыг хэрэгжүүлж байж цаашаа алхана гэж. Энийг хийхгүй бол ингэж явсаар байгаад бид нар тэгээд ер нь 40 их наяд руу бараг очих юм билээ. Ямар ч хөшүүрэг хэрэглэхгүй. Тэгэхээр тэр утгаараа бол цаашаа энэ нийгмийн даатгалын сангийн алдагдлыг бууруулах тогтолцооны шинэчлэл гэж хэлж болно. Орлого талаа бодох ёстой. Яах вэ Засгийн газрын зүгээс бол Ашигт малтмалын хуулийг өргөн мэдүүлээд хэлэлцэж байгаа. Энэ хууль бол мэдээж энэ эдийн засгаа тэлэхэд бол том. өөрчлөлтийг авч ирнэ.

Дээрээс нь та бүхний хэлэлцэж байгаа энэ Ганхуяг гишүүний маань Зөвшөөрлийн хууль байна. Энэ бизнесийн эрх чөлөө байна. Тэгээд сая энэ татварын хууль ч гэсэн өнөөдөр зардал гаргаад байгаа мөртөө яг үнэндээ энэ чинь хөдөлмөр эрхлэлтийг л дэмжих гээд байгаа шүү дээ. Ажлын байрыг нэмээд дэмжих

гээд байгаа шүү дээ. Тэгэхээр Ганхуяг гишүүн бол энэ ажлын хэсгийг ахлаад онцгой хувь нэмрээ орууллаа.

Би ажлын хэсгийн ахлагч гишүүдэд талархал илэрхийлье. Зүгээр энэ орлого талаа бол бид нар эдгээр хуулиуд батлагдвал явуулна. Төслүүдээ урагшлуулж байна дуусдаггүй яриануудаа дуусаж байна. Одоо ингээд зэс бол ямар ч байсан үе үеийн Засгийн газар ярьсан гараанаас гарчихлаа. Компани нь шалгарчихлаа. Гангийн үйлдвэр дээр хураангуй лист нь гарчихлаа. Хөнгөн цагааны үйлдвэр дээр бол хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийж байна. Тэгээд импортыг орлох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, нөгөө боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бид нар урдаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариултаа гүйцээе.

Н.Учрал: Ер нь боловсруулах үйлдвэрийн төслүүдээ эрэмбэлсэн. Тэгэхээр орлого талаа бол анхаарч ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь яах вэ олон жил яригдсан төрийн өмчийн компани энэ намайг Хэрэг эрхлэхийн дарга байхад өргөн мэдүүлсэн хууль. Ингээд Их Хурлаар анхны хэлэлцүүлгээ давж байна. Би үнэхээр их баяртай байна. Энэ төрийн өмчийн компанийн хууль батлагдсаны дараа энэ бол төрийн өмчийн компаниудын дунд хувьсгал болно оо. Сая 14 компани буулгаад Чингис хаан баялгийн сангийн менежментийн чиглэл рүү явуулаад яг хөрөнгийн удирдлага руу чиглүүлчихсэн. Сая нөгөө Франклин Темплтоны хүмүүстэй чинь 2, 3 удаа хэлэлцүүлэг хийлээ. Тэгээд одоо ер нь олон улсын менежмент рүү өгнө өө. Ассет менежмент хийнэ. Ингээд нэг жоохон зориг гаргаад хөдөлчихье гэж бодоод байгаа юм.

Тийм учраас оролцоо багасгасан орлогоо тэлсэн ажлуудыг явуулна. Салбар болгонд байгаа энэ тогтолцооны өөрчлөлтүүдийг засахгүйгээр сонгууль дөхөж байгаа юм байна гээд хоосон 10, 20 хувь нэмээд явбал үр дүнд хүрэхгүй л гэдэг ийм л төлөвлөгөөтэй байна.

С.Бямбацогт: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Тийм энэ хуулийн концепц бол надад таалагдаад байгаа юм. Тэгээд энэ дээр манай салбарын яамныхан сайн ажилласан байна лээ. Тэгэхээр харин энэ зүгээр хэлэлцүүлгийн шатанд энэ нийгмийн, Төсвийн байнгын хорооны хамтарсан ажлын хэсэг гаргаад тэгээд магадгүй концепцоо баталж авах нь зөв. Гэхдээ одоо мөнгөнийхөө хэмжээгээр шат дараатайгаар хэрэгжүүлэх байдлаар нэвтрүүлж явахгүй бол би яг зүгээр л 2027, 2028 онд төсөв дээр л их санаа зовниод байна л даа. Тэгээд яах вэ энэ хоорондоо тэр нэг эдийн засгийн юмнуудаа тэлтийн тэр бодлогоо явуулаад том төслүүдийг хөдөлгөх нь хөдөлгөөд ингээд явахгүй бол аягүй гоё хуулиуд баталчихдаг. Тэгээд хэрэгжүүлж чаддаггүй хэрэгжүүлэлт дээр унадаг ийм юу үүсгэх вий гэдэг дээр санаа зовниод байгаа юм.

Тэгэхээр нэмэлт эх үүсвэр олох асуудлууд дээрээ энэ салбарын бусад сайд нар харагдахгүй байна гээд байгаа маань тэр талын ажлууд ерөөсөө хийгдэхгүй байна аа. Тэр талын ажлуудыг сайд нар чинь хийх ёстой. Үнэнийг нь шаардлагатай хэлж байх ёстой. Өнөөдөр Байнгын хороон дээр үнэнийг нь хэлэхээр гүйж гараад л хэвлэлийн.

С.Бямбацогт: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тийм Ганхуяг гишүүний энэ санал одоо маш зөв л дөө. Яг намар төсөв бариад ороод ирэхээр тэтгэврийг инфляцтай уялдуулж нэм гэдэг шаардлага л үүснэ. Ерөөсөө тэр нэг 769 мянган төгрөгийн доод хэмжээгээр тогтоолгочихсон. Тэгсэн мөртөө 3-ны 1 нь 25 жил ажиллачихсан, 15, 20, 25 жил ажилласан хүмүүсийг яг адилхан тэтгэвэр тогтоочихсон. Энэ ахмадууд дээр би бүгдэд нь 10 хувийн тэтгэвэр нэмэх надад би бол одоо ингэж орж ирмээргүй байгаа юм. Тогтолцоо өөрчлөхгүйгээр ингэж бие биеэ хуурч худлаа ярьж явсаар байтал ийм л байдалд хүрчихсэн. Тийм учраас олон жилийг урамшуулдаг энэ зөв тогтолцоог парламент батлаад өгчихвөл намар энэ зөрүү ч арилчихна 140 мянган хүний баталгаа тэтгэвэр ч гэсэн ялгаатай тогтчихсон. Энэ дээрээ инфляцтай уялдуулж нэмнэ гэвэл харин ард түмний амьжиргаа, орлогын баталгааг хангуулахад том дөхөм болно гэж үзэж байгаа. Тэгээд аль аль байнгын хорооны ажлын хэсэг байгуулахыг дэмжиж байна.

С.Бямбацогт: Дахиад тодруулъя Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Тийм энэ хаврын чуулганаар ингээд амжуулаад оруулаад ирчхэж байгаа нь бол маш зөв. Тэгэхгүй бол одоо энэ чинь яг намар бол төсөв хэлэлцэх үед цалин нэмэх, тэтгэвэр нэмэхийн уралдаан ер нь зарлачихдаг шүү дээ. Тэгээд л ерөөсөө бүх юман дээр зарчмын зөрүүтэй санал оруулаад л ингээд явчихдаг. Тийм болохоор энэ яг энэ тогтолцооныхоо шинэчлэл талаас нь хараад энэ хаврын чуулганаар оруулаад, тэгээд төсвөө өргөн барихдаа энэ юунууд тоо параметруудээ тааруулаад л өргөн барихаас өөр аргагүй л дээ.

Тэгээд яах вэ ажлын хэсэг дээр нэлээн сайн ярих ёстой байх, байнгын хороод дээр нэлээн сайн хэлэлцүүлэг хийх ёстой байх. Зүгээр концепцоо эвдэхгүйгээр нь аль болох шаардлагатай бол 1, 2 жилээр хойшлуулах ч байдаг юм уу нааш цааш нь хөдлөх байдлаар хуулиа бол батлуулаад авах нь зөв л дөө. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя алга байна. Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Тэтгэврийн реформыг бол дэмжиж байна. Тэгээд ялангуяа энэ шударга тэтгэврийн тогтолцоо руу шилжиж байгаад маш их баяртай байна. Учир нь НДШ-ээ жишээлбэл 40 жил төлсөн багш нар, эмч нар, төрийн албан хаагчид яагаад 5-7-хон жил өндрөөр НДШ-ээ тооцуулаад төлчихсөн хүнээс би бага тэтгэвэр аваад байгаа юм бэ гээд манай ахмадууд байнга хэлдэг. Тэгэхээр энийг шударга тогтолцоо руу нь шилжүүлээд нөгөө 5 жил түрүүчийн парламентын үед 2020-2024 онд бөөн попрол явж байгаад 5 жил болгочихсоныг үе шаттайгаар 10 жил болгож байгаад би бол одоо маш их баяртай байна. Тэгэхээр миний ойлгосноор энэ 2028 оноос эхлээд 10 жил минимум НДШ-ээ төлж байж тэтгэврээ тогтоолгох юм байна гэж ойлгож байгаа. Энэ зөв үү тиймээ.

Миний бас нэг асуулт баяртай байгаа зүйл нь 15-22 насны оюутнууд өөрийн хүсэлтээр НДШ-ээ төлөхгүй байж болно гэсэн байна. Тэгэхээр оюутнууд маань бас орлого маш чухал байдаг. Сургалтын төлбөр энэ тэр гээд тэгээд НДШ арай залуу байгаа юм чинь одоохондоо төлөхгүй байя гэсэн ийм санал хүсэлтүүд их ирдэг. Тэгэхээр өөрийн хүсэлтээр гэхээр энэ яг процесс нь яг яаж явах вэ? Компанидаа хэлээд компани нь НДЕГ-тай холбогдоод ингээд төлөхгүй байж болно гэсэн үг үү? Энийг нь би жоохон ойлгомжгүй байна уу гэж хараад асууж байгаа юм.

Энэ жижиг, дунд бизнесүүд старт апуудыг дэмжиж байгаа заалт байгаа нь их таалагдсан. 5 хүртэлх ажилтантай жижиг компаниуд тиймээ 3 хүртэлх ажилтныг нь ААН-ийн НДШ-ээс 3 жил буюу 36 сар хөнгөлнө өө гэгчихсэн байна. Тэгээд энэ дээр зүгээр нэг санаа зовж байгаа юм нь нэг жижиг компани 5 хүнтэй 3 хүнийхээ НДШ-ийг 3 жил чөлөөллөө, энэний дараа дахиад нэг өөр шинэ компани үүсгээд, тийшээгээ хүмүүсээ шилжүүлээд, ингээд нөгөө энэ хуулийн цоорхойг ашиглаад байх вий гэдэг ийм санаа зовнил байна. Энийг асуумаар байна. Энэнээс яаж урьдчилан сэргийлэх вэ?

Дараагийн нэг зүйл нь тэтгэвэр өвлөгддөг ийм анх удаа бид нар зохицуулалтыг өмнөх парламентаар хийсэн. Нийт тэтгэврийн 20 хувийг гэр бүлийн хүн нь түрүүлээд нас барвал үлдсэн хүндээ ингээд өгдөг ийм бас энэрэнгүй хүмүүнлэг заалтыг оруулж өгсөн. Одоо болохоор энэ маань баталгаат тэтгэврийн 50 хувь болж өөрчлөгдсөн байна. Тэгэхээр энэ нь нөгөө өмнөх заалтаа дордуулчихгүй байгаа гэдэг дээр санаа зовж байна. Энэ дээр хариулт авмаар байна.

Мөн одоо тэтгэмжийн даатгалын санг ажилгүйдлийн сан 2-ыг ингээд нэгтгэж байгаа юм байна. Энэ ямар учраас, ямар зорилгоор ингээд нэгтгэж байгаа юм бэ гэсэн ийм асуултууд байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Ер нь энэ нийгмийн даатгалын сангийн зарлага жил ирэх тусам ихсээд байна. Тэгэхээр 1.6 орчим их наядыг төсөв дээр тавьж яваад байна шүү дээ бид нар. Намайг 2020 онд энэ тэтгэврийн реформ шинэчлэл ярьж ажлын хэсгийг ахалж байхад 3 залуу хүн тутам, 3 залуу хүн нэг ахмад хүний тэтгэврийг төлж байна гэж ярьдаг байсан юм. Өнөөдөр өөрчлөгдсөн байна. 2 залуу хүн нэг ахмад хүний тэтгэврийг төлнө өө гээд.

Цаашаа энэ хуваарилалтын тогтолцоо нэг залуу хүн нэг ахмадын тэтгэвэр төлөх буюу 90 оны бага төрөлтийн үеийнхэн 60 оны их төрөлтийн үеийнхний ачааг үүрч байгаа байхгүй юу хуваарилалтын энэ тогтолцоо. Тэгэхээр бид нар яаж энэний алдагдлыг бууруулах вэ, зарлагыг бууруулах вэ гэвэл хамрах хүрээг тэлэх ёстой учраас хөшүүрэг хэрэглэнэ. Энэ хөшүүрэг нь өөрөө нөгөө олон жил шимтгэл төлснийг урамшуулах 57-той бол 60-тайдаа гарвал 12 хувь цалингий чинь нэмж тооцно шүү, 35 жилээс дээш хөдөлмөрлөчихвөл таны цалингийн 67.5 хувиар тооцдог байсныг бид нар 72.5 хувиар тооцдог болж байгаа гэдэг ч юм уу энэ хөшүүрэг хэрэглэж байна.

2-т бол ер нь ийм нөгөө шимтгэл төлөх хөшүүргийг хэрэглэхийн тулд энэ жижиг бизнесүүд дээр жишээ нь 5 ажилтантай бол 3 хүртэлх ажилтны НДШ-ийг чөлөөлнө өө гэхээр энэ чинь нөгөө төлөх сонирхлыг сэдэлжүүлнэ. Дээрээс нь оюутнууд бол ажиллуулж байгаа ажил олгогч ажилтантайгаа тохиролцоод шимтгэлээс чөлөөлүүлж болох ийм заалтуудыг оруулж өгсөн. Дээрээс нь энэ хувийн сектор байгаа юм. Энэ хувийн секторт байгаа ажилтан албан хаагчид шимтгэл төлүүлэх сонирхлыг тэр тэтгэвэр өндөр тогтооно шүү олон жил хөдөлмөрлө гэдгээр нь хөшүүрэгдэхийн тулд нөгөө хувийн секторт байгаа ажилтан албан хаагчид бид нар би хэрвээ шимтгэлээ төлье өө гээд ирвэл 24 сар хүртэлх хугацаанд нь 50 хувь

хөнгөлчхөж байгаа юм. Тэгэхээр нийгмийн даатгалын санд тэр хувийн секторынхон хамрагдаад эхэлнэ гэдэг ийм хөшүүргийг хэрэглэж байгаа юм.

Тэгэхээр нөгөө бодлогын хувьд шударга тогтолцоо гээд байна юу гэхээр нийгмийн даатгалын сангийн алдагдлаа ер нь бууруулъя аа. Тэр жилийг ч гэсэн нөгөө хойшлуулъя гээд байгаа бол энэ чинь одоо биш. 2028 оноос 3, 3 сараар нь хэрэгжүүлээд явъя. 2028 оноос гэхэд 5 жилийг үе шаттайгаар буюу жилд 1, 1 жилээр нэмэгдүүлээд явъя. Тэр нь 2028 онд 6 жил болох юм байна ч гэдэг юм уу. Энэ бол өөрөө ийм реформын шинжтэй зохицуулалтуудыг тусгаж өгсөн. Тэгээд ингээд энэ нэг алдааг засаад урагшаа хараад явахгүй бол энэ чинь бараг 40 их наяд болох юм байна лээ шүү дээ. Одоо энэ чинь бараг 5 жилийн дараа гэхэд л. Ингээд эхлэхэд бол тэтгэвэр тавина гэж бараг байхгүй. Тэгээд давхар хагас хуримтлал руугаа алхъя гэж байгаа. Тэгэхээр ийм бодитой өөрчлөлтүүд бий болно оо. Ажлын хэсгээс нэмж хариулъя. Аубакир сайд.

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя нэмж.

Т.Аубакир: Яагаад ажилгүйдлийн тэтгэмжийн сан даатгалын сан болон ажилгүйдлийн даатгалын санг нэгтгэж байгаа вэ гэж асууж байна. Бид нар өнгөрсөн 2025 онд ажилгүйдлийнхээ сан дээр 90 орчим тэрбум төгрөг хуримтлуулаад ажилгүйдлийн тэтгэмжээ олгосон. Сүүлийн үед бол ажилгүйдлийн тэтгэмжийг зохиомлоор бий болгож авах тийм 9 сар хүртэл ажиллаад ажилгүйдлийн тэтгэмж авдаг эрх үүсдэг. 76 хоногтой тэнцэх цалинг. Гэтэл хувийн хэвшлүүд дээр мөн зарим байгууллагууд дээр намайг юу гэдэг юм тиймээ захирал аа намайг ажлаас чөлөөлөөд өгөөч, үгүй чи ажлаа хий л дээ хийнэ ээ хийнэ. Гэхдээ ажилгүйдлийн тэтгэмжээ аваад ингээд хийгээд явж байя гэдэг. Зохиомлоор ингээд эрэлт гэдэг юм уу тэгээд нөгөө талдаа зарим байгууллагууд дээр цомхотгол үүссэнтэй холбоотой өнгөрсөн жил 10, 11 сард бид нар ажилгүйдлийн тэтгэмжээ тасалдаж эхэлсэн.

Энэ жилийн 2026 оны улсын төсөв дээр бид нар төсөв өргөн барихдаа 192 тэрбум төгрөг төсөвлөсөн ажилгүйдлийн сан дээр. Мөн л одоо...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Аубакир сайд.

Т.Аубакир: Нээрээ нэг минут. Тэгээд ингээд хүрэхгүй байгаа учраас бид нар энэ ажилгүйдлийн тэтгэмжийг олгодог одоо хэрвээ өөрийн хүсэлтээр гарсан бол 76 хоног биш та 55 хоног шүү, 9 сар биш 12 сар болгоно шүү гэдэг юм уу жоохон нөгөө ажилгүйдлийн тэтгэмжийн сан дээрээ бид нар тодорхой хэмжээний зохицуулалт хийгээд үйлдвэрлэлийн ослын сан бол бас үлдэгдэлтэй үлддэг сангуудын нэг. Бид нар нөгөө талдаа ажилгүйдлийн тэтгэмжээ сантайгаа хооронд нь гүйлгэж болдог энэ зохицуулалтыг энэ хуулиа дагуулж оруулж ирж байгаа.

Мөн таны асуусан 5 хүртэл ажилтантай ААН-ийн 3 хүнийг чөлөөлье гэдэг маань бид нар энэ дундаж давхаргыг илүүтэй бий болгох, шинээр бизнес эрхэлж байгаа залуучуудад мөн татвар дахиад нийгмийн даатгалын шимтгэл гээд урагшаа өндийхөд бас амаргүй байдаг. Энэ бол маш олон судалгаа хийж байгаад 3 хүнийг одоо 36 хүртэл сараар НДШ-ээс буюу тэр тэтгэврийн шимтгэл гэдэг зүйлийг хөнгөлж өгье. Нэгэнт хөдөлмөрийн харилцаанд орж байгаа юм чинь бусад нөгөө ослын шимтгэлүүдээ төлдөг, ажилгүйдлийн шимтгэлээ төлдөг зохицуулалтууд үлдээд ингээд нийгэм...

С.Бямбацогт: Ажлын хэсгээс индрийн 4 дүгээр микрофон. Хэн хариулах вэ? НДЕГ-ын дарга Батжаргал хариулъя. Тэтгэвэр өвлөгдөх асуудал байсан байх тиймээ.

Б.Батжаргал: За тийм. Одоогийн мөрдөж байгаа зохицуулалтаар тэтгэврийн тусгай зохицуулалт гээд дундаж тэтгэврийн 20 хувь гэсэн зохицуулалт байгаа. хуулийн төсөл дээр бол 2 хувь биш 1 хувь буюу нэг дээр нэмэх нь 0.5 гэсэн зохицуулалтаар орж байгаа. Энэ мөнгө бол одоо энэ хөтөлбөр бол энэ мөнгө бол энгийн хүн дээр хуримтлал болж бичилт хийгдэнэ бэлэн яг бодит мөнгөөр. Тэгээд хэрвээ энэ даатгуулагч нас барах юм бол энэ өвлөлтийн харилцаа явна. Баталгаат тэтгэвэр дээр бол 1-ээс 100 мянгаас 300 мянган төгрөгийн хэмжээтэй байгаа. Тэгээд хэрвээ гэр бүлийн гишүүний нэг нь нас барах юм бол энэ өөрийнх нь авч байгаа баталгаат тэтгэврийн 50 хувь нь өөр дээр нэмэгдэж орж ирэхээр ийм зохицуулалт хийчихээр ерөнхий балансын хувьд бол энэ зохицуулалт бараг үргэлжилж байгаатай адилхан ийм үр дүнг үзүүлж байгаа юмаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Энэ НДШ-тэй холбоотой хууль өөрөө асар өргөн агуулгатай хууль аа. Ажил олгогчийн харилцааг, тэтгэвэр, тэтгэмж, шимтгэл, халамж авч байгаа гэхээр одоо Монгол Улсын бүхий л иргэнд 3.5 сая иргэнд бүгдэд нь хамаатай ийм том хууль хэлэлцэгдэж байна. Тэгээд энэ хуулийг хэлэлцэхдээ ингээд яаралтай горимоор ингээд үндсэндээ энэ чуулганыг хаах болж байхад яаралтай горимоор орж ирж хэлэлцэж байгаа нь энэ нийгмийн хэлэлцүүлэг өрнүүлэх ийм боломж бололцоог олгохгүйгээр хэлэлцүүлж байгаа нь энэ бол тийм таагүй л явдал байна. Чухам яагаад яаралтайгаар ингэж хэлэлцэх болсон бэ? Энэ чинь суурь асуудал. Бид нар өмнөөс зөндөө энэ асуудлыг яриад маш тийм дэлгэрэнгүй нийгмийн бүхий л бүлгүүдэд. Яагаад гэвэл энэ 3.5 сая иргэнд бүгдээрэнд нь хамааралтай асуудал.

Тэгээд уг нь бол яаралтай горим гэдэг чинь үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлыг яаралтайгаар оруулж ирнэ гэдгийг гэдэг нэрийн доор ингэж чухал асуудлыг ингэж яаран оруулж ирж байгаа, чуулганы хаалт руу ингэж шахаж байгаа нь зохисгүй л ийм нөхцөл байдал харагдаж байна. Тэгээд энэ дээр нэг тайлбар өгөөч.

2 дугаарт нь одоо тогтолцооны шинэчлэлүүд хийгдэж байна гэж байна. Яг одоо 1.6 их наядын алдагдалтай байгаа нийгмийн даатгалын сан энэ өөрчлөлтүүдийг хийснээр жилийн дараа, 2 жилийн дараа, 5 жилийн дараах энэ нийгмийн даатгалын сангийн нөхцөл байдал алдагдал аль зүгт, яаж өөрчлөгдөх юм, ямар эерэг өөрчлөлтүүд энэ дээр гарч байгаа вэ гэдэг дээр эхлээд нэг тайлбар авъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Яах вэ. Ер нь тэгээд л үе үеийн парламент, үе үеийн Засгийн газар ингээд ахмадууд тэтгэвэр нэмэх шаардлагатай гээд үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас ингээд шаардаад эхлэхээр төсөв дээр нэг 10, 15 хувийн нэмэгдэл тавиад л ороод ирдэг юм билээ. Тэгээд тэр нь өөрөө шударга биш. Үнэхээр 2012 онд тэтгэвэрт гарчихсан. Цалингаа сая 400-аар бодуулчихсан, 5 жилийн дараа гарчихсан. Нөгөө 2 сая 400-аас бодуулчихсан зөрүүтэй 140 мянган хүн хараад байгаа байхгүй юу. Тэгээд тэр иргэдэд 10 хувь нэмэхээр бага дээр нь ч бага нөгөө их дээр нь ч их ямар ч ялгаа байхгүй. Тэгээд 15, 20, 25 жил шимтгэл төлсөн иргэдийн

дунд ямар ч ялгаа байхгүй. Тэгээд бүгдэд нь 10, хамгийн харамсалтай нь 25 жил ажиллачихсан ахмадууд тэтгэврийн доод хэмжээ авч байгаа нь ахмадуудын 3-ны 1-ийг эзэлж байгаа шүү дээ.

Би тэгэхээр дахиад нэг намар тэтгэврийг нэг 10 хувь нэмнэ гээд би ерөөсөө ороод ирэхийг хүсээгүй юмаа Ерөнхий сайдын хувиар. Тийм учраас эхлээд энэ шударга тогтолцооны шинэчлэлийг хийчихвэл намрын төсөв илүү шинжлэх ухаанч үндэслэл бүхий болно гэдэг. Дээрээс нь эрт тэтгэвэрт гарахыг бол бид нар урамшуулмааргүй байна. Эхний жилүүдэд баталгаат тэтгэврийг шинээр нэвтрүүлж байгаатай холбогдуулаад мэдээж зардал өсгөчихсөн. Дунд хугацаандаа бол хэмнэлт үүсэх тооцоо гарсан. Яагаад гэхээр энэ өөрөө даатгал. Даатгалын хамралтын хүрээг нэмж байгаа юм. Яг энэ тогтсон шинэчлэл хийсний дараа бол хэн ч би эрт тэтгэвэр тогтоолгоё гэхгүй шүү. Яагаад гэвэл ажилласан жилийг нь урамшуулаад эхлэхээр. 35 жил дээр чинь шууд 72.5-аар цалингаар нь тооцоод эхлэхээр тэр параметр энэ тэр нь өөрчлөгдөөд эхлэхээр хүн чинь илүү төлье, илүү олон жил ажиллая гэдэг сэдэл рүү явж байгаа сэдэл рүү. Харин эрт тэтгэвэрт гараад, эрт тэтгэвэр тогтоолгоё гэвэл нөгөө 4 хувиар нь багасгаж тооцоод илүү олон жил ажиллавал 4 хувиар нь нэмж тооцоод явах ёстой байхгүй юу. Одоогийн хуулиар ирэх онд бид нар хэрвээ зөвхөн тэтгэврийг индексжүүлэхэд бараг 6-аас 800 тэрбум төгрөг шаардана шүү дээ хуулийн хуультай.

Тэгэхээр тэгж одоо энэ ахмадуудыгаа хуураад яах вэ. Одоо энэ тогтолцоог хийчихье. Яагаад гэхээр энэ тийм яараад байгаадаа биш юу вэ гэхээр энэ анхааралтай ажиглаж, ажлын хэсэг ажилласаар ер нь 1958 оноос хойш л зүтгэж яваа л юм байна лээ л дээ. 2024 онд бол Нийгмийн даатгалын багц хууль баталсан. Гэхдээ гүйцэж чадаагүй. Би өөрөө энэ 2020 онд Их Хурал дээр ажлын хэсгийг нь ахалж байсан тэрнээс хойш 6 жил шинэ тутам биш. Тэгэхээр энэ тогтолцоог хийж байж намар төсөв дээр илүү үндэслэл бүхий тэтгэвэр нэмнэ гэдэг бол яг байгаа олох, зорилтот бүлгээ олох, шударга байх зарчим агуулахгүй бол энэ чинь халамж биш шүү дээ. Халамж шиг ажилласан жил хамаагүй ээ гээд тэгшитгээд нэмээд байхаар өнөөдрийн энэ их бухимдал үүссэн.

С.Бямбацогт: Аубакир сайд хариулчих. Дараад нь нэмж тодруулъя.

Т.Аубакир: Тийм энэ яах вэ нэн яаралтайгаар орж ирсэн. Бид нар 9 сарын 1-ний дотор дараа жилийнхээ улсын төсвийг өргөн барих ёстой. Одоо тэтгэвэр хэрвээ энэ хууль батлагдах юм бол үүнийгээ дагаад маш олон тооцооллууд бид нар хийгдэнэ, маш олон параметр өөрчлөлтүүд орж ирж байгаа. Ер нь бол энэ тэтгэврийн асуудал, энэ нийгмийн даатгалын тогтолцооны асуудал бол аль нэг улс төрийн хүчний асуудал гэхээсээ илүү нийгмийн суурь асуудал болчихсон л доо. Тийм учраас бид нар намын бүлгүүд дээр танилцуулаад явж байна.

Ажил эрхэлж байгаа оюутнуудтай хүртэл бид нар уулзаж судалгаа хийж үзсэн. Яг тэтгэвэр авч байгаа ахмадуудтай. Мөн тэр тэтгэврийн зээлийг олгодог тэтгэвэр ороход нь гүйлгээг нь хийж өгдөг банкны теллерүүдтэй бид нар хүртэл уулзсан. Энэ бол зөвхөн одоо ингээд л энэ тиймээ энэ чинь 2020 оноос хойш ингээд л яваад л байдаг, яваад л байдаг, 30 орчим жил хуримтлагдчихаад байдаг тиймээ. Хэрвээ одоо магадгүй Ерөнхий сайдын өмнө 2 сонголт байлаа. Сая 500 мянган төгрөг болгооч ээ гэхэд нь энийгээ ингээд мөнгөө ингээд нэмэгдсэн болох уу, үгүй бол үүгээрээ бид нар ерөөсөө нэгмөсөн реформын өөрчлөлтөө хийх үү гэдэг сонголтын 2 сонголтын өмнө байж байгаад энэ 2 дахь буюу энэ...

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Үгүй ээ яах вэ би тодорхой тоо асуусан л даа. Тогтолцооны өөрчлөлт реформ шинэчлэлт хийж байгаа болбол наад нийгмийн даатгалын сан чинь хэрхэн яаж бие даах чиглэл рүү явах ёстой вэ? Бие даах чиглэл рүү явна аа гэдэг нь бид төсвөөс нөхөж байгаа энэ 1.6 их наядын алдагдал чинь ирэх жилүүдэд яаж өөрчлөгдөх вэ? Хэрэвзээ энэ их энэ алдагдлын хэмжээ чинь их хэмжээгээр нэмэгдээд байвал та нар ямарваа нэгэн тогтолцооны өөрчлөлт хийгээгүй байна аа. Зүгээр л гал унтраах дахиад л тэдэн процент, тэдэн процентоор нэмье гэдэг нөгөө нийгмийн даатгалын сангаа хэрхэн яаж мөнгөжүүлэх юм, хэрхэн яаж арвижуулах юм энэний менежмент яах юм гэдэг тогтолцоо энэний цаана байхгүй байгаагийн л илэрхийлэл байхгүй юу. 1.6 их наяд чинь 2 их наяд, 3 их наяд гээд л цаашаа явахаар тоонууд бас харагдана лээ. Тэгвэл хаана нь шинэчлэл байгаа юм, хаана нь өөрчлөлт байгаа юм, ямар тогтолцооны өөрчлөлт байгаа юм?

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Өнөөдрийн нийгмийн даатгалын сан дээр одоо 1.6 их наяд төгрөг улсын төсвөөс аваад явж байгаагийн 900 тэрбум төгрөг нь цэргийн тэтгэвэрт гарсан хүмүүс 23 мянга орчим иргэн байдаг. Үлдсэн нь бол 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгосон иргэдийн мөнгө байгаа юм. Энэ таны хэлж байгаа санал маш зөв. Энэ яг шимтгэлд суурилсан классик утгаараа явах ёстой энэ сан. Гэтэл энэ сангийн өнөөдрийн үүсчихсэн байгаа нөхцөл байдлыг бий болгосон нь өөрөө энэ нийгмийн даатгалыг улс төрөөр шийдэх ёсгүй л дээ. Тэгээд энэ чинь нийгмийн хамгааллын асуудал. Тийм учраас энэ аливаа улс төр орсон хуулиудын уршгаар яг өнөөдрийн байж байгаа нийгмийн даатгалын сан бий болсон юм.

Тийм учраас энэ дээр би бас танд уулзахдаа хэлж байсан. Бид нар аль нэг улс төрийн хүчин биш. Монгол Улсын парламент болж эндээс шийдвэр гаргах ёстой. Яг шимтгэлд суурилсан утгаараа явъя гэх юм бол саяын одоо шимтгэл төлдөггүй сегментүүдээ цэргийн тэтгэврийнхэн, малчны тэтгэврийнхэн тиймээ энэ бусад тэтгэврүүдээ бид нар тусад нь сангаасаа гаргаж байгаад яг шимтгэл дээрээ явах юм бол энэ хийж байгаа реформ...

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Тэгээд энэ яриагаа товчилъё. Уг нь бол зөвхөн шимтгэлээс гадна үндэсний баялгийн сангаар байгалийн баялгаас энийг мөнгөжүүлэх орлогожуулах, бусад үндэсний баялгийн сангийн тэр менежментийг ашиглах гээд бусад зүйлсүүд байсан байх ёстой байх аа гэж бодож байгаагаа хэлье.

Хоёрдугаарт нь Их Хурлын даргаас нэг асуулт байгаа нь манай Түвшин нарын гишүүдийн өргөн барьсан хууль хаачив аа? Яг хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг тодорхой хэмжээний бас идэвхжүүлэх урамшуулах талын хуулийг Түвшин нарын гишүүд өргөн барьсан. Энэ хуулийг эргүүлж харахлаар тэр өргөн барьсан заалтуудыг дордуулсан байдлаар ганц 2 өгүүлбэрээс энд харагдаж байна. Миний санаж байгаагаар өнгөрсөн жил байнгын хороогоор хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн санагдаж байна. Нэгдсэн чуулганаар оруулж Засгийн газраас өргөн барих хуультай нэгтгэж хэлэлцэх боломжтой гэж хойшлуулсан санагдаж байна.

Гэтэл одоо энэ хэлэлцүүлэг дээр байхгүй болчих юм. Энэ бол бүтэн жилийн өмнөх хууль байхгүй байхад одоо...

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя. Аубакир сайд дараа би хариулъя.

Т.Аубакир: Тийм. Түвшин нарын гишүүдийн хууль 41 гишүүн өргөн барьсан. Түвшин гишүүнтэй би энэ нэн яаралтай орохоос өмнө ярилаа. Бас хөдөө орон нутгаар яваад байх шиг байна. Тэгээд уул нь даргын дэргэдэх зөвлөл дээр яригдаад одоо хэлэлцэх эсэх дээрээ яг зогсчихоод байгаа шүү дээ. Тийм учраас хэлэлцэх эсэхээ давуулаад цаашдаа уул нь хамтраад явах боломж байсан. Одоо энэ Улсын Их Хурал дээр нөгөө хэлэлцэх эсэх дээр зогсчихсон байхгүй юу. Энэ процессоо явуулахын тулд хурлын даргатай яриад даргын дэргэдэх зөвлөл дээр хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаад явахад огт би өөрөө хойноос нь Түвшин гишүүн рүү ярьж байгаа шүү дээ. Хаа байна аа багш аа энийгээ ингээд яая. 41 гишүүн байгаа. Тийм ээ ингээд энэ хуулийг цаашаа хамтатгаад явах нэгэнт л одоо яг саяын түрүүний бидний ярьснаар бид нар хамтраад парламентаараа шийдвэр гаргах ийм бололцоо бол бүрэн байгаа шүү дээ.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. Тэр дордсон заалт яриад байна. Дордсон заалттай холбоотой.

Н.Учрал: 2015 онд энэ Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлогыг баталсан байдаг. Тэр тэтгэврийн сангийн алдагдлыг тэр Жи Ти Пи-гийн 2 хувиас ихгүй байлгана гэсэн зорилттой шүү дээ. АН засаглаж байхад Төрөөс тэтгэврийн талаар баримтлах бодлого тэр бодлогыг л бид нар бариад ажиллаж байна. Гүйцэтгэх засаглал бол хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ ээ. Энэ хязгаарлагдмал нөөц байгаа. Тийм учраас өнөөдөр ямар арга хэмжээ авах вэ гэдгээ санхүүгийн нөөцдөө тулгуурлаад л шийдэж байгаа. Гоё сайхан юм ярих бол амархан. Тэгэхдээ энэ тэтгэврийн шинэчлэл бол тогтолцооны өөрчлөлт. Энэ бол шударга тогтолцооны реформ. Тэрнээс биш бүгдийг нь тэтгэврийн тэдэн хувь нэмнэ, эдэн хувь нэмнэ гэсэн тогтолцооны өөрчлөлт огт биш. Юутай ч энэ тэтгэвэр гарвал олон жил шимтгэл төлснөөрөө ялгамжтай байдлаар тэтгэвэр нэмэгдэх нь бол дамжиггүй. Цаашаагаа алдагдал буурна.

С.Бямбацогт: Түвшин нарын гишүүдийн санаачилсан хууль Их Хурал дээр байгаа. Энэ бол засгаас өргөн барих хуультай бас хамт хэлэлцье гэдэг байдлаар хүлээгдэж байсан. Тэгээд байнгын хороодоос ирэх 7 хоногийн тов дараалалд оруулах саналаа Даргын зөвлөлд оруулдаг. Тэгээд өнгөрсөн 7 хоногийн даргын зөвлөлийн хурал дээр энэ 7 хоногийн тов дараалалд оруулахаар байнгын хороодоос саналууд ирээгүй. Тэгээд энэ асуудал ороогүй байгаа.

Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: 2026 оныг Боловсролыг дэмжих жил гээд зарлачихсан байгаа. 2026 он бараг талдаа орлоо. Миний хувьд бол 2025 оны 7 сарын 2-ны өдөр Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн бариад ингээд бас жил болж байна аа. Тэгээд 3 хоногийн дотор та нар шуурхай яаралтайгаар оруулдаг юм байна. Монголын багш нарынхаа нийгмийн асуудал дээр бол үнэхээрийн ийм хүнд сурталтай хуулийг нь хэлэлцэх эсэхийг нь оруулахгүй ийм байдалтай байгаад бол би үнэхээр харамсаж байна аа. Тэгээд тухайн тэр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр энэ миний урд байгаа багшийн тэтгэврийн насыг

өөрөө хүсвэл эмэгтэй 50, эрэгтэй 55 настай тэтгэвэрт гаргадаг болгоно оо гэсэн энэ заалт байгаа юм. Бямбацогт дарга аа сонсож байна уу та?

Тэгээд энэ хуулийн одоо миний энэ хуулийн төслийг хэзээ хэлэлцэх вэ? Энийг асууя 1 дүгээрт. Тэгээд 2024 оны 4 сард Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн ивээл дор зохион байгуулагдсан Монголын багш нарын 8 дугаар Их хурал гээд болсныг та бүхэн маань мэдэж байгаа тийм ээ. Энэ 8 дугаар Их хурал дээр мөн л энэ тэтгэврийн нас яригдсан. Эрэгтэй 55, эмэгтэй 50 гээд. Тэгээд энийг бүүр ингээд юу 2024 оны 4 сарын 13-ны өдөр Монголын багш нарын 8 дугаар Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 4 дүгээр тогтоол гэж баталсан.

Энэ дээр болохоороо энэ тогтоолын 3 дугаар хавсралт багшийн нийгмийн баталгаа цалин хөлсний талаар хэрэгжүүлэх арга хэмжээ, 11 дүгээр зүйл дээр боловсролын байгууллагын багшийн тэтгэврийн насыг өөрөө хүсвэл эрэгтэй 55, эмэгтэй 50 гээд ингээд оруулчихсан байна. Тэгэхээр энэн дээр та бүхэн маань ямар ажил хийсэн бэ? 2024 оноос хойшоо. Тэгээд энийг бүүр асуумаар байна Учрал сайд аа. Би таныг Их Хурлын дарга байхад нөгөө хуулиа ярьж л байсан. Өнөөдөр таныг Ерөнхий сайд болоход бас нөгөө л хуулиа ярьж л байна. Бас л нөгөө энэ багш нарын нийгмийн асуудал ямар ч шийдсэн юмгүй ингээд байлгаад байх юм. Тэгээд энийг одоо хэзээ шийдэх вэ? Энэ хуулийг хэзээ хэлэлцэх вэ?

Тэгээд энэ сая ийм хууль оруулж ирж байгаа бол багш нарт нэг ийм асуудал байгаа даа гээд ингээд сэтгэл гаргаад оруулчих хүн ч байсангүй юу? Би бол та нарыг бүгдээрээ мэдэж байгаа л гэж бодож байна. Багш нар энийг чинь одоо 2024 онд Монголын багш нарын 8 дугаар Их хурлаар бараг Ардын намын ерөнхийлөгч нь ч байсан, Ерөнхий сайд нь Оюун-Эрдэнэ байсан, Хурлын дарга Занданшатар байсан. Тэгээд за л гээд гарцгаасан. Одоо өнөөдөр хийсэн юмгүй сууж байна аа.

Тэгэхээр энэн дээр одоо би Учрал сайдаас маш тодорхой хариулт сонсохыг хүсэж байна. Багш нар ч гэсэн энэн дээр бараг бүтэн жил гаруй нөгөө хууль хэзээ хэлэлцэх вэ гээд надаас бараг худалч хүнд өдөр болгон багш нар асууж байна. Тэгэхээр энэн дээр одоо та бүхэн маань эрх барьж байгаа намынхан, Ерөнхий сайд нь ч байна, Их Хурлын дарга нь ч байна. Та хоёр хоёулаа тодорхой хариулт өгөөрэй. Энэ хуулийг хэзээ хэлэлцэх юм бэ? Энэ хууль дээр чинь энэ байгаа байхгүй юу. Энэ хамгийн гол заалт. Тэгээд энийг нэг хариулт тодорхой хариултыг би Учрал сайд, энэ Бямбацогт дарга 2-оос асууя. Тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм Мөнхтуяа гишүүн бид 2 ч багш нарын төлөө олон жил аль аль нь сэтгэл зүтгэл гаргаж ажиллаж байгаа хүмүүс учраас боловсролын салбарын гол ачааг нь үүрч байгаа энэ багш нарыг дэмжих бодлого бол манай Засгийн газрын гол бодлого. Гэхдээ зүгээр нэг зүйлийг хэлэхэд энэ удаагийн тэтгэврийн энэ тогтолцооны шинэчлэлийн гол зорилго бол эрт тэтгэвэрт гарвал тэтгэвэр багаар тогтоолгох, илүү олон жил шимтгэл төлбөл өндөр тогтоолгох шударга зарчим руу шилжье гэж зорьж байгаа. Одоо яагаад хүмүүс эрт тэтгэвэрт гаръя гэдгийг илүү сонгоод байна вэ гэхээр илүү олон жил шимтгэл төлөөд эрт биш хойно тэтгэвэрт гарлаа гэхэд өндөр тэтгэвэр надад оногдохгүй учраас аль болох эрт гарчихъя гээд байна шүү дээ. Үнэхээр 5 жил хөдөлмөрлөөд жил болгон 4, 4, 4 хувийг нэмдэг байсан бол манай багш нар 60 насандаа тэтгэвэрт гаръя гэхэд асуудал байхгүй.

Гэтэл 50 настайдаа гарсан ч, 60 настайдаа гарсан ч тэтгэвэр нь ялгаагүй юм чинь эрт л гаръя гэдэг бодол байна шүү дээ.

Тэгэхээр манай энэ нийгмийн даатгалын сангийн бодлого чинь өөрөө ерөөсөө энэ хүрээгээ тэлэх ямар ч бодлого байхгүй. Олон жил шимтгэл төлснийг урамшуулдаггүй ийм тогтолцоо байхгүй юу. Харин багш нарыг бид нар тиймээ тэтгэврийн насыг наашлуулъя гэхээс илүүтэйгээр олон жил шимтгэл төлбөл илүү өндөр тогтоолгоно гэдэг зарчмаа бариад магадгүй наснаас нь шалтгаалаад тэр нөгөө хичээлийн 7 хоногт өгч байгаа хичээлийн цагийг нь багасгах бусад дэмжлэгүүдийг өгөх ёстой.

Ер нь бол багш нарын хувьд одоогийн тэр 1958 оны тэтгэврийн тогтолцоогоороо бол өнөөдөр хүртэл эмэгтэй багш нарын нас 55, эрэгтэй нь 60 хэвээрээ байгаа тиймээ 55, 60-тай. Энэ насыг бид яг 1958 оноос хойш хөндөөгүй 55, 60. Гэхдээ эмэгтэй багш 4 хүүхэдтэй байх юм бол 50 насандаа гарах эрх нь хэвээрээ байгаа. Тэгэхээр бид нар бол цаашдаа илүүтэйгээр нөгөө ажлын цагийг нь богиносгох, дээрээс нь нөгөө ачаалалтай ангид нэмэлт багш оруулах, нөгөө туслах багшийнхаа орон тоог бий болгох, дээрээс нь тэтгэвэрт гарчихсан бол НДШ-ээс чөлөөлүүлэх. Дээрээс нь багш хүн зөвлөх үйлчилгээ ч юм уу янз бүрийн ажил хийхэд нөгөө бүх гэрээнээс шимтгэл төлөхийг нь бид нар зогсоочихлоо шүү дээ. Жишээ нь 2 хүртэлх гэрээ байгуулаад багш нар одоо ажил хийвэл зөвлөх үйлчилгээ ч юм уу хийвэл тэр нь шимтгэл төлөхгүй. Ийм хөшүүргүүдээр дэмжиж өгч байгаа.

Тэгэхээр Мөнхтуяа гишүүн ээ, ер нь бол бүгдээрээ энэ 5 жилийн урьд хойно тэтгэвэрт гарах дээр ямар ч тэтгэврийн ялгаа байлгахгүйгээр ингээд яваад байхаар хүн болгон эрт тэтгэвэрт гаръя гэж л бодоод байгаа юм. Тэгээд яг үнэндээ эргээд харахаар нөгөө нийгмийн даатгалын сангийн алдагдал ингээд жил ирэх тусам нэмэгдээд, сүүлдээ тэтгэврээ ч тавьж чадахгүй хэмжээнд л очоод байгаа юм л даа. Яг үнэнээ хэлэхэд.

С.Бямбацогт: Аубакир сайд нэмж хариулъя.

Т.Аубакир: Тийм Мөнхтуяа гишүүний хэлж байгаа зүйл одоо яах вэ өмнө нь энэ чинь 1958 оноос хойшоо эмэгтэй багш 55-тай, эрэгтэй 60-тай гэдэг хууль бол хэвээрээ байгаа. Гэхдээ яах вэ тэр тухайн үеэс хойших өнөөдөр багш нарын нөхцөл байдал харьцангуй сайжирсан л даа. Наад зах нь шохой барьж ажилладаггүй гэдэг ч юм уу тиймээ энэ эрт тэтгэвэрт гарах нь өөрөө нөгөө тэтгэвэр бага тогтчих бас нэг үндэслэл болдог юм шүү. Та 50-тай гарчих гээд боломж өгчихдөг нөгөө багш маань гараад үгүй би яагаад ингээд бага тэтгэвэртэй болчхов гэдэг дахиад нэг 5 жил ажиллаад тиймээ энэ чинь ажлын нөхцөл харьцангуй сайжирчихсан яг өнөөдрийн байдлаар энэ насжилт уртсаж байгаатай холбоотой дэлхий дээр яг өнөөдөр 55 улс насыг нэмэх арга хэмжээ аваад эхэлчихлээ шүү дээ. Нэг үеэ бодвол одоо хүн урт насалдаг болсон байна аа тиймээ. Энэ чинь 50-тай, 55-тай эмэгтэй, 60-тай эрэгтэй гэдэг бол харьцангуй хөдөлмөрийн чадвартай байгаад байдаг. Хэдий их ажиллах тусмаа нөгөө хүн маань нийгмийн хамгааллаа хүртээд тэтгэвэр нэмэгдэх боломж юмаа гэдгийг та бас харж үзээд...

С.Бямбацогт: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Учрал сайд, Бакир сайд хоёртойгоо би бүүр хамт хэдэн багш нар цуглуулаад уулзъя даа. Та нар маань бол ер нь нэг багшийн ажлыг их амархан

гэж бодоод байх шиг байна. 2-6 насны ид хөдөлгөөнтэй байгаа энэ насны хүүхдэдээ ингээд 60 настай багш биеийн тамирын хичээл заагаад зогсоно гээд та нар бод доо. Асар хүнд шүү. Энэ бол нэг зүгээр харагдаж байгаа шигээ биш. Тэгээд та нар маань болохоор нэг тийм гоё юм л яриад байна. Тийм гоё юм бол байхгүй шүү багшийн амьдралд. Би бол зориод тэр багш нарын хүнд нөхцөлийнх нь л юмыг яриад байгаа юм. Яах вэ сайн сайхан юм байгаа л даа. Гэрэл гэгээтэй юм. Яг тодорхой одоо бүр 50 настай би гаръя гээд байгаа багш нар байна шүү дээ. Тэр хүмүүстэй та нар уулз аа. Би энд зохиогоод л багш нар 50-тай гаръя гээд байна гээд...

С.Бямбацогт: Асуултаа гүйцээчихье. Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Тэгээд одоо багш нарын групп дээр Бакир сайд өөрөө мэдрэмжтэй бол ороод хараарай. Яг өчигдөр таны нөгөө хэлсэн 50-тай гаргаж яах гээд байгаа юм бэ гээд Сайнзориг гишүүний бас 50-тай гаргаж яах гээд байгаа юм бэ гэсэн. Тэр юуны чинь доор багш нар шаагиж байгаа шүү. Битгий эргүүтээд бай та нар. Амьдрал мэдэхгүй байна гээд загнаж байна шүү дээ бид нарыг. Яг үнэн бодит юмыг л та нар ярь. Тэрнээс ёстой гоё байна, сайхан байна, багш нар одоо 55, 60 хүртлээ ажилламаар байна гэж ерөөсөө ярихгүй байна. Бодит ингээд яг хөрсөн дээрх юмаа ярихгүй гал унтраах юм яриад байна аа, харамсалтай байна.

Тэгэхээр би одоо Учрал сайд, Аубакир сайд 2-той одоо нэг 500 багштай ч юм уу уулзмаар байна цуг тийм.

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Тийм тийм. Энэ Мөнхтуяа багш багш нарынхаа төлөө үргэлж л дуугарч л байдаг зөв л дөө. Тэгээд яг өнөөдрийн энэ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийнхаа нэмэлт өөрчлөлтийг хийчхээд тодорхой хэмжээний реформын шинж чанартай олон жил ажилласан хүндээ ашигтай байдаг, ээлтэй байдаг энэ тогтолцоогоо хийчхээд 5 дугаар Их хурлыг дахиж хийгээд дахиад багш нараасаа асууя. Ажиллавал 9 рүү орчихсон уу тиймээ. Дараагийн багш нарын Их хурлыг реформоо танилцуулаад одоо та энэ хүрээнд энэ реформыг хараад судлаад үз. Одоо та тэтгэвэрт гармаар байна уу гэж бас асууж үзье. Үнэхээр гармаар байна аа гэвэл дахиад зохицуулалт хийж бас болох байх. Гэхдээ эрт тэтгэвэрт гарахад тэтгэвэрт гарах нь өөрөө тухайн нөгөө ажилтныхаа нийгмийн хамгааллыг доройтуулдаг шүү. Бид нар ингээд хүн л амьдарч байгаа бол нийгмийн хамгаалал заавал цуг явах ёстой, заавал цуг явах ёстой.

Ажлын нөхцөл хүнд байгаа бол ажил олгогч нь тэрийг сайжруулах үүрэгтэй. ХАБ-ын тухай хуулиараа байдаг ч юм уу. Тэр хүнийг ялангуяа одоо энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нар бол асар хүнд...

С.Бямбацогт: Тодруулчихсан шүү дээ. Та 2 болчихсон. Тэр хууль Улсын Их Хурлын гишүүд нөгөө нийт иргэн улсын эрх ашгийг эрхэмлэнэ ээ гэж тангараг өргөдөг. Бид нар бас нөгөө хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх ёстой. Улс орныхоо төсөв санхүү эдийн засгийн нөхцөл байдалтайгаа уялдуулж санаачилж байгаа хуулиудаа санаачлах ёстой. Тэгээд хэт одоо дааж давахгүй хууль санаачлаад тэрийг нь Их Хурал дээр батлах гээд батлах хэцүү, батлахгүй хэцүү. Тийм болохоор мэргэжлийн байнгын хороод нь таны санаачилсан хуулийг чуулганаар хэлэлцүүлье. Хэлэлцэх асуудалд оруулъя гэж саналаа оруулж ирэхгүй байгаа юмаа. БСШУ-ны

байнгын хороо өөрөөр хэлэх юм болбол. Яагаад гэвэл хэт өндөр ачаалал авах нь ээ одоо Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо шүү дээ тийм ээ.

Улсын төсөв ДНБ-ний 7 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг боловсролын салбарт зарцуул аа гэсэн агуулга тийм гэж байгаа. Гэтэл өнгөрсөн жил чинь бид нар төрийн албан хаагчдын цалингаа бүгдийг нь нийтэд нь нэмэгдүүлье гэж байгаад та бүхэн бас санал гаргаад багш нар, эмч нарынхаа эрүүл мэндийн салбар боловсролын салбарынхаа цалинг нэлээн өндөр нэмчихсэн. Төрийн захиргааны бусад албан хаагчдын цалин нэмэгдээгүй, ахмадуудынхаа тэтгэврийг хангалттай нэмж чадаагүй дөнгөж 8-хан хувиар нэмсэн бол манай багш нарын цалин 100 2 дахин нэмэгдсэн байгаа шүү дээ. Үгүй ийм байж байхад бид нар бас нэг төрийн албан хаагчдыг адилхан л ард түмний төлөө зүтгэж байгаа төрийн үйлчилгээ ард иргэддээ хүргэх гээд зүтгэж байгаа улсууд ийм ялгавартай хандаад байх нь зохимжгүй байгаад байгаа юм.

Дээрээс нь төсөв санхүү маань даах бололцоогүй байна аа. Тэгээд өнгөрсөн жил ингээд шийдчихсэн байхад дахиад ийм асуудал шийдэх гээд улсын төсөв хэцүү байхад ингээд гэдэг асуудлаар мэргэжлийн байнгын хороод нь оруулж ирэхгүй байгаа. Тийм болохоор та бүхэн бас нэгэнтээ хангалттай манай боловсролын салбарынхан бол хангалттай сэтгэл хангалуун байгаа шүү дээ. Цалин хангалттай нэмчихлээ болчихлоо гээд. Яг наад таны ярьж байгаа эмэгтэй 50, эрэгтэй 55-ыг чинь бол монгол хүний дундаж наслалт 74 болчихсон. Түүнтэй холбоотойгоор тэтгэвэрт гарах насаа жаахан ахиулаад олон жил ажилласнаар илүү их тэтгэвэр авдаг болъё гээд нэг хэсэг нь хүсээд байдаг ихэнх нь. Цөөн нэг хүсэх хүмүүс нь тэтгэвэрт гарах насаа наашлуулъя гэдэг асуудал ярьдаг байх. Тэр нь бол цөөхөн. Гэтэл илүү одоо юу гэдэг юм залуу зандандаа илүү ажил хийх бүтэмжтэй, туршлагатай, чадвартай үедээ тэтгэвэртээ гар гээд насыг нь 50 болгочихоор бүгд 50 настай тэтгэвэрт гардаг болчих юм бол тэр хүмүүс чинь эргээд одоо бас хамт олонгүй, эргээд хийх ажилгүй бас асуудлууд байдаг л байх.

Тэгээд нэлээн сайн сая Ерөнхий сайд ярилаа. Ерөнхий сайд, Аубакир сайд та хэд маань багш нартайгаа уулзаад, санал бодлыг нь сонсоод, Энх-Амгалан сайдтайгаа хамт тэгж байгаад нэг асуудлаа ярих нь зөв байх аа. Ямар ч гэсэн 2026 оны тухайд эрүүл мэндийн салбар, боловсролын салбарт хангалттай асуудал шийдэгдсэн. Тийм болохоор дахиад энэ тэтгэврийн асуудал яригдаж байна. Энэ дээр та шаардлагатай бол наад гаргаж байгаа саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлдээд оруулах боломжтой байж байгаа. Иймэрхүү байдлаар нэг шийдээд явчихъя аа.

Тэгэхээр нуур амгалан бол нугас амгалан гэж тиймээ. Хүний бодоогүй, санаагүй юмыг бодуулаад, сануулаад, хүсээгүй юмыг тийм үү хүсүүлээд, ингээд үймүүлээд, бужигнуулаад ингээд тогтворгүй байдал үүсгээд энэ улс орныхоо эдийн засаг төсвөө бодохгүй ерөнхийдөө амьдрал болж байна даа гэж бодож байхад хэн ч гэсэн тэгээд 100 сая төгрөгийн цалин авах уу? Би чамд 100 сая төгрөгийн цалинтай болгоё гэх хүн амлаад явах юм бол хүн болгон л тэгмээр байна л гэж хүснэ шүү дээ. Тэгээд бодоогүй, санаагүй юмнаас нь сануулж бодуулаад бас нэг тогтвортой ажлаа хийж байгаа салбарынхныгаа бас битгий сэтгэл санааг үймүүлээч ээ. Энэ асуудал дээрээ та нэг жоохон анхаараарай гэдгийг хэлье ээ.

Тэгэхээр Ерөнхий сайдтай, Боловсролын сайдтайгаа хамтдаа багш нартайгаа бас нэг уулзаад хэлэлцүүлэг хийгээд санал асуулга явуулаад, судалгаа хийгээд үзээч ээ. Тэгж байгаад асуудлаа ярьж болно.

Эрдэнэбат гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Хуулийн төслийг яах вэ ерөнхийд нь үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаа. Ялангуяа одоо ахмадууд сүүлийн нэг жил гаруй энэ тэтгэвэр тэтгэмжийг нэмэх асуудлыг одоо маш их тавьж байгаа. 600, 700 мянган төгрөг нэг талаар бол одоо баталгаагүй амьжиргааны баталгаажих доод түвшин инфляцын өсөлтийг бол одоо ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гүйцэхгүй байгаа. Тэгээд бид нар нөгөө инфляцынханд л дөнгөж одоо нөхөх байдлаар ингээд цаашаа удаан явах юм бол үндсэндээ тэтгэвэрт гараад яг ихэнх нь нөгөө ядуурал руу орно оо гэдэг л ийм байдалтай байгаад байна л даа. Тэгэхээр энэ дээр бол одоо шийдэл гаргаад тэтгэврээ нэмэгдүүлэх ийм боломжуудыг гаргаж алсдаа би тэтгэврээ шударгаар олон жил төлөх юм бол би баталгаатай жил болгон өсөөд, үнэ цэнийг нь алдуулахгүйгээр авах юм байна аа гэдэг энэ үндсэн концепцыг хийхийн тулд яг энэ шударга тогтолцоо руу нь оруулахаас өөр арга байхгүй.

Тэрний наана яараад ингээд бүгдийг нь ижилхэн ингээд тэгье ингэдэг байдлаар ингээд явах юм бол энэ цаашдаа одоогийн тэтгэвэр төлж байгаа хүмүүсийн хувьд жоохон итгэл үнэмшил алдагдана. Ецэ илүү бага төлөөд ихийг авъя гэдэг энэ гинжин урвал одоо хэзээ ч дуусахгүй. Эцсийн дүнд нь яах вэ гэхээр бүгд тэтгэвэр авч чадахгүй ээ гэдэг ийм эрсдэл байна. Тийм учраас одоо энэ хууль дээр энэ шударга тогтолцоо буюу энийг нь маш оновчтой хийгээд урамшуулагдахуйц хийгээд өгөх юм бол энэ даатгал төлөхгүй байгаа хүмүүс чинь аяндаа ороод ирнэ гэдэг нэг зүйлийг хэлмээр байна.

Хоёрдугаарт энэ шилжилтийн юман дээр хожигсод болон хожигдогсод гээд нэг 2 юм байна хохирогчид гээд. Энийг л уул нь засмаар байгаа юм. Би 2023 онд Нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт орж байхад яг сүүлийнхээ 5 жилийг аваачаад хамгийн доод талаар төлж байснаа хамгийн дээд талаар төлөөд эхэлчихдэг. Энийг засъя аа. Жилд өсөж байгааг нь дээд тал нь нэг 20 орчим хувиар л өсгөө. Тэгэх юм бол тэр 5 жилийнх нь дунджаар, түүнээс дээш 10 дахин нэг жилийн дотор цалин нэмэгдчихдэг тийм байгууллага гэж бараг байхгүй шүү дээ. Энэ бол одоо цэвэр хуулийн цоорхойг ашиглаж байгаа. Нэг хэсэг нь одоо маш жоохныг халбагаар сан руу хийгээд шанагаар хутгаж аваад байгаа. Энэний эцсийн дүндээ бид нар нэг тогооноос авч байгаа учраас дийлэнх нь хохироод байгаа. Энийг бол зайлшгүй засах ёстой. Харин ч бид нар оройтож орж ирж засаж байна гэдгийг бас би хэлмээр байна. Тэгэхээр энэ тал дээр одоо бас яаралтай хэлэлцэхээс өөр аргагүй байгаа юмаа гэдгийг би 1 дүгээрт тодруулж хэлье.

Гэхдээ энэ өвлүүлэх асуудал энэнээс бол хэзээ ч ухарч болохгүй. Би бол одоо тэр баталгаат тэтгэврийг 50 хувь гэж байна. Би тодруулаад асуухад нөгөө эхнэр юм уу нөхөр нь аль нэг нь нас барахад тэтгэврийнх нь 20 хувь нэмэгдүүлнэ гэдэг нь өөрчлөгдчихөв үү яачхав гэдгийг би тодруулга авчихъя.

Дээрээс нь энэ удаагийн юун дээр хууль хэлэлцэхэд одоо бид нар 4 жил, 2 жилийн цаадах наадхыг харахгүй, 20 жилийг хармаар байна аа. Асрах сувилах гээд одоо бид нар бүгдээрээ л ямар нэгэн хэн нэгний асаргаанд орно. Япон, Герман Европын оронд яадаг вэ гэхээр 20 жилийн өмнөөс ирээдүйд 20 жилийн дараа

хүмүүсийн дундаж наслалт еще өснө, асрах сувилуулах хүн олон нэмэгдэнэ. Өнөөдөр 0.1 хувь байсан ч гэсэн өнөөдрөөс хуримтлуулж эхэлье гэдгийг энийг эхлүүлмээр байна аа. Тэгээд яах вэ нөгөө нийгмийн даатгалын юуг хүлээгээд тодорхой энэ асрах сувилах гэдэг юм дээр энэ үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг нэг хувиар буулгаж байна. Нэг хувь буулгахыгаа ядаж 0.3-ыг нь авч үлдээд, 40 наснаас дээш насны хүмүүс бүгдээрээ асрах сувилгааны даатгалыг төлье. 20 жилийн дараа тэр даатгалаараа гэртээ сувилгаа үйлчилгээ авдаг ийм тогтолцоогоо хэдүүлээ хийгээд өгье өө. Өнөө маргаашдаа хадгалж байгаа боловч нөгөө талаараа энэ бол даатгалын сангийн хуримтлалыг тогтвортой хуримтлалыг бий болгоно. Мөн 10-15 жилийн дараа тэтгэвэрт гарах гэж байгаа өнөөдрийн 45-тай, 50-тай хүмүүст хэрэг болох юмаа гэдгийг би бас зориуд хэлмээр байна. Энэ тал дээр Ерөнхий сайд бас та энэ зүйл дээр анхаарч өгөөч ээ гэдгийг хэлмээр байна.

Насыг бас асуудал дээр болон тэтгэврийг бодох дундаж энэ хувилбар дээр бас бодох асуудлууд байна аа. Би энийг хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжчихээд бас хувилбар танилцуулъя гэж бодож байна. Нэмэлт...

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Одоо энэ тэтгэврийн шинэчлэл реформ гээд бараг хэдэн жил ч ярьчхав. 2024 онд тэр нийгмийн даатгалын багц хууль баталсан байна. Нэг алхсан. Гэхдээ ер нь ингээд нэг ийм сонгуулийн циклийн өмнө дандаа нөхөн төлүүлнэ ээ гээд л. Тэгээд л янз бүрийн органик хуулиар дамжуулаад ингээд тухайлсан зарим зарим бүлгүүдийн насыг хойшлуулаад, урагшлуулаад яг үнэндээ ингээд сэглээд хаячихсан юм байна лээ. Тэгэхээр цаашаа энэ нийгмийн даатгалын сан орлого олоод зарлагаа бууруулах ямар ч бололцоо байхгүй. Тэгэхээр тэр ахмадуудаас асуухаар миний ингээд тэтгэврийн зөрүү 5 жилийн дараа гарсан хүнтэй харьцуулахад минийх бага байна шүү дээ. Миний тэтгэвэр яагаад бага байгаа вэ гэвэл 1991 онд намайг 40 настай байхад тэтгэвэрт гаргачихсан юмаа. Тэгээд эрт гарчихсан учраас багаар тогтоолгочихсон гээд ингээд байдаг. Тэгэхээр ерөөсөө л энийг энэ сонгуулийн циклийн өмнө дандаа ингэж сэглэж хаясаар байгаад ийм л нөхцөл рүү ингээд оруулчихжээ. Тэгэхээр энэ дуусдаггүй яриаг дуусгах нь манай Засгийн газрын бодлого, татвар ч гэсэн өнөөдөр батлагдлаа. Тэгээд дуусдаггүй л яриа. Энэ тэтгэвэр ч гэсэн. Энэ бол одоо үнэнийг хэлж байгаа юм энэ тэтгэврийн энэ шинэчлэлээр бол.

Тэрнээс биш яах вэ 9 сард нэг бүгдийг нь нэг 15 хувь нэмлээ шүү гээд ороод ирж болно. Тэгэхдээ дахиад л нөгөө бухимдал. Насыг нь урд хойно нь оруулчихсан ингээд нөхцөл байдал чинь ийм байгаа шүү дээ гээд л ингээд л эхэлнэ. Тийм учраас бид нар ерөөсөө цаашдаа нэг л хуулиар асуудлыг шийддэг болох ёстой. Тэр нэг янз бүрийн хуулиудаар дамжуулж тэр тэтгэврийг насыг нь урагшаа хойшоо тавьдгийг болиулах хэрэгтэй гэдгийг л хийж байгаа. Тийм учраас энэ баталгаат тэтгэвэр гэдэг бол гараанаас гаргах гэж байгаа нь юу вэ гэхээр нөгөө ажилласан жилийг урамшуулах гэж байна шүү дээ. Тэгэхээр ялгамжтай тогтоогоод эхлэхээр хүмүүсийн тэтгэвэр ялгаатай тогтоно. Тэр зөрүү үүсээд байгаа 140 мянган хүнийг шийдээд эхлэхээр тодорхой асуудал ялгамжтай тогтоод эхэлнэ. Тэгээд ер нь өөрөө нөгөө нийгмийн даатгалын санд шимтгэл төлөөч ээ гэдэг ийм хөшүүргүүдийг хэрэглээд эхлэхээр бол энэ чинь нөгөө зарлага буурна аа л гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм биш учраас хүн болгон, салбар болгон өөрөө тэтгэврийн насыг наашлуулж өгөөч ээ л гэдэг яг үнэндээ. Яагаад гэхээр угаасаа 5 жилийн дараа гарлаа гээд тэр тэтгэвэр өндөр тогтохгүй юм чинь эртхэн гаръя гэдэг бодол илүү давамгайлна шүү дээ. Хэрвээ илүү олон жилийг нь жил болгон 4 4 4 хувиар нь нэмээд яваад эхэлбэл нэмэгдэнэ шүү дээ. Цалингийн 72 хувь болгочихвол нэмэгдэнэ тиймээ. 1.5-ыг 2 хувийн нэмэгдэл хийгээд эхэлбэл нэмэгдэнэ. Тэгэхээр ийм бодит одоо хөшүүргүүдийг хийгээд эхлэхээр энэ сангаа цаашаа аварна. Дээрээс нь хагас өгөгдөл рүү шилжинэ, хувийг нь нэмбэл тэтгэврийн сантай болно, тэнд шимтгэл төлбөл татвараас чөлөөлнө. Бүх талын хөшүүргийг хийж байна.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ ээ. Эрдэнэбат гишүүн үгээ хэлье.

С.Эрдэнэбат: Хуулийн төслийг яаралтай хэлэлцэх нь зөв өө зөв. Энэ шударга тогтолцоог 1 сарын өмнө ч билүү хийхээс өөр арга байхгүй. Энийг одоо үзэл баримтлалын хувьд бол одоо энэ хаврын чуулганаараа шийдээд, ахмад настнуудад хүлээлт үүссэн энэ тэтгэвэр тэтгэмж нэмэх нэг талаар бол хохирсон маш олон ахмад байгаа юмаа. Тухайн үедээ шударгаар олон жил төлчхөөд тэгээд дээд таазаар хязгаарлагдаад олон ахмадууд бол хохирсон байдаг юм. Энийг зайлшгүй засаж байж дараа дараагийн нэмэгдлүүдийг шийдээд явахгүй бол хоцорсон нэг жил тутам л улам холдуулах ийм зүйлийг авчрах учраас энийг бол дэмжиж байгаа.

Гэхдээ бас асуух анхаарах ёстой асуудлууд байна аа. Тухайлбал үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн сан гээд яг ний нуугүй хэлэхэд бараг зарцуулдаггүй, тэгээд баахан хадгалсан, тэгээд одоо сүүлдээ шууд огцом ингээд бууруулъя гэдэг дээр би жоохон эргэлзэж байгаа. Энэ зүйл дээрээ бас эргэж хараарай. Тэрнийхээ ядаж нэг 0.5 хувь 50 хувийг нь гэдэг юм уу ирээдүйдээ дахиад энэ тэтгэврийн сангийн хүндрэлээс сэргийлж, тэр асрах сувилах гэдэг ийм зүйлийг бол оруулж ирэх ийм саналтай байна. Энийг бол одоо хэлэлцүүлгийн шатанд одоо нэмээд явчих боломжтой болов уу гэж би бодож байна аа.

Ер нь бол нэг 35 жил төлсөн эмэгтэй, 40 жил төлсөн эрэгтэй тэтгэвэрт гарах эрхийг нь л өгчих хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй бол зөвхөн нас ингээд хараад байхаар 20 жил, 25 гэдэг нь бол зарим нь бага төлөнгүүтээ насандаа хүрэнгүүтээ авдаг. Гэтэл 30, 40 жил төлөөд огт тэтгэврээ авч чадахгүйгээр нас барчихсан хүмүүс ч гэсэн хохироод байгаа маш олон хүн байгаа юм шүү дээ. Ийм зүйлийг бид нар маш тодорхой болгох юм бол энэ тэтгэврийн даатгал төлөхгүй байгаад байгаа маш олон хүн чинь аяндаа орж ирнэ ээ гэдгийг бол хэлмээр байна аа.

Ингээд нийгмийн хэлэлцүүлэг гэдгийг зөвхөн багш гэлтгүй байх уу энэ бол тодорхой төлөөлөл буюу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл бусад байгууллагуудаасаа бас би саналыг нь авсан болов уу гэж би бодож байна. Хэрвээ аваагүй бол энэ асуудал дээрээ зарчмын зарим асуудал дээр нь саналыг нь аваарай гэдгийг хэлмээр байна аа.

Тэр жил нэмэх асуудлыг ер нь бол одоо сүүлийн 5 жилийнх нь төлчхөөд байгаа тэр цоорхойг хаах гээд өмнө нь арай чадаагүй юм. Тухайлбал жилд огцом 10 дахин өсгөдөг тэгж тэтгэврээ төлсөн мэтээр энэнээс болоод л асуудал үүсээд

байгаа учраас энийг яг жирийн шударга төлж байгаа иргэдийг хохироохгүйгээр тодорхой надад бол санал бий. Жилд тодорхой дээд тал нь тийм хувиар өссөн өсгөж төлж болно оо гэдэг тэр хувилбарыг манай ажлын хэсгийнхэн болон Гэр бүл, хөдөлмөр нийгмийнхэн судалж үзээрэй. Би бас саналаа өгчихье гэж бодож байна аа.

Ингээд хуулийг бол одоо дэмжиж байна. Тэгээд ахмадууд маань мөн одоо ахмадын асуудал яриад байгаа гэж хараад байгаа. Яг өнөөдөр 10 жилийн дараа, 15 жилийн дараа, 20 жилийн дараа тэтгэвэрт гарах хүн энэ хуулийг хараад шударга юм байна, би еще илүү шударгаар төлье, илүү ихийг төлье, буцаагаад үр өгөөжтэй байдлаар авъя гэдэг нь баталгаатай байх ёстой. 4, 4 жилээр ч гэдэг юм уу тодорхой хугацаанд ингээд өө энэ болохгүй байна гэдэг байдлаар энийг сэвээд саваад байж бас болохгүй асуудал байгаа юм. Тийм учраас эдгээр өөрчлөлтүүд бол маш их хүлээлттэй асуудлууд байгаа гэдгийг хэлмээр байна аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүнд баярлалаа. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт үгээ хэлье алга байна. Батбаярын Жаргалан гишүүн алга байна, Цэндийн Баатархүү гишүүн алга байна аа. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг Баасан гарагийн 10 цагаас нэгдсэн байдлаар явуулна аа. Санал хураалтыг хойшлууллаа.

22.3 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арван хоёр.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна аа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир танилцуулна. Таныг индэрт урьж байна аа.

Т.Аубакир: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, хөтөлбөр, тэтгэврийн даатгалыг олон давхарга тогтолцоонд шилжүүлэх, тэтгэврийн тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог сайн дурын нэмэлт хэлбэрээр дэмжин, ахмад настан, олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх, даатгуулагчийг илүү олон жил хөдөлмөрлөж шимтгэл төлөхийг урамшуулах, санхүүгийн зах зээлийг дэмжих зорилт тодорхойлсон. Иргэд сайн дурын үндсэн дээр хуримтлал үүсгэж нэмэлт эх үүсвэрээс тэтгэвэр авах сонирхол нэмэгдэж байгаа боловч энэхүү харилцааг зохицуулсан бие даасан хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна аа. Энэ нь хувийн тэтгэврийн тогтолцоонд хамрагдаж байгаа иргэдийн эрх зөрчигдөх эрсдэлийг бий болгож байна. Түүнчлэн, хүн амын насжилт, дундаж наслалтын өсөлтөөс үүдэлтэй хөдөлмөр эрхлэх хугацаа уртсаж байгаатай холбогдуулан

иргэдийг цалин орлоготой байх үедээ бүрэн хуримтлал бүхий хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд хамруулж, зөвхөн улсын тэтгэврийн даатгалын сангаас гадна олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна аа.

Энэ хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн холбогдох төр, хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангаж хувийн нэмэлт тэтгэврийн анхдагч хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төслийг 11 бүлэг 49 зүйлтэйгээр шинэчлэн боловсрууллаа.

Хуулийн төсөл нь Монгол Улсад тэтгэврийн олон давхарга тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгагчийн болон төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг, чиг үүргийг тодорхойлох, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох, маргаан шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хамгаалах зэрэг зохицуулалтыг тусгасан болно оо.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн хувийн нэмэлт, тэтгэврийг нэг удаа 5-аас 10 жилийн хугацаанд мөн насан туршдаа авах, мөн тэтгэврийн наснаас өмнө хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэврээ тогтоолгон авах эрхтэй бөгөөд нас барсан тэтгэврийн хуримтлалаа өвлүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ ээ.

Ажил олгогчийн тухайд ажилтныхаа нийгмийн хамгааллыг дэмжсэн хүний нөөцийн шинэ бодлого хэрэгжүүлэх, ур чадвартай ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулах, байгууллагын нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн бүтээмжээ нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна аа. Мөн даатгал тэтгэврийн сангуудын хөрөнгө урт хугацаанд өссөнөөр дотоодын хөрөнгийн зах зээлд урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болж, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой юмаа.

Иймд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Төслүүдийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого хөтөлбөрт тэтгэврийн даатгалыг олон давхаргат тогтолцоонд шилжүүлж, ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төслийг баталснаар хувийн тэтгэврийн сангууд бий болж, ахмад настан нэмэлт тэтгэврийн орлоготой болох, эдийн засагт хөрөнгө оруулалтын урт хугацааны эх үүсвэр бий болж хөрөнгийн зах зээлийг дэмжих, ажил олгогч ажилтны хооронд тогтвор суурьшилтай хөдөлмөрийн харилцаа үүснэ ээ гэж үзсэн байна аа.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг баталснаар улсын төсөвт 262.8 тэрбум төгрөгийн зардал шинээр үүснэ ээ гэж хууль санаачлагчид үзжээ. Хуулийн төслийг ди парламент цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн саналыг авсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа ажилтан ААНБ-ынхаа нэмэлт тэтгэврийн хөтөлбөрөөс гадна бусад хувийн тэтгэврийн сангийн хөтөлбөрт хамрагдаж болох эсэх ажил олгогчийн НДШ төлөх тэтгэвэр тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр тэтгэврийн даатгалын 17 хувийн шимтгэлийг үе шаттайгаар хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх, хамгийн эрсдэлгүй баталгаатай Засгийн газар болон нийслэлээс гаргасан бонд зэрэг санхүүгийн хэрэгслийг худалдаж авахдаа хөрөнгө оруулалтын менежментийн компаниар заавал дамжуулахгүй байх. Нэмэлт тэтгэврийн сангийн баталгаат өгөөжийн талаар Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж буй даатгуулагчид үүсэж болзошгүй эрсдэл хувийн тэтгэврийн сангийн эрсдэлийн удирдлага, татварын зохицуулалт, дундаж орлоготой зээлтэй иргэд нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэх боломж, орлогын ялгаатай байдал, ирээдүйд тэтгэврийн зөрүү үүсгэж болзошгүй талаар тус тус асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа НДШ төлөх тэтгэвэр тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн нь хэт өндөр байгаа талаар, ажил олгогчийн шимтгэл төлөх цалинд дээд хязгаар тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаяр хуулийн төсөлд шимтгэл хуваалцах зарчмыг тусгах, тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг үе шаттайгаар хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломжийг нээх. Хамгийн эрсдэлгүй баталгаатай төрөөс гаргаж буй бондыг хөрөнгө оруулалтын менежментийн компаниар заавал дамжуулахгүй байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийг оновчтой удирдах, гадаад улсын өндөр өгөөжтэй үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, Засгийн газрын бондод хөрөнгө оруулалт хийх боломжийг нээх талаар.

Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Даатгуулагч иргэдийн эрх ашгийг хамгаалах, өвлөгдөх харилцааг зохицуулах дундаж насжилт нэмэгдэж байгаа энэ үед эмэгтэй хүн тэтгэвэрт гарснаас хойш 20 жил, эрэгтэй хүн 16 жил ажиллах чадамжтай байгааг харгалзан тэтгэвэрт гарах насны хязгаар болон хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгож буй асуудлыг тэтгэврийн шинэчлэлийн хүрээнд авч

үзэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганмаа Иргэдийн хуримтлалыг зах зээлийн эрсдэлээс хамгаалах, Хувийн тэтгэврийн сангийн сайн засаглал үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, Хувийн тэтгэврийн сангууд гэрээгээр тохирсон баталгаат өгөөжийг өгч чадахгүй нөхцөлд зохицуулалт хийх. Ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт эдийн засаг, санхүүгийн мэдлэгийн түвшнээс үл хамааран ажилчид хамрагдаж, үр өгөөжийг нь хүртдэг байх. Сангийн сайн засаглалыг бэхжүүлж хараат бус ТУЗ-ийг байгуулах, гишүүдэд санхүүгийн боловсрол олгох, мэдээ мэдээллээр тогтмол хангах талаар, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара Дундаж орлоготой иргэдийг сайн дураараа хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдахад төрөөс татварын дэмжлэг үзүүлэх, иргэдийн хуримтлалын үнэ цэнийг хамгаалах талаар. Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийг хөрөнгийн аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын эрсдэлийг удирдах төрийн хяналтын талаар тус тус санал хэлсэн.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 69.6 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 65.2 хувийн саналаар, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 69.6 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүнд баярлалаа.

Ажлын хэсэг Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Ванчингийн Рэнцэнханд түрүүний ажлын хэсэг хэвээрээ байна. Дээрээс нь нэмэгдээд Алтанбулагийн Нинжин Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх, Жаргалсайханы Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны

Эрх зүйн хэлтсийн дарга, Түдэвийн Цэрэнбадрал Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн дэд дарга, Зоригтын Батболд Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч. Ийм ажлын хэсэг нэмэгдсэн байна шүү.

Улсын Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бүрэн гүйцэд хариулт өгөх ёстой. Худлаа мэдээлэл өгөх, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлгүй хандахыг хориглодог хуулийн хариуцлагатайг сануулъя та бүхэндээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал болон байнгын хорооны санал дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна, Болдын Уянга гишүүн алга байна, Жудагийн Баярмаа гишүүн алга байна, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна, Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль орж ирж байна аа. Энэ бол маш чухал ийм хууль болж байгаа. Иргэд маань ирээдүйдээ зориулсан энэ тэтгэвэр хуримтлалыг бий болгох ийм сайн боломж бүрдэж байна аа. Тэгээд энэ хууль дээр нэг шинэ санаа орж ирж байна. Энэ бол хувийн тэтгэврийн сан гээд. Энэ тэтгэврийн сангаар дамжиж иргэд маань ирээдүйнхээ тэтгэвэр тэтгэмжийн сангаа хадгаламжаа бий болгох нь л дээ. Тэгэхлээр энэ ер нь ямар байгууллагаар зохион байгуулагдах юм бэ? Санхүүгийн байгууллага байх юм уу, ХХК байх юм уу, банк бус байх юм уу? Тэгээд энийг хяналтыг хэрэгжүүлэх байгууллага нь Монгол банк юм уу, СЗХ юм уу? Хэрвээ СЗХ бол энэ олон байгууллагуудыг хянаж барах уу? Энэ яагаад гэхлээр яг энэ хадгаламжтай ижилхэн, банктэй ижилхэн энэ маш том цар хүрээтэй ийм байгууллагуудын бүтэц бий болох гээд байна шүү дээ.

Тэгээд 2 дугаарт нь бол энэ даатгалаар хамгаалагдсан байх ёстой. Ингэж олон талаар хамгаалагдаж байж хяналтын бүтэц нь сайн, системийн хувьд сайн хамгаалагдсан даатгалаар хамгаалагдаж байж энэ урт удаан хугацааны ирээдүйн хадгаламжийг эргүүлээд өгөөжтэй нь иргэддээ буцааж өгөх энэ бүтэц бий болох юм шүү. Иргэдийн зүгээс бас нэг юм асуучихмаар байна. Иргэд маань ирээдүйдээ зориулаад хадгаламж бий болгох гэж байгаа. Тэгэхлээр энэ маань хэр дижитал системд холбогдсон байгаа юм бэ? Өнөөдөр бид нар нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувийн буцаалтыг өгч байгаа иргэддээ. Гэтэл зарим иргэд маань НӨАТ-ынхаа 2 хувийн буцаалтыг авдаггүй иргэд байдаг. Энэ 2 хувийнхаа буцаалтыг авдаггүй иргэд маань энэ хувийн тэтгэврийн сан дээрээ энэ хуримтлалаа энэ авахгүй байгаа НӨАТ-ыгаа шууд холбох ийм дижитал холболтын систем нь бий болох боломж байна уу гэдэг энэ 2 асуултыг асууя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. Ерөнхий сайдын микрофон.

Н.Учрал: Энэ 2020 онд Их Хурлын гишүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн концепцтой ижилхэн хувийн нэмэлт тэтгэврийн хууль. Яах вэ бид бол одоо өнгөрсөн хугацаанд бол ТББ-ын статустайгаар компани ААН байгууллагууд, иргэдийн нөгөө ажилтнуудынхаа тодорхой шимтгэлийг хуримтлуулаад ингээд өнөөдрийг хүртэл явж ирсэн олон банк санхүүгийн байгууллагууд ч гэсэн байгаа. Эхнээсээ тэтгэвэрт ч гараад эхэлчихсэн байгаа. Энэ хувийн нэмэлт тэтгэврийн хууль батлагдсанаар одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөрөнгө оруулалтын сангийн хууль байна.

Тэгэхээр Хөрөнгө оруулалтын сангийн хуулиар хувийн тэтгэврийн сан бол өөрөө хөрөнгө оруулалтын сан байна. Хөрөнгө оруулалтын сан СЗХ -ноос зөвшөөрөл авна. Хөрөнгө оруулалтын санг хэн удирддаг вэ гэвэл хөрөнгө оруулалт менежментийн компани удирддаг.

Тэгэхээр Хөрөнгө оруулалт менежментийн компани тус санг удирдаад тэр санд шимтгэл төлж даатгал төлж байгаа тэр даатгуулагч нартаа энэ бүтээгдэхүүнүүдийгээ санал болгодог. Жишээ нь одоо та цалингийнхаа тэдэн хувийг манайд хийвэл жилд тэдэн хадгаламжийн хүү 16, 17 биш гэхэд ядаж нэг 10 хувийн өгөөж тооцно оо. Жилд эрүүл мэндийн ийм бүтээгдэхүүнд хамрагдана аа, жилд нэг оношилгоонд орно оо ч гэдэг юм уу ийм байдлаар. Ингээд хувийн тэтгэврийн сангууд хоорондоо өрсөлддөг. Тийм учраас Хөрөнгө оруулалтын сангийн хуулиараа Санхүүгийн зохицуулах хороо өөрөө хяналт тавьж ажилладаг. Тэгэхээр хувийн тэтгэврийн сан бол СЗХ-ноос зөвшөөрөл авна аа гэсэн үг.

Тэгэхээр одоо бол хувийн тэтгэврийн сан гээд бие даасан хуульгүй мөртөө Хөрөнгө оруулалтын сан байгуулаад ийм тэтгэврийн хуримтлал аваад ингээд шимтгэлээс нь аваад өгөөжийг нь бодоод ажиллаж байгаа ийм ТББ-ын ч статустай, компанийн ч статустай ийм байгууллагууд байдаг. Хууль гарснаараа бол хувийн тэтгэврийн сан бол өөр давхар үйл ажиллагаа явуулахгүй, зөвхөн тэтгэврийн сангийн үйл ажиллагаа явуулна. СЗХ-нд бол хяналтаа хэрэгжүүлнэ. Тэгээд нөгөө Кастодиан банк бүртгэл хяналтаа тавина. Гол нь нөгөө ажилтан шимтгэлээсээ хувийн тэтгэврийн санд төлье өө гэж хүсвэл тийшээ төлсөн хэсэг дээр нь татварын хөнгөлөлт чөлөөлөлт өгч байгаа байхгүй юу. Энүүгээрээ л маш том дэвшил.

Тэгэхээр энэ бол нөгөө албан журмын биш сайн дурын хэлбэртэй цалингаасаа хувийн тэтгэврийн санд өгье өө гээд. Тэгэхээр энэ тэтгэврийн тогтолцооны 3 тулгуурт байх бодлогын шинэ ийм тулгуурыг бий болгож байна гэсэн үг. Тэгэхээр нийгмийн даатгалын сангаас ч тэр, хувийн тэтгэврийн сангаас ч тэр тэтгэвэр авах бололцоог бүрдүүлж байгаа юм.

С.Бямбацогт: За тодруулъя Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Энэ чинь иргэдийн иргэдээс татан төвлөрүүлэх гээд байна л даа хөрөнгө. Тэгэхлээр СЗХ бол одоо хөрөнгийн зах зээлийг хариуцаж байгаа, банк бусуудыг хариуцаж байгаа. Банк бус бол өөрийнхөө хөрөнгөөр эргэлддэг. Тэгэхлээр тэр утгаараа СЗХ -нд хяналтын хувьд хамаагүй ер нь хөнгөн байдаг. Одоо энэ иргэдийн хөрөнгийг татан төвлөрүүлэх гэж байгаа болохлоор энэ бол маш эрсдэлтэй. Өмнө нь бид нар энэ санхүүгийн хоршоо гээд маш олон хүмүүсээс ингээд хөрөнгө төвлөрүүлээд дампуурсан ийм одоо туршлага гашуун туршлага байгаа. Тэгэхлээр энэн шиг юм болчих вий. Монгол банк дээр энэ хяналтыг бол маш сайн тавьдаг. Энэ арилжааны банкнуудын энэ хяналтынхаа функц дээрээ анхаараач ээ л гэж хэлж байгаа юм.

Тэгээд НӨАТ дээр бас асуух гээд байгаа байхгүй юу. Тэр НӨАТ бид нар ерөөсөө хэрэглэдэггүй хүмүүс байж байгаа шүү дээ. Тэрийг уул нь автоматаар нь холбочихвол зөвхөн энэ сан руу ч биш ЭМД-ын сан руу ч юм уу тиймээ аль нэг хэрэгцээ...

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Ер нь хувийн тэтгэврийн сан бол хөрөнгө оруулалтын сан. Тэгэхээр Хөрөнгө оруулалт менежментийн компани удирдаад эхлэхээрээ СЗХ-нд хяналтаа тавиулаад ингээд явна. Тэнд бүртгүүлнэ. Тэгэхээр хувийн тэтгэврийн санд шимтгэл төлөөд хамрагдаж байгаа даатгуулагч нар бол өөрөө тэр Засгийн газрын бонд авах юм уу, үнэт цаас авах юм уу, хувь хувьцаа авах юм уу гэдгийг бол өөрөө тэрэн дээр санд оролцогч нар бол өөрөө шийдвэр гаргалтад оролцоно гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр мэдээж тэр сан чинь өөрөө ашигтай ажиллахын тулд тэр хөндлөнгийн менежментийн компани нь тэр хөрөнгийг удирдана. Тэгээд ер нь бол ингээд иргэн болгоны хуримтлалтай тийм санг л тийм ассет менежмент хийнэ гэдэг ийм л үг. Тэгэхээр яах вэ даатгуулагчид нэмэлт баталгаа л өгч байна гэсэн үг.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс нэмж хариулъя. 4 дүгээр микрофон. Нэрээ хэлээд хариулаарай.

Т.Цэрэнбадрал: Гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. СЗХ Цэрэнбадрал. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан зарчмын дагуу тэтгэврийн сангийн хяналт зохицуулалтыг үндсэндээ Төв банк болон СЗХ-той ижил чиг үүрэг бүхий байгууллагууд нь хяналт тавьж ажилладаг. Манай хуулийн төсөл дээр СЗХ хяналт тавихаар оруулж ирж байгаа. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 39 хөрөнгө оруулалт менежментийн компани байна. Үндсэндээ энэ дээр хөрөнгө бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сангийн нийт хөрөнгийн дүн 700 орчим тэрбум төгрөг байгаа.

Тэгэхээр манай хөрөнгө оруулалт менежментийн компаниудын хувьд бол харьцангуй одоо хөрөнгийн менежмент хийж тэр тал дээр бол зохицуулалтад ороод явж байгаа, нэлээн туршлагатай болж байгаа гэж харж байгаа. Зүгээр Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс энэ хууль гарснаар хөрөнгийн зах зээл дээр нэлээн томоохон өөрчлөлт, урт хугацааны хөрөнгө бий болно гэж харж байгаа. Бидний тооцож байгаагаар бол одоо ойрын 5 жилийн хугацаанд ойролцоогоор 1.1 их наяд орчим төгрөгийн хуримтлал бий болох болов уу гэсэн тийм хүлээлттэй байгаа. Энэ тооцооллоо хийхдээ бид нар Монгол Улсад өнөөдрийн байдлаар сая 100 сая 15...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя.

Т.Цэрэнбадрал: Өнөөдрийн байдлаар сая 15 мянган нийгмийн даатгал төлдөг иргэн байна. Манай дундаж цалин 2 сая 877 мянга байгаа. Үүнээс дунджаар олон улсын жишгийн дагуу хувь хүн 2 хувь, ААН 2 хувиа төлөөд явах юм бол одоо ойрын 5 жилийн хугацаанд 1.5 их наядын ийм хуримтлал үүснэ ээ гэсэн ийм тооцоолол байна. Энэ нь манай нийгмийн хамгааллын одоо энэ асуудлыг шийдэхээс гадна хөрөнгийн зах зээл дээр урт хугацааны хөрөнгө бий болох, эргээд хөрөнгийн зах зээл хөгжихөд ихээхэн ач холбогдолтой гэж харж байгаа.

С.Бямбацогт: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: 2020 онд 7 сард би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар томилогдоод тэгээд бараг анхны уулзалтуудын нэг Улсын Их Хурлын гишүүн Учрал залуу гишүүнтэй уулзалт хийгээд яг энэ тэтгэврийн хувийн нэмэлт тэтгэврийн хуулийн тухай ярьж байсан юм. Тэгээд тухайн үедээ болохлоор Учрал гишүүн яг энэ хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын энэ асуудлыг ярьж байхдаа албан журмаар цуглуулж хуримтлуулж байгаа 17 хувийн тэтгэврийн шимтгэлийн 4 хувийг энэ хувийн нэмэлт тэтгэврийн сангуудаар тэнд хуримтлуулаад, тэгээд одоо энэ

менежментийг нь хийх ийм саналыг гаргаж байсан. Тэгээд мэдээж одоо салбарын яам бол албан журмаар цуглуулж байгаа хөрөнгийг хувийн хэвшлүүдэд өгч болохгүй шүү дээ. Тэгээд энэ дээр нэлээд маргаж мэтгэлцэж тэгээд дундын санал дээр санал нэгдэж ямар ч байсан энэ хуулийг батлах нь зүйтэй. Энэ бол одоогоор ийм тэтгэврийн сангуудыг үүсгэсэн байгаа тэтгэврийн сангуудыг татварын бодлогоор дэмжье.

Нөгөө талдаа улсын энэ тэтгэврийн системийг тодорхой хэмжээнд хагас хуримтлалын энэ тогтолцоо руу шилжүүлъя. 17 хувийн тэтгэврийн шимтгэлийн 2 хувийг нь буюу ажилд нь нэг хувь, ажил олгогч нэг хувь, бодитой мөнгөөр нь хуримтлуулъя, эхлэлийг нь тавья гэдэг ийм шийдвэрийг тухайн үедээ гаргаж байсан. Тэгэхээр энэ хувийн нэмэлт тэтгэврийн сангууд байхгүй биш байгаа. Бараг сүүлийн 20 жил ч үйл ажиллагаа явуулж байгаа Нэйшнл Лайф гэж компани ч байна. Глобал Голомт банкны үүсгэж байсан анхдагч энэ тэтгэврийн ууган сан байна. Хамгийн олон хүн хамрагдаж байгаа Ард тэтгэврийн данс байгаа. Ард тэтгэврийн дансанд одоо бараг 90 мянган хүн байгаа билүү, 100 хэдэн мянган хүн байгаа билүү. Хамгийн олон хүн хамрагдсан ийм сан байдаг. Энэ бол урт хугацааны буюу Лайф иншуренс гэдэг агуулгаараа урт хугацааны амьдралын даатгал гэдгээрээ яг энэ тэтгэврийн энэ хуримтлал Санхүүгийн зохицуулах хорооны энэ даатгалын төрөлдөө ороод явж байгаа.

Үүнийг бол албан ёсоор хувийн нэмэлт тэтгэврийн зохицуулалтад оруулаад тэгээд эдгээр ААН байгууллагуудыг татварын бодлогоор дэмжиж өгч байгаа ийм хууль аа. Би энэ асуултыг яагаад асуусан бэ гэхлээр нэг талдаа ажил олгогч төлж байгаа шимтгэлийг дээд хэмжээг нь хязгаарлаагүй байгаа одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар. Тэгээд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг Ерөнхий сайд Учралд өргөн барьсан. Үүн дээрээ эхний ээлждээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэн дүнгээр ажил олгогчийн төлөх дээд хэмжээг нь хязгаарлаж байгаа юм байна аа. Энэ бол яах вэ юу ч үгүй байснаас ядаж 12-оор эхлээд ингээд аажим бууруулж явах нь зүйтэй.

Тэгэхээр яг гол асуух гээд байгаа юм юу вэ гэхлээр 2021, 2022 онд энэ нийгмийн даатгалын багц хуулиудыг тухайн үедээ 5 багц хуулийг өргөн бариад тэгээд 2023 онд батлагдаад тэгээд 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн. Одоо 2026 он. 2 жилийн хугацаанд тухайн үедээ та бидний тохирч байсан 1, 1 хувийг бодитоор хуримтлуулъя гэж байсан тэр мөнгөн дүн маань яг бодитой хуримтлагдаагүй байна аа. 2 жилийн хугацаанд нэрийн дансан дээр бас яг тэр жишээлбэл миний төлсөн 2 хувь бол яг бодитоор мөнгөн дүнгээрээ бичигдээгүй байгаа байхгүй юу.

Тэгээд би энийг хаанаас хараад байна вэ гэхлээр Е монгол дээрээ дахиад төрд байгаа миний мэдээллийг хараад энэ дотроо миний тэтгэврийн мөнгөн хуримтлал гэж харахлаар 847 мянган төгрөг байгаад байгаа байхгүй юу. Уг нь ингээд 2 жилийн хугацаанд сар бүр би 2 хувиа ингээд л хуримтлуулах ёстой шүү дээ. Тэгэхээр энийг мөнгөжүүлэх үү...

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Яах вэ ер нь 2024 оны энэ нийгмийн даатгалын багц хуулиар бол 2 хувийг хуримтлалд шилжүүлээд тэгээд мөнгөжүүлнэ гээд зорьсон. Гэтэл өнөөдөр нэг 380 орчим тэрбум төгрөг л ингээд хуримтлагдсан. Тэрнээс хойш энэ чинь нэг

хуримтлалаа нэмж чадаагүй мөнгөжүүлээгүй байна л даа. Тэгээд энэ юутай холбоотой вэ гэхээр тогтолцооны хувьд бүтэн хийж чадаагүй. Нэг ёсондоо бол тэр хуримтлалыг тэр хөрөнгө оруулалт менежментийн компаниар ч юм уу удирдуулаад бодитойгоор тэр өгөөжийг нь тэр даатгуулагчид өгч чадаагүй. Жишээ нь ер нь бол одоо кинон дээр гардаг нөгөө Итгэлт баян бол дэрнийхээ дор мөнгөө хийгээд хадгалдаг. Одоо орчин цагт тэгээд бэлэн мөнгийг хадгалаад суудаг хүн гэж байхгүй шүү дээ. Тэгээд тэр мөнгийг яаж үржүүлэх вэ, яаж эргэлдүүлэх вэ л гэж бодно.

Тэгэхээр нөгөө байгаа мөнгөөрөө байгаагаар нь байлгаад байвал илжирнэ гэж кинон дээр ч хүртэл гардаг, тэр Итгэлт баян хэлдэг шүү дээ. Тэгэхээр бид нар байгаа хөрөнгийг яаж удирдах вэ гэдгийг бодож чадахгүй л яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр манай эдийн засаг чинь өөрөө энэ нэг ийм банк суурьтай, нэг тулгууртай, санхүүгийн зах зээл дээр бас нэг ийм 2 тулгууртай болох ёстой юм. Тийм учраас бид энэ салбар дээр бодит дэмжлэг үзүүлье ээ. Энэ бол өөрөө энэ хувийн нэмэлт тэтгэврийн хууль. Тийм учраас тэр татварын хөнгөлөлтийг нь үзүүлчихье гэж бодоод энэ хуулийг оруулж ирсэн.

Тэгэхээр үнэхээр даатгуулагч өөрөө шимтгэлээсээ би хувийн тэтгэврийн сандаа өгье өө гэвэл тэнд төлж байгаа дээр нь татварын хөнгөлөлттэй байгаад эхлэхээр тэрийг ХОМК нь удирдахаар жилд нэг 10-15 хувийг ч юм уу ингээд өгөөжийг нь тооцох байхгүй юу. Тэр нь өөрөө бонд авах уу, үнэт цаас авах уу. Тухайн үед Ариунзаяа гишүүнийг сайд байхад бол тухайн үед юу гэж хэлсэн бэ гэхээр ажилтан 2 хувь, ажил олгогч 2, 2 хувь, 17 хувийн. Ингэж чадвал жилд бараг тухайн үед бол 300-гаад тэрбум тэр хөрөнгийн зах руу гарах гэж байгаа байхгүй юу. Тэр 300 тэрбумаар нөгөө хувьцаа авах, бонд авах, үнэт цаас авах, санхүүгийн захыг дэмжих гэж байгаа юм. Тэгэхээр энэ удаа бол албан журмаар гэхээсээ илүүтэйгээр сайн дурынх нь байдлаар тийшээ төлсөн дээр нь татварын хөнгөлөлт үзүүлчихье.

Төр бол өөрөө харин нийгмийн даатгалын сангаас нэг хувиа шимтгэл төлөхийг нь зөвшөөрчихье. Ингэвэл Засгийн газар 0.5 хувийг нь хийчихье. Тэгэхээр 1.5 хувь бол хуримтлал руу байна. Хуримтлалыг бид нар өгөөжийг тооцно. Тэгэхээр одоо цаашдаа бол зүгээр байгаа юмыг байгаагаар нь байлгаж болохгүй. Тийм учраас Баялгийн сан бол ер нь цаашаа нөгөө ерөөсөө л өгөөжийг тооцдог зарчим руу шилжье ээ. Тэгэхээр яг таны хэлж байгаа шиг ер нь баялгийн сангаа хөрөнгө оруулалтын сангийн хэлбэр лүү явуулъя. Шаардлагатай бол Норвеги шиг тэтгэврийн сан ч болж болно шүү дээ. Хүн болгонд хүрэх загвар нь.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Яг одоо л чихэнд чимэгтэй юм сонсогдож байгаа байхгүй юу. Яагаад гэхлээр яг бусад улс орнууд чинь баялгийн хуваарилалтаа хийхдээ яг энэ тэтгэвэр лүү нь шилжүүлээд тэртээ тэргүй хүн болгон юу гэдэг юм тэтгэвэртээ гарах нь ойлгомжтой учраас ингээд орон сууц, эрүүл мэнд, боловсрол гэхээсээ илүүтэй эдгээр гурваа хэрэгцээгээ хангачихсан байгаа бол би тэтгэвэр хэлбэрээрээ авмаар байгаа байхгүй юу.

Яг одоо түрүүний миний хэлсэн Чингис хаан нэрийн дансан дээр жишээлбэл одоо хүн болгон дээр 300 мянган төгрөг, 306 мянган төгрөг байгаад байна. Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал дээр ядаж одоо энэ байгаа 847, 850 мянган төгрөгөө бараг энэ 2-ыг ингээд энэ сан дээрээ нийлүүлээд тэгээд төрөөс олгож байгаа ЭТТ-н 1072 ч байдаг юм уу эс үгүй бол бусад одоо энэ баялгийн хуваарилалтуудыг энэ

сан дээрээ миний нэрийн дансан дээр нь мөнгө нь нэгдэж яваад, тэгээд тэрнээсээ төр өөрөө хөрөнгө оруулалтаа хийгээд надаа өгөөж боддог. Эс үгүй бол одоо би хаашаа хаашаа хөрөнгө оруулахыг надаас асуудаг бол би тэрнийгээ шийддэг. Тэгээд тэр нь арвиждаг. Улс орон хамтдаа хөгждөг, бүх нийтээрээ баялгаасаа хүртдэг тийм болмоор байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Энэ хуулийг анх ярьж байхад би Үйлдвэрчний холбооны ерөнхийлөгч байж байсан. Тэгээд Учрал Ерөнхий сайд тухайн үед Их Хурлын гишүүн ажлын хэсгийг ахалж байсанг би санаж байна. Уул нь тэр үед бас эхлээд яваад эхэлчихсэн байсан бол өдийд бас нөгөө шударга тогтолцооных нь шударга эргээд төлсөн юмаа буцаагаад авдаг гэдэг энэ зүйл маань бас нэг 5 жил өнгөрчихсөн овоо хуримтлалтай болох байсан болов уу гэж бодож байгаа юм. Гэхдээ одоо оройтох юу байх вэ. Энийгээ одоо хийх ёстой.

Түрүүний Ариунзаяа гишүүний хэлдэг тэр баялгийн сангаас тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт урамшууллыг нь холбож өгөх нь их чухал аа. Энийг бол одоо хийх ёстой. Бүүр цаашлаад манай даатгалын сан маань бас ч үгүй боломжийн болоод ирсэн болбол одоо энэ 17 хувийн төлж байгаагийн бас нэг 0.5, 1 хувь ч гэдэг юм уу энэ хувийн даатгалын ер нь тухайн даатгуулагч нарт сонголтыг нь өгөөд ер нь оруулах хэрэгтэй байгаа юм. 100 хувь өвлөж авдаг, өөрөө тэрийгээ хэрэглэдэг. Тэгээд насныхаа сүүлд гадаад, дотоод жагсаал хийж миний тэтгэвэр нэм гэж орилохоосоо илүүтэйгээр өөрийнхөө хуримтлуулсан юмыг өөрөө зарцуулаад байдаг ийм зүйл байгаа.

Тэгэхээр одоо хувийн тэтгэвэр дээр би яах вэ буцааж авах энэ тэр гэдэг дээр та хэдийн сонголтын хувьд шууд 100 хувь буцааж авах гэдэг байдлаар энэ тэр оруулж байна уу, эс үгүй бол тэрийг нь тухайн компаниуд нь эрхийг нь олгочоод байна уу гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарх нь хэчнээн компани ААН-ээр хязгаарлаж байгаа вэ? АНУ-д зах замбараагүй анх олгоод бараг мянган хувийн тэтгэврийн даатгал байж байгаад бүгдээрээ нөгөө дампуурах асуудал руу орж байсан. Тэгэхээр тооны хязгаарлалт дээр яаж анхаарч байна вэ? Түүнийг хянах хяналтын зөвлөл ТУЗ гэдэг тал дээр яг ямар хамгаалалтыг хийж байгаа вэ? Энийг бол иргэд бас нэлээн асуугаад байгаа юм. Олон компаниуд бол менежмент сайтай компаниуд ажилчдаа алдчихсан гэхийнхээ оронд тэтгэврээр нь барьж аваад уячхаж байна шүү дээ. Ажилчдадаа хувьцаа олгоод бариад авчхаж байна, нэмэлт тэтгэврээр нь бариад авчхаж байна. Би чамд тогтвортой ажилласан жил болгонд чинь 1 хувийн, 2 хувийн хувийн тэтгэвэр бий болно оо. Чи тэтгэвэрт гараад манай компаниас гарвал хангалттай гарна аа гэж.

Тэгээд энийг манай улс болон бусад салбарууд энийг итгэл үнэмшлийг нь бий болгоод өгөх юм бол энэ бол маш том хөрөнгө оруулалтын сан бөгөөд ирээдүйдээ бид нар зөвхөн улсын тэтгэврээс хараад суугаад байх биш хувийнхаа тэтгэврээр нөгөө гадаадад аялдаг, зугаалдаг, орон сууц авдаг, өвдөж зовбол тэндээсээ авчихдаг ийм сан болгох боломжтой. Тийм учраас одоо яг хувийн тэтгэврийн даатгалын сангууд хэчнээн төгрөг байгаад байна вэ? Буцааж олгосон тийм тэтгэвэрт гарчихсан хэчнээн хүн байна вэ тэрийгээ яг яаж олгож байгаа тийм кэйсүүдийг манай нийгмийн даатгалынхан судалж үзсэн үү гэдэг дээр тодруулаад асуучихъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ерөнхий сайд.

Н.Учрал: Яах вэ ер нь хувийн нэмэлт тэтгэврийн хууль батлагдахаар хөрөнгө оруулалтын сан байгуулагдаж байгаа учраас энэ хувийн тэтгэврийн сан бол өөрөө яг Хөрөнгө оруулалтын сангийнхаа хуулийн дагуу л явна. Тэгэхээр энэ Хөрөнгө оруулалтын сангийн хуульд зааснаар бол тэр ТУЗ-ийн гишүүдийн шалгуур шаардлага хуульдаа бий. Хараат бус гишүүн хэн байх вэ гэдгийг бол тодорхой заасан. ТУЗ бол 9-өөс багагүй гишүүнтэй. Тэр шаардлагуудыг бол яг Хөрөнгө оруулалтын сангийн ТУЗ-ийн зарчмын дагуу. Яагаад гэхээр хөрөнгө оруулалтын сан байгуулахад бол СЗХ-оос өөрөө зөвшөөрөл авдаг. Тэгэхээр тэр шаардлагуудаараа л явна гэсэн үг.

Тэгэхээр тэр санг бол мэргэжлийн хөрөнгө оруулалтын менежментийн компани удирдана гэдэг бол хаа хаанаа хариуцлагажиж байгаагийн л илэрхийлэл. Тэрнээс өнөөдөр бол жишээ нь Голомтын тэтгэврийн ууган сан гээд л байна. Тэр Ардын сан байна. Зөндөө л сангууд байгаа. Зарим компаниуд энийг хуулийн хүрээнд биш зүгээр нэг ийм даатгалын компанийн хэлбэрээр, ТББ-ын хэлбэрээр ингээд л зохион байгуулаад л байсан. Тэгэхдээ эдгээр хүмүүс тэтгэвэрт гарвал гарахад сан хэрвээ эрсдэлд орвол яах вэ гэдэг дээр одоо хүртэл хуульгүй л яваад байгаа. Тэгэхээр одоо энэ хувийн тэтгэврийн санд шимтгэл төлсөн иргэдийг бас хамгаалах гэж байгаа бодлого энэ Хувийн тэтгэврийн сангийн эрх зүйн орчин, статус бий болж байгаа явдал мөн. Энэ эрсдэлээс сэргийлэх юм.

Тэгэхгүйгээр одоо ингээд зүгээр нэг ийм компанийн хуулийг бариад эсвэл нэг ийм ТББ-ын заримаар статустайгаа ингээд явуулаад байвал энэ өөрөө маш их эрсдэл дагуулах учраас хуулийг нарийвчлан зохицуулж өгч байгаагийн гол шалтгаан бол одоо бас хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэрт гарчихсан хүмүүсийгээ бодож байгаагийн илэрхийлэл.

Тэгээд Эрдэнэбат гишүүн бол МҮЭХ-ны Ерөнхийлөгч байхад бид хоёр 2020 онд энэ асуудлыг ярьж байсан. Өнөөдөр ч гэсэн тэр нэвтрүүлэг яригдаж байна. Тэрнээс хойш 6 жил өнгөрсөн. Тэгээд 6 жил өнгөрөхөд энэ хувийн тэтгэврийн санг байгуулаад явсан байсан бол өнөөдөр санхүүгийн захыг ямар бодитойгоор дэмжих байсан бол, ямар олон хүмүүс тэтгэвэрт гарах байсан бол оо гэж бодоход бол цаг хугацаа хайран. Тэгээд ажлын хэсэг ажиллаж анхааралтай ажигласан энэ 10, 20 жилд одоо тэгээд юу эсийг хийж бүтээх боломж байсан. Тийм л учраас энэ дуусдаггүй яриагаа л дуусгачихъя л гэж би зориод байгаа юм. Тэгээд манай Засгийн газар энэ асуудлуудыг барьж аваад ингээд зоригтой энэний ард гарна.

Ерөөсөө тэтгэврийн шинэчлэл гэдэг бол давхар хөрөнгийн зах зээлийг дэмжих бодлого шүү. Энэ тэтгэврийн шинэчлэл гэдэг бол иргэн болгонд яг хүрэх ганц суваг шүү. Тийм учраас тэр Үндсэн хуулийн 6.2 газрын хэвлийн баялгийн дийлэнхийг ард түмэн эзэмшинэ. Тэр Баялгийн сангийн хуулийг амилуулах цор ганц тогтолцоо бол тэтгэвэр юм байна лээ. Тэгэхээр энэ зарчмаар...

С.Бямбацогт: Ажлын хэсэг СЗХ нэмж хариулъя.

Т.Цэрэнбадрал: СЗХ Цэрэнбадрал. Хувийн тэтгэврийн сангийн хувьд хуульд хуулийн төсөлд заасны дагуу ХХК хэлбэртэй байгуулагдахаар туссан байгаа. Тодорхой хуулийн төсөлд хязгаарлагдмалд туссан. Тухайлж хэлэх юм бол нэг

хувьцаа эзэмшигчдийн хувьцаа эзэмшигч дээд хязгаар нь 20 хувь байгаа. Өөрөөр хэлбэл одоо 5 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчид хамтарч хувийн тэтгэврийн санг байгуулах байгаа. Мөн дүрмийн сангийн хувьд 15 тэрбум төгрөгийн лимитийг тавьж өгсөн байгаа. Мэдээж хувийн тэтгэврийн санг үүсгэн байгуулж байгаа энэ төлөөлөн удирдах зөвлөлийн компани дээр мэргэжлийн тодорхой шалгуурууд тавигдаж байгаа. Тухайлж хэлэх юм бол одоо төлөөлөн удирдах зөвлөлийн хувьд дийлэнх гишүүд нь хараат бус байх, тэр дотроо тэтгэвэр хувийн тэтгэврийн санд хамрагдсан иргэд буюу гишүүдийн төлөөлөл 3-аас доошгүй байх зэрэг одоо энэ хязгаарлалтуудыг бол оруулж өгсөн байгаа.

Ер нь бол зүгээр хувийн тэтгэврийн сангийн гол хөрөнгийн удирдлага менежмент аюулгүй байдлын тал дээр нэлээн асуудал гарч байна. Энэ дээр нэгд энэ хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийн удирдлагыг Хөрөнгө оруулалт менежментийн компани буюу сан...

С.Бямбацогт: Ганзориг гишүүн асуултаа асууя.

П.Ганзориг: Өнөөдөр Монгол Улсын бас энэ тэтгэврийн тогтолцоонд томоохон шинэчлэл хийх хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль хэлэлцэж байгаа нь маш чухал үйл явдал гэж харж байна. Тэгээд өнөөдрийн байдлаар Монгол Улсын тэтгэврийн тогтолцоо ямар нөхцөл байдалтай байгааг нэг 3-хан тоогоор тодорхой бид нар харж болно.

Нэгд, нийгмийн нэг тэтгэвэр авагчид ноогдох НДШ төлөгч өнөөдөр бол 2, 1, 2-ын харьцаатай байгаа. Энэ маань 2050 он гэхэд буюу 25 жилийн дараа 1, 1 болох яг одоогийн байгаа тогтолцоогоороо хэрвээ явсан тохиолдолд ийм хүнд нөхцөл байдал руу явах ийм бас тооцоолол бий.

2-т, 2026 оны байдлаар нийгмийн даатгалын санд бас төсвөөс зарлага хэлбэрээр санхүүжүүлж өгч байгаа хэмжээ 1.6 их наяд төгрөг. Энэ ялгаа байхгүй 2050 он гэхэд Дэлхийн банкны судалгаагаар ДНБ-ий 5 хувьд хүрэх эрсдэлтэй гэж байгаа юм. Тэгэхээр энд бол Монгол Улсын эдийн засаг төсөв бол даах энэ боломж байхгүй.

3-т, одоогийн байгаа тогтолцоо маань нэг давхаргат тогтолцоо учраас ганцхан суурь тэтгэвэртэй. Тэгээд Монгол Улсын иргэд маань ажил хөдөлмөрлөж байгаад тэтгэвэрт гарлаа гэхэд амьжиргааны баталгаажих түвшинд тэтгэвэр нь хангагдаж чаддаггүй, амьдралынх нь чанар орлого бол эрс дорддог. Тэгэхээр энд бол хэдхэн параметр өөрчлөөд зогсохгүй энэ олон давхаргат тэтгэврийн тогтолцоо руу шилжиж энэ тогтолцооны шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай тулгарсныг харуулж байгаа юмаа.

Тийм болохоор олон давхаргат тогтолцоо руу шилжиж суурь тэтгэвэр, нэмэлт тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн ийм тогтолцоонууд оруулж ирж, ирээдүйд бас тэтгэвэрт гарч байгаа хүмүүс маань олон орлогын эх үүсвэртэй болж явж байгаа нь маш чухал юмаа гэдгийг тодотгож хэлье 1-д.

2-т, түрүүн бас гишүүд дурдаж байна. Яалт ч байхгүй энэ хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо үндэсний хуримтлалыг бий болгодог. Үндэсний хуримтлал маань энэ хөрөнгө оруулалтын сан тэтгэврийн сангуудаар дамжаад бий болохоороо хөрөнгийн зах зээл дээр институционал хөрөнгө оруулалтууд эрчимждэг. Өнөөдөр

Монгол Улсын санхүүгийн зах зээл ер нь бол нэг баганатай, банкны одоо ерөнхийдөө үндсэн 85 хувийг нь банкнууд бүрдүүлдэг ийм тогтолцоотой явж байгаа. Тэгэхээр энэ үндэсний хуримтлалууд үүсээд, хуримтлал үүсээд хөрөнгө оруулалтын сан үүсээд явах юм бол энэ маань цаашдаа зээлийн хүүг бууруулах макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулахад хүртэл чухал нөлөөтэй. Иргэдэд одоо олон тэтгэврийн ач холбогдлоос гадна ийм чухал нөлөөтэй гэдгийг бас тодотгож хэлье.

Тэгээд өнөөдөр нийт Их Хурал маань бас олон чухал асуудлаар нийтдээ 14 цаг хуралдаж энэ хувийн нэмэлт тэтгэвэр, нийгмийн даатгалын ерөнхий хууль суурь тогтолцоонууд дээр нь нэмээд бид нар татварын багц хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа. Ингэснээрээ бизнес эдийн засгийн орчиндоо нийтдээ татвар дээр гээд тэгэхэд чинь одоо 2.5 их наяд төгрөгийн шууд давхар эффектээр бол 4 их наяд гаруй төгрөгийн дэмжлэг үзүүлэх...

С.Бямбацогт: Тодруулж асуултаа гүйцээж асууя. Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Өнөөдрийн чуулганаар Засгийн газраас бизнес, эдийн засаг, бизнесийн орчинд чухал нөлөөтэй хуулиудыг өргөн барьсныг хэлэлцлээ. Мөн Их Хурал бас ингээд 14 цаг гаруй ингээд тасралтгүй хуралдаж энэ чухал хуулиудыг энэ хаврын чуулганд батлахаар явуулж байгаад талархал илэрхийлмээр байна. Тэгээд энэ Татварын багц хууль дээр гэхэд одоо 2.5 их наяд төгрөгийн шууд эффект, давхар нөлөө нь бараг 4 их наяд гаруй төгрөгийн ААН ард иргэдийн татварын ачаа дарамтыг хөнгөлж байгаа гээд энэ чухал шийдвэрүүдийг ингэж сайн хуралдаж Их Хурлын гишүүд маань идэвхтэй оролцож гаргаж байгаад талархлаа илэрхийлье.

Ялангуяа энэ татварын багц хууль дээр 3 ч удаа ажлын хэсэг гарч ажилласан, ахалж ажилласан Хассуурийн Ганхуяг гишүүндээ бас талархал илэрхийлье ээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Ер нь үг хэлчихлээ тийм ээ. Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Би түрүүн нөгөө боловсролын ерөнхий хууль юмаа асуухад манай Бямбацогт дарга намайг загнаад байна л даа. Нуур амгалан бол нугас амгалан ч гэх шиг. Яасан юм нуурыг чинь би самраад байгаа юм уу. Танд та ер нь миний хэлэх үгийг заахгүй шүү дээ наанаасаа. Би өөрийнхөө эрх үүргийнхээ хүрээнд нийгмийн бүлгийн төлөөлөл учраас тухайн салбарынхаа асуудлыг ярьж байгаа. Тэрнээс би энэ Монголын төрийг самаръя гэж яриагүй харин ч сүүлийн 30 жил та нарын самарсан юмыг чинь засах гээд яриад байна. Та нар самраа биз дээ, би самарсан юм уу. Битгий ийм сонин юм яриад бай за юу? Би ер нь танд загнуулах гэж энэ Их Хурлын гишүүн болоогүй шүү.

Ер нь бол боловсролын салбар чинь багшийн хомсдолд орчхоод байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр энэ ядаж энэ тэтгэврийнх нь насан дээр та нар анхаарал хандуулаач. Аягүй муухай тийм хүний төлөө биш зөвхөн хувийн эрх ашиг өөрсдийгөө л хамгаалах юмаа хийдэг шүү дээ та нар. Хэзээ та нар нэг их ард иргэдийнхээ төлөө ажиллаад байгаа юм ер нь. Ажиллачихсан бол ер нь ийм гоё ийм асуудал гарах уу ер нь. Тэгчхээд одоо зүгээр Их Хурлын гишүүний үг хэлэх эрхэнд хүртэл халдаад суухгүй шүү та наана аа.

Монгол Улсад дундаж цалинтай иргэд өрхийн орлогынхоо дийлэнхийг өдөр тутмын хэрэглээндээ зарцуулж байгаа нөхцөлд энэхүү сайн дурын хуримтлалын

тогтолцоонд бодитоор хэдэн хүн хамрагдана гэж Засгийн газар тооцсон бэ? Хамрагдалт бага байвал энэ хууль зөвхөн өндөр орлоготой хэсэгт үйлчлэх санхүүгийн бүтээгдэхүүн болж хувирах ийм юм дүр зураг харагдаж байна. Энэ дээр нэг хариулт өгөөрэй.

Тэгээд иргэдийн хуримтлуулсан мөнгөн хөрөнгөд төр ямар ч баталгаа гаргахгүй атлаа иргэдийг олон 10 жилийн турш мөнгөө төвлөрүүлэхийг уриалж байгаа нь иргэдийн эрсдэлийг хувийн хэвшилд шилжүүлж байгаа юм шиг харагдаад байна. Тэгээд 20-30 жилийн дараа сангийн хөрөнгө алдагдал хүлээвэл хариуцлагыг нь хэн хүлээх вэ? Төр даахгүй гэхихсэн байна шүү дээ энэ хууль дээр чинь. Тэгээд хэн хүлээх вэ? Энэ 2 асуултад хариулаад өгөөрэй. Тэгээд энэ Монголын багш нар өдөр шөнөгүй надаас асуугаад байгаа шүү. Тэрнээс би энд бужигнуулаад самраад байгаа юм байхгүй шүү. Тэрийг би хатуу хэлмээр байна.

С.Бямбацогт: Би уул нь та чинь асуугаад миний хууль хэлэлцэж өг, би багш нарын төлөө хүн гээд. Тэгэхээр нь би тэгээд л таны асуултад хариулсан юм. Таны асуултад хариулсан юм. Тэгээд хариулахаар тэгээд хүн загналаа гэх юм тийм. Та өөрөө тэгээд үгүй энэ чинь урд талдаа 50 нас, 55 нас гэж тавьчихаад Монгол Улс багшийн хомсдолд орчихлоо гээд яриад суугаад байна. Улам л залуу тэтгэвэрт нь гараад улам л их хомсдолд орно шүү дээ. Энэ логикоо ойлгож байгаа юм уу та. Ойлгож байгаа юм уу та? Үнэхээр туршлагатай чадвартай ард түмнийхээ төлөө ард түмэндээ хүүхдэдээ заая гэж бодож байгаа туршлагатай сэтгэлтэй багш нарыг тийм үү 60 нас, 65-д нь ажлыг хүсвэл ажиллуулж болно биз дээ. Тийм уян хатан юмаа ярьчих гээд хэлэхээр тэгээд ерөөсөө л учир зүггүй өөрийнхөө хэлж байгаа үгний утгыг ч ойлгохгүй тэгээд л логикгүй юм ярих юм. Би загнасангүй ээ таныг. Би таныг огт загнасангүй. Бакир сайд хариулъя.

Т.Аубакир: Тийм тийм манай Мөнхтуяа гишүүн багш нарын төлөө л санаа зовоод хэлэх нь зөв л дөө тэгээд ойлгож байна. Нийтийн эрх ашиг тийм. Энэ нийтийн эрх ашиг гэснээс энэ одоо эдгээр хүмүүсийн хуримтлалыг хамгаалах тэр мөнгийг алдахгүй байх хамгаалалтуудыг бид нар хийж өгөх ёстой л доо. Тэгээд энэ хувийн нэмэлтийнхээ хуулиар бид нар тухайн тэр ХК-ийн буюу сангийн нэг хүний эзэмших хувийг 20 хувь байна аа. Үүнээс бид нар хэтрүүлж болохгүй ээ гээд тийм эрсдэлүүдээ ингээд хуваах ёстой тиймээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн санд та асууж байна. Илүүтэй ингээд чинээлэг хэсэг рүү чиглэх юм биш үү гэж. Өнөөдөр яг 135 мянган иргэн 80 орчим тэрбум төгрөгийн төвлөрөл үүсгэчихсэн. Нөгөө 135 иргэн маань яг одоо үнэхээрийн чинээлэг том том компанийн захирал уу гээд харахаар жирийн л олон хүнтэй компанид ажилладаг ажилтнуудаа нөгөө тогтвор суурьшилтай ажиллуулах баталгаатай тэтгэвэртэй болох хүрээнд хэрэгжүүлээд эхэлчихсэн байгаа юм. Бид нар эрх зүйн орчныг нь бий болгочих юм бол энэ маань сая манай санхүүгийнхэн хэлж байна тиймээ. 2 их наяд орчим хүрэх бололцоотой. Зарим улс орнуудад ДНБ-дээ 100 хувь тэнцэхүйц хүртэл хувийн нэмэлт тэтгэврийн сангуудтай болчихсон байна шүү дээ. Энэ маань энэ нийгэмд өөр салбаруудад хөрөнгө оруулалт хийх шинэ хөрөнгө оруулалтын сангийн эх үүсвэртэй болно оо.

Бид нар одоо яг таны санаа зовж байгаа саяын хүмүүсийн мөнгийг хамгаалах юм уу гэдэг шиг яг 130 мянган хүнд даатгуулчихсан ч гэсэн яг тэд нарыг хамгаалах хууль эрх зүйн орчин байхгүй байгаа. Бид нар ингээд бий болгож өгөөд магадгүй одоо 3 сая 600 орчим мянган хүнтэй 5, 10 жилийн дараа магадгүй одоо сайхан өөр

хөрөнгө оруулалт хийх ийм эх үүсвэр болох байх аа гэсний үндсэн дээр бид нар энэ анхдагч энэ анхны энэ хувийн нэмэлтийнхээ хуулийг сангийн хуулийг оруулж ирж байгаа юмаа.

С.Бямбацогт: Мөнхтуяа гишүүн тодруулъя.

Ц.Мөнхтуяа: Махны үнэ нэг хонь 600 мянга хүрээд, ахмадын тэтгэвэр 700 мянга байгаа тиймээ. 100 мянган төгрөгөөр ахмадуудаа яаж амьдар гэж Монголын төр хэлээд байгаа вэ. Энэ асуудлаа яаж зохицуулах гэж байна. Ахмадууд тэтгэврээ нэмүүлье гээд зогсонгуут нэг ийм зальжин маягийн юм гаргаж ирээд ийм юм битгий хийгээрэй гэж би бас та хэддээ анхааруулж хэлмээр байна. Ер нь бол энэ ахмадууд чинь аргаа бараад л энэ гадаа ирээд зогсоод байгаа шүү дээ. Энэ хүмүүсийг одоо яах вэ хэдүүлээ. Та нар ингээд л нэг худлаа аргацаасан өнөө маргаашийн хурал хуй ажлын хэсэг гэж явтал хэчнээн ахмад тэнд турж үхээд өлбөрч дуусаж байна. Энэ асуудал дээрээ та нар нэг хариуцлага хүлээмээр байна ер нь.

С.Бямбацогт: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Тийм тийм аргацаасан гэж хэрвээ аргацаах байсан бол сая 500 мянга болоход нь бид нар сая 500 мянган төгрөг яаж болгох вэ гэдэг аргыг хайх байсан байх л даа. Ингээд аргацаахгүйгээр бид нар энэ ерөөсөө тогтолцоогоо реформ хийе л дээ гээд энэ хуулийг оруулж ирж байгаа юм л даа. Та маш зөв асуулт асуулаа. Ядуурлаа яах юм бэ гэж. Одоо бид нар тэтгэвэр нийгмийн даатгалын зүйл гэдэг ганцхан сангаас авч байгаа мөнгөнөөсөө илүү нөгөө ахмадуудын тэтгэврийг зарцуулж байгаа, илүүдээ өргөн хэрэглээний барааны үнийг өсөөд байгаа үед нь өргөн хэрэглээний барааны үнийг зохицуулдаг механизмаа төр давхар ажиллуулахгүй л бол энэ барааны үнэтэй өрсөлдөөд л, уралдаад л, цалин тэтгэврээ нэмээд л байх юм бол энэ болохгүй ээ.

Тийм учраас давхар нөгөө бодлогуудаа авч байх ёстой. Нөгөө талдаа ахмадууд тэтгэвэр аваад юунд зарцуулж байна гэдэг судалгаануудыг хийсэн. Хамгийн их зарцуулж байгаа зүйл маань эм. Ядаж байхад чанаргүй. Уугаад байдаг, уугаад байдаг үйлчилдэггүй, ханиад нь зүгээр болдоггүй тиймээ. Энэ Батшугар сайдтай бид нар Засгийн газар дээр ярилцаж байгаа. Эдгээр цогц арга хэмжээгээ авч үзээд Батшугар сайд аа...

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Одоо байнгын хорооны санал. Хуулийн төслүүдийн талаар байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үгээ хэлнэ үү. Мэндбаярын Мандхай гишүүн алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Энэ удаагийн хаврын чуулганаар олон чухал хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэж, Улсын Их Хурлаар эцэслэн баталж байна. Өнөөдөр Засгийн газраас өргөн барьсан Татварын багц хуулийг хэлэлцэхэд нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 50 саяыг 400 сая болгохыг дэмжиж, энэхүү саналыг ард иргэд ААН-ийнхээ төлөө гаргасан эрхэм гишүүддээ юуны өмнө талархлаа илэрхийлье ээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг би дэмжсэн байр суурь дээрээс саналаа хэлнэ. Дэмжиж байгаа үндэслэлээ 3 зүйл дээр гаргаж хэлье гэж бодсон юм.

Өнөөдөр 2025 оны статистик дүнгээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689 мянга, дундаж хэмжээ 893900 төгрөг байгаа. Энэ нь хөдөлмөрийн хөлсний дундаж цалин хөлстэй харьцуулах юм бол нэг 32.3 хувийг нь эзэлж байна л даа. 32.3 хувьтай дүйцэж байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 1952 онд баталсан 102 дугаар конвенцод зааснаар бол өндөр насны тэтгэвэр бодох доод хэмжээг дундаж цалин хөлсний 40 хувиас багагүй байна аа гэж заасан. Бидний тэтгэвэр тооцож байгаа арга аргачлал дээр 45 хувиар тооцож байгаа. Арга аргачлалаараа конвенцын шаардлагыг хангаж байгаа юм шиг мөртөө өнөөдөр бодит байдал дээр амьдралд авч байгаа тэтгэвэр дундаж цалин хөлсөнд эзэлж байгаа хувь хэмжээ 40 хувиас бага байна.

Тэгэхээр зайлшгүй энэ зөрүүг арилгаж бодит хэмжээнд хүргэхийн тулд дундаж тэтгэврийг багадаа сая 91900 төгрөгт хүргэж байж өнөөдөр энэ конвенцын шаардлагыг хангаж бид 40 хувьдаа барих юмаа. Тийм учраас энэ дундаж тэтгэврийг нэмэгдүүлэх бодлогыг энэхүү хувийн нэмэлт тэтгэврийн хуулиар бас оруулж ирж байгаад нь дэмжиж байгаа.

2 дахь асуудал бол НДШ-ийн төлөх дээд орлого ажилтнаас буюу иргэнээс өөрөөс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээтэй байгаа. Өөрөөр хэлбэл 7 сая 920 мянган төгрөгөөс төгрөгөндөө НДШ төлж байгаа. Ийм хэмжээний цалин авч байгаа хүн бол өнөөдөр нэг 96.5 мянган даатгуулагч байна аа гэж үзэж байгаа. Тэгэхээр бид Хувь хүний орлогын албан татварыг НДШ-ийг хувь хүнээс суутгахдаа хязгаар тогтоож байгаа мөртөө ажил олгогчийн талаас төлж байгаа дээр ямар нэгэн хязгаар байхгүй байгаа нь өнөөдөр бизнес эрхэлж байгаа олон бизнес эрхлэгчдэд, олон ажил олгогч нарт дарамт болж байна аа. Тийм учраас энийг хязгаар тогтоож тодорхой түвшинд хязгаарлаж орж ирж байгаагаараа бизнес эрхлэгчдэд, ажил олгогчдод НДШ бол татвар биш юмаа. Энэ бол одоо ажилтнаа бодсон жишээлбэл төлөх ёстой, нийгмийн хариуцлагын шимтгэл юмаа гэдгийг тогтоож өгч байгаа дэмжлэг болж байгаа гэдгийг нь хэлэхийг хүсэж байна.

3 дахь асуудал хэдийгээр хувийн тэтгэврийн даатгалын тогтолцоо Монгол Улсад үүссэн байгаа ч гэлээ гэсэн өнөөдөр хууль эрх зүйн орчин бүрдээгүй өнөөдрийг хүрсэн байна. Хууль эрх зүйн орчин байхгүй байгаа ч гэлээ гэсэн олон ААН-үүд өөрсдийнхөө ажилчдад тэтгэврийн сан байгуулаад, тэтгэврийн даатгалын хэлбэрээр хуримтлал үүсгүүлж байна. Ажилтнаас ч авч байна, байгууллага ажилтнаа урамшуулаад олон жил ажилласан ажилтандаа энэ санг үүсгээд дундын хуримтлал үүсгээд явж байгаа ААН-үүд олон байна. Нөгөө талдаа манайд даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа олон даатгалын компаниуд даатгалын бүтээгдэхүүн болгоод нэмэлт тэтгэврийн даатгалын бүтээгдэхүүнийг гаргаад үүнд олон даатгуулагчид хөрөнгө мөнгөө хадгалуулаад явж байна.

Өнөөдөр олон улсын жишгээр тэтгэврийн даатгалын сан бол маш том хөрөнгө оруулалтын сан болсон байна. Энэ сангаар эдийн засгийн эргэлтэд оруулдаг, өсөж үрждэг, арвиждаг хамгийн том хөрөнгө оруулалт хийж байгаа сан болсон гэдгийг 2023 оны дэлхийн хөрөнгө оруулагчдын нийт хөрөнгө оруулалтын 46 хувийг тэтгэврийн даатгалын сан эзэлж байна аа гэдгийг энэ статистикаар харж болж байгаа юм. Тийм учраас өнөөдөр ийм хэмжээний хуримтлалыг үүсгэчихсэн байгаа эрх зүйн зохицуулалт нь байхгүй байгаа энэ даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахын тулд зайлшгүй энэ даатгалын хууль хэрэгтэй юмаа гэдгийг...

С.Бямбацогт: Үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа. Одоо хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн санал хураалтыг маргаашийн чуулганаар явуулна аа.

22.56 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арван гурав.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүн 2026.06.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт оруулах өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна аа.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын хуулиудаар өнөөдрийн чуулган амьсгалж байна. Миний хувьд 7 гишүүний хамтаар нийгмийн даатгалын хуулийн ганцхан өгүүлбэр өөрчлөх жижигхэн хуулийн төсөл өргөн барьсан юмаа.

Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Батлут, Мөнхбаясгалан, Нарантуяа-Нара, Түвшин, Тэмүүлэн, Эрдэнэбат, Энхнасан зэрэг гишүүдтэй хамт энэхүү нийгмийн даатгалын хуулийн нэмэлт өөрчлөлтийг өргөн барьсан. Энэ ажил маань бол Эрдэнэбат гишүүнээр ахлуулсан ахмадын хөгжлийг хуулийн хэрэгжилтийг цаашлаад санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн зүгээс боловсруулж өргөн барьсан хууль. 2024 онд ахмадын хөгжлийг дэмжих нэлээд олон хуулиудыг бас өмнөх Улсын Их Хурал баталсан. Энэ дотроо ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн түүнчлэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд батлагдсан байдаг аа.

Эдгээр нь юу юм бэ гэхлээр Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар заалтын 145.4 дээр байгаа өмчийн хэлбэр үл хамаарч ААНБ 50-иас дээш ажилтантай бол ажиллагсдынхаа 2 хувьд нь ахмадыг ажиллуулна аа, ажиллуулах үүргийг хүлээж байгаа. Нөгөө талдаа ахмадын ахмад настны хуулиар нийгмийн даатгалын хуульд чиглэл өгч, тэтгэвэр авч байгаа ахмад ажил хөдөлмөр эрхлэх юм бол өөрийн хүсэлтээрээ тэтгэврийн шимтгэл төлөхгүй байж болно оо. Нэгэнтээ тэтгэвэр тогтоолгочихсон бол тэтгэврээ аваад тэгээд цалин хөлснөөсөө тэтгэврийн шимтгэлийг ажилтан 8.5 хувь, ажил олгогч 8.5 хувь ингээд 17 хувийн шимтгэлийг төлөхгүй байж болно оо гэсэн ийм сонголтыг хуулиар нээлттэй болгосон. Энэ нийгмийн даатгалын хууль дээр тухайн үедээ өөрчлөлт орохдоо ганцхан зүйл заалтаар хязгаарласан нь 50-аас, 20-иос 7.6 буюу 5.1.1-ээр хязгаарласан байгаа юм. Энэ нь болохлоор 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн 65 нас хүрсэн ахмадад үйлчилнэ ээ гэсэн ийм хуулийн зохицуулалт.

Мэдээж өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа хүмүүс бол 65 нас гэлтгүй наана нь ч гэсэн хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа маш олон ийм бүлгүүд байдаг. Хамгийн наад захын жишээ нь малчны тэтгэвэр, малчны тэтгэвэр одоо ердийн наснаас 5 жилийн наана тогтоолгодог. 4 хүүхэдтэй

ээжүүдийн хувьд ч гэсэн наана тогтоолгож байна. Хүнд нөхцөлд ажиллаж байгаа мөн түүнчлэн онцгой нөхцөлд ажилласан тэгээд цэргийн тэтгэвэр тогтоолгосон маш олон өөр насны бүлгийн ахмадууд өндөр насны тэтгэвэр тогтоолгож байна аа.

Тэгээд энэхүү хуулийн төсөл маань ямар өөрчлөлтийг бий болгож байна вэ гэхлээр нийгмийн даатгалын хуулийнхаа яг өндөр насны тэтгэвэр гэсэн 5.1 гэсэн энэ бүлгийг бүхэлд нь хамруулаад дээрээс нь цэргийн тэтгэвэр авч байгаа иргэд тэтгэврээ тогтоолгочхоод түүний дараагаар дахин хөдөлмөр эрхлэх юм бол өөрийн хүсэлтээр тэтгэврийн шимтгэл төлөхгүй байх энэ боломжийг нь нээж өгөх ийм хуулийн төсөл.

2025 оны байдлаар ажил хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр тогтоолгосон 62.2 мянган иргэн байгаа бол эдгээрээс 33.1 мянган хүн шимтгэлээс энэ тэтгэврийн шимтгэлээс чөлөөлөгдсөн, 29.1 мянган иргэн тэтгэврийн шимтгэлээсээ чөлөөлөгдөөгүй хуулийн ийм хязгаарлалттай байгаад нас нь 65 хүрээгүй учраас тэтгэврийн шимтгэлээ хэвээр нь төлж байгаа юмаа. Тэтгэврийн шимтгэлийг хэвээрээ төлөх энэ боломжийг гэдэг юм уу энэ одоо хүсэлтээрээ хэвээрээ байгаа хүмүүс ямар боломж байдаг вэ гэхлээр шимтгэл төлсөн сар бүрд нь тухайн анх тогтоолгож байсан тэтгэвэр нь сард 0.125 хувиар нэмэгдэх ийм боломжтой байдаг. Дараа жил нь тухайн тэтгэврийн шимтгэл төлсөн сар бүрд нь 0.125 хувиар нэмэгдүүлэх ийм боломжтой.

Тэгэхээр энийг сая төгрөгөөр бодож үзэх юм бол тухайн сардаа 1250 төгрөгөөр нэмэгдүүлээд жилийн эцэстээ бол 15 мянган төгрөгийн нэмэгдэл нэмэлт тогтоолгох нь байна. Гэтэл тэтгэврийн шимтгэлээ төлөхгүй байя гэсэн энэ сонголтыг хийх юм бол тухайн сардаа жишээлбэл ажилтан 8.5 хувь гэдэг чинь сая төгрөгөөс бодвол 85 мянган төгрөг, мөн түүнчлэн ажил олгогч бас 85 мянган төгрөг. Ингээд бодитоор гар дээрээ 85 мянган төгрөгийг илүү хадгалах ийм боломж ажилтанд үлдэх нь байна. Нөгөө талдаа ажил олгогч ч гэсэн тэтгэврийн шимтгэлийн дарамтаас ангид байх боломжтой байх нь гэсэн үг ээ.

Ийм учраас эдгээр хуулийн заалтын энэ ахмадуудыг тодорхой хэмжээнд ийм юу гэдэг юм ялгаварласан байгаа байдлыг арилгах хуулийн төслийг санаачилж өргөн барьсан. Засгийн газар яг нийгмийн даатгалын хуулийг өргөн барихдаа энэ заалтыг хөндсөн байна лээ. Гэхдээ бидний хууль санаачлагчдаас арай өөр заалтаар хөндсөн байгаа буюу 5.1.1 биш 5.1.2 буюу тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй гэдэг ийм заалтаар одоо өөрчилж оруулж ирсэн байна лээ.

Тэгэхээр бидний өргөн барьсан хууль дээр 1 дүгээрт малчин орж ирж байна, эмэгтэйчүүд орж ирж байна, мөн түүнчлэн хүнд хортой нөхцөлүүд орж ирж байна, мөн цэргийн тэтгэвэр орж ирж байна аа. Тэгэхээр бидний өргөн барьсан байгаа хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг нь шийдвэрлэж өгөөд харин хэлэлцүүлгийн явцад ажлын хэсгүүдээ нэгтгэх ийм саналыг ажлын хэсгийн зүгээс гаргаж байгаа. Ингээд шигтгэснээрээ тодорхой хэмжээнд энэхүү боломжийг олон олон ахмадууддаа бий болгох боломж бүрдэнэ ээ гэж үзэж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа. Хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье ээ.

С.Бямбацогт: Баярлалаа. Төслийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах танилцуулна аа.

Ж.Галбадрах: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүнээс 2026 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчид хүн амын дунд ахлах настны тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 04 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын хүрээнд улсын төсөвт 95.8 тэрбум төгрөгийн зардал шинээр үүснэ гэж хууль санаачлагчид үзжээ. Хуулийн төслийг ди парламент мн цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтийн санал авч байгаа болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж санал хэлээгүй болно оо.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 62.5 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Галбадрах гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Басангийн Батжаргал НДЕГ-ын дарга, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн алга байна, Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн алга байна, Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна, Чинбатын Ундрам гишүүн алга байна, Лувсанжамц гишүүн алга байна, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна аа. Үг хэлэх

гишүүд байна уу? Өнөөдөр чинь нийгмийн даатгалаар ер нь амьсгалчихлаа шүү дээ тийм ээ. За үг хэлэх гишүүд алга байна. Сархадын Зулпхар гишүүн үгээ хэлье.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд та бүхэнд үдшийн мэнд дэвшүүлье. Өнөөдөр бид нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэлийн дараагийн алхам руу нь хөтлөх 3 ч хуулийг яаралтай горимоор хэлэлцэж байна. Сая бас зарим гишүүд маань энийг яаралтай оруулж ирдэг нь зөв, буруу гэсэн байр суурь илэрхийлж байна. Энэ бол байж болно. Гэхдээ нэг зүйлийг бид ойлгох ёстой. Энэ хууль бол хэдийгээр яаралтай горимоор орж ирсэн боловч яаралтай биш байдлаар, маш няхуур нарийн судалсан, олон талын ийм хэлэлцүүлэг дээр тулгуурласан байдлаар орж ирж байгаа хууль гэдгийг онцлон тэмдэглэмээр байна. Яг ордны зүүн талын хашаанд 10 сар болж байна ахмадууд маань зогсож байна. Энэ бидний нийгмийн хэлэлцүүлгийн нэг хэсэг нь тусгал нь гэж ойлгох ёстой.

Тэрнээс гадна өнгөрсөн 15 жил энэ тогтолцооны асуудлаар зөв буруу сорилт болон жишээ нь гарч байгаа үр дүнг хэлэлцсэн хэлэлцүүлгүүд болсон. Байнга судлаачдын болон шинжээчдийн бас тооцооллуудыг хэлэлцсэн тодорхой одоо хугацаанд хуулийн өөрчлөлтүүд орж ирсэн. Хамгийн ойрын хуулийн өөрчлөлт бол 2023 оны өөрчлөлт. Тухайн үед Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байсан Булгантуяа, түүнээс өмнө жишээ нь сайд байсан Ариунзаяа нар энэ хуулийг тухайн үед нь боловсруулж байсан. Залгуулаад одоо жишээ нь Энх-Амгалан сайд өнөөдрийн хэлэлцэж байгаа хуулийн үндсийг судалгааг хийж байсан бол Аубакир сайд энэ хуулийн жишээ нь шинэчлэлийг гардан хэрэгжүүлэх бодлогын шинэ саналыг оруулж ирж байна. Нөгөөтээгүүр одоо Ариунзаяа гишүүд нар хуулийн саналыг оруулж ирж байна аа.

Нэг зүйлийг бид ойлгох ёстой. Өнөөдрийн өргөн баригдаж байгаа хуулиуд бол дан ганц нийгмийн хүлээлт байгаад зогсохгүй нөгөө талдаа манай одоо жишээ нь нийгмийн даатгалын тогтолцооны өөрийнх нь маш чухал хийгдэж байгаа шинэчлэлүүдийн дараагийн алхам гэж ойлгох ёстой, дараагийн алхам. Бас энд бол их өрөөсгөл зүйлүүд их яригдаж байгаа. Бас энийг бид олон нийтэд зөв ойлголт өгөх ёстой. Нийгмийн даатгалын сан бол дампуурсан гэж ярьдаг үгүй. Нийгмийн даатгалын санд яг шимтгэл төлөөд тэндээс эрхийнхээ дагуу тэтгэвэр авдаг улсуудын тухайд бол энэ сан бүрэн ажиллаж байгаа. Тэр битгий хэл 2023 оны өөрчлөлтөөс хойш энэ сангийн удирдлага мэргэжлийн болсонтой уялдаад, сүүлийн 1 жил гарны хугацаанд сангийн чөлөөт үлдэгдлийг банканд байршуулснаар 105 тэрбум төгрөгийн орлого олсон. Энэ бол өөрөө шинэчлэлийн бас тусгал нь тодорхой түвшинд гарч байна гэсэн үг.

Хэзээ бид энийг ярьж байна гэхээр зэрэг төрөөс хариуцдаг жишээ нь тэтгэврүүд бий. 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан улсууд нөгөөтээгүүр цэргийн тэтгэвэрт гарсан улсуудын тэтгэврийг төр өөрөө хариуцдаг. Энэнтэй уялдсан байдлаар жил болгон төрөөс хариуцдаг татаас гэж хэлдэг. Татаас нэмэгдэж байгаа учраас энийгээ бас дампуурал гэж ойлгож байгаа нь өрөөсгөл шүү гэдгийг энд онцлон хэлье. Хэрвээ энэ сан дампуурчихсан байсан бол 30 жилд бидний энэ нийгмийн шинэчлэлийн, нийгмийн шилжилтийн өнөөдрийн нийгмийн хамгааллын нөхцөл байдлыг даван туулах боломжгүй байсан. Энийг бол зөв ойлгох ёстой. Мэргэжлийн түвшинд би энийг ярихгүй болбол...

С.Бямбацогт: Сүхбаатар Эрдэнэбат гишүүн үгээ хэлье.

С.Эрдэнэбат: Хууль хамтран санаачлагчийн хувьд бол ажлын хэсгээс манай ахмадууд маань тодорхой хэмжээнд ажиллаад, шимтгэлээ төлөөд одоо үндсэндээ гавьяаныхаа амралтад гарлаа гэж хэлдэг. Тийм учраас ахмад настнуудын тэтгэвэр маань харьцангуй бага байгаа учраас дийлэнх нь давхар ажил хийе гэж хүсэл эрмэлзэл дүүрэн байдаг. Нөгөө талаас ахмадуудыг ажилд авах хөшүүрэг нь цаана нь байгаа юмаа. Зөвхөн НДШ-ээс чөлөөлөх гэж байна, хөнгөлөх гэж байна гэж харахаасаа илүү ялангуяа 50 буюу түүнээс дээш настай эмэгтэйчүүд, 55, 60 настай мөн цэргийнхэн бол одоо 45, 50-даа гардаг.

Тийм учраас өөрөө хүсвэл нэгэнт нийгмийн даатгалынхаа шимтгэлийг төлөөд гарчихсан учраас эдгээр хүмүүсийг ажилд авах хөшүүрэг нь нөгөө талдаа ажил олгогч нарт бий болгож өгөх гэдэг энэ өөрөөр хэлбэл ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд ихээхэн хөшүүрэг болох хууль юмаа гэдэг энэ үзэл баримтлалаар бол одоо манай ажлын хэсгээс гишүүд маань санаачлаад, Ариунзаяа гишүүн маань бид өргөн барьсан. Тэгээд ийм учраас энэ хуулийг дэмжиж өгнө үү гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг Баасан гарагийн нэгдсэн чуулганаар явуулна аа.

23.10 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арван дөрөв.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна аа. Таныг индэрт урьж байна.

Дав.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 37 гишүүнээс 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

ХЗБХ 2026 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Алтанхуягаас төслийн 1 дүгээр зүйлийн цэргийн гэсний дараа албаны офицер ахлагч гэж нэмж төслийн дагаж мөрдөх

хугацааг хасах зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Ажлын хэсэг танилцуулъя. Монгол Улсын ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Шагдарын Үнэнтөгс, Эрдэнэцогтын Дарханцэцэг Улсын Их Хурлын гишүүний зөвлөх.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна, Баярмагнайн Баярбаатар гишүүн алга байна. Асуулт асуух гишүүд алга байна. Зарчмын зөрүүтэй саналууд байгаа. Саналаар маргааш санал хураалт явуулна.

23.13 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Арван тав.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна аа. Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч Оюунсайханы Алтангэрэл танилцуулна аа Улсын Их Хурлын гишүүн.

О.Алтангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 10 дугаар сарын 4, 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 27 дугаар захирамжаар дээрх хүрээнд хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэлээр ахлуулж, ажлын хэсгийн дэд ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа,

Мөнхбаясгалан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Баярбаатар, Баасанжаргал, Жаргалан, Хэрлэн, Тэмүүжин, Пүрэвдаваа, Үүрийнтуяа, Хосбаяр, Номинчимэг, Одонтуяа, Отгонбаяр, Ганмаа, Соронзонболд, Сайнзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Хууль зүйн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 16-ны өдөр хуралдаанаараа дээрх хууль хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулсан талаарх санал, дүгнэлтийг танилцуулж байна аа.

Гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гэр бүл, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг олон улсын чиг хандлагатай нийцүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах баталгааг нэмэгдүүлэх, гэр бүлийн гишүүдийн эрх, үүргийн тэнцвэрийг хангах, шүүхийн практикт үүсэж байгаа хүндрэл бэрхшээлийг арилгахад чиглэсэн цогц өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгахаар дараах зарчмын зөрүүтэй саналуудыг боловсрууллаа. Үүнд:

1.Хуулийн зорилго, зарчим, нэр, томъёоны зохицуулалтыг боловсронгуй болгож, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг гэр бүлийн харилцаанд баримтлах үндсэн зарчим болгон тодорхойлж, гэр бүл, гэр бүлийн гишүүн, бүтэн өнчин хүүхэд, үрчлэгч, сонирхогч тал зэрэг нэр томъёоны тодорхойлолтыг нарийвчлан тогтоож хууль хэрэглээний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

2.Гэрлэхийг хүсэгчид эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдах. Хүсвэл төрөл садангийн холбоотой эсэхээ тогтоох зорилгоор ДНК-ийн шинжилгээ хийлгэх боломжийг нээж, анх удаа гэрлэх гэж байгаа иргэдэд гэр бүлийн боловсрол олгох тогтолцоог хуульчилж, гэр бүлийн харилцаа, эцэг эхийн үүрэг хариуцлага, хүүхдийн хөгжил, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтын эрх зүйн үндсийг тогтоох.

3.Гэрлэлтийг бүртгүүлэх журам, гэрлэхэд харшлах нөхцөл байдлыг тодорхой болгож, гэрлэгчдийн эрх үүрэг, гэр бүлийн үнэт зүйлтэй холбоотой зохицуулалтыг шинэ шатанд гаргаж байна аа. Тухайлбал гэрлэгчид бие биеэ хүндэтгэх, асран халамжлах, тэжээн тэтгэх гэр бүлийн уламжлал үнэт зүйлээ эрхэмлэх үүрэгтэй байхаас гадна гэр бүлийн тогтвортой байдлыг хангах үүргийг хуульд тусгаж байгаа нь гэр бүлийн эрх зүйн харилцааны ёс зүйн суурь зарчмыг бататгах.

4.Гэрлэлт дуусгавар болох болон гэр бүл цуцлах ажиллагааг хүүхдийн эрхэд тулгуурлан шинэчилж, гэрлэлт дуусгавар болох үндэслэлүүдийг тодорхой болгож, гэрлэлт цуцлах ажиллагаанд хүүхдийн эрх дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах зарчмыг тусгах.

5.Хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн нас, хөгжлийн онцлог, хүүхдийн санал, эцэг эхийн хүмүүжүүлэх чадвар, оролцоо, хүүхэдтэй тогтоосон харилцаа, амьдралын нөхцөл байдал зэрэг олон улсын жишигт нийцсэн шалгуурыг харгалзан үзэхээр тусгасан нь гэр бүлийн эрх зүйн харилцааг шинэчлэх.

Хүүхдийн эрх, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, эцэг эх, хүүхдийн эрх, дээд ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах үндсэн субъект болохыг тодорхойлж, хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд төрийн байгууллага албан тушаалтан болон бусад эрх бүхий этгээдийн оролцоог нарийвчлан тусгах.

7.Эцэг эх хүүхдийн эрх, үүргийн зохицуулалтыг шинэчилж, хүүхдийн гэр бүлийн орчинд амьдрах, хүмүүжих, боловсрох, хөгжих, өв залгамжлах болон үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулж, эцэг эх хүүхдийн асуудлаар хамтын шийдвэр гаргах, хүүхдийн саналыг харгалзан үзэх, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг хамгаалах талаар эцэг эхийн үүргийг шинээр тусгах.

8.Хүүхдийн асрамж болон тусдаа амьдарч байгаа эцэг эхийн эрх үүргийг олон улсын жишигт нийцүүлж, хүүхдийн асрамжийг авсан тал хүүхдийн өдөр тутмын асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байх бөгөөд нөгөө тал хүүхдийн талаар мэдээлэл авах эрхтэй байхаар. Мөн хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол зөрчилтэй байгаа гэж үзвэл хүүхэд өөрөө 14 нас хүрсэн тохиолдолд шүүхэд хандах боломжийг бүрдүүлэх.

9.Эцэг эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх тогтолцоог боловсронгуй болгож, эцэг эх байх эрхийг хязгаарласан эсхүл хассан хүний зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хариуцлагыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгаж, эрх сэргээх асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн санд болон сургалтад хамрагдсан байдлыг харгалзан үзэх.

10.Гэрлэгчид эцэг эх, хүүхэд, төрөл садангийн хүмүүсийн харилцан тэжээн тэтгэх эрх үүргийг тодорхой болгож, насанд хүрсэн хүүхэд хөдөлмөрийн чадваргүй эцэг эхээ тэжээн тэтгэх үүргийг тусгайлан зохицуулж, хүүхдийн тэтгэлгийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг зарчмын болон найруулгын нийт 90 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Аргагүй л айрагийн хүүхэд байх нь дээ. Уушги сайтай нэг амьсгаагаар 32 цагаан лонх тоолдог маш хурдан санал, дүгнэлтийг уншиж танилцууллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах ШЕЗ-ийн гишүүн, Доржсүрэнгийн Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлого зохицуулалтын газрын дарга, Дондогийн Давааням УБЕГ-ын дарга, Оюунбаатарын Оюунзул ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч, Няндагийн Наранцэцэг Улсын бүртгэлийн газрын Иргэний бүртгэлийн газрын дарга, Эрдэнэбаярын Баярбаясгалан ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Батсайханы Тэнүүн Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын Байгалийн шинжлэх ухааны хэлтсийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийн эрхлэгч, Зоригийн Түвшинжаргал Гэр бүлийн бодлого судлаач, Сөртөөний Пүрэвсайхан Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч,

Мангалсүрэнгийн Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын Хүн ам, гэр бүл хөгжлийн бодлогын төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Батсуурийн Нарангэрэл Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газрын ахлах бүртгэгч, Бямба-Оюугийн Отгон УБЕГ-ын Иргэний бүртгэлийн газрын улсын ахлах бүртгэгч, Сэргэлэнгийн Солонго ГИХГ-ын Иргэний харьяатын газрын хариуцсан ахлах мэргэжилтэн, Жавзандоржийн Азжаргал Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж бодлого хариуцсан шинжээч, Дамдинчойжилын Ундраа Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн, Хүчирхийллийн үндэсний хорооны гишүүн ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүдийн асууж байгаа асуултад бүрэн гүйцэд, үнэн зөв, бодитой мэдээлэл өгч хариулна. Худлаа мэдээлэл өгөх, Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандах, асуултад хариулахаас татгалзах юм бол хуулийн дагуу холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээдгийг сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаг гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асуухаа болилоо, Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асуухаа болилоо, Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн алга байна. Асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энэ уначих гээд байна. Алтангэрэл гишүүн ээ яах вэ. Хурдан хураавал яадаг болов уу. Санал хураалтыг хойшлуулъя даа. Баасан гарагийн нэгдсэн чуулганы хуралдаанаар санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг хойшлууллаа.

Одоо чинь юу байгаа билээ? 23 цаг 20 минут болж байна. Тэгээд 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа Улсын Их Хурал амжилттай хэлэлцэж дууслаа.

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан хамгийн сүүлд өнөөдөр эцэслэтэл суусан Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, Булгантуяа, Ариунзаяа, Хүрэлбаатарын Баасанжаргал, манай Саранчулуун, Эрдэнэбат, Золжаргал, Алтангэрэл, Цогтбаатар, Мөнхтуяа, Зулпхар, Бейсен, Аубакир нарын гишүүддээ их баярлалаа.

Тэгээд чуулганы нэгдсэн хуралдаан мөн одоо шөнө орой болтол ажлын хэсгийн хуралдаанд хүрэлцэн ирж чуулгандаа оролцох гэсэн ажлын хэсгийн гишүүддээ их баярлалаа. Бас оройтсон бол, чилээсэн бол уучлаарай. Тамгын газрынхандаа баярлалаа.

Тэгээд өнөөдрийн нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье ээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА